Улсын бүртгэлийн дугаар Нууцын зэрэглэл: **Б**

.........................................

**Суурь судалгааны төсөл**
**Гэрээний дугаар: 82/2017**

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН**

# “МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НӨЛӨӨЛӨХ СУБЪЕКТИВ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ ” (2017-2019) СЭДЭВТ СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТАЙЛАН

| | |
|---|---|
| **Төслийн удирдагч:** | Академич Г.Чулуунбаатар |
| | ШУА-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгч |
| **Захиалагч:** | Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам |
| **Санхүүжүүлэгч:** | Шинжлэх Ухаан, Технологийн Сан |
| **Гүйцэтгэгч:** | ШУА-ийн Философийн хүрээлэн |

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН**

Улаанбаатар хот
2019 он

# “МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НӨЛӨӨЛӨХ СУБЪЕКТИВ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ” (2017-2019) СЭДЭВТ СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТАЙЛАН


| | |
|---|---|
| **Төслийн удирдагч:** | Академич Г.Чулуунбаатар |
| Төслийн гүйцэтгэгч: | Ш.Ариунаа доктор ( Sc.D) |
| | Б. Даш-Ёндон (ФХ, ЭШТА), доктор ( Sc.D) |
| | А.Цанжид, доктор ( Sc.D) |
| | Ш.Ганхуяг (ФХ, ЭША), доктор (Ph.D) |
| | Ж. Энхбаяр (ФХ, ЭШДэА) доктор (Ph.D) |
| | О.Хатанболд (ФХ, ЭШДэА), доктор (Ph.D) |
| | Б.Цэрмаа (ФХ, ЭШДэА), магистр |



| | |
|---|---|
| **Захиалагч:** | Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам |
| **Санхүүжүүлэгч:** | Шинжлэх Ухаан, Технологийн Сан |
| **Гүйцэтгэгч:** | ШУА-ийн Философийн хүрээлэн |

Улаанбаатар хот

2019 он


ГАРЧИГ

РЕФЕРАТ...3
НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ...5
1.1. Суурь судалгааны төслийн зорилго...5
1.2. Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага...5
1.3. Суурь судалгааны төслийн нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол...5
1.4. Судлагдсан байдал...6
1.5. Суурь судалгааны төслийн үр дүнгээс гарсан зарим дэвшилтэт талууд...7

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ...9
ГУРАВ. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТОЙМ...22
3.1. Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд хийсэн контент анализ...22
3.2. Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг...47
3.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл...52
3.4 Эрдэм шинжилгээний илтгэл...54
3.5. Арга зүйн матриц...56
3.6. Сүүлийн 10 жилд хийгдсэн олон нийтийн санаа бодлын судалгаа, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ...151
3.7. Нэг сэдэвт хамтын бүтээл...172
3.8. Ном товхимол...175
3.9. Бүтээлийн жагсаалт...177

ХАВСРАЛТ..............................................................................................................................180

## РЕФЕРАТ

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Философийн салбараас 2017-2019 онд "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн шинжилгээ" 82/2017 суурь судалгааны төслийг гүйцэтгэсэн болно.

Энэхүү төсөл нь ерөнхий суурь философийн хувьд нэг нэгдмэл онол, үзэл баримтлалын хүрээнд хийгдсэн. Сүүлийн арав гаруй жилийн туршид ШУА-ийн Философийн хүрээлэн судалгааны ажлынхаа нэг тэргүүлэх гол чиглэлийг Монгол Улсын хөгжлийн бодлого, түүний философийг боловсруулах явдал хэмээн тодорхойлж цуврал төсөл хэрэгжүүлсэн билээ. Энэ төслүүдийн хүрээнд хэд хэдэн дорвитой бүтээл хэвлэгдэн гарсан. Тэдгээрт хөгжлийн асуудлыг социал философийн үүднээс хэрхэн ойлгох, монголын нийгмийн хөгжлийн асуудлыг шинжлэхэд арга зүйн хувьд ямар ямар зарчимд үндэслэх вэ? гэдгийн ерөнхий дүр зураг гарсан гэж үзэж болно.

Харин энэхүү төслийн судалгааны гол зорилго бол хөгжлийг социаль философийн үүднээс ойлгож Монгол Улс урт хугацаанд тогтвортой хөгжихөд хүн, хүний хүчин зүйлээс хамааралтай хүчин зүйл буюу субъектив хүчин зүйл юу байх, түүний улсын хөгжилд үзүүлэх нөлөө ямар байхыг тоймлон гаргах явдал юм. Бидний хувьд цаг хугацаа, орон зайн хэмжүүрийг хамтад нь Монгол Улсынхаа урт хугацааны буюу 15-аас дээш жилийн хөгжлийн ирээдүйг тооцсон стратегийн бодлогын хэрэгжилтэд нөлөө үзүүлдэг, тэгэхдээ чухамхүү хүнээс, хүний ертөнцөөс бүхэлд нь хамааралтай хүчин зүйлсийн тухай ярьж байгаа болно. Урт хугацааны хөгжлийн стратегийг хүн төрөлхтөн, тэгэхээр манай улс ч түүхэн цаг хугацаа бүрд өөр өөр тусгайлсан нэр оноож тодорхойлсоор иржээ.

Энэхүү суурь судалгааны төслийн үр дүнд хөгжил хэмээх нэн өргөн хүрээтэй том ухагдахууныг философи, ёс зүй, улс төр, эдийн засгийн гэх мэт олон талаас тайлбарлаж, гүнзгийрүүлэн судалж, судлан буй асуудлын хүрээнд нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл олныг хэвлэн нийтлүүлсэн нь сургалт, судалгааны мэдээллийн эх сурвалж болох төдийгүй төр засгийн бодлого үйл ажиллагаанд ач тусаа өгөх практик ач холбогдолтой.

Төслийн үр дүнд бид нэг сэдэвт хамтын бүтээл 1, эрдэм шинжилгээний өгүүлэл 9, илтгэл 14, санал зөвлөмж 1, орчуулгын бүтээл, ном, товхимол 7, Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд хийсэн контент анализ-

1, Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн төсөлтэй харьцуулсан матриц -1, сүүлийн 10 жилд хийгдсэн олон нийтийн санаа бодлын судалгаа, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ-1, эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг 3-ыг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгэн шинжилж зөвлөмж боловсруулан төрийн холбогдох байгууллагад хүргүүлсний зэрэгцээ хэвлүүлж нийтийн хүртээл болгов. Контент анализыг бэлтгэхдээ монгол хэл дээрх 63, англи хэл дээр 20, орос хэл дээрх 4 баримт материалыг эх хэрэглэгдэхүүн болгон ашигласан.

Суурь судалгааны үр дүнгээр гарсан бүтээлүүд нь эрдэм шинжилгээ, сургалтын практикт шууд хэрэглэгдэж байгаа болно.

**ТҮЛХҮҮР ҮГС:** *хөгжил, субъектив хүчин зүйл, стратегийн бодлого, бодлогын хэрэгжилт, урт хугацааны хөгжил*

## ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧИД

Төслийн удирдагч: Г.Чулуунбаатар, Академич

Гүйцэтгэгчид: Ш.Ариунаа, доктор ( Sc.D)

Б. Даш-Ёндон (ФХ, ЭШТА), доктор ( Sc.D)

А.Цанжид, доктор ( Sc.D)

Ш.Ганхуяг (ФХ, ЭША), доктор (Ph.D)

Ж. Энхбаяр, (ФХ, ЭШДэА) доктор (Ph.D)

О.Хатанболд (ФХ, ЭШДэА), доктор (Ph.D)

Б.Цэрмаа (ФХ, ЭШДэА), магистр

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Баруун Сэлбийн гудамж-15, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 2 дугаар байр, Философийн хүрээлэн

Утас: 976-330847

Э-шуудан: chuluunbaatar@mas.ac.mn

# Нэг. ҮНДСЭН ХЭСЭГ

## 1.1. Суурь судалгааны төслийн зорилго

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг олох замаар сөрөг нөлөөллийг саармагжуулах, гарч болох эрсдлээс сэргийлэх арга замыг тодорхойлоход оршино.

## 1.2. Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага

Монгол Улс хүний хөгжлийн үзүүлэлтээр дэлхийн 177 орноос 92, эдийн засгийн өрсөлдөх чадварын индексээр дэлхийн 140 орноос 99, бизнесийн орчны индексээр дэлхийн 190 орноос 74, авлигын индексээр 93 дугаар байрыг тус тус эзэлж байна. Монгол Улс хөгжлийн олон үзүүлэлтээр бүс нутгийн улс орнууд, дэлхийн дунджаас доогуур байдалтай байсаар байна.

Монгол Улс НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилго болон бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан 2016 онд "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030"-ыг батлан гаргасан билээ. Эл бодлогын хэрэгжилтэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн нөлөөллийг судалж тодорхойлох шаардлага нь дараах үндэслэлүүдээр чухалчилагдаж байна. Үүнд:

- Улс орноо хөгжүүлэхэд нийгмийн оюун санаа, ёс суртахуун, улс төрийн соёлын доройтол ноцтой саад учруулах хэмжээнд хүрээд байгаагийн шалтгаан, хөгжилд үзүүлэх нөлөөллийг нь тодорхойлох нь чухал.
- Монголчуудынхаа сэтгэлгээ, сэтгэл зүйн онцлог, уламжлалт ёс заншил, соёл, урлаг, шашин шүтлэг зэрэг монголын нийгэм оюун санааны амьдралыг бүхэлд танин мэдэхгүйгээр улс орны урт хугацааны хөгжлийн бодлого хэрэгжих боломжгүй.
- Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд засаглалын харилцааны субъектив үзэгдлүүд хүчтэй нөлөөтэй байгааг судалж тодорхойлох тулгамдсан шаардлага байгаа нь сүүлийн жилүүдийн туршлагаас харагдсан.

## 1.3. Суурь судалгааны төслийн нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол

Монгол Улс 1992 оноос хойш хөгжлийн урт болон дунд, богино хугацааны 517 төсөл, хөтөлбөр, бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажилласан ч хэрэгжилт нь хангалтгүй, хоорондын уялдаа муу байсан. Иймд "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль"-д зааснаар хөгжлийн бодлогын баримт бичиг нь урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх боломжтой гэж үздэгийг үндэс болгон энэ хугацаанд нийгмийн хөгжлийн субъектив хүчин зүйлсийн өөрчлөлт, нөлөөлөл ямар түвшинд буйг тодорхойлсноор дараах шинжлэх ухаан, нийгмийн ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

- Бодлогын судалгааны шинэ чиглэл илүү үр нөлөөтэй хөгжих, шинэ мэдлэг, онол арга зүйг бодлого хэрэгжүүлэх практикт ашиглах боломж сайжирна.
- Судалгааны ажлын үр дүнд бодлогын хэрэгжилтийн оюун санааны болон улс төр, засаглалын орчин нөхцөл харьцангуй цогц байдлаар тодорхойлогдоно.
- Монгол улсын урт хугацааны тогтвортой бодлого хэрэгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийн эерэг ба сөрөг үр дагаврыг урьдчилан тооцоолох, улмаар болох эрсдлээс сэргийлэх боломж бүрдэнэ.
- Бодлогын хэрэгжилт, тодорхой төсөл, хөтөлбөр, төлөвлөлтийн үр дүнг үнэлж дүгнэхдээ субъектив хүчин зүйлсийг тусгасан шалгуур үзүүлэлтийг боловсруулах шинжлэх ухааны үндэслэл бий болно.
- Цаашдаа шинэ батлан гаргах бодлого, хөтөлбөрүүд монголын нийгмийн "хөрс"-нд бууж үр ашигтай хэрэгжихэд түлхэц болно.

**1.4. Судлагдсан байдал**

Монгол Улсад Бодлогын шинжлэх ухаан, бодлого судлал эхлэлийн төдий байгаа гэж үзэж болно. 2000 оны эхэн үеэс ННФ /нээлттэй нийгмийн хүрээлэн/-аас голлон санаачилж Еоин Янг, Лиза Квин нарын зохиосон Төв ба Зүүн Европын орнуудын бодлогын зөвлөхүүдэд зориулсан "Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь" (Уб., 2002) нэртэй анхны гарын авлагыг орчуулжээ. Мөн энэ үед Удирдлагын академийн багш Я.Бямбасүрэн, П.Доржсүрэн, нар "Төрийн бодлого" (Уб., 2006) авлагыг зохиосон буй.

Профессор А.Цанжид бакалаврын сургалтанд зориулж Жон Юл Ли, Чад Андерсон нарын "Бодлогын шинжилгээ" (2010) сурах бичгийг англи хэлнээс орчуулсан байна. Мөн цөөнгүй судалгааны өгүүлэл нийтлэгджээ.

Удирдлагын академиас "Бодлогын шинжилгээ" сэтгүүлийг эрхлэн хэвлүүлж байна.

"Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтэнд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн шинжилгээ" сэдэвт суурь судалгаанд арга зүйн үндэслэл, сурвалж хэрэглэгдэхүүн болох бүтээлүүд 2010 оны үеэс гарч эхэлсэн гэж үзэж болно. Тухайлбал,

- Академич С.Норовсамбуу, академич Г.Чулуунбаатар, профессор Б.Даш-Ёндон нарын удирдлагаар хэвлэгдсэн "Монголын нийгмийн өөрчлөлт" (Уб., 2008, 2013) хамтын бүтээл,
- Профессор А.Цанжидын бичсэн "Төр барихуйн Монгол ухаан" (Уб.,2011) нэгэн сэдэвт зохиол,
- Нээлттэй нийгэм форум, СУИС-аас хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд нийтлэгдсэн "Соёлын бодлого: Соёл урлагийн салбарын хувьчлал" (Уб., 2010),
- С.Будням, Б.Цогоо Монгол улсын шилжилтийн үеийн эдийн засгийн бүтцийн математик шинжилгээ. (Уб.,2012)

Доктор Б.Даш-Ёндон туурвиж, академич Г.Чулуунбаатарын редакторласан бүтээлүүдээс дурдвал:

- "Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус)" (Уб.,2013),
- "Нийгмийг танихуй: түүх-хөгжлийн философи" (Уб., 2014),
- "Соёмбо сүлд-Монгол ухаан" (Уб., 2015),
- "Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус)" нэмж засварласан хоёрдахь хэвлэл. (Уб., 2017),
- Хөгжихүйн философи. (УБ., 2019)
- Доктор Р.Батмэнд "Монголын хөгжлийн бодлогын философи: улс төр эдийн засгийн ухаан холбогдох нь", (Уб., 2016) зэрэг бүтээлүүдийг дурьдаж болно.

УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Судалгааны албанаас Нийгэм эдийн засаг, дэд бүтэц, санхүүгийн салбар; Уул уурхай ашигт малтмалын салбар; Эрх зүй, төрийн байгуулалт, гадаад бодлогын асуудал; Нийгмийн бодлогын асуудал; Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгал орчны асуудлаар цаг үеийн шинжтэй судалгаа шинжилгээний ажлуудыг хийж, "Бодлогын судалгаа, шинжилгээ" /2009-2015 онд/ хэмээх 21 боть цувралыг эмхэтгэн гаргасан байна. Эдгээр нь шийдвэр гаргах, хууль тогтооход тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг гаргах, хувилбаруудын эерэг сөрөг талыг үнэлэх, аль болох өргөн хүрээтэй мэдээлэл судалгаагаар богино хугацаанд шийдвэр гаргагчдыг хангах зорилготой хэрэглээний мэдээллүүд бөгөөд бидний судалгаанд чухал хэрэглэгдэхүүн болох юм.

### 1.5. Суурь судалгааны төслийн үр дүнгээс гарсан зарим дэвшилтэт тал

- Бодлогын шинжилгээний чиглэлээр Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн оюуны болон улс төр, засаглалын хүчин зүйлсийн шинжилгээнд хамаарах сэдвээр эрдэм шинжилгээний 2 ном туурвиж нийтийн хүртээл болгов. Эдгээр нь бодлогын хэрэгжилтийн субъектив хүчин зүйлс, оюун санаа, улс төрийн болон засаглалын орчин нөхцөлийг цогц хөндсөнөөрөө агуулгын хувьд бүхэлдээ шинэлэг бүтээл болж чадсан гэж үзэж байна.
- Хөгжлийн урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд хэрэг болох бодлогын зөвлөмж, шинэ санаа оноо дэвшүүлсэн 6 өгүүлэл нийтлэгдэнэ. Өгүүллүүд хөгжлийн бодлогын хэрэгжилтэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийг: **а.** оюуны соёлын, **б.** шашин зан үйлийн, **в.** сэтгэл зүйн, **г.**засаглалын харилцааны, **д.** улс төрийн соёл, боловсролын гэх мэтээр ангилан тус бүрээр нь шинэлэг санаа дүгнэлтүүд дэвшүүлсэн.
- Хөгжлийн талаарх сонгодог ба сонгодог бус философи дахь хөгжлийн тухай үзэл санааг тоймлон гаргаж, эдгээр үзэл баримтлалын үүднээс хөгжлийн субьектив хүчин зүйлс, урт хугацааны хөгжлийн бодлогыг засаглалтай холбох асуудлыг судалгааны баялаг эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан авч үзсэн байна.

- Хөгжлийн урт хугацааны бодлогын хэрэгжилтэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн асуудлаар судлаач, мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлэгт бодлогын шинжилгээний тодорхой илтгэлүүд тавьж хэлэлцүүлсэн.

# Хоёр. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

## МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН СУБЬЕКТИВ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ СУДЛАХ ОНОЛ, ФИЛОСОФИ АРГА ЗҮЙ

ШУА-ийн Философийн хүрээлэн сүүлийн арав гаруй жилийн туршид судалгааны ажлынхаа нэг тэргүүлэх гол чиглэлийг Монгол Улсын хөгжлийн бодлого, түүний философийг боловсруулах явдал хэмээн тодорхойлж хэд хэдэн цуврал төсөл хэрэгжүүлсэн билээ. Энэ төслүүдийн хүрээнд хэд хэдэн дорвитой бүтээл[1] хэвлэгдэн гарсан юм. Тэдгээрт хөгжлийн асуудлыг социал философийн үүднээс хэрхэн ойлгох, монголын нийгмийн хөгжлийн асуудлыг шинжлэхэд арга зүйн хувьд ямар ямар зарчимд үндэслэх вэ? гэдгийн ерөнхий дүр зураг гарсан гэж үзэж болно. Ялангуяа профессор Б.Даш-Ёндон, Ч.Ган-Өлзий нарын судалгааны үр дүнг харьцуулж үзвэл энэ хоёр эрдэмтэн олон тодорхой асуудлаар үзэл бодлоо ялгаатай илэрхийлж байгаа боловч хөгжлийг үзэх философи хандлагын хувьд түүнийг Б.Даш-Ёндон "хөгжил бол...найрсах үйл явц, найрссан төрх байдал..." гэсэн үзлийн үүднээс, Ч.Ган-Өлзий хөгжлийг "зохицол, шүтэн барилдахуйн онол"-ын үүднээс шинжлэх тухай ярьж байгаа нь тун ойртсон байр юм.

Профессор Б.Даш-Ёндонгийн «хөгжил» гэдэг ойлголтыг онол, практикийн үүднээс тодорхойлсон ойлгомжтой тодорхойлолтыг иш үндэс болгож байна. Тэрээр ***онолын үүднээс:*** «Хөгжил гэдэг бол ерөнхийлж хэлбэл, юмс, үзэгдэл өөрөөсөө салаалан цэцэглэж, салаалсан нь бие даан төгөлдөржиж, улмаар эргээд нэгдмэл болгодог холбоонд орж найрсах үйл явц, найрссан төрх байдлыг заасан нэр томъёо юм» гээд **практикийн үүднээс:** «Хөгжил, хөгжлийн явц, эсхүл хөгжлийн үзүүлэлт гэдэг бол нийгэм, үндэстэн, улс орон хэрэгцээндээ тулгарсан юмаа өөрөө үйлдвэрлэж бүтээх, ашиглах, эдгээр ажил хэргээ зохион байгуулах ур чадварын үе шат, сайхь үе шатны шинж чанар юм»[2] хэмээн томъёолжээ.

Хөгжлийг социаль философийн үүднээс Монгол улс урт хугацаанд тогтвортой хөгжихөд хүн, хүний хүчин зүйлээс хамааралтай хүчин зүйл буюу субьектив хүчин зүйл юу байх, түүний улсын хөгжилд үзүүлэх нөлөө ямар байхыг тоймлон гаргах нь л бидний зорилго мөн.

---

[1] Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2011, Батын Ч.Ган-Өлзий Хүмүүнлэгийн гурван ертөнцийн гоц чанарыг судлахуйн чандмань эрдэнэ. УБ., 2011, Батын Ч. Ган-Өлзий. Тогтвортой хөгжил, оюуны ертөнцийн философи. УБ., 2018, Д.Чулуунжав. Нийгмийн философи: Онол, туршилт, сургамж, шүүмж. УБ., 2014., Б.Даш-Ёндон. Цаг үе: сэтгэл, бодрол, философи. УБ., 2012. Монголын нийгмийн өөрчлөлт. Нэмж засварласан 2 дахь хэвлэл. УБ., 2013,

[2] Б.Даш-Ёндон. "Монголын хөгжлийн философи". Философийн ухаанаар шинжлэх ухааны доктор\ScD\-ын зэрэг горилж бичсэн диссертацийн хураангуй. Гар бичмэлийн эрхтэй. УБ., 2019 7 дахь тал

Тэгэхлээр урт хугацаа гэдэг ямар цаг хугацаа байх вэ? гэдэг асуудал гарна. Ирээдүй судлал /футурологи/, бодлого төлөвлөлтөд "одоогийн байдал" "ойрын ирээдүй", "алсын ирээдүй" гэх эсвэл "богино хугацаа", "дунд хугацаа", "урт хугацаа" гэх мэт он жилээр баримжаалсан ойлголтууд нэгэнт хэвшсэн зүйл. Эдгээрийн аль нь, ойролцоогоор хэдэн жилийг хамрах нь ч бараг тогтчихсон. Гэхдээ философийн үүднээс цаг хугацаа бол нэг чиглэлтэй, эргэж буцдаггүй, орон зайн хэмжүүртэй уялдаж байдаг маш нарийн утга учиртай ойлголт.

Тийм болохоор бидний хувьд цаг хугацаа, орон зайн хэмжүүрийг хамтад нь Монгол Улсынхаа урт хугацааны буюу 15-аас дээш жилийн хөгжлийн ирээдүйг тооцсон стратегийн бодлогын хэрэгжилтэд нөлөө үзүүлдэг, тэгэхдээ чухамхүү хүнээс, хүний ертөнцөөс бүхэлд нь хамааралтай хүчин зүйлсийн тухай ярьж байгаа болно. Урт хугацааны хөгжлийн стратегийг хүн төрөлхтөн, тэгэхээр манай улс ч түүхэн цаг хугацаа бүрд өөр өөр тусгайлсан нэр оноож тодорхойлсоор иржээ.

Өнөөдөр хүртэл улс орнуудад хэрэгжиж буй хөгжлийн урт хугацааны үзэл онолуудыг судлаачид ерөнхийд нь **глобаль ба эндоген** үзэл баримтлал гэж хоёр ангилан шинжилсэн байх аж. Глобаль үзэл баримтлал гэх нь ерөнхийлсөн нэр. Тодорхой үзэл баримтлалын хувьд бол өөр өөрийн оноосон нэртэй, бас тус тусын өвөрмөц онцлогтой юм. Нийтлэг зүйл нь дэлхийн хөгжлийг тодорхойлж буй том орнуудын хөгжлийн бодлогын үндэс болдогт оршино.

1960-аад оноос НҮБ болон түүний харьяа байгууллага "...хөгжлийг эдийн засгийн өсөлттэй адилтгадаг үзэл баримтлал", түүнтэй төсөөтэй онолууд юм. Энд эдийн засгийн өсөлтийг нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээр хэмждэг. Хөгжлийн стратеги 1970-аад оныг хүртэл үндсэндээ эдийн засгийн үр ашиг, үйлдвэрлэлийн өсөлтийг голлосон үзэл баримтлалд суурилж байлаа. Энэ хугацаанд хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах талаар тодорхой амжилт олсон ч хүрээлэн буй орчны доройтолд хүргэсэн нь хөгжлийн шинэ стратеги буюу Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бий болох үндэс болсон байдаг.

1970-аад оноос энэ үзэл баримтлал хүний хөгжилд илүү анхаарах болж, хүний тал бүрийн хөгжлийн тухай буюу "хүн төвтэй хөгжлийн үзэл баримтлал" болон баяжсан гэж үзэж болно. 1974 оны Кокайн Тунхаглалд "хөгжил гэдэг бол юмсын хөгжил бус хүний хөгжил байх ёстой"[3] гэсэн энэ үзэл баримтлалын гол агуулгыг хураангуйлсан томьёолол юм.

Үндсэндээ 1990-ээд оноос "даян дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал" бий болж одоо эдүгээ дэлхийн ихэнх улс орнууд, түүний дотор Монгол улс түүнийг жишиг баримжаа болгож байна. Энэ үзэл баримтлал нь мөн л **глобаль шинжтэй** бөгөөд гол онцлог нь экологийн өөрчлөлтийн үнэ цэнэ, хүчин зүйлийг чухалчилдагт оршино. Хөгжлийн тухай эдгээр үзэл баримтлал НҮБ болон олон

[3] Cocoyos Decleration. UNEP\UNCTAD. 1974

улсын банк, санхүүгийн байгууллагын хөгжлийн тухай ойлголтын гол ноён нуруу, хэрэгжүүлэх бодлогын цөм нь болсоор байна. Монгол улсын төрийн бодлогын албан ёсны бараг бүх шийдвэр энэ үзэл баримтлалын хүрээнд бий. Харин улс төрчид, судлаачдын үзэл бодлоо илэрхийлж буй тухайд бол **эндоген үзэл баримтлал**ын үзэл санаа, зарчмууд их тодорхой харагддаг.

Ийнхүү XX зууны сүүлийн хагасаас эхлэн "Тогтвортой хөгжил" хэмээх нэр томьёо урт хугацааны хөгжлийн стратегийн гол тодотгогч агуулга болсон байна.

**Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал.** Хүрээлэн буй орчныг доройтуулахгүйгээр хүний сайн сайхан аж байдлыг нэмэгдүүлэх нь "Тогтвортой хөгжил"-ын гол агуулга аж. 1972 онд Стокольм хотноо НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас олон улсын тогтвортой хөгжлийн анхны "Хүн төрөлхтөн ба Байгаль орчин" чуулга уулзалтыг зохион байгуулж тогтвортой хөгжлийн тунхаглал болон хүрээлэн буй орчны хөгжлийн 26 зарчмыг баталсан билээ. Хөгжил ба Хүрээлэн буй орчны талаарх Даян дэлхийн Комисс 1987 онд Брундтландын Комиссын тунхаглал буюу "Манай нийгмийн ирээдүй" нэртэй баримт бичгийг батлан гаргаснаар Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн зарчмууд анх удаа албан ёсоор томьёологдсон гэж үздэг байна. Чухам энэ үеэс тогтвортой хөгжил бол байгалийн баялаг, технологийн хөгжил, хөрөнгө оруулалт, засаглалын өөрчлөлтийг ашиглан одоо болон ирээдүй үеийнхээ төлөө эрэлт хэрэгцээг хохироохгүйгээр нийгэм бүхэлдээ хөгжих үйл явц гэсэн ойлголт өргөн хүрээнд хэрэглэгдэх болов.

НҮБ-ын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Брундтландын комисс "Манай ирээдүй" (*1987 он*) тайландаа энэхүү үзэл баримтлал нь "хүмүүний нийгэмлэгийн тогтвортой хөгжил" хэмээх нэр томьёог өргөн ашигласны үр дүнд НҮБ-ын хүрээнд цаашдын хөгжлөө олсон байна. Тогтвортой хөгжлийн хүчин зүйл нь хүний амьдралын чанарыг сайжруулж, биологийн, нийгмийн, эдийн засгийн, соёлын, улс төрийн, эд материалын болон экологийн нөхцөл байдлыг тооцоолон хүний нөөцийн хөгжлийг өөртөө агуулдаг учраас энэ үзэл хандлага богино хугацаанд нийтэд хүлээн зөвшөөрөгджээ.

Үүнээс хойш 1992 онд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын (ХБНБУ) Рио де Жанейро хотод зохион байгуулагдсан НҮБ-ын Рио-гийн "Байгаль орчин ба Хөгжил" Даян Дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтад Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүтэй төлөөлөгчид оролцон олон улсын тогтвортой хөгжлийн хамтын нийгэмлэгт анх удаа нэгдэн орсон түүхтэй. Тус дээд хэмжээний чуулга уулзалтаар тогтвортой хөгжлийн тунхаглалын 27 зарчмыг батлаж, НҮБ-ын гишүүн орон бүр өөрсдийн XXI зууны Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрөө боловсруулах үүрэг амлалт авч, тогтвортой хөгжлийг хангах арга хэмжээг зохион байгуулж ирсэн.

Манай улс 1996-1999 онд "Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр"-өө боловсруулж, түүнтэй нийцүүлэн нийт 21 аймаг, нийслэлийн

хэмжээнд Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг боловсруулсан билээ. "Монгол Улсын XXI зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр"-т тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал /2001он/, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого /2008/ зэрэг урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөр жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ирсэн гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, даян дэлхийн тогтвортой хөгжлийн үйл явцад Монгол улс 20 гаруй жилийн турш идэвхитэй оролцогч, улсынхаа хөгжлийн урт хугацааны бодлогыг энэ үзэл баримтлалтай нягт холбон тодорхойлдог орон болоод байна.

Монгол Улсын төр засгаас сүүлийн жилүүдэд хөгжлийн бодлогын асуудалд онцгой анхаарал хандуулж олон тооны чухал шийдвэрийг гаргав. 2016 онд Монголын парламент "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" хэмээх урт хугацааны бодлогын баримт бичиг, "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай" хуулийг тус тус баталжээ. Харин 2015 оны 9 дүгээр сарын 25–нд НҮБ–аас батлан гаргасан "XXI зууны тогтвортой хөгжил-2030" хэмээх баримт бичигт гишүүн орнууд бодлогодоо тусгаж хэрэгжүүлэх 17 зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнийг дагалдаж даян дэлхийн тогтвортой хөгжлийн онол, парадигмд гарч буй шинэ өөрчлөлт, тэдгээрийг тусгасан "Социаль чиг баримжаатай эдийн засаг", "Мэдлэгийн эдийн засаг", "Мэдлэгийн Менежмент, "Мэдлэгт суурилсан хөгжил", "Судалгаа хөгжүүлэлтийн ажил" зэрэг шинэ ойлголт, категориуд судалгаа, хөгжүүлэлтийн ажлын эргэлтэд маш эрчимтэй орж ирлээ. Эдгээр нь чухамдаа тогтвортой хөгжлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд хүний буюу субьектив хүчин зүйлсийн үүрэг улам бүр өссөөр буйн илэрхийлэл мөн.

Өнөөдөр дэлхийн улс орнууд НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаар Үндэсний сайн дурын илтгэлүүдээ бэлтгэн хэлэлцүүлж байгаа бөгөөд манай улс 2019 онд ийм илтгэлээ бэлтгэж хэлэлцүүлэхтэй холбоотойгоор НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд ба Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын зорилтууд, түүний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг харьцуулах шаардлага гарч байгаа болно.

"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д энэхүү урт хугацааны баримт бичгийн гол зорилтыг хэрэгжүүлснээр хүрэх эцсийн бодит үр дүнг: Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно" хэмээн тодорхойлсон байна.

Үзэл баримтлалд улсаа хөгжүүлэх ойрын 15 жилийн зорилтыг: а\. Эдийн засгийн тогтвортой хөгжил, б\. Нийгмийн тогтвортой хөгжил, в\. Байгаль орчины тогтвортой хөгжил, г\.Тогтвортой хөгжлийн засаглал гэсэн үндсэн дөрвөн багцаар тодорхойлж, зорилт бүрийг нэг /2016-2020/, хоёр /2021-2025/, гурав /2026-2030/ гэсэн

гурван үндсэн үе шаттай хэрэгжүүлэхээр заажээ. Харин хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх үзүүлэлтүүдийг тодорхой заагаагүй байна.

НҮБ-аас баталсан ТХЗ-ууд нь хүмүүн төрөлхтөн, эх дэлхий, хөгжил цэцэглэлт, энх тайван, хамтын ажиллагаа (partnership) гэсэн таван тулгуурт үндэслэн дэлхийн улс бүрт, хөгжлийн гадна хэнийг ч үлдээлгүй хүн бүрийн оролцоог хангах цогц 17 зорилгыг дэвшүүлж, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг боловсруулжээ.

Мэргэжилтнүүдийн тооцоогоор НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилттой бөгөөд хэрэгжилтийг хянах нийт 244 үзүүлэлтээс Монгол Улс одоогийн байдлаар 118 үзүүлэлтийг тооцох аргачлал, мэдээллийн эх үүсвэрийг болгожээ[4]. Энэ нь тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд хяналт тавих, улмаар эрчимжүүлхэд зарим хүндрэл учруулж болзошгүй. Иймд үлдсэн үзүүлэлтийг тооцох үндэсний статистикийн холбогдох бусад байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх шаардлага үүсжээ. Энэ талаар Үндэсний сайн дурын илтгэлд тодорхой дурьдсан байна.

Өөрөөр хэлбэл, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д дэвшүүлсэн зорилтуудыг НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан нарийвчлах бодит хэрэгцээ буй болж дэлхий дахины болон улс орныхоо хөгжилд гарч буй өөрчлөлт, шинэ нөхцөл байдлыг тусгаж баяжуулан боловсруулах зорилт урган гарч байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй бодож улс орноо шинэ нөхцөл байдалд хөгжүүлэх бодлогын философитой, түүнийг амьдрал ахуйдаа буулган хэрэгжүүлэх урт хугацааны төлөвлөгөөтэй, тэдгээр зохистой үйлчлэх хууль эрх зүйн зохицуулалттай байх нь нэн чухал билээ.

Хөгжлийн философийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхэд бодлого, төлөвлөлтийн бүхий л үйл явцыг ***цаг хугацааны логик дараалал, нийгмийн зохион байгуулалтын шатлал бүрээр нь цэгцтэй хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин*** нэн чухал. Сүүлийн жилүүдэд улсаа хөгжүүлэх төрийн бодлогын эрх зүйн ийм орчин бүрхэг байсны улмаас бодлогод тасалдал, хийдэл тэр ч бүү хэл хүлцэшгүй алдаа завхрал цөөн биш гарав. Энэ байдлыг манай төр ямар нэг хэмжээнд ойлгож УИХ-аас хөгжлийн бодлого, төлөвлөлтийн ажлыг хуулиар зохицуулах болж, улс орон даяар мөрдөгдөж байгаа хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаарх тогтоол, шийдвэр, заавар, журмыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байгаа нь сайн эхлэл.

Монгол улсад өнөөдөр төрийн бодлогын хэмжээнд батлагдсан хоёр зуу хол давсан тооны бодлого, хөтөлбөр, төслүүд байгаа тухай мэдээлэл буй. Монголын парламент тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг батлахдаа: "Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн

[4] Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт. Монгол Улсын засгийн газар. УБ., 2019., 18 дахь тал

эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах"[5] тухай шийдвэр гаргасан билээ. Хийгээд буй ажлуудын аль нь шинжлэх ухааны үндэстэй судалгаа шинжилгээнд тулгуурлаж чадахгүй байна. Монгол улсаа хөгжүүлэх бодлогын хэрэгжилт нь юуны өмнө, Монголоо түүх, уламжлалтай нь одоогийн бодит байдлаар нь цогц судлан таних ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулж чадвал хамгийн үр дүнтэй байх боломжтой. Чухам ийм үзэл, зарчмын өнцөгөөс л бодлого боловсруулахаас эхлээд хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үр дүнг үнэлж дүгнэх бүх шатанд хандаж ажилладаг болсон нөхцөлд л Монгол улсын хөгжилд шинжлэх ухааны оруулах хувь нэмэр бодитой болж чадна.

Эдүгээ хүртэл боловсруулан хэрэгжүүлж ирсэн бодлогын баримт бичиг, бодлогын судалгааны үйл ажиллагааны талаарх мэдээллээс үзэхэд хөгжлийн бодлогод философи нь бүрхэг, санаанууд нь тунхаглалын шинжтэй, ихээхэн тарамдуу байгаа учраас цэгцтэй нэг үзэл болгож үе үеийн засгийн газрууд нэгдмэл стратегийн хэмжээнд залгамжлан хэрэгжүүлж чадсангүй. Хамгийн гол нь ард түмний сэтгэл оюунд шингэж, итгэл үнэмшил болсонгүй, хүн зоны ажил амьдралд нь хэвшиж үндэсний хувьд нэгтгэж нягтруулах үзэл санааны хөтөч болж хэрэгжсэнгүй.

Үүний гол шалтгаан нь хөгжлийг үзэх үзэл, үзэл баримтлал нь улсынхаа хөгжлийн түвшин, соёл иргэншлийнхээ онцлог, хүн ардынхаа сэтгэл оюуны бодит эрэлт хэрэгцээг тусгахын оронд өрнөдөөс гаралтай, их гүрнүүд бодлого, соёл иргэншлээ түгээн дэлгэрүүлэхэд голлон ашиглаж буй хөгжлийн номлолыг хэт өрөөсгөлөөр шүтэж ирсэнтэй холбоотой гэж үзэж болно.

Өөрөөр хэлбэл, манай засаг төрийнхөн бидний дээр дурьдсан глобаль ба эндоген үзэл баримтлалаас глобаль үзэл баримтлалыг дагаж ирсэн байна. Орчин үед ямар ч улс орон, ялангуяа манай мэтийн бага орнууд дурьдсан хоёр хувилбарын аль нэгийг хатуу баримтлах нь бараг боломжгүй зүйл. Харин алийг нь суурь болгох вэ? гэдэг нь нухацтай бодох асуудал. Монгол улсын хөгжлийн бодлогын тухайд хөгжлийн тухай эндоген үзэл баримтлалыг суурь болгож, олон улсын хамтын нийгэмлэгийн идэвхтэй оролцогчийн хувьд глобаль үзэл баримтлалуудыг үндэснийхээ язгуур эрх ашигт нийцүүлэн харгалзаж байх шаардлагатай гэж үзэж байна.

Эндоген буюу дотоодоосоо үүсвэрлэсэн хөгжлийн тухай үзэл нь өөрийн хөгжлийн замыг нийгмийн дотоодын уг чанараас ургуулан олох тухай санаанд үндэслэдэг. Эндоген шинж нь:

- Тухайн орны үндэсний уламжлалт үнэлэмж, соёлыг хүндэтгэх
- Тусгаар тогтнол, үндэсний язгуур эрх ашгийг дээдлэх

[5] "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай" Монгол Улсын Их хурлын тогтоол. 2016 оны 02 сарын 05 өдөр Дугаар 19

- Ард түмний бүтээлч идэвхид тулгуурлах
- Дотоод боломжийг дээд зэргээр ашиглах эдгээр аж.

Ийм үзэл баримтлалыг Латин Америкийн орнуудын эрдэмтэд гаргаж ирсэн бөгөөд үүнийг "хараат байдлын онол", Орос, Хятадын болон Азийн орны эрдэмтдийн дэвшүүлдэг "Хятадын онцлог бүхий социализм байгуулах онол" гэх мэтийг нэрлэж болох юм.

Ийм үзэл баримтлалыг суурь болгож байгаа улс орнууд урт хугацааны хөгжлийн бодлогоо тодорхойлохдоо дор дурьдсан зүйлүүдийг хөгжлийн нөөц, эх сурвалж хэмээн тооцоолдог болжээ. Энэ нь:

- Үндэсний соёл, хүмүүний хөгжил, бүтээх чадавхи
- Технологийн хуримтлал, түүний хүрсэн төвшин
- Байгалийн нөөц баялаг, түүний үр өгөөжтэй ашиглалт, боловсруулалт
- Хөрөнгийн хуримтлал, санхүүгийн давуу тал [6]

Эдгээрийг манай улсын урт хугацааны хөгжлийн бодлогод ямар нэг хэмжээгээр тооцсон байдаг байх. Бидний хувьд хөгжлийн субьектив хүчин зүйлд холбогдох талаас нь голлож тус бүрийг нь товч хөндөж байна.

Өөрөөр хэлбэл, манай орны цаашдын хөгжлийн бодлого нь энд дурдсан үндсэн чиглэлээр тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдан тодорхойлогдоно. Энэ гол чиглэлүүд бол чухамдаа урт хугацааны хөгжлийн үйл явцад нөлөөлөх субьектив хүчин зүйлүүдийн хүрээг тодорхойлж байгаа болно.

**Тухайн орны үндэсний уламжлалт үнэлэмж, соёлыг хүндэтгэх** гэсэн үзүүлэлтийг үндэсний соёл, хүмүүний хөгжил, бүтээх чадавхийн үзүүлэлтээр хэмжиж болно. Тэгвэл манай бодлогын баримт бичгүүдэд үг хэллэг, тунхаглалын байдлаар бол хангалттай бий. Гэхдээ соёл иргэншил, хүн ардынхаа амьдралын гүн рүү нэвтэрч, гол зүйлээ олох, түүнийгээ хэрэгжүүлэх талаар туйлын хангалтгүй байдаг. Үүнийг олон улсын хэмжээнд гаргадаг мэдээлэл ч, манай эрдэмтэдийн судалгааны дүгнэлт ч тодорхой харуулж байна. Тухайлбал, Дэлхийн 2018 оны аз жаргалын тайланд 156 орноос 94 дүгээр байр[7] НҮБ-аас жил бүр гаргадаг Хүний хөгжлийн илтгэлд 2016 оны байдлаар 0.735 оноо буюу 92 дугаар байрт жагссан[8] мэдээ гарчээ. 2017 оны 11 дүгээр сарын 16-нд ЮНЕСКО-гоос тэмдэглэдэг Дэлхийн философийн өдрийг тохиолдуулан ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, ШУА-ийн Философийн хүрээлэнтэй хамтарч зохион байгуулсан "Тогтвортой хөгжил: Оюуны соёл" сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан зарим илтгэлүүдэд энэ тухай маш тодорхой дурьдсан байна[9].

---

[6] Хөгжлийн урт хугацааны бодлогын харьцуулсан шинжилгээ. Үндэсний хөгжлийн хүрээлэн. Уб., 2014. 11 дэх талд үзнэ үү.

[7] https://s3.amazonaws.com/happiness-report/2018/WHR_web.pdf. 2018.04.02

[8] http://hdr.undp.org/. 2018.04.02

[9] Тогтвортой хөгжил, оюуны соёл. ЭШБХ-ын эмхтгэл. УБ., 2017. 34 дэх тал

Монгол улсын тогтвортой хөгжлийн нийгэм, оюун санааны гол суурь болсон хүний хөгжил, үндэсний уламжлал, үнэлэмж, соёлын үзүүлэлтүүдийг улс орны цогц хөгжлийн бүрдэл хэсгийн хэмжээнд хүргэж өөд татахгүйгээр урт хугацааны хөгжлийн ямар ч зорилт хоосон тунхаглал төдий зүйл болж үлдэх нь ойлгомжтой. Хүнээ хөгжүүлэх, түүхэн уламжлал, үндэсний үнэт зүйлсээ өөд татаж бэхжүүлэх, үндэсний соёлын дархлаагаа хүн бүрийн оюуны сэтгэхүйд шингээж баталгаажуулах нь тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх гол хүчин зүйл болно.

**Технологийн хуримтлал, түүний хүрсэн төвшини**й хувьд бид дэлхий дахины хөгжлийн шинэ хандлагаас ихээхэн хоцорч яваа аж. Өнөөдөр хүн төрөлхтний технологийн хөгжил дэвшлийг бүхэлд нь Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалтай холбон үзэх боллоо. Тоон, физикийн, биологийн салбарын тэргүүлэх технологиудын хил хоорондын зааг арилж, хиймэл оюун ухаан, тоон технологийн эрин үеийг бий болгож улс төр, нийгэм ба эдийн засагт гүн нөлөөлөх явцыг Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал гэж нэрлэж байна.

2016 онд Швейцарийн Давос–Клостерсд болсон Дэлхийн эдийн засгийн форум "Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалыг төгс эзэмших" гэсэн нэртэйгээр уг асуудлыг тусгайлан хэлэлцэв. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын бий болгох боломжийг ашиглах, түүний үр ашгийг хүртэх, болзошгүй сөрөг нөлөөлөлд бага автах, саармагжуулах үүднээс улс орнууд өөрсдийн онцлогт тохирсон бодлого, хөтөлбөр гарган ажиллаж байна.

Манай орны тухайд төрийн бодлогын төвшинд зөвхөн эхлэлийн шинжтэй УИХ-д Цахим бодлогын түр хороо байгуулсан, Засгийн газар "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-доо дурьдсан төдий байна. Харин нөхцөл байдлыг Монгол Улсын Шинжлэх ухааны академи бусдаас түрүүнд онцлон анхаарч 2018 онд эрдэмтэн судлаачдын өргөн бүрэлдэхүүнийг хамруулж тодорхой судалгаа хийсний үндсэн дээр ээлжит Их чуулганыхаа өргөтгөсөн хуралдаанаар аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын үеийн Монгол Улсын хөгжлийн зангилаа асуудлуудыг нухацтай шүүн хэлэлцэж, төр засгийн байгууллагууддаа хандан маш ойрын үед цаг алдалгүй сайн авч хэрэгжүүлэх гол арга хэмжээг цогц хамарсан маш сайн Зөвлөмжийг хүргүүлжээ[10]. Одоо энэ зөвлөмжид заасан ажлуудыг төр засаг маань анхаарч ажиллах нь нэн чухал байна.

Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын үед гарах өөрчлөлтийг эхнээс нь зөв ойлгож, түүнийг ухаалгаар тосч угтах, нэгдэн хөгжиж чадах эсэх нь Монгол Улсын засаг төр хэр зэрэг зөв, оновчтой бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж чадахаас хамаарах нь тодорхой. Ийм учраас юуны өмнө дэлхийн улсуудын туршлагаар Аж үйлдвэрийн дөрөв дэх хувсгалын шинэ эрин үед Монгол улсаа хөгжүүлэх бодлогоо нэн даруй тодорхойлж хүний нөөцөө бэлтгэх, технологи

---

[10] Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал ба Монгол улсын хөгжлийн зангилаа асуудлууд. Монгол Улсын ШУА, УБ., 2018, 26-36 дахь тал

хөгжүүлэлтийг дэмжих, шинжлэх ухаан технологийн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтыг дорвитойхон өсгөхөд чиглэсэн шийдэмгий алхам хийх шаардлагатай байна.

**Байгалийн нөөц баялаг, түүний үр өгөөжтэй ашиглалт, боловсруулалт.** Энэ үзүүлэлтийн тухайд манай нийгэмд ноцтой зөрчилт нөхцөл байдал бий болж үргэлжилсээр байна. Манай улс бол байгалийн нөхөн сэргээгдэхгүй болон сэргээгдэх нөөц баялагийн хувьд дэлхийд дээгүүр ордог орон. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн геологийн шаталсан судалгаа, эрэл хайгуулын ажлын үр дүнд 80 гаруй төрлийн ашигт малтмалын 1100 гаруй орд, 10000 орчим илрэл, олон мянган эрдэсжсэн цэгийг тогтоож, 2017 оны байдлаар 57 сая тонн зэс, 37 тэрбум тонн нүүрс, 1.2 тэрбум тонн төмрийн хүдэр, 2500 тонн алт, 2 сая тонн цайр, 48 сая тонн хайлуур жонш, 190 тонн уран, 333 сая тонн газрын тосны баталгаат нөөцийг бүртгээд байгаа[11] тухай тооцоо гарсан байна.

Өнөөгийн байдлаар уул уурхайн салбар манай эдийн засагт шийдвэрлэх үүрэгтэй тэргүүлэх салбар болон хөгжиж, экспортын нийт бүтээгдэхүүний 86 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 71 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 20 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 64 хувь, улсын төсвийн орлогын 25 хувийг дангаараа бүрдүүлж байна[12]. Сүүлийн жилүүдэд бий болсон эл байдал нь улсын хөгжилд олон зөрчилт хандлагыг үүсгэж, эерэгээсээ илүү сөрөг нөлөөлөл үзүүлэх боллоо. Юуны өмнө эдийн засгийг өрөөсгөл бүтэцтэй, ганц салбараас хамааралтай, эмзэг, тогтворгүй болгож байна. Үүнийг төрийн түшээдээс эхлээд бүх нийтээрээ зөвшөөрдөг ч зохицуулах, сөрөг нөлөөллийг хязгаарлах талаар ямар ч ахиц гарахгүй байгаа нь харамсалтай.

70 гаруй сая малтай, мах болон малын ашиг шимээр хүн ардаа элбэг хангалуун амьдруулах хангалттай нөөцтэй, хүн амынхаа хүнсний хэрэгцээг бүрэн хангахуйц хэмжээнд га талбайд үр тариа, хүнсний ногоо тариалдаг, малын гаралтай, болон хүнсний бусад олон төрлийн экологийн цэвэр бүтээгдэхүүнийг экспортод гаргах өргөн боломжтой манай орны тухайд тогтвортой хөгжлийн энэ чиглэлд хамаарах аль ч зорилтыг түвэггүй ханган биелүүлэх бүрэн боломж бий. Харин экологийн тэнцвэрт байдал, байгалийн нөхөн сэргэгдэхгүй баялагийг хамгаалах тухайд онцгойлон анхаарах шаардлага байна. Энэ тухайд юуны өмнө дараах хэдэн асуудал чухал гэдгийг мэргэжлийн хүрээнийхэн онцолдог.

*Нэгд,* Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн усны нөөцийн нэгдсэн менежмент боловсруулах,

[11] Үндэсний аюулгүй байдал ба уул уурхай. /Үндэсний батлан хамгаалах их сургууль, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн/. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2018 он, 85 дахь тал
[12] Мөн тэнд., 86 дахь тал

*Хоёрт,* Цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлэх,

*Гуравт,* Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгалах, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулах үндсэн дээр Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хангах бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад голлон чиглэх шаардлагатай болж байна.

**Хөрөнгийн хуримтлал, санхүүгийн давуу тал**. Монгол улсын хөрөнгийн хуримтлал, төсөв санхүүгийн өнөөгийн байдал нь урт хугацааны тогтвортой хөгжлийн найдвартай суурь болж чадах эсэхэд эргэлзээ төрөхүйц дүр зурагтай болжээ. Дэлхийн өрсөлдөх чадварын 2017-2018 оны тайланд Монгол Улс 138 орноос 3.8 оноогоор 101 дүгээр байр[13], Дэлхийн хөгжлийн индексийн 2017 оны тайланд 149 улсаас 76 дугаарт жагссан байна.[14]

Үүний зэрэгцээ бас манай эдийн засгийг ойрын хугацаанд эрчимтэй өсөлттэй байх боломжтой талаар дотоод гадаадын судалгаа мэдээллийн байгууллагууд зарим нэг наштай таамаглал дэвшүүлж байна. "Экономист" сэтгүүлийн шинэ дугаар "Дэлхий 2019 онд" хэмээх сэдвээр нийтлэгджээ. Уг сэтгүүлд ирэх онд дэлхийд эдийн засгийн өсөлтөөр тэргүүлэх 10 орны тоонд Монгол Улсыг багтаажээ. Эдийн засгийн өсөлтөөр эхний 10 байрт орсон улсуудыг хэдэн хувийн өсөлттэй байгаагаар нь доорхи байдлаар жагсаасан байна.1. Сири 9.9%. 2. Бангладеш 7.7% 3. Энэтхэг 7.6% 4. Бутан 7.4% 5. Этофи 7.3% 6. Лаос 7.3% 7. Руанда 7.2% 8.Мянмар 7.2% 9. Кампуч 6.8% 10. Монгол 6.8%[15]. Хэрэв манай улсын эдийн засгийн өсөлтийн энэ хэмжээ харьцангуй урт хугацаанд үргэлжилж чадвал цөөн хүн амтай, авсаархан эдийн засагтай, хөгжлийн асар их боломжийг өөртөө агуулсан улсын хувьд хөгжлийн ирээдүйг өөдрөгөөр төсөөлөх бүрэн боломжтой билээ.

---

[13] http://www3.weforum.org/docs/GCR2017-2018/05FullReport/TheGlobalCompetitivenessReport2017%E2%80%932018.pdf. 2018.04.02

[14] https://openknowledge.worldbank.org/handle/10986/26447. 2018.04.02

[15] https://eaglenews.mn. Эдийн засгийн өсөлтөөр тэргүүлэх орны жагсаалтад оржээ. 2018.11.30




Улс орон хүн ардаа урт хугацаанд хэвийн зохистой хөгжүүлэх бодлого маш тодорхой философитой байх нь чухал. Энэ философи хэдэн суурь зарчимд үндэслэнэ. Ийм зарчмын эхнийх нь, Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, монголын ард түмний үндэсний язгуур эрх ашиг, монгол хүний эрх чөлөөтэй амгалан тайван амьдралыг хангах ***эрхэм зорилгын*** хүрээнээс гажихгүй байх явдал. Дараагийн гол зарчим бол ***"шинжлэх ухааны үндэстэй мэдлэгт суурилсан хөгжлийн зарчим"***. Үүний тулд хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийн шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтыг ашиглах нь чухал. Гуравдахь чухал зарчим гэвэл улсаа хөгжүүлэх бодлого ***"залгамж шинжтэй, найрсан зохицсон, нэгдмэл, цогц байх"*** зарчим мөн.

Монголын **хөгжлийн философи** монгол түмний түүхийн зуун зууныг өртөөлж уламжлагдсан оюун сэтгэлгээний сан хөмрөгөөс үүсвэрлэж бүтэх ёстой. Хөгжлийн философид соёл иргэншлийн онцлог, үндэсний сэтгэлгээний язгуур үндэс, хүн ардынхаа сэтгэл оюун, ёс суртахууны суурь үнэлэмжүүдийг зөв оношилж, бодлогодоо онож тусгахын тулд дараах философи үзэл, номлолыг нарийн судалж түүнд үндэслэх нь чухал. Үүнд:

- *Хос эхлэл, шүтэн барилдаж хөгжихүйн тухай үзэл, хоёр ёсны тухай сургаал*
- *Орон зай, цаг хугацаа, хэмжээ хязгаар, уялдаа зохирлыг тэгш уялдуулах ёс буюу "Цаг"-ийн номлол*
- *Монголын буддизм, төв ёсны үзэл номлол*
- *Төрөө дээдлэх ёс, андгай тангаргаар баталгаажсан эв нэгдлийн үзэл*
- *Үндэсний ардчилсан үзэл ба ардчилсан уламжлал*

Улс орноо урт хугацаанд хөгжүүлэх төрийн бодлогод үндэстний оюуны шавхагдашгүй гол нөөц, урт хугацааны хөгжлийн явцад шийдвэрлэх нөлөө үзүүлэх

гол субьектив хүчин зүйл болсон үндэсний хэмжээний **"итгэлцэл", "ёс суртахууны засаглал"** гэсэн үндсэн хоёр асуудлыг онцолж байна. Энэ хоёр сэдэв бол Монгол улсын төрийн бодлогын хэмжээнд яригддаг олон асуудлын дотор хамгийн ерөнхий бөгөөд бүрхэг байгаа тэр хэсэг мөн.

***Итгэлцэл бол нийгмийг нягтруулагч, эв нэгдлийг хангагч гол нөөц мөн.*** Аливаа улс орны хөгжлийг хэмжихдээ "... нийгмийн хувьд иргэдийн нэгдэл нягтрал биелэн, соёлын талаар итгэлцэл, дэг журам төлөвшиж, иргэний ухамсар тогтсон байхыг..." гол үндэс болгодог жишиг дэлхийн олон оронд тогтоод байна. Энэ нь "...хувь хүмүүсийн хоорондын хамтын ажиллагаа нь хувь хүн тус бүрийн ур чадварын хязгаарыг давсан синержи /synergy/ үр дүн гаргадаг. .... "итгэлцэл, хамтын ажиллагаа нь нийгмийн синержи үр өгөөжийг дээд зэргээр нэмэгдүүлдэг"[16] гэсэн онолын гаргалгаатай юм.

Өнөөдөр манай оронд бүрэлдээд удаж байгаа нийгэм-улс төрийн сэтгэл зүйд ноёлж буй бараг бүх сөрөг үзэгдлийг үндэсний хэмжээнд **үл итгэлцэл** хавтгайрсантай холбож үзэхээс өөр аргагүй. Улс төржсөн талцал, үнэн худал нь үл нотлогдох хардалт, улс төрийн өшөө авалт, атаа хорсол, авилга гээд бүх сөрөг үзэгдэл төрж үржих сэтгэл зүйн хөрс нь үл итгэх явдал мөн. Жишээлбэл, "авилга бол улс төрийн үл итгэлцлийн үр дагавар мөн", "Авилга ба үл итгэлцэл нь салшгүй барьцалдсан тойрогт оршдог"[17] гэх мэтийн дүгнэлтийг олон улсын нэр хүндтэй судалгааны байгууллагууд хийсээр байна. Өөрөөр хэлбэл, авилга нь улс төрд үл итгэх, хуульд үл итгэх, улс төрийн бодлогод үл итгэх, төрийн байгууллага, албан хаагчдад үл итгэх явдлаас эхэлдэг, улмаар нийгмийг ил далд дайсагнал, талцалд гарцаагүй хүргэдэг байна.

Итгэлцлийг бий болгож бататгах гол үндэс нь иргэдийн мэдлэг, хүмүүжил, ухамсрыг тэдний эдийн засгийн болон эрх зүйн боловсрол, ёс суртахуунтай холбож цэгцтэй, дэс дараатай сайжруулах төрийн онцгой бодлого хэрэгжүүлэх явдал мөн. Эндээс ёс суртахууны асуудал зүй ёсоор хөндөгдөнө. *Ёс суртахуун* бол ямар нэг байдлаар хэм хэмжээ тогтоож зохицуулдаг нийгэм, соёлын үзэгдэл. Энэ утгаараа нийгмийн бүх эд эс, салаа мөчирт хүрч үйлчлэх чадвартай байдаг. Тэгэхлээр төрийн бодлого ч, хууль тогтоомж ч аль аль нь ёс суртахуунаас төрж, ёс суртахуунаар дамжин хэрэгждэг байх учиртай.

Өнөөдөр манай нийгэмд "...хуулийн цоорхойг ашигла, хуулийг сахиж мөрдвөл хохирно..." гэх ойлголт маш их газар авсан гэдгийг олон нийтийн санаа бодлын судалгаа нотолдог. Энэ бол зөвхөн манай орны үзэгдэл ч биш. 2000 оны үед Солонгосын Эрүүгийн хэргийн Бодлогын судалгааны хүрээлэнгээс явуулсан санал асуулгаар Өмнөд Солонгост ч ...нийгмийн тэн хагас нь хуулийг үл тоох хандлагатай

---

[16] Юү Жун Гынь. Хөгжингүй орон болохын нууц. \Нийгмийн баялгийн хуримтлалын аргууд\" 2007, Уб., 2017. 25 дах тал
[17] Мөн тэнд. 184 дэх тал \Ulsaner, 2003, p 172\

байгаа...” дүн гарч байжээ.[18] Энэ бол юуны өмнө хууль ба ёс суртахуун хоёр уялдаж холбогдоогүйн бодит баримт мөн.

Ер нь хууль ба ёс суртахууны холбоо хамаарлыг хоёр талтай эргэх холбоотой гэж үзэж болно. Ёс суртахууны хэм хэмжээнээс хууль төрж болно. Хууль тогтвортой, үр нөлөөтэй үйлчлээд ёс суртахууны хэм хэмжээ болон тогтож болно. Ийм харилцан хамаарал эргэлэг шинжтэй ч байж болох магадлалтай.

Манай Үндсэн хуульд байгаа, “төрт ёс” гэдэг ойлголт бол юуны өмнө “төрийн хэргийг ёс суртахуунаар” засах, явуулах тухай үзэл санаа. Эндээс хууль цааз ба ёс суртахууны харьцаа төрт ёсонд ямар байх учиртай вэ? гэдэг асуудал гарна. Мэдээжээр хуулийг төрийн зүгээс албадлагын шинжтэй механизмуудаар хэрэгжүүлнэ. Ёс суртахуун бол ард түмний оюун сэтгэхүй, сэтгэл санаа, зан үйлийн хэм хэмжээ, хүмүүжил боловсрол гээд албадлагын биш хүн ёсны арга механизмаар өөрөө хэрэгжинэ.

[18] Мөн тэнд. 175 дахь тал

# ГУРАВ. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТОЙМ

## 3.1. КОНТЕНТ АНАЛИЗ

### МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ХИЙСЭН КОНТЕНТ АНАЛИЗ*

Бидний өгүүлэн буй эл сэдвийн хүрээнд тодотгон үзэж буй тогтвортой хөгжлийн асуудлаарх түүхийн хуудсыг эргүүлэн үзэхүл, сонирхолтой атлаа ээдрээтэй дүр зураг ажиглагдана. Тухайлбал, Монгол Улсын XXI зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг 1994-1998 онд боловсруулан Монгол Улсын Засгийн газраас 1998 оны 5 дугаар сард баталснаас хойш хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 2002, 2006, 2010 онд тус тус гүйцэтгэж, хэрэгжилтийн тайланг гаргаж ирсэн. Улмаар 2011 онд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийг[19] боловсруулан батлах нэг чухал суурь үндэслэл болсон гэж үзэж болно.

Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр бол ирэх зуунд эрх чөлөөтэй, чинээлэг амьдрах монгол үндэстний чин эрмэлзэл төдийгүй сайхан амьдралын төлөө Засгийн газар ард иргэдтэй хамтарч ажиллах зорилтыг тодорхойлсон явдал юм. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын хөгжлийн уламжлалыг хадгалсан эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр үлэмж амжилт олсоны илрэл. Гэвч, манай нийгмийн амьдрал, монголчууд бидний аж төрөх ёс, төрийн удирдлагын чадал тэнхээ нь тэдгээрт оролцогч иргэн нэг бүрийн ухамсарлал, ойлголтоос ихээхэн хамаарна. Үүний дотор монгол хүний чин хүслэнгийн асуудал, тодруулбал, монгол хүнд юу хэрэгтэйн тухай ойлголтын асуудал чухал учир холбогдолтой. Тухайлбал, сэтгэл амгалан амьдрал, өндөр нэр төр, монгол хүнд дээдлэгдсэн монгол төр хэрэгтэй бөгөөд иргэн хүний чин хүслэн гутвал, эсхүл түүнээ ойлгохгүй бол улс орон уруудан доройтдог нь жам. Тиймээс Монголын хөгжлийн философи улс орныхоо амьдралд шинээр илрэн гарч буй үзэгдэл, зөрчлийг соргогоор анхааран судалж, төр засагтаа, ард олондоо, үзэгдэл зөрчлийн субьектүүдэд анхааруулж байх ёстой сэтгэлгээний барьц, логик сайтай үндэслэл бүхий хүмүүний амьдрал ёс суртахуун-боловсрол, эдийн засаг-аж ахуй, улс төр-удирдахуйн бодлого гэсэн өвөр хоорондоо авцалдаа бүхий иж бүрэн бүрдэл болох[20] учиртай бөлгөө.

---

* *Энэхүү контент анализыг төслийн гүйцэтгэгч, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн ЭШДэА, доктор (Ph.D) О.Хатанболд хийсэн.*

[19] Монгол Улсын Засгийн газар. НҮБХХ. Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго. Rio+20 United Nations Conference on Sustainable Development. УБ., 2012. 5 дахь тал.

[20] Даш-Ёндон Б. Монгол хүний чин хүслэнгийн асуудалд (монгол хүнд юу хэрэгтэй вэ). ШУА. Философийн хүрээлэн. Хүмүүний ертөнц ба тогтвортой хөгжил. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. Ред. Пүрэвсүрэн Б., Энхбаяр Ж. УБ., 2018, 55, 57 дахь талууд. тал.

Нөгөөтэйгүүр, 2002 оны Хүний хөгжлийн илтгэлд *«... үр нөлөөтэй засаглал бол хүний хөгжлийн гол сүнс нь бөгөөд үүнд хүрэх гол арга бол ... хамгийн өргөн утгаараа ардчилсан бодлого дээр бат үндэслэгдсэн байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, аливаа тодорхой орон буюу бүлэг орны баримталж байгаа ардчилал бус, засгийн газар, олон үндэстний корпораци, бусад хүчний зүгээс ард түмний амьдралд дураар авирлах, хариуцлагагүй үйлдэл хийхээс хамгаалж, тэдэнд оролцооны аргаар засгийн эрхийг барих боломж олгох бүлэг зарчим болон үндсэн үнэт зүйлс дээр суурилах ёстой»*[21] хэмээн тэмдэглэжээ. Үүнээс улбаалан, «Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр» (1998)-ийн залгамж болгон «Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого» (2008-2016)-ыг батлан хэрэгжүүлсэн юм. Үндэсний хөгжлийн цогц бодлогыг тодорхойлохдоо Монгол Улсын Үндсэн хууль (1992), Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал (1996), Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (1998), Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөр (2005), «Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал», «Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал», «Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг», «Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын илтгэл», «Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал», «Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт» (2005), «Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр» зэрэг Монгол Улсын төр, засгийн бодлогын 304 баримт бичигт томъёолсон үзэл баримтлал, үндсэн зорилт, агуулгыг багтааж, тэдгээрийн нэгдмэл байдлыг хангах зарчмыг баримталсан байна.

Бид энэхүү контент-анализыг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030, Монгол Улс дахь урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд хийсэн агуулгын задлан шинжилгээ хийснийг дараах байдлаар танилцуулж байна.

[21] НҮБХХ. Хүний хөгжлийн илтгэл. Нэгдмэл биш дэлхий ертөнцөд ардчиллыг гүнзгийрүүлэх нь. НҮБХХ-ийн хэвлэл. 2000//Ли Рой. Ардчиллын олон улсын хэм хэмжээний хүрээ. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл. УБ., 2003, 241 дэх тал.

## МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ХИЙСЭН КОНТЕНТ-АНАЛИЗ

Аливаа улс орны тогтвортой хөгжлийн гол нөхцөл, шийдвэрлэх хүчин зүйлийн нэг гол зорилт бол үр нөлөө бүхий тогтвортой засаглал билээ. Тогтвортой хөгжил, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тогтвортой, ардчилсан засаглалыг бэхжүүлэх нь нэн чухал. Гэвч төрийн албыг боловсролтой, мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчнээр бүрдүүлж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, төрийн бүх шатны байгууллагуудын удирдлагын манлайлал, ил тод байдал, хариуцлагыг өндөрсгөх, улс төрийн тогтвортой байдлыг хангах, хууль дээдлэх зарчмыг бүх нийтээрээ дагаж мөрдөх, шийдвэр гаргах үйл явцад талуудын оролцоо ялангуяа эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, зохицуулалтын чанарыг сайжруулж, авлигыг арилгах сорилтууд тулгарч байна.

Монгол Улс Үндсэн хуулиараа парламентын засаглалтай орон болovч хагас Ерөнхийлөгчийн засаглалын олон шинжийг хадгалсан улс төрийн шилжилт хийсэн. Эл огцом шилжилтээс хамааран эдийн засагт уналт бий болж, улмаар нийгмийн ялгарал түргэн явагдаж, ажилгүйдэл, ядуурал, авлига зэрэг сөрөг үзэгдлүүд богино хугацаанд бий болж өргөжсөн. Нөгөө талаар, ардчилал, эрх чөлөөний талаарх хэт ерөнхий, гэнэн төсөөлөл, улс төрийн соёлын доогуур төвшингөөс хамаарч эрх зүйт төр, ардчиллын хөгжилд бэрхшээл, хүндрэл гарч, улмаар гажуудал, завхрал алхам алхамаар газар авах боллоо. Энэ нь өнөөгийн Монгол Улсад иргэний нийгмийн хяналтын үүргийг бэхжүүлж, урамшуулах цаг үеийн шаардлага бий болсныг харуулахын зэрэгцээ ИНБ-уудын ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх, чингэхдээ тэдний үйл ажиллагаанд хариуцлага, ил тод байдлын зарчмыг нэвтрүүлэх явдлыг дэмжих хэрэгтэй. Чингэхдээ засаг төрөөс иргэний нийгэм санаа бодлоо илэрхийлэх, зохион байгуулагдах, хөгжлийн үйл явц зэргийг хянахад оролцох, улсын салбарын үйл ажиллагааг хянах үүргийг биелүүлэх, эвсэл, сүлжээ байгуулах, зөвлөх, нөөц баялагийн ашиглалтын тухай шинжээчийн шаардлага хүргүүлэх, улс төрийн хүсэл зоригийг дэмжих, сурталчлах, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, нийгмийн бүлэг, ялангуяа эмзэг, гадуурхагдсан хэсгийг дайчлах зэрэгт зориулан эрх зүй, улс төр, институцийн орон зайг бий болгон санаачлан ажиллах ёстой. Ийнхүү хариуцлагатай байдлын үндэс бол иргэдийн итгэл ба нийгмийн тогтвортой үйл ажиллагаа, түүний үр нөлөө юм.

Монгол Улс даян дэлхийн тогтвортой хөгжлийн үйл явцад нэгдэн ороод хорь гаруй жил болж байна. Энэ хугацаанд олон улсын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу «XXI зууны тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөр»-ийг баталж, 2002 оны Иоханнесбургийн «Тогтвортой хөгжил»-ийн тунхаглал зэрэг үйл ажиллагааны

хөтөлбөрт нэгдсэнээрээ тогтвортой хөгжлийн зарчмуудыг эх орондоо хэрэгжүүлэх үндэсний бодлого, хөтөлбөртэй болсон. Чухамдаа, дэлхий дахины тогтвортой хөгжлийн үзэл баримтлал эрчимтэй хэлэлцэгдэж, улс орнуудын тогтвортой хөгжил нь засаглалын үр нөлөө, тогтвортой байдлаас хамаарна гэдэгт олон улсын хэмжээнд онцлон анхаарах зүйл болсоор ирсэн. Энэ утгаараа, «Нийгмийн тогтвортой хөгжил» хэмээх ойлголтыг түгээмэл хэрэглэхгүй байна. Харин «хүний хөгжил», «хүмүүн капитал» гэх мэт ойлголтыг өргөн хэрэглэдэг. Нийгмийн болон эдийн засгийн тогтвортой хөгжлийн гол цөм нь хүн, байгалийн зохистой харилцаанд үндэслэсэн нийгмийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэвшүүлж, түүнийг хүний хөгжил тэр дундаа хүмүүсийн бие биендээ болон институцид итгэх итгэлийг нэмэгдүүлэхтэй холбон тайлбарладаг.

Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтыг ханган биелүүлэхийн тулд Монгол Улсын Их Хурлаас 2016 онд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030[22] нь тогтвортой хөгжлийн олон улсын үзэл баримтлал[23] түүний тулгуур багана буюу тулгын гурван чулууг *эдийн засаг, хүмүүний хүрээлэн буй орчин, нийгмийн* хүрээг гол үндэслэл болгосон. Дээр дурдсан судалгаа шинжилгээний үр дүнд эдгээр үзэл баримтлалд буй гурав гурвуараа багцлагдсан үзүүлэлтүүдийн хоорондын уялдаа холбоо, харилцаа хамаарлыг нарийн тооцож, түүний үндсэн дээр хүрэх түвшин, мөн чанарыг нарийвчлан судлаагүйгээс танин мэдэхүйн төвшинд ч, бодлогын зарчим, зорилтуудын хүрээнд ч нарийн үр дүнг тооцон шинжлээгүй, тооцоолоогүй зүйл их байгааг дүгнэсэн нь бий. Үүнээс улбаалан энэ зургаан үзүүлэлтийг нэг үндэстэн улсын хэмжээнд өөр хооронд нь уялдуулан цогц байдлаар авч үзвэл, нийгмийн тогтвортой хөгжлийн бодит дүр төрхийг илүү оновчтой тодорхойлох боломжтой мэт санагдана. Мөнхүү зарчмуудын гол үзэл санаа нь хүн байгалийн шүтэлцээ, нийгмийн тогтвортой, зохистой хөгжлийн асуудал гэдгийг бид мартаж болохгүй. Энэ нь угтаа хүмүүнлэг ардчилсан иргэний нийгмийг монголын онцлогт тохируулан цогцлоох тогтвортой хөгжлийн онолын үндэслэлийг боловсруулахын тулд ардчилсан нийгэмд эрх чөлөөт хүний хүлээх үүргийн онолыг хүй хамтлаг (коммунити)-ын шударга ёсны онол ба Хабермасын бүтээсэн хамтран үйлдэхүйн философитой шүтэн барилдуулж, эргэцүүллийн өндөр түвшинд холбогч гүүр болгон ашиглах хамгийн оновчтой хувилбар[24] ажээ. Нөгөө талаар шударга ёсны нөхцөл байдал гэдэг нь бодит байдалд хадгалагдан үлдэх ёсгүй анхдагч төлөв байдлын таамаглал аж. Энэ нь анхны нөхцөл байдлын үнэн зөв эсэх нь эсэргүүцлийн тэнцвэрийн нөхцөлд гаргаж авсан шударга ёсны зарчмууд нь бидний үндсэн оюун дүгнэлтэнд хэр зэрэг тохирч байгаа эсэхээс хамаарах ажээ

[22] УИХТГ. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030: үндэслэл, хамрах хүрээ. УБ., 2016 74 дэх тал.
[23] https://www.undp.org/content/undp/en/home/sustainable-development-goals.html
[24] Батын Ган-Өлзий Ч. Тогтвортой хөгжил: нийгмийн шударга ёсны философи (компаратив философийн судалгаа). Ред. Хатанболд О., Философийн хүрээлэн. ШУА. УБ., 2019, 77 дахь тал

2018 оны Дэлхийн хүний хөгжлийн индекс, шалгуур үзүүлэлтээр Монгол Улсын Хүний хөгжлийн индекс (ХХИ) 0.741 байгаа нь 2012 оноос хойш тасралтгүй өссөнийг харуулж байна. Нөгөө талаар, социалист дэглэмээс ардчилсан дэглэмд нэгэн гараанаас хамт шилжсэн бусад улс орнуудын хувьд Монгол Улсын хүний хөгжлийн индекс харьцангуй доогуур үнэлгээтэй байна. ХХИ-ийн өсөлтөөр бол Монгол Улсад нийгмийн тогтвортой байдлыг хангах боломж аажмаар бүрдэж байгаа болон 2015 оноос хойш өндөр төвшинтэй орнуудтай харьцуулахад нэг хүнд ногдох ҮНО (GNI - 11 2017 оны байдлаар)-ийн хэмжээ харьцангуй бага байна.

Доорх хүснэгтээс харвал, Засаглалын тогтвортой байдал нь энэхүү тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тууштай хэрэгжүүлэх, түүний бодит үндэслэхүйц хийгээд хэмжигдэж хэрэгжихүйц байдалд нэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

*Хүснэгт 2. Хүний хөгжлийн индексийн хандлага 1990-2017*[25]

*(Human development index trends 1990-2017)*

| ХХИ эрэмбэ *(оноор)* | Хүний хөгжлийн индекс (ХХИ) | | | | | | | | Эрэмбэ. өөрчлөлт | ХХИ өсөлтийн жилийн дундаж | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1990 | 2000 | 2010 | 2012 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2012 2017 | 1990 2000 | 2000 2010 | 2010 2017 | 1990 2017 |
| Хүний хөгжил нэн өндөр түвшинтэй орнуудад *(багтсан 58 орноос 5 орныг жишээ болгов)* | | | | | | | | | | | | | |
| 1 Норвеги | 0.850 | 0.917 | 0.942 | 0.942 | 0.946 | 0.948 | 0.951 | 0.953 | 0 | 0.76 | 0.27 | 0.17 | 0.42 |
| 7 Хонг конг БНХАУ | 0.781 | 0.828 | 0.901 | 0.911 | 0.923 | 0.927 | 0.930 | 0.933 | 3 | 0.58 | 0.87 | 0.49 | 0.66 |
| 45 Унгар | 0.704 | 0.769 | 0.823 | 0.830 | 0.833 | 0.834 | 0.835 | 0.838 | -4 | 0.89 | 0.68 | 0.26 | 0.65 |
| 58 Казакстан | 0.690 | 0.685 | 0.765 | 0.781 | 0.793 | 0.797 | 0.797 | 0.800 | 0 | -0.07 | 1.12 | 0.64 | 0.55 |
| Хүний хөгжил өндөр түвшинтэй орнууд *(багтсан 52 орноос 6 орныг жишээ болгов)* | | | | | | | | | | | | | |
| 70 Гүрж | - | 0.673 | 0.735 | 0.750 | 0.765 | 0.771 | 0.776 | 0.780 | 7 | - | 0.88 | 0.85 | - |
| 80 Азербайжан | - | 0.640 | 0.740 | 0.745 | 0.758 | 0.758 | 0.757 | 0.757 | -1 | - | 1.47 | 0.32 | - |
| 88 Украйн | 0.705 | 0.671 | 0.733 | 0.743 | 0.748 | 0.743 | 0.746 | 0.751 | -8 | -0.50 | 0.88 | 0.34 | 0.73 |
| 92 Монгол Улс | **0.579** | **0.589** | **0.697** | **0.720** | **0.734** | **0.737** | **0.743** | **0.741** | **4** | **0.17** | **1.70** | **0.87** | **0.92** |
| 112 Молдав | 0.651 | 0.597 | 0.670 | 0.684 | 0.696 | 0.693 | 0.697 | 0.700 | -3 | -0.86 | 1.15 | 0.62 | 0.27 |

[25] United Nations Development Programme. Human Development Indices and Indicators: 2018 Statistical Update. New York, NY, USA. pp. 22-26. http://hdr.undp.org/sites/default/files/2018_human_development_statistical_update.pdf

Уг үнэлгээтэй холбогдуулан 2019 оны Дэлхийн хүний хөгжлийн илтгэлд хүмүүсийн сайн сайхан амьдралд нэн чухал ач холбогдолтой зүйл бол тэгш бус байдлын хэмжүүрийг зөв ойлгох явдал хэмээгээд: «*Тэгш бус байдлыг чухалчлах болсон шалтгаан ямар асуудалд энэ төрлийн бэрхшээл гарч буйг тодорхойлох нь чухал. Тэгш бус байдал ямар төвшинд хэрхэн харагдаж байгааг илүү нарийвчлан тодорхойлохдоо дэлхий даяар өрнөж буй эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны өөрчлөлтийг тэгш бус байдал хэрхэн өөрчлөгдөж буй талаар илүү гүнзгий ойлголттой болохын тулд хэмжилтийг бодитоор гүйцэтгэснээр үр дүнтэй шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг боловсруулах боломж бүрдэнэ*»[26] хэмээн онцлон тэмдэглэсэн.

Монгол Улсын төр, засгийн бодлогын 304 баримт бичигт томъёолсон үзэл баримтлал, үндсэн зорилт, агуулгыг багтааж, тэдгээрийн нэгдмэл байдлыг хангах зарчмыг баримталсан энэ үндэсний тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын гол үндэслэл юм. Гэвч эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилт, уялдаа холбоог хангах, дараа дараагийн шатны баримт бичгийн уламжлал, нэн ялангуяа мэргэшиж туршлага хуримтлуулсан хүний нөөцийн залгамж холбоог хангах талаар хангалтгүй ажилласаар иржээ. Монголын төр засгийн байгууллагуудын хөгжилд үр дүнтэй нөлөө үзүүлж буйд өгсөн шинжээчдийн үнэлгээгээр монголын ардчилал улс орны хөгжилд болон төр засгийн байгууллагуудад хэрхэн нөлөөлж буй байдлын талаар үнэлсэн байдлаас харахад ардчилал эдийн засаг, улс төр, төрийн алба, улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд дунджаар буюу аль алинаар нь нөлөөлсөн бол, гадаад харилцаа, хүний хөгжилд харьцангуй эерэгээр нөлөөлсөн гэж үзсэн байна.

*Хүснэгт 3. Монголын төр засгийн байгууллагуудын хөгжилд үр дүнтэй нөлөө үзүүлж буйд өгсөн шинжээчдийн үнэлгээний дүн*

| Он | Эерэгээр нөлөөлсөн | Эерэг нь илүү | Аль алинаар нь нөлөөлсөн | Сөрөг нь илүү | Сөргөөр нөлөөлсөн |
|---|---|---|---|---|---|
| **1. Эдийн засгийн хөгжилд** | 12.5% | 18.8% | 46.9% | 15.6% | 9.4% |
| **2. Улс төрийн хөгжилд** | 9.4% | 18.8% | 37.5% | 28.1% | 6.3% |
| **3. Төрийн албаны төлөвшилд** | 3.1% | 6.3% | 37.5% | 31.3% | 21.9% |
| **4. Хүний хөгжилд** | 9.4% | 50.0% | 28.1% | 0.0% | 9.4% |
| **5. Улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд** | 21.9% | 25.0% | 34.4% | 9.4% | 9.4% |
| **6. Гадаад харилцаанд** | 34.4% | 40.6% | 18.8% | 3.1% | 3.1% |

*Төр засгийн дараах байгууллагуудад хэрхэн хөгжсөн талаарх үнэлгээ*

| Байгууллагуудын нэрс | маш сайн | сайн | дунд | тааруу | маш муу | мэдэхгүй |
|---|---|---|---|---|---|---|

[26] Дэлгэрэнгүйг https://www.undp.org/content/undp/en/home/news-centre/news/2019/2019_HDR_inequality.html -ээс үзнэ үү.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **1. Ерөнхийлөгчийн институтэд** | 0.0% | 18.8% | 37.5% | 21.9% | 9.4% | 12.5% |
| **2. Улсын Их Хуралд** | 6.3% | 15.6% | 31.3% | 28.1% | 18.8% | 0.0% |
| **3. Засгийн газарт** | 0.0% | 18.8% | 40.6% | 21.9% | 18.8% | 0.0% |
| **4. Орон нутгийн удирдлагын байгууллага, ИТ-ийн хуралд** | 0.0% | 15.6% | 37.5% | 31.3% | 12.5% | 3.1% |
| **5. Засаг дарга нарын үйл ажиллагаанд** | 0.0% | 6.3% | 31.3% | 43.8% | 15.6% | 3,1% |
| **6. Засаг төрийн байгууллагуудын өөр хоорондын харилцаанд** | 0.0% | 3.1% | 31.3% | 40.6% | 21.9% | 3.1% |

*Эх сурвалж: «Монголын ардчиллын үнэлгээ» Шинжээчдийн үнэлгээний дүнгээс. 2016 оны 3-4 сар.*

Нөгөө талаар тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын үүрэг, хариуцлага нэн өндөр ч төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгаа, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагууд болон иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа чухал бөгөөд талуудын оролцоотой тогтвортой хөгжлийн талаарх ойлголт, мэдлэгийг үе шаттай хүргэх сургалт, танин мэдэхүйн үйл ажиллагааг зохион байгуулж, ур чадварыг сайжруулах хэрэгтэй.[27] Төлөөллийн ардчиллын гурван гол институцид итгэх олон нийтийн итгэл төдийлэн тогтвортой биш байна. Гэхдээ сонгож авсан 4 жилийн аль ч үед нь Ерөнхийлөгчийн институтэд итгэх олон нийтийн итгэл УИХ, Засгийн газраас илүү байдал хадгалагдаж байна. Харин төрийн албаны төлөвшилд сонгуулийн жилийн дараанаас төрийн албан мэргэшсэн албан хаагчдыг улс төрийн намын харъяаллаар ажлаас халах, чөлөөлөх явдал сүүлийн жилүүдэд огцом ихсэж байгаатай холбогдуулан шинжээчид түүний төлөвшил хөгжилд ардчилал нь илүүтэй сөрөг нөлөө үзүүлж буйг онцолсон байна. Төр засгийн байгууллагуудын хөгжил түүний тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаанд ардчилал нь эерэгээсээ сөрөг үнэлгээ илүү давамгайлсан байдал уг үнэлгээнээс харагдаж байна.

Дэлхийн эдийн засгийн форумын «Ирээдүйн ажил мэргэжлийн тайлан-2018»-ийн «Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын өнөө ба ирээдүй» хэсэгт дурдсанаар[28] аж үйлдвэр болон салбар хоорондын харилцан адилгүй байдал, чиг үүргийн хуваарилалтын эргэн тойронд болж буй аливаа нөхцөл байдал хийгээд олон янзын хөрөнгө оруулалтад технологийн шинэчлэлийг нэвтрүүлсэнээр ажиллах хүчний болон түүнд дасан зохицох чадварт шууд нөлөөлөхийг онцолжээ. Түүнчлэн, эл нөхцөл байдлаас улбаалан, аж үйлдвэрийн бүхий л төрлийн салбарт дадал туршлага хуримтлагдаж улмаар түүнийг бүрдүүлэх шинэ бүрэлдэхүүн үүсэн буй болохын хамтаар тэдгээрийн чиг үүргийн бүтэц, орчил зэргээс үүдэлтэй эрэлт хэрэгцээ буурах, цаашлаад нөлөөлж буй үүргийн шинж чанарт өөрчлөлт орох болно хэмээсэн нь бий. Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал дэлхий даяар дэлгэрч буй энэ цаг дор ажил, мэргэжлийн ирээдүй нь дэлхийн улс орон бүрт, бүс нутаг хооронд нийтлэг болон ялгаатай шинж байдлаар хөгжих чиг хандлага бий болж, улмаар орон бүр янз бүрээр төлөвлөж байна. Бидэнд буй сүүлийн үеийн баримтаас харахул, улс орон бүрт давамгайлж байгаа аж үйлдвэрийн салбаруудад тухайлбал,

[27] УИХТГ. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030: үндэслэл, хамрах хүрээ. УБ., 2016, 54, 74 дэх тал.
[28] World Economic Forum. Insight Report. The Future of Jobs Report 2018. Center for the New Economy and Society. Cologny/Geneva. Switzerland. 2018. pp. 15-23. ISBN 978-1-944835-18-7

ажил, мэргэжлийн ирээдүйн талаарх хэсэгт дурдсанчлан үндэсний хэмжээний нэгдмэл байр суурь бүхий үр дүнгийн талаар тусгайлан тэмдэглэсэн байна.

Францын ерөнхийлөгч Эммануэль Макрон Элисейн ордны оффист *«The Economist»* сэтгүүлд өгсөн ярилцлагадаа апокалиптикийн талаар Европ *«тунадасын ирмэг дээр байна»* хэмээн ярилцлагадаа онцолжээ. Тэрбээр ярилцлагадаа НАТО, транс-атлантикийн холбоотнуудын "толгойн өвчин (brain-death)" болж буй нэг асуудал Европ өөрийн гэсэн цэргийн хүчийг хөгжүүлэх цаг үеийн шаардлага бий болсоныг дурдсан. Өөрөөр хэлбэл, Европын Холбоо нь дан ганц зах зээлийн үйл ажиллагаа явуулахаас гадна мэдээллийн технологийн өндөр бодлого, их өгөгдөл, цаг уурын өөрчлөлт болон улс төрийн блок бүхий бодлогыг авч хэрэгжүүлж байх ёстой. Түүнчлэн улс төрийг бодитоор олж харах ёстой, тухайлбал ОХУ-тай харилцаагаа сэргээх хэрэгтэй. Протекционизм ба авторитаризм өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа өнөө үед Европ нойрноосоо сэрж, өөрсдийг нь хүлээж буй илүү хатуу, уучлал багатай ертөнцөд өөрсдийгөө бэлтгэх хэрэгтэй гэв. Түүнчлэн, Ноён Макрон европчуудаас энэхүү тулгамдаж буй өөрчлөлтийн цар хүрээг даван туулахад хэцүү ч гэлээ үүнийг шийдвэрлэх шаардлагатай гэдэгт итгэл дүүрэн байгаа гэдэгтээ аль болох хурдан хариулах нь зүй хэмээн онцлон тэмдэглэжээ.[29]

Тэгвэл, бид аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалд бэлэн үү гэсэн асуулттай нүүр тулах болно. Үүнд хариулахын тулд бид юун түрүүнд өнөөдрийг хүртэл туулж ирсэн хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх, чингэхэд гадаадын хөнгөлттэй зээл, тусламжийг үр дүнтэй, ард олондоо өгөөжтэй зарцуулж[30] ирсэн эсэхэд шинжилгээ хийж, дүгнэн хэлэлцэх нь нэн чухал.

Дээрх шинжилгээг эхлэхээс өмнө, өнгөрсөн хугацааны түүхийн хуудсыг эргэн харах нь зүйтэй болов уу. Монгол Улс 1980-аад оны төгсгөлд ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалтын үйл явц, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг эрчимжүүлэх, мухардлаас гаргах гэсэн оролдлогод аль хэдийнээ татагдан орсон билээ. Энэ үед манай оронд улс төрийн уур амьсгал зөөлрөх тийшээ хандаж, эдийн засагт шинэчлэл хийх гэсэн хандлагууд гарч эхэлсэн юм. Тухайлбал, 1988 оны 12 дугаар сард хуралдсан МАХН-ын Төв хорооны 5 дугаар бүгд хурлын шийдвэрт «Эдийн засаг, улс төрийн систем, нийгэм, оюун санааны хүрээг бүхэлд нь хамарсан өөрчлөн байгуулалт хийх нь нам, ард түмний хойшлуулашгүй зорилт болж байна» гэж тэмдэглэсэн байв. Энэ үед эдийн засгийн салбарт аж ахуйн шинэ механизм нэвтэрүүлэх, малчдад малыг гэрээ, түрээсээр өгөх, нээлттэй эдийн засгийн бодлого явуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байсан ба 1989 онд эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх шийдвэр гаргасан байна.[31] 1990 оны эхэн гэхэд

[29] The Economist. Emmanuel Macron's stark warning to Europe. Novemver 7, 2019 https://view.e.economist.com/?qs=8c4d45b1bda2aab4880e0ed567505271cb2c4543397064d503ae978868222ccff27f6135384a40f25657c34b6bcafa3a83aa363ebe587c7310f231cdaa9d00d37355e13db318e6f7d0fb740d657300e0

[30] Магистрант С.Санжжавын хамт энэхүү харьцуулсан шинжилгээг 2019 оны 10 дугаар сард тус хамтын бүтээлийн зүйл бичилттэй холбогдуулан эл бичил шинжилгээг гүйцэтгэсэн бөгөөд ийнхүү үр дүнг нэгтгэн нийтэлж байна.

[31] Намжим Т. Монгол Улсын эдийн засаг. II боть. УБ., 2004, 793 дэх тал.

монголын ард түмний өмнө улс төрийг ардчилах, эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх, оюун санаа, сэтгэлгээний өөрчлөлт хийх зэрэг давхар, давхар сорилт тулгарсан юм. Гэвч эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх онолын болоод практик мэдлэг төрийн удирдлага, нийт иргэдийн дунд буй болоогүй байлаа. Ийнхүү бид зах зээлийн тогтолцоо руу бараг «харанхуй»-гаар орсон учраас авч явуулсан арга хэмжээнүүд нь ихээхэн сөрөг үр дагавар авчирч эдийн засаг гүнзгий хямарсан билээ. Энэхүү хямралын эхийг 1990 оны эхээр гарсан «Эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх тухай» Засгийн газрын тогтоол тавьсан бөгөөд тэрээр 20 дугаар тогтоол гэж алдаршсан юм. Энэ үед эдийн засгийн салбарт тавих гол зорилт нь түүнийг зохистой бүтэц, үр ашигтай цогцолбор бүхий бааз дээр суурилан хөгжүүлэх, улмаар эдийн засгийн балансжилтыг ханган ард түмний аж амьдралын түвшинг дээшлүүлэхэд зохистой, төлөвлөгөөтэй шат дараалсан алхамуудыг авч хэрэгжүүлэх нэн чухал байсныг бид одоо л ойлгон ухамсарлаж байна.

1950-1960-аад онд шинээр тусгаар тогтносон улс орнуудын хувьд үндэсний хөгжлийн төлөвлөгөө нь тусгаар тогтнолын нэгэн бэлэг тэмдэг болж байсан[32] гэж хэлж болох юм. Эл агуулгаараа, дэлхийн улс орнууд нэгдсэн нэг зорилго, зорилттойгоор НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, биелэлтээ хамтран хэлэлцэж ирсэн билээ. Дэлхий нийтийн МХЗ[Мянганы хөгжлийн зорилтууд] 2015 онд дуусгавар болсонтой холбоотойгоор дэлхийн улс орнууд дараагийн 15 жилийн хугацаанд хүн төрөлхтний хөгжлийг хурдасгах, чингэхдээ тэгш бус байдлыг арилгаж, нийгмийн хөгжлийн үр шимийг тэгш эрхтэйгээр хүртэх боломжийг бүрдүүлэх нэгэн зорилгын дор томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн үзэж, тэрхүү зорилгыг бий болгохын төлөө нэгдсэн.

2012 онд Бразилын Рио Де Жанейро хотод НҮБ-аас зохион байгуулсан «Тогтвортой хөгжил» дор хуралдсан бага хурлаар МХЗ-уудын үргэлжлэл болох тогтвортой хөгжлийн зорилтуудыг санаачлан хэрэгжүүлэхээр санал гарган, төслийг боловсруулахаар тогтсон юм. Эл ажлын хүрээнд 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болсон «Мянганы хөгжлийн зорилтууд»-ын үргэлжлэл болгон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулганаар ТХЗ[Тогтвортой хөгжлийн зорилт]-уудыг 17 зорилго, 169 зорилттойгоор батлан, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр тогтсон.[*]

[32] Билгээ Г., Оргилмаа Р., Халиун Д. Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан байгууллагын талаарх Үндсэн хуулийн зохицуулалт, зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны байгууллагуудын чиг үүрэг, бүтцийн харьцуулсан лавлагаа. Судалгааны эмхэтгэл- XXIX боть. УИХТГ. Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс. УБ., 2019, 406 дахь тал.

[*] НҮБ-ын ТХЗ-ууд батлагдсантай холбогдуулан Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх «Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030»-ыг боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцэн, 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлан, тухайн өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

*Хүснэгт 4. Тогтвортой хөгжлийн зорилтуудын зорилго, зорилт, хэмжих шалгуур үзүүлэлтүүд*

| Зорилго | Зорилгын нэр | Зорилт | Үзүүлэлт |
|---|---|---|---|
| **1** | Ядуурлыг устгах | 7 | 14 |
| **2** | Өлсгөлөнг зогсоох | 8 | 13 |
| **3** | Эрүүл мэндийг дэмжих | 13 | 27 |
| **4** | Чанартай боловсролыг дэмжих | 10 | 11 |
| **5** | Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах | 9 | 14 |
| **6** | Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах | 8 | 11 |
| **7** | Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх | 5 | 6 |
| **8** | Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох | 12 | 17 |
| **9** | Инноваци болон дэд бүтцийн нэмэгдүүлэх | 8 | 12 |
| **10** | Тэгш бус байдлыг бууруулах | 10 | 11 |
| **11** | Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих | 10 | 15 |
| **12** | Хариуцлагатай хэрэглээг дэмжих | 11 | 13 |
| **13** | Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах | 5 | 8 |
| **14** | Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах | 10 | 10 |
| **15** | Хуурай газрын эко системийг хамгаалах | 12 | 14 |
| **16** | Энх тайван, шударга ёсыг цогцлоох | 12 | 23 |
| **17** | Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх | 19 | 25 |
| | **Бүгд** | 169 | 244 |

*Эх үүсвэр: ҮСХ, www.1212.mn*

ТХЗ-уудын хүрээнд 17 зорилго, 169 зорилт, 244 үзүүлэлтийн хүрээнд хэрэгжилтийг дүгнэхээр НҮБ-аас тодорхойлсон. Харин манай улсын хувьд 2015-2017 оны байдлаар төсөл хэлбэрээр 113 зорилтын холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг тооцон гаргасан байна. Бид энэ удаагийн судалгааны хүрээнд 17 дугаар зорилгод дүн шинжилгээ хийв.

Тогтвортой хөгжлийн зорилтууд дахь Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын өнөөгийн хүрсэн төвшин хийгээд түүнийг бэхжүүлэх боломж, нөөцийн чадавхид шинжилгээ хийхийг зорив. Чингэхдээ бид энэ зорилттой холбоотой тоон мэдээлэл харьцангуй бага байдаг хэдий ч ҮСХ-оос

2015-2017 оны хооронд тоон мэдээллийг тооцон 19 зорилтоос 7 зорилтын 10 шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тооцоолж гаргасныг энд дурдах нь зүйтэй гэж үзэв.

*Хүснэгт 5. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх талаарх харьцуулсан дүн (оноор)*

| № | Зорилго 17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|
| **1** | 17.1.1. ДНБ-д эзлэх төсвийн нийт орлого | 16.6 | 16.3 | 21.5 |
| **2** | 17.3.1 Улсын нийт төсөвт гадаадын шууд хөрөнгө оруулалт болон хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь | 11.7 | 26.8 | 65.8 |
| **3** | 17.3.2 ДНБ-нд эзлэх мөнгөн гуйвуулгын хэмжээ, ам. доллараар | 2.7 | 2.7 | 2.3 |
| **4** | 17.4.1 Бараа, үйлчилгээний экспорт дахь өрийн үйлчилгээний эзлэх хувь | 30 | 30.1 | 23.3 |
| **5** | 17.8.1 Интернет ашигладаг хувь хүмүүсийн эзлэх хувь | 82 | 87.8 | 94 |
| **6** | 17.11.1 (7)Монгол Улсын экспортын дэлхийн экспортод эзлэх хувь | 0.025 | 0.027 | 0.033 |
| **7** | 17.18.2. (7)Албан ёсны статистикийн үндсэн зарчмыг тусгасан статистикийн хууль тогтоомжтой эсэх, (тийм-1, үгүй-2) | 1 | 1 | 1 |
| **8** | 17.18.3. (7)Бүрэн санхүүжилттэй эсвэл хэрэгжилтийн шатанд яваа статистикийн үндэсний хөтөлбөртэй эсэх, (тийм-1, үгүй-2) | 1 | 1 | 1 |
| **9** | 17.19.2. (a) Сүүлийн 10 жилд хүн ам, орон сууцны тооллогыг наад зах нь 1 удаа зохион байгуулсан, (b) нас баралтын бүртгэлийг 80%, төрөлтийн бүртгэлийг 100% -д хүргэсэн эсэх (тийм-1, үгүй-2) | 1 | 1 | 1 |
| | a) Сүүлийн 10 жилд хүн ам, орон сууцны тооллогыг наад зах нь 1 удаа зохион байгуулсан эсэх | 1 | 1 | 1 |
| | b) Нас баралтын бүртгэлийг 80%, төрөлтийн бүртгэлийг 100% -д хүргэсэн эсэх | 1 | 1 | 1 |

*Эх үүсвэр: ҮСХ, www.1212.mn*

1970-аад оноос үүссэн системийн шинжтэй эдийн засгийн томоохон хямрал болон бусад гадаад болон дотоод хүчин зүйлээс үүдэн үзэл санааны болон үзэл суртлын асуудал хүчээ алдаж эхэлсэн нь зарим улс оронд улс төрийн хүсэл зоиг дутсан, зохистой тоо мэдээ, тооцоолол, төлөвлөлтийн үр чадвар хоцрогдсон, онолын хувьд төөрөгдөлд осрн зэрэг асуудлууд тухай үеийн дэлхийн улс орнуудын эдийн засгийг тогтворгүйжүүлж, улмаар алс хэтийн төлөвлөлтийг хүндрүүлж, харилцан ашигтай сонирхлын байдлыг сааруулж бууруулахад нөлөөлөх засаглалын болон төрийн оролцооны томоохон гажуудал бий болох үндэслэл болсон гэж үзэж болно. Энэ нөхцөл байдал Монгол Улсыг тойрж гараагүйн дээр тухайн үед Монгол Улс социалист, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас ардчилсан, чөлөөт зах зээлийн нийгэмд шилжиж, нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөнөөс хойш хугацаанд Монгол Улсын эдийн засаг хүндэрч байсан түүхтэй. 1991 оноос дэлхийн улс орнуудаас, мөн олон улсын байгууллагуудаас манай улсад буцалтгүй тусламжийг олгож эхэлсэн байдаг.

Өөрөөр хэлбэл, Оюутолгойн гэрээ байгуулагдсаны үндсэн дээр 2010 оноос шууд хөрөнгө оруулалтын хэмжээ огцом нэмэгдэж улмаар 2011 онд дэлхийд гайхагдсан 17.5 хувийн өсөлтийг бий болгосон бол өрийн бодлогыг зөв явуулаагүйтэй

холбоотоойгоор 2019 оны байдлаар нийт гадаад өрийн ДНБ-ний эзлэх хэмжээ 220 хувьд хүрсэн нь дэлхийд тэргүүлэх үзүүлэлт[33] болоод байна. Бид дээрх зургаас Монгол Улсын гадаад өр хэрхэн нэмэгдсэнийг харж болох байна. Үнэндээ, үндэсний аж үйлдвэрийн дорвитой өсөлтийг бүрэн хангах, чингэхийн тулд өөрсдийн "онцлог" талаа нэн тэргүүнд олж мэдрэх, түүнийгээ хөгжүүлэх, бодлогожуулах явдал. Мөн гадаад тусламж дэмжлэгийг үр өгөөжтэй, бодитоор зарцуулах чинггэхдээ гадны дэмжлэгийг "хэт шүтэх"-ээс аль болох зайлсхийж, гагцхүү «дороо сууръгай дотроо бодолтой» хандаж гэмээ нь өөрийг чинь өөрийнхөө юм болгох гэсэн санаанаас хөндийрүүлж чадмой. Энэ мэтчилэн олон арван зүйлийг дурдах болох авч гагцхүү бид хөгжлийн философи гэдгийн зорилго нь хөгжүүлэх бодлогын нийтлэг цаад үндсийг олж тодорхойлоход туслах онолын үзэл баримтлалыг олоход оршино.[34]

*Зураг 1. Монгол Улсын гадаад өрийн байдал (2019 оны 7 дугаар сарын байдлаар)*




Хэдийгээр Монгол Улсад гадны хандивлагч улс орнуудаас хандив тусламж аихийг үзүүлсэн хэдий ч гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, өрийн дарамт 2010-2109 онд огцом ихэссэн. Энэ нь сүүлийн арван жилд Монгол Улсын эдийн засгийн өсөлт болон нийт өрийн ДНБ-нд эзлэх хэмжээгээрээ дэлхийд тэргүүлэх боломж олдсон онцлог үе тохиож байна.

1996 оноос эхлэн Өрийн хэмжээ их, ядуу буурай орнууд Teavily Indebted Poor Country (HIPC)-ын санаачилгын хүрээнд хүлээн авагч улс орнууд эрүүл мэнд, боловсрол, хоол тэмээжл болон ядуурлыг бууруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалт оруулах тохиолдолд өрийг хөнгөлөх тохиролцоонууд хийгдэж ирсэн бөгөөд зээлдэг нараас хүлээн авагч орнуудад ядуурлыг бууруулах стратеги, ядуурлын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ, хөрөнгө оруулалт болон ядуурлын хэмжээг үнэлэх тооцох арга хэрэгсэлтэй байхыг[35] шаардах болсон. Энэ нь угтаа үндэсний хөгжлийн төлөвлөлтийг улс орнуудад нэн нарийвчлалтайгаар дахин сэргээх, улмаар үндэсний

[33] Конрад Аденаурын сан. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2019). Хамтын бүтээл. Ред. Төртогтох Ж., Ганзаяа С. УБ., 224 дэх тал.
[34] Даш-Ёндон Б. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). Нэмж засварласан II хэвлэл. Ред. Чулуунбаатар Г. ШУА. Философийн хүрээлэн. УБ., 2017, 103-107 дахь тал.
[35] Билгээ Г., Оргилмаа Р., Халиун Д. Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан байгууллагын талаарх Үндсэн хуулийн зохицуулалт, зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны байгууллагуудын чиг үүрэг, бүтцийн харьцуулсан лавлагаа. Судалгааны эмхэтгэл- XXIX боть. УИХТГ. Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс. УБ., 2019, 407 дахь тал.

хэмжээнд тулгамдсан асуудлуудыг нэн яаралтай шийдвэрлэх арга замыг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлэх шаардлага бий болж буйг онцолсон явдал болно.

*Хүснэгт 6. Гадаадын тусламж*
*(улсаар, сая ам. доллараар, эзлэх хувиар)*

| № | Хандивлагч орнууд болон хөгжлийн байгууллагууд | 1991-2017 он, сая ам.доллар | Донор улс орон эзлэх хувиар |
|---|---|---|---|
| 1 | Япон | 950.5 | 36.2 |
| 2 | АНУ | 321.4 | 12.2 |
| 3 | Герман | 233.0 | 8.9 |
| 4 | НҮБ | 188.0 | 7.2 |
| 5 | АХБ | 161.3 | 6.1 |
| 6 | Дэлхийн банк | 96.0 | 3.7 |
| 7 | Голланд | 75.3 | 2.9 |
| 8 | Европын холбоо | 88.3 | 3.4 |
| 9 | БНХАУ | 64.2 | 2.4 |
| 10 | Дани | 44.2 | 1.7 |
| 11 | Өмнөд солонгос | 33.9 | 1.3 |
| 12 | Швед | 33.0 | 1.3 |
| 13 | Австрали | 28.4 | 1.1 |
| 14 | Итали | 20.2 | 0.8 |
| 15 | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага | 18.7 | 0.7 |
| 16 | Норвеги | 14.0 | 0.5 |
| 17 | Франц | 12.9 | 0.5 |
| 18 | Их Британи | 9.2 | 0.3 |
| 19 | Канад | 5.8 | 0.2 |
| 20 | Бусад | 228.2 | 8.7 |
| **Нийт** | | **2626.4** | **100.0** |

*Эх үүсвэр: Сангийн яам*

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн бодлого, үйл ажиллагааг дэмжих чиглэлээр хөгжлийн түнш бүхий улс орнууд болон олон улсын хөгжлийн байгууллагуудаас 1991-2017 онд нийт 2.6 тэрбум ам.долларын тусламжийг олгож ирснийг дараах хүснэгтээс дэлгэрэнгүй харж болхоор байна.

Бид, Монгол Улсын Сангийн яамны тоон мэдээлэлд шинжилгээ хийж 1991-2017 оны хооронд Монгол Улсад үзүүлсэн буцалтгүй тусламжийг улсаар авч үзвэл, Япон Улс нийт буцалтгүй тусламжийн 36.2 хувийг, АНУ 12.2 хувийг, Герман Улс 8.9 хувийг тус тус олгож байсан бол, олон улсын байгууллагаас Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ) 7.2 хувийг, Азийн хөгжлийн банк (АХБ) 6.1 хувийг, Дэлхийн банк 3.7 хувийг тус тус эзэлж байна. Харин бусад улс орнууд, олон улсын байгууллагууд 25.7 хувийг эзэлж байна.

*Зураг 2. Гадаадын тусламж*
*(улсаар, эзлэх хувиар)*




*Хүснэгт 7. Гадаадын тусламж*
*(салбараар, сая ам. доллараар, эзлэх хувиар)*

| № | Гадаад зээл тусламжийг салбараар | 1991-2017 | Донор улс орон эзлэх хувиар |
|---|---|---|---|
| 1 | Боловсрол | 396.4 | 15.1 |
| 2 | Эдийн засгийн реформ, Засгийн газар | 300.9 | 11.5 |
| 3 | Эрчим хүч | 260.0 | 9.9 |
| 4 | Хөдөө аж ахуй | 251.8 | 9.6 |
| 5 | Дэд бүтэц | 217.5 | 8.3 |
| 6 | Эрүүл мэнд | 194.9 | 7.4 |
| 7 | Байгаль орчин | 158.1 | 6.0 |
| 8 | Нийгмийн хамгаалал | 137.1 | 5.2 |
| 9 | Хот төлөвлөлт, барилга | 124.6 | 4.7 |
| 10 | Аж үйлдвэр | 107.7 | 4.1 |
| 11 | Цахилгаан холбоо | 83.9 | 3.2 |
| 12 | Санхүүгийн салбар | 28.7 | 1.1 |
| 13 | Уул уурхай | 23.8 | 0.9 |
| 14 | Худалдаа | 9.8 | 0.4 |
| 15 | Бусад | 331.1 | 12.6 |
| | НИЙТ ДҮН | **2626.4** | **100.0** |

*Эх үүсвэр: Сангийн яам*

*Зураг 3. Гадаадын тусламж*
*(улсаар, эзлэх хувиар)*




*Эх үүсвэр: Сангийн яам*

2017 оны байдлаар, хөгжлийн түнш орнууд болон олон улсын байгууллагуудаас олгосон энэхүү тусламжийг салбараар нь авч үзвэл, боловсролын салбарт 15.1 хувийг, эдийн засгийн реформд 11.5 хувийг, эрчим хүчний салбарт 9.9 хувийг, хөдөө аж ахуйн салбарт 9.6 хувийг, дэд бүтцийн салбарт 8.3 хувийг, эрүүл мэндийн салбарт 7.4 хувийг, байгаль орчны салбарт 6.0 хувийг, нийгмийн хамгааллын салбарт 5.2 хувийг, бусад салбарт 27.0 хувийг тус тус буцалтгүй тусламжийн хөрөнгийг зарцуулсаныг Зураг 3-аас харж болно.

2018 оны төсөвт гадаад тусламжийн ашиглалт 110.0 тэрбум төгрөгөөр батлагдсан байна.

Монгол Улсын Засгийн газар 1991-2017 онд Хөгжлийн түнш орнууд, олон улсын байгууллагуудаас нийт 4.4 тэрбум ам.долларын гадаад хөнгөлөлттэй зээлийг авч ашигласан байна. Үүнийг зээлдүүлэгч хөгжлийн түнш орнуудаар авч үзвэл: Япон 26.7 хувийг, Азийн хөгжлийн банк 26.4 хувийг, Дэлхийн банк 14.7 хувийг БНХАУ 13.6 хувийг, бусад улс орнууд, ОУБ, сангууд тус тус 18.6 хувийг эзэлж байна (Зураг 4).

Үүнээс хөнгөлөлттэй зээлийг салбараар ангилвал, дэд бүтцийн салбарт 29.2 хувь, эдийн засгийн реформ болон сангийн салбарт 14.9 хувийг, нийгмийн хамгааллын салбарт 10.8 хувийг, эрчим хүчний салбарт 10.7 хувийг, барилга, хот төлөвлөлтийн салбарт 8.2 хувийг, худалдааны салбарт 7.2 хувийг, бусад салбарт 19.1 хувийг тус тус зарцуулсан байна (Зураг 5).

2018 оны төсөвт гадаад төслийн зээлийн ашиглалт 835.9 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 110.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 2019 онд 1.2 их наяд төгрөгийн зээл, тусламж ашиглахаас 525.7 тэрбум төгрөг буюу 42.3 хувийг Азийн хөгжлийн банк, 254.9 тэрбум төгрөг буюу 20.5 хувийг БНХАУ-ын зээл, тусламж эзэлж байна.[36] Үүнээс дүгнэвэл тогтвортой байдлыг хадгалахын тулд эдийн засаг, нийгмийн салбартаа төсвийн хатуу сахилга баттай байх шаардлагатай.[37]

*Зураг 4. Гадаад хөнгөлөлттэй зээл (донор улс, олон улсын байгууллагаар, эзлэх хувиар)*




*Зураг 5. Гадаад хөнгөлөлттэй зээл (салбараар, эзлэх хувиар)*




*Эх үүсвэр: Сангийн яам*

Нөгөө талаар, Монгол Улс гадаадын зээл тусламжийг үр ашигтай зарцуулах, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэхэд шийдвэр гаргах, бодлого боловсруулах төвшинд хянах механизмын бүрдүүлэн ажиллах шаардлага буй болсныг энэхүү шинжилгээнээс харагдана.

«Төв банк бол төсвөө алдагдалд оруулчихсан сангийн сайдын хувьд асуудлаас гарах хялбар арга зам болдог». Эдийн засгийн уналттай жилүүдийг эс тооцвол Сингапурын

[36] Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, төсвийн тухай хуулийн танилцуулга.
[37] Ли Куан Ю. Сингапурын хөгжлийн нууц. Гуравдагч ертөнцийн орон үсрэнгүй хөгжилд хүрсэн түүх: 1965-2000. «Монсудар» хэвлэлийн газар, УБ., 2015, 258 дахь тал.

ганц ч сангийн сайд «Татвараас олж буй орлогоосоо давж зарцуулахгүй» гэсэн үндсэн зарчмаасаа хэзээ ч хазайж байгаагүй юм[38].

Энэхүү шинжилгээнээс улбаалан, бид ТХҮЗБ-уудын хүрээнд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын өнөөгийн бодлого хоорондын нийцтэй байдалд [39] шинжилгээ хийж үзэхэд дараах байдал ажиглагдсан. Тухайлбал, тус үзэл баримтлалын хүрээнд нийслэл Улаанбаатар хотын Тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахаар ажиллаж байна. Эл ажлын хүрээнд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтын зорилго, зорилтуудыг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй хэрхэн уялдуулах, харилцан хамаарлын шинжилгээг дараах байдлаар гүйцэтгэв.

*Хүснэгт 8. ТХҮЗБ-ын зорилго, зорилтуудыг НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй харьцуулсан байдал*

| № | ЗОРИЛГЫН НЭР | Зорилтын тоо хэмжээ | НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020 (*Холбоотой заалтууд*) |
|---|---|---|---|
| 1 | Зорилго 1: Ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх | 7 | 10 |
| 2 | Зорилго 2: Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх | 8 | 1 |
| 3 | Зорилго 3: Хүн амыг эрүүл сайн сайхан амьдрах нөхцлөөр хангах | 13 | 17 |
| 4 | Зорилго 4: Хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотой хүргэх, насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэх | 10 | 15 |
| 5 | Зорилго 5: Жендэрийн тэгш байдлыг хангах | 9 | 1 |
| 6 | Зорилго 6: Хүн амыг аюулгүй, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах | 8 | 8 |
| 7 | Зорилго 7: Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой эрчим хүчээр хангах | 5 | 10 |
| 8 | Зорилго 8: Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүн амыг үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах | 12 | 17 |
| 9 | Зорилго 9: Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг хөгжүүлэх, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгох | 8 | 6 |
| 10 | Зорилго 10: Тэгш бус байдлыг багасгах | 10 | 0 |
| 11 | Зорилго 11: Хотын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих | 10 | 39 |
| 12 | Зорилго 12: Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих | 11 | 2 |
| 13 | Зорилго 13: Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах | 5 | 5 |
| 14 | Зорилго 14: Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах | 10 | 0 |
| 15 | Зорилго 15: Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол доройтлыг бууруулж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. | 12 | 1 |
| 16 | Зорилго 16: Засаглалын бүх шатанд хариуцлага, ил тод байдлыг хангасан, оролцоо бүхий чадварлаг институцийг бүрдүүлэх | 12 | 10 |
| 17 | Зорилго 17: Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх | 19 | 5 |

*Хүснэгт 9. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтын зорилго, зорилт ба Улаанбаатар хотыг 2020 хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага*

[38] Ли Куан Ю. Сингапурын хөгжлийн нууц. Гуравдагч ертөнцийн орон үсрэнгүй хөгжилд хүрсэн түүх: 1965-2000. «Монсудар» хэвлэлийн газар, УБ., 2015, 258, 259 дэх тал.

[39] Докторант Ц.Баттулгын хамт энэхүү шинжилгээг 2019 оны 11 дүгээр сард хамтын бүтээлийн зөйл бичилттэй холбогдуулан эл бичил шинжилгээг гүйцэтгэсэн бөгөөд ийнхүү үр дүнг нэгтгэн нийтэлж байна.

| № | ЗОРИЛГЫН НЭР | Зорилтын тоо хэмжээ | Улаанбаатар хотыг 2020 хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага: 2016-2020 (Холбоотой заалтууд) |
|---|---|---|---|
| 1 | Зорилго 1: Ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх | 7 | 0 |
| 2 | Зорилго 2: Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх | 8 | 2 |
| 3 | Зорилго 3: Хүн амыг эрүүл сайн сайхан амьдрах нөхцлөөр хангах | 13 | 0 |
| 4 | Зорилго 4: Хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотой хүргэх, насан турш сурч боловсрох боломжийг бүрдүүлэх | 10 | 6 |
| 5 | Зорилго 5: Жендэрийн тэгш байдлыг хангах | 9 | 0 |
| 6 | Зорилго 6: Хүн амыг аюулгүй, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах | 8 | 2 |
| 7 | Зорилго 7: Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой эрчим хүчээр хангах | 5 | 6 |
| 8 | Зорилго 8: Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүн амыг үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах | 12 | 10 |
| 9 | Зорилго 9: Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг хөгжүүлэх, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгох | 8 | 10 |
| 10 | Зорилго 10: Тэгш бус байдлыг багасгах | 10 | 0 |
| 11 | Зорилго 11: Хотын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих | 10 | 14 |
| 12 | Зорилго 12: Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих | 11 | 0 |
| 13 | Зорилго 13: Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах | 5 | 2 |
| 14 | Зорилго 14: Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах | 10 | 0 |
| 15 | Зорилго 15: Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол доройтлыг бууруулж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална | 12 | 1 |
| 16 | Зорилго 16: Засаглалын бүх шатанд хариуцлага, ил тод байдлыг хангасан, оролцоо бүхий чадварлаг институцийг бүрдүүлэх | 12 | 1 |
| 17 | Зорилго 17: Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх | 19 | 3 |

Бидний шинжилгээгээр, 2016-2020 онд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баримтлах бодлогын хүрээнд хамгийн их анхаарал хандуулсан салбарыг дараах хэлбэрээр тодорхойлогдож болохыг тодруулав.

1. Зорилго 11: Хотын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих;
2. Зорилго 7: Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой эрчим хүчээр хангах;
3. Зорилго 4: Хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотой хүргэх, насан турш сурч боловсрох боломжийг бүрдүүлэх;
4. Зорилго 1: Ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх;
5. Зорилго 8: Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүн амыг үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах;
6. Зорилго 3: Хүн амыг эрүүл сайн сайхан амьдрах нөхцлөөр хангах;
7. Зорилго 6: Хүн амыг аюулгүй, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах;

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтын зорилго, зорилтуудыг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй хэрхэн уялдуулахад юун түрүүнд бодлогын харилцан уялдаатай, нэгдмэл, залгамж чанартай тогтвортой байдылг хангахуй хэмжээний бодлогыг

боловсруулан хэрэгжүүлэх явдал нэн чухал юм. Үүний нэг тод жишээ бүхий бодлогын зөвлөмжийг Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн талаарх «Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл -2019»-д дараах байдлаар томъёолсон байна. Үүнд «...Бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа гол шалтгаан нь бодлого боловсруулах цогц арга зүй, хэрэгжүүлэх үйл явц нь шинжлэх ухааны үндэслэл, нөхцөл байдлын нарийвчилсан судалгаа муутай, хөгжийн бодлогын хувилбар боловсруулах явцад иж бүрэн шинжилгээ хийгдэгүй, эдийн засгийн болон үйлдвэрлэлийн бодит нөөц боломжийг сайтар тооцоогүй, шийдвэрлэх асуудлаа ач холбогдлоор нь эрэмбэлэн тодорхойлсон байдал нь ойлгомжгүй байдаг зэрэгтэй холбоотой»[40] хэмээн онцлон тэмдэглэсэн.

Үүнээс улбаатайгаар, бид тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтын зорилго, зорилт ба Улаанбаатар хотыг 2020 хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагыг (Хүснэгт 9) дээрх байдлаар харьцуулав. Хүснэгтээс харвал, Улаанбаатар хотыг 2030 хүртэлхи хөгжлийн чиг хандлагад тусгасан голлох салбарыг дараах хэлбэртэй байна гэж үзэх болохоор байна. Үүнд:

1. Зорилго 11: Хотын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих
2. Зорилго 9: Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг хөгжүүлэх, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгох
3. Зорилго 7: Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой эрчим хүчээр хангах
4. Зорилго 8: Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүн амыг үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах
5. Зорилго 4: Хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотой хүргэх, насан турш сурч боловсрох боломжийг бүрдүүлэх

Бид энэхүү шинжилгээгээр Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтын зорилго, зорилт ба нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийхийг оролдсон бөгөөд түүний үр ддүнд дараах сонирхолтой дүр зураг ажиглагдсан болно.

[40] Монгол Улсын Засгийн газар. Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт. УБ., 2019, 75 дахь тал.

*Хүснэгт 10. ТХҮБ-ын зорилгуудыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал*

| № | ЗОРИЛГЫН НЭР | Зорилтын тоо хэмжээ | Дэд хөтөлбөрүүд, тоо |
|---|---|---|---|
| 1 | Зорилго 1: Ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх | 7 | 8 |
| 2 | Зорилго 2: Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх | 8 | 4 |
| 3 | Зорилго 3: Хүн амыг эрүүл сайн сайхан амьдрах нөхцлөөр хангах | 13 | 8 |
| 4 | Зорилго 4: Хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотой хүргэх, насан турш суралцах боломжийг бүрдүүлэх | 10 | 4 |
| 5 | Зорилго 5: Жендэрийн тэгш байдлыг хангах | 9 | 5 |
| 6 | Зорилго 6: Хүн амыг аюулгүй, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах | 8 | 9 |
| 7 | Зорилго 7: Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой эрчим хүчээр хангах | 5 | 2 |
| 8 | Зорилго 8: Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүн амыг үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах | 12 | 15 |
| 9 | Зорилго 9: Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг хөгжүүлэх, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгох | 8 | 12 |
| 10 | Зорилго 10: Тэгш бус байдлыг багасгах | 10 | 1 |
| 11 | Зорилго 11: Хотын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих | 10 | 11 |
| 12 | Зорилго 12: Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих | 11 | 2 |
| 13 | Зорилго 13: Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах | 5 | 2 |
| 14 | Зорилго 14: Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах | 10 | 0 |
| 15 | Зорилго 15: Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол доройтлыг бууруулж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална | 12 | 0 |
| 16 | Зорилго 16: Засаглалын бүх шатанд хариуцлага, ил тод байдлыг хангасан, оролцоо бүхий чадварлаг институцийг бүрдүүлэх | 12 | 18 |
| 17 | Зорилго 17: Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх | 19 | 7 |

*Хүснэгт 11. ТХҮБ-ын зорилгуудын нийслэлийн хөгжлийн баримт бичигт тусгагдсан байдлын эрэмбэлэл*

| ЗОРИЛГЫН НЭР | | Нэгт буюу нэг зорилгод харгалзах дундаж |
|---|---|---|
| Зорилго 11: | Хотын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих | 2.1 |
| Зорилго 7: | Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой эрчим хүчээр хангах | 1.2 |
| Зорилго 9: | Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг хөгжүүлэх, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгох | 1.2 |
| Зорилго 8: | Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүн амыг үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах | 1.2 |
| Зорилго 1: | Ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх | 0.8 |
| Зорилго 4: | Хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотой хүргэх, насан турш суралцах боломжийг бүрдүүлэх | 0.8 |
| Зорилго 16: | Засаглалын бүх шатанд хариуцлага, ил тод байдлыг хангасан, оролцоо бүхий чадварлаг институцийг бүрдүүлэх | 0.8 |
| Зорилго 6: | Хүн амыг аюулгүй, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах | 0.8 |
| Зорилго 3: | Хүн амыг эрүүл сайн сайхан амьдрах нөхцлөөр хангах | 0.6 |
| Зорилго 13: | Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах | 0.6 |
| Зорилго 2: | Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх | 0.3 |
| Зорилго 17: | Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх | 0.3 |
| Зорилго 5: | Жендэрийн тэгш байдлыг хангах | 0.2 |
| Зорилго 12: | Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих | 0.1 |
| Зорилго 15: | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол доройтлыг бууруулж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална | 0.1 |
| Зорилго 10: | Тэгш бус байдлыг багасгах | 0.0 |
| Зорилго 14: | Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах | 2.1 |

Энэхүү хүснэгт (Хүснэгт 10)-ээс тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтын зорилго, зорилттой нийцсэн, орон нутгийн түвшинд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийг голлох салбараар нь дараах хэлбэртэй байгааг харж болно. Үүнд:

1. Зорилго 9: Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг хөгжүүлэх, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгох
2. Зорилго 16: Засаглалын бүх шатанд хариуцлага, ил тод байдлыг хангасан, оролцоо бүхий чадварлаг институцийг бүрдүүлэх
3. Зорилго 8: Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүн амыг үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах
4. Зорилго 1: Ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх
5. Зорилго 6: Хүн амыг аюулгүй, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах
6. Зорилго 11: Хотын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтын зорилго, зорилтууд нийслэл Улаанбаатар хотын өмнө дурдсан хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан байдлыг дараах байдлаар эрэмбэлэл үүсгэж болохоор буйг бид санал болгож байна.

Энэ бүхнээс үзэхүл, 2000 оны МХЗ болон 2015 оны Тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг хөгжлийн томоохон санаачилга зорилтуудыг хэрэгжүүлэхэд зөв ухаалаг төлөвлөлт, хяналт шинжилгээний механизмууд хэрэгтэй болж байгаагийн дээр улс орнууд нь эдийн засгаа либералчилсэн хэдий ч үндэсний хөгжлийн аппаратуудаа хадгалж үлдэх нь үндэсний хэмжээний томоохон санаачилга, улс төрийн хүсэл тэмүүлэл байхыг шаардаж байна.

Монгол Улсын Засгийн газраас тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн талаар үндэсний сайн дурын илтгэл буюу «Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019»-д онцгойлон дүгнэсэнээр Монгол Улсын Тогтвортой хөгжлийг үзэл баримтлал -2030 –ыг 2016 онд батлан гаргаснаас хойш даруй гурван жил өнгөрсөн бөгөөд энэхүү туршлагыг эргэн харахул, улс орныхоо хөгжлийн стратегийг шинж хандлагаар өөрчлөн сайжруулах шаардлага бий болсныг анхаарах нь зүйтэй. Чингэхдээ эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлэх хөгжлийн стратегийг баримтлах нь чухал боловч гагцхүү ирээдүйд энэхүү өсөлтийн үр шимийг хүн бүрд хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлэх нь нэн чухал төдийгүй стратегийн чиг хандлагаа өөрчлөх нь амаргүй ч бүхий л талууд харилцан ойлголцож зөвшилцөлд хүрэх нь ач холбогдолтой болохыг онцлон[41] дурдсан байна. Мэдээж хэрэг, ийнхүү онцлон дурдсаны гол шалтгаан нь нийгэм, эдийн засгийн болон бүс нутгийн хөгжлийг дэмжих, ялгаварлан гадуурхалтыг зогсоох, эрх тэгш боломжийг олгоход чиглэсэн төрийн нэгдмэл бүхий бодлого, зохицуулалттай байх зарчмыг хэрэгжүүлж, түүний залгамж чанарыг оновчтой, нээлттэй, хөгжлийн бодит бодлого, төлөвлөлт бүхий уян хатан, ухаалаг тогтолцоог бүрдүүлэн ажиллах шаардлага тус улсын улс төрийн намууд, сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан засгийн газруудын нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх явдал хэмээн үзнэм.

[41] Монгол Улсын Засгийн газар. «Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019». Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт. УБ., 2019, 74 дэх тал.

## Ном зүй

*Монгол хэл дээр*


АШБСТО-ын олон улсын V бага хурал., НҮБХХ, (2003). Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл. Улаанбаатар, Монгол Улс

АШБСТО-ын олон улсын V бага хурал., НҮБХХ, (2005). Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). Улаанбаатар, Монгол Улс

Бийтхам. Д, Бойл. К, (2005). Ардчиллыг танилцуулахуй: 80 асуулт, хариулт. Орч Г.Батбаяр. Ред. Жаргалсайхан Б.АШБСТО-ын олон улсын V бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төсөл. Улаанбаатар, Монгол Улс

Бовэйрд Тони., Лөйффлер Элке, (2014). Улс салбарын менежмент, засаглал. Орч. Очирсүх Я., Өлзийбаяр В., Зүльфикар С. Ред. Батсүх Ш. Доржсүрэн Д. Удирдлагын академи. «Адмон» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Болдбаатар Б, (2019). Монголын улс төрийн үйл явцын хөгжилд үзүүлэх эдийн засаг, засаглалын зохистой нөлөөллийн асуудал (бичил судалгааны товхимол). ШУА. Философийн хүрээлэн. Ред. Баасансүрэн Д. Хатанболд О. «Тод бичиг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Ганбат Д., Чулуунбаатар Г. Төмөр С., Ган-Өлзий Ч, ба бусад, (2006). Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. ННФ. «Адмон принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Ган-Өлзий Ч Батын, (2006). Улс төрийн ертөнцийн өөрийгөө нээн харуулах гоц чанарыг судлахуй. ФСЭЗХ. ШУА. «Бэмби сан» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Ган-Өлзий Ч Батын, (2015). Нийтийн хүрээний өөрөө тодрох гоц чанар. Философийн хүрээлэн. ШУА. «Бэмби сан» ХХК Улаанбаатар, Монгол Улс

Ган-Өлзий Ч. Батын, (2019). Тогтвортой хөгжил: нийгмийн шударга ёсны философи (компаратив философийн судалгаа). Ред. Хатанболд О. Философийн хүрээлэн. ШУА. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Голосов Г.В, (1995). Сравнительная политологоя в Новосибирск. РФ

Даваадулам Ц, (2010). Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг. Ред. Цэвэгмид Д. «Мөнхий үсэг» хэвлэлийн газар. Улаанбаатар, Монгол Улс

Даш-Ёндон Б, (2017). Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). Нэмж засварласан II хэвлэл. Ред. Чулуунбаатар Г. ШУА. Философийн хүрээлэн. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Даш-Ёндон Б, (2019). Хөгжихүйн философи (эрдэм шинжилгээний үгүүлэл, илтгэл). Ред. Чулуунбаатар Г., Баяртсайхан Н. ШУА. Философийн хүрээлэн. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Дэлхийн хүний хөгжийн илтгэл – 2002, (2005). Сайн засаглалыг хүний хөгжлийн төлөө чиглүүлэх нь. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. «Бит пресс» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Дэмбэрэл Д, (2011). Ёс зүйт төр. Ред. Батмөнх Д. УИХ-ын Тамгын газрын хэвлэх үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс

Зегер ван дер Вал. 21 дүгээр зууны төрийн албаны менежер. Орч. Даваадулам Ц., Ред. Сүхбаатар Ж. НҮБХХ. Төрийн албаны зөвлөл. «Хөх Монгол принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Инглхарт Рональд, (2005). Олон түмэн ардчиллыг дэмжих явдал хир зэрэг найдвартай байгаа вэ – бид үүнийг яаж хэмжиж болох вэ?. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. «Нэнчин» хэвлэлийн үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс

Конрад Аденаурын сан, (2019). Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2019). Хамтын бүтээл. Ред. Төртогтох Ж., Ганзаяа С. «Адмон принт» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Ли Куан Ю, (2015). Сингапурын хөгжлийн нууц. Гуравдагч ертөнцийн орон үсрэнгүй хөгжилд хүрсэн

Мане Пьер, (2005). Орчин үеийн ардчилал засаглалыг хуваарилах тогтолцоо болох нь. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. «Нэнчин» хэвлэлийн үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс

Маршалл Альфред, (2011). Эдийн засгийн ухааны зарчмууд. Орч. Энхээ Ч. Ред. Батбаатар Ц. «Монсудар» хэвлэлийн газар. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар. НҮБХХ, (2004). Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт Монголд. Үндэсний анхдугаар илтгэл. «Адмон» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар. НҮБХХ, (2008). Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Засгийн газар, (2011). НҮБХХ. Шведийн олон улсын хөгжлийн агентлаг (SIDA). Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл-2011. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Засгийн газар, (2019). Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Засгийн газар. НҮБХХ, (2012). Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго. Rio+20 United Nations Conference on Sustainable Development. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Засгийн газар. НҮБХХ, (2012). Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго. Rio+20 United Nations Conference on Sustainable Development. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Засгийн газар. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо. НҮБХХ, (2009). Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. Үндэсний гурав дахь тайлан. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Засгийн газар. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо. НҮБХХ, (2011). Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. Үндэсний дөрөв дэх тайлан. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг. Үндэсний хөгжлийн газар, (2018). Монгол Улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ –(Тайлан II). Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг. Үндэсний хөгжлийн газар, (2018). Монгол Улсын дунд хугацааны (2020-2025) тогвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл (Тайлан III). Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Сангийн яам. НҮБХХ, (2007). Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. Үндэсний хоёр дахь тайлан. «Адмон» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам. НҮБХХ, (2013). Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. Үндэсний тав дахь тайлан. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

МХЗ-9 төсөл, НҮБХХ. ФСЭХ, (2010). Засаглалын үнэлгээг төлөвлөхүй: арга зам, ашиг тус, өртөг зардал. Хэрэглэгчийн гарын авлага. Орч. Цэрэннадмид Ч. Ред. Доржсүрэн П. «Сансудай» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Намжим Т, (2004). Монгол Улсын эдийн засаг. II боть. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

НҮБХХ, (2000). Хүний хөгжлийн илтгэл. Нэгдмэл биш дэлхий ертөнцөд ардчиллыг гүнзгийрүүлэх нь. НҮБХХ-ийн хэвлэл.

НҮБХХ. Сайн засаглалыг хангах төсөл, (2003). Засаглалын нэр томъёоны тайлбар. Улаанбаатар, Монгол Улс

Ортега-и-Гассет Х, (2001). Түмний түрэлт. Орч Энхээ Ч. «Адмон принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Ортега-и-Гассет Х. Түмний түрэлт. Орч Энхээ Ч. «Адмон» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

Поппер Карл, (2003). Нээлттэй нийгэм түүний дайсан. Орч. Гомбосүрэн Ц. «Адмон» хэвлэлийн газар. Улаанбаатар, Монгол Улс

Прзиворский Адам. Ардчилал ба хөгжил: Бид юуг мэдэх, юуг мэдэхгүй вэ?. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл. «Нэнчин» хэвлэлийн үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс

Ролл Ричард., Талбот Р.Жон, (2005). Улс төрийн эрх чөлөө, эдийн засгийн чөлөөт байдал ба хөгжил цэцэглэлт. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. «Нэнчин» хэвлэлийн үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс

Сен Амартия, (2005). Ардчиллын сул талыг шийдвэрлэснээр ардчиллыг гүнзгийрүүлэх нь. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. «Нэнчин» хэвлэлийн үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс

Сен Амартия, (2014). Хөгжил бол эрх чөлөө. Орч. Энхбаатар А. Мөнхжаргал Э. Ред. Мөнхтуяа Ч. «Монсудар» хэвлэлийн газар. Улаанбаатар, Монгол Улс

Сен Амартия, (2014). Хөгжил бол эрх чөлөө. Орч. Энхбаатар А. Мөнхжаргал Э. Ред. Мөнхтуяа Ч. «Монсудар» хэвлэлийн газар. Улаанбаатар, Монгол Улс

УИХ. Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль, төсвийн тухай хуулийн танилцуулга.

УИХТГ, (2016). Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030: үндэслэл, хамрах хүрээ. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

УИХТГ, (2016). Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030: үндэслэл, хамрах хүрээ. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

УИХТГ, (2019). Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс. Судалгааны эмхэтгэл- XXIX боть. УИХТГ-ын хэвлэх, олшруулах цех. Улаанбаатар, Монгол Улс

ҮАГ. Нийцлийн аудитын газар, (2017). Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан *"Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөө"*-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэсэн байна. Улаанбаатар, Монгол Улс.

Фукуяама Фрэнсис, (2005). «Төрт ёсноос» эхлэх нь. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. «Нэнчин» хэвлэлийн үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс

Фукуяама Фрэнсис, (2014). Улс төрийн тогтолцооны эх сурвалж. Орч. Гомбосүрэн Ц. «Монсудар» хэвлэлийн газар. Улаанбаатар, Монгол Улс
Хатанболд О, (2017). Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. Ред. Чулуунбаатар Г., Ганбат Д., Цэцэнбилэг Ц. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс
Хатанболд О, (2017). Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. ред. Чулуунбаатар Г., Ганбат Д., Цэцэнбилэг Ц. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс
Цанжид А, (2001). Улс төрийн шинжлэх ухаан. Улаанбаатар, Монгол Улс
Цанжид А, (2001). Улс төрийн шинжлэх ухаан. Улаанбаатар, Монгол Улс
Чимид Б, (2006). Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. Улаанбаатар, Монгол Улс
Чулуунбаатар Г, (1999). XX, XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил. ФСЭХ. «Бэмби сан» ХХК. Улаанбаатар, Монгол Улс
ШУА. Философийн хүрээлэн, (2018). Хүмүүний ертөнц ба тогтвортой хөгжил. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. Ред. Пүрэвсүрэн Б., Энхбаяр Ж. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс

*Англи хэл дээр*
Arend Lijphart, (1984). Democracies. Patterns of Majoritarian and Consensus Democracies in Twenty-One-Countries. New Heaven-London, USA & UK
Arend Lijphart, (1992). Parliamentary versus Presidential Government. Oxford Readings in Politics and Government. Oxford University Press., USA & UK
China University of Petroleum, (2019). Notice of the 14th China-Mongolia-Russia International Conference. «Study on Pressing Issues Faced by Neighboring Countries in the Contemporary World» Qingdao Huanghai University.
Dahl A. Robert, (1978). Poliarchy: Participation and Opposition. New Heaven-London, USA & UK
Ernst Fraenkel. (1973). Strukturanalyse der modernen Demokratie. Hamburg, Deutchland
Giovanni Sartori, (1992). Demokratiethorie. Darmstadt.
Hicks J.R, (1981). Wealth and Welfare. Oxford. Basil Blackwell.
Hicks J.R, (1981). Wealth and Welfare. Oxford. Basil Blackwell. USA
Huntington P. Samuel, (1991). How countries Democratize. Political science quarterly, New Haven., 1991, Vol. 106.
Juan J. Linz, (1975). Totalitarian and Authoritarian Regimes. Handbook of Political Sceince #3. Macropolitical Theory, Reading/Mass
Samuel P. Huntington, Clement H. Moore, (1970). Authoritarian Polities in Modern Soceity. The dynamics of Established One-Party-Systems. NY-London, USA & UK
Sen Amartya, (1999). Development as Freedom. Anchor books. A Division of Random House, Inc. New York, USA
Sen Amartya, (1999). Development as Freedom. Anchor books. A Division of Random House, Inc. New York
Seymour M. Lipset, (1983). Political Man. The Social Bases of Politics. London, United Kingdom
Weiss T, (2000). Governance, Good Governance and Global Governance: Conceptual and actual challenges, Third World Quarterly, 21 (5).
Wentao Zhang, (2019). The «Belt & Road» Initiative and Its Chinese Traditional Philosophical Root. International Relations and Diplomacy Journal. David Publishing Company. March 2019, Vol. 7, No.03. p 120. DOI:10.17265/2328-2134/2019.03.003.
Wentao Zhang, (2019). The «Belt & Road» Initiative and Its Chinese Traditional Philosophical Root. International Relations and Diplomacy Journal. David Publishing Company. March 2019, Vol. 7, No.03.
World Economic Forum, (2018). Insight Report. The Future of Jobs Report 2018. Center for the New Economy and Society. Cologny/Geneva. Switzerland.
Yimei Wang, (2018). The Belt and Road Initiative: what will China offer the world in its rise. Jinhyuan Neighborhood, New World Press. Renmin University, PRC.
Yimei Wang, (2018). The Belt and Road Initiative: what will China offer the world in its rise. Jinchuan Neighborhood, Renmin University, PRC. New World Press. Beijing, People's Republic of China

*Цахим эх сурвалж*
https://www.undp.org/content/undp/en/home/news-centre/news/2019/2019_HDR_inequality.html
https://www.undp.org/content/undp/en/home/sustainable-development-goals.html
State Great Khural (Parliament of Mongolia), (2016). Mongolia Sustainable Development Vision 2030. UB, Mongolia. http://www.legalinfo.mn/annex/details/7105?lawid=11725
State Great Khural (Parliament of Mongolia). Parliament's Resolution #13, January 31, 2008. UB, Mongolia.
State Great Khural (Parliament of Mongolia). Parliament's Resolution #25, April 21, 2005. UB, Mongolia. http://www.legalinfo.mn/law/details/6660?lawid=6660

The Economist, (2019). Emmanuel Macron's stark warning to Europe. Novemver 7, 2019 https://view.e.economist.com/?qs=8c4d45b1bda2aab4880e0ed567505271cb2c4543397064d503ae978868222ccff27f6135384a40f25657c34b6bcafa3a83aa363ebe587c7310f231cdaa9d00d37355e13db318e6f7d0fb740d657300e0

*the Wealth of Nations*), - М.: Соцэкгиз.

United Nations Development Programme, (2018). Human Development Indices and Indicators: 2018 Statistical Update. New York, NY, USA. http://hdr.undp.org/sites/default/files/2018_human_development_statistical_update.pdf

*Орос хэл дээр*

Международный форус экспертных центров Китая, Монголии и России, (2017). Сборник материалов форума. Ассоциация экспертных центров Китая, Монголии и России. 18-22 Сентября 2017. Улан-Удэ. Республика Бурятия. Российская Федерация.

Смит А, (1962). Исследование о природе и причинах богатства народов (An Inquiry into the Nature and Causes of the Wealth of Nations), Соцэкгиз, Москва, СССР.

«China-Mongolia-Russia Economic Forum. Corridor: Roadmap» Международный форус экспертных центров Китая, Монголии и России – 2017. Сборник материалов форума. Ассоциация экспертных центров Китая, Монголии и России. 18-22 Сентября 2017. Улан-Удэ. Республика Бурятия. Российская Федерация.

Смит А, (1962). Исследование о природе и причинах богатства народов.

## 3.2. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Төслийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн бодлого, түүний философи үндэслэлийг боловсруулахад чиглэж хийгдсэн судалгааны дүн мэдээллийг танилцуулах, харилцан солилцох, түүнд дэвшүүлсэн санаа, хөндсөн асуудлыг хэлэлцэх зорилгоор 2017 оны 12 дугаар сарын 15-нд **"Монголын нийгмийн хөгжлийн философи ба бодлого"** сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан. Тус хуралд төслийн удирдагч академич Г.Чулуунбаатар "Монголын хөгжлийн бодлого: Асуудал ба шийдэлд холбогдох зарим санаа" илтгэлийг бичиж хэлэлцүүлсэн. Мөн төслийн гүйцэтгэгчид болох доктор (Sc.D) Б.Даш-Ёндон "Монголын хөгжлийн философи: Улс төрийн эдийн засгийн ухааны диалектик", доктор (Sc.D) А.Цанжид "Монголын хөгжлийн бодлогын зарчмууд" сэдэвт үндсэн илтгэлүүдийг тус тус хэлэлцүүлсэн.
2. 2019 онд **"Монгол улсын хөгжил дэх мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхайн зохистой хамаарлын тулгамдсан асуудлууд"** сэдэвт эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг 2019 оны 6 дугаар сарын 24-нд зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийг нээж төслийн удирдагч, академич Г.Чулуунбаатар, доктор (Sc.D) Б.Даш-Ёндон хэлэлцүүлэгт зориулан үг хэлж, хэлэлцүүлгийн үндсэн илтгэлийг доктор (Ph.D) Б.Батхишиг "**Монголын мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн салбаруудын зохистой хамаарал, харьцааны асуудал**" сэдвээр бэлтгэж хэлэлцүүлсэн.

   Хэлэлцүүлэгт салбар салбарын олон эрдэмтэд оролцсоноос дурьдвал, академич Т.Дорж, С.Нямзагд, ахмад эрдэмтэн, Хөдөлмөрийн баатар, доктор, профессор Г.Очирбат, ахмад эрдэмтэн, доктор (Sc.D) Ц.Балхаажав, Ш.Батсүх, Ц.Сүхбаатар, Л.Дүгэржав, доктор (Ph.D) Р.Батмэнд, Л.Оюун, Д.Батмөнх, Ц.Сосорбарам, Б.Чинзориг нараас гадна Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд оролцсон.

   Эрдэмтэд хэлэлцүүлгийн сэдвийг ихэд сонирхож, хэлэлцүүлгээс гарах зөвлөмжид өөрсдийн санал, зөвлөмжөө хэлж танилцуулсан. Эдгээрийг багцлан хэлбэл, энэ салбарууд нэгдмэл нэг байдлаар засгийн нэгдлийг хангах хэрэгтэй, нарийвчлан, төрөлжиж хөгжих нь их чухал, ялангуяа мал аж ахуй дээрээ түшиглэн хөгжих ёстой, эдийн засгийн ямар тогтолцоогоор явах ёстой гэдгээ тодорхой болгож хөгжих нь чухал, төрөлжсөн (салбар бүр дээр) банктай болох хэрэгтэй, мал аж ахуйгаа хөгжүүлэхийн тулд малчдыг бизнес сэтгэлгээтэй болгож, мал аж ахуйгаа эдийн засгийн эргэлтэнд оруулах арга ухаанд суралцуулахад анхаарах хэрэгтэй, мөн малаа өсгөж хөгжлийн суурь болгон хөгжүүлж бодлогоор зохицуулах хэрэгтэй, бэлчээрийн мал аж ахуй дээр бусад бүх салбар нь уяж зангидагдан явах ёстой, ус бол бүх салбарыг холбох чухал зүйл

мөн гэх мэт олон чухал зөвлөмжийг танилцуулсан үр дүнтэй хэлэлцүүлэг болсон.

**ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН ЗӨВЛӨМЖ**

- Монголд МАА, газар тариалан, уул уурхай аль аль нь хэрэгтэй, аль нэгийг нь **хэтрүүлэн** үнэлэхгүй байх.
- Монгол улс бол хөдөө аж ахуйг хөгжүүлэх салбар дээрээ төрөлжсөн улсын банктай болох.
- Хөдөлмөрөө хоршиж ирсэн монголынхоо өөрсдийн арга туршлагыг эргэж сэргээж үүнийг дэмжиж хөгжүүлэх.
- Эн тэргүүнд хөгжлийнхөө бодлогын суурь болгох, тэргүүлэх салбар нь мал аж ахуйн салбар байх хэрэгтэй. Мал аж ахуйн талаар Үндсэн хуульд байгаа заалт, бусад бодлогод цоо шинэ байдлаар хандах;
- Нүүдлийнхээ мал аж ахуйг л хөгжүүлж илүү нарийн гүнзгийрэн төрөлжих.
- Мал гэдэг бол байгалиа сүйтгэдэггүй; Экологийн цэвэр хүнс хаана байна гэхээр, цэнгэг ус, зэрлэг сайхан онгон өвс идэж тунгалаг ус ууж байдаг малтай холбоотой учраас монголын хөгжлийн үзэл баримтлал бол нүүдлийн мал аж ахуйгаа л голлох хэрэгтэй. Тэгэхдээ хуучин аргаар нь биш, энд бол цоо шинэ үзэл баримтлал, цоо шинэ бодлого, цоо шинэ хөрөнгө мөнгө зарах шаардлагатай.
- Малын тоог бол ган зуд зохицуулдаг, зохицуулж байсан түүх бий. Энэ үлийн цагаан оготно, энэ бэлчээрийн талхагдал өөрөө байгальд өөрөө нэг цэгцэрнэ, зүй тогтлоороо цэгцэрнэ. Ингэхлээр энэ зүй тогтлыг бид нилээн сайн судлаж, түүнийг дагуулж бодлогоо гаргах.
- Бодлогоор малын тоо толгой, сүргийн бүтцийг зохицуулж ирсэн хуучны уламжлалыг сэргээх.
- Бэлчээрийг зохистой ашиглах эдийн засгийн болон хариуцлагын механизмыг нэвтрүүлэх, үүнд бэлчээрийг малчид, өрхүүдэд эзэмшүүлэн ашиглуулах, малын тооны өсөлттэй уялдуулан бэлчээрийг тэлэх арга хэмжээ авах, бэлчээр ашиглалтын менежментийг сайжруулах зэрэг цогц арга хэмжээ авах.
- Нүүдлийн мал аж ахуй, газар тариалангийн бүсийг зааглаж, бүсийг нь тогтоож өгөх. Ган зуд болоод хүндэрсэн үед тариалангийн бүсээсээ нүүдлийн мал аж ахуй байдаг газрууд руугаа дэд бүтэц бий болгоод тэгээд тэжээлийн ургамал бусад зүйлээ хүргэдэг тийм дэд бүтцийн зангилааг үүсгэх.
- Монголын хөдөөг хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх.
- Аймгийн төвүүдэд мах боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж, мах бэлтгэл, экспортын системийг нэгдсэн зохион байгуулалтад оруулахын хамт боломжтой аймгуудад малын зарим түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах.

- Хонины нэхий болон ноосон бүтээгдэхүүнийг ОХУ, Казахстан зэрэг хүйтэн, сэрүүн бүсийн орнуудад экспортлох боломжтой нөхцөл бүрдүүлэх талаар Засгийн газар анхаарч шийдвэрлэх.
- Турк болон малын түүхийн эд боловсруултаар тэргүүлдэг орнуудын техник, технологийг оруулж ирэн жижиг үйлдвэрүүд байгуулах замаар малчдыг өөрөө үйлдвэр эрхлэгч болгомоор байна. Малчдыг үйлдвэр эрхэлдэг, орлогоо нэмэгдүүлдэг арга ухаанд сургах.
- Хөгжлийн үзэл баримтлал, салбаруудын хоорондын хамаарал ярихдаа яг ижил хамааралтайгаар биш, суурь нь бол мал аж ахуй, тэгээд газар тариалан гэх мэтээр авч үзэх хэрэгтэй. Харин уул уурхай ашиглах хязгаарыг тогтоож өгөх ёстой, жишээ нь, 30 жил уул уурхайг хөгжүүлнэ, тэрнээс цааш хөгжүүлэхгүй гэдэг байдлаар зохицуулалт хийх.
- Монгол улсын газар нутгийн хэдэн хувиас илүүгүйг лицензээр уул уурхайг эрхэлнэ, жишээ нь 5%-иас, Монгол улсын нутаг дэвсгэрийн 35-40%-ийг дархан цаазат газрын хамгаалалтанд авна гэх мэт суурь заалтуудыг үндсэн хуулинд оруулж өгөх.
- Засгийн нэгдмэл байдал гэдэг онолыг баримталж засгийн нэгдмэл байдлыг хангах.
- Бодлого бол, хөгжил бол Монгол улс нэг улс юм бол, тэр улсын л юм байх ёстой. Монгол улсыг хөгжлийн бодлогоор удирдахын тулд Монгол улсыг тэр чигээр нь нэг юм болгон, суурь болгон авч үзэх хэрэгтэй. Уул уурхай, мал аж ахуй, газар тариалан гэж тус тусад нь салгаж авч үзэхгүйгээр, нэг бодлогод хамрагдаж, нэг бодлогод цаашаа нэмэр болж байгаа эсэхийг харгалзаж бүх зүйлийг улсын шинжтэй авч үзэх.
- Уул уурхайн үйлдвэрлэл, экспортын орлогын нэг хэсгийг аж үйлдвэрийн парк байгуулах ажилд зориулж, малын түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг Улаанбаатарын гадна баруун болон зүүн талд байршуулах.
- Хариуцлагатай уул уурхайг төлөвлөшүүлэх талаар судлах, уул уурхайн талаар баримтлах бодлого дээр яаж тусгах вэ гэдгийг ярих нь зүйтэй.
- Бусад салбарууд яагаад эдийн засгийн систем дотор уул уурхайн салбар шиг жин дарахгүй байна, энэ юунаас хамаараад байна гэдгийг гаргаж тавьсан судалгааны ажил хийх хэрэгтэй.
- Өндөр үнэлэмж бүхий үйлдвэрүүдийг эдийн засгийн эргэлтэнд оруулж чадвал аяндаа өрсөлдөөн бий болоод ажилчдаа алдахгүй байх үүднээс хөдөлмөрийн үнэлгээ нэмэгдэнэ.
- Монгол улсын хөгжлийн концепцийг урагшлуулах, эрдэмтдийн дуу хоолойг төр засагт хүргэсэн форум зохион байгуулах.
- Цаашид манай улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэхдээ үр ашигтай, өгөөж сайтай цөөн тооны уурхайг ээлж дараатай, тодорхой хуваарьтай, эмх цэгцтэй,

зохион байгуулалттай эзэмшиж ашиглах, бусдыг нь нөөцөнд байлгах, үүний тулд уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, түүнд хүчин чадал, газар орон, цаг хугацаа, ээлж дараалал, нөхөн сэргээлт, дэд бүтэц, хүн амын нийгмийн асуудал зэргийг иж бүрэн тооцож тусгах.

- ❖ Уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ юуны өмнө зам, дэд бүтцийг бий болгох, байгаль орчныг хамгаалах, хүн амын нийгмийн асуудлыг шийдвэрлэх шаардлага тавьж, гүйцэтгэлийг хянах.
- ❖ Нөөцийг нь ашиглаад дууссан газрын техникийн болоод биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж, малын бэлчээр болгож ашиглах нөхцлийг бүрдүүлэхэд хатуу хяналт тавих.
- ❖ Уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд ашигласан усыг эргүүлж ашиглах, аль болох гадаргын ус ашиглах шаардлага тавихын зэрэгцээ нүүрс баяжуулах хуурай технологи нэвтрүүлэх ажлыг дэмжих.
- ❖ Цаашид дотоод, гадаадын компаниудад уул уурхайн ашиглалтын зөвшөөрөл өгөхдөө боловсруулах үйлдвэр барих шаардлагыг тодорхой хугацаатай тавьж, гүйцэтгэлийг хянах.
- ❖ Тариалангийн бүс нутгийг тогтоох тухай Засгийн газрын шийдвэрийг тууштай биелүүлж, газар тариалангийн бүс нутгийн хил хязгаарыг сахин хамгаалах, үүний тулд хашаажуулах, ойн зурвас байгуулах, малчид, тариаланчдын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх.
- ❖ Газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхийг бүх талаар дэмжиж, эрчимжсэн болон үйлдвэржсэн мал аж ахуйг газар тариалангийн үйлдвэрлэлтэй хослуулан эрхлэх ажлыг өргөтгөх.

Дээрх зөвлөмжийг нэгтгэн **"Монгол улсын хөгжил дэх мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхайн зохистой хамаарлын тулгамдсан асуудлууд" (Уб., 2019)** зөвлөмжийн товхимлыг бэлтгэн хэвлүүлсэн.

3. **"Innovation of the belt and road initiative; the perspective of central European political and economic philosophy"** эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг 2019 оны 10-р сарын 2-нд зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлгийн үндсэн илтгэлийг "Innovation of the belt and road initiative; the perspective of central european political and economic philosophy" сэдвээр Чех улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Глобал судлалын төвийн захирал, доктор (Ph.D) Marek Hrubec хэлэлцүүлсэн.

   Хуучин социалист систем задран унаж, ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнуудын зарим нь том улс орнуудын эрхшээл нөлөөнөөс өөрийгөө хамгаалахын тулд хэт тусгаарлагдсан бодлого явуулж ирсэн нь тухайн улсуудын хөгжил дэвшилд сөрөг нөлөө үзүүлэх болсон бол, зарим нь хэт нээлттэй бодлого баримталж том гүрнүүдийн эдийн засгийн нөлөөнд автагдах болжээ. Иймд "Даяаршил-Дангаааршил" зохистой харилцаанд байх ёстой, хөгжил буурай улс

үндэстэн бүр үндэсний тусгаар байдал, үндэсний шинжээ хадгалах талаар ухаалаг бодлого явуулах нь зүйтэй. Аль ч улс үндэстэн өөрийн хүсэл зоригтой байдаг тул бүс нутаг, макробүсийн асуудлыг шийдвэрлэхдээ хувь нэмрээ оруулж өөрийгөө илэрхийлж байх ёстой. Ингэснээр тухайн бүс нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, хөгжил дэвшилд хамтран оролцох боломж нээгдэж байдаг. Мөн аливаа нөөц баялгийг чөлөөтэй нэвтрүүлэх, техник технологийн инноваци, шийдлийг санал болгох хүлээн авах боломж бий болно гэдгийг тэрээр онцоллоо. Профессор Б.Даш-Ёндон "Хөгжихүйн философи" сэдвээр, Удирдлагын академид "Монголын хөгжихүйн философийн үндсэн санаа" сэдвээр ШУТИС-д лекц уншив.

## 3.3. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

1. **Б.Даш-Ёндон.** *Монголын хөгжлийн бодлого дахь улстөрийн эдийн засгийн ухаан: зах зээлийн асуудал* - Хөгжихүйн философи. УБ., 2019. /90-104 дэх тал/ Тус өгүүлэлд Монголын хөгжлийн философийг боловсруулах асуудлыг хөндөн судлах явцдаа Монголд өөрийн гэсэн улстөрийн эдийн засгийн ухаан хэмээх мэдлэгийн салбарыг шинэ утга агуулгатайгаар боловсруулах нь зайлшгүй болон тулгарчээ гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Энэ санаа бол Монгол улс эдийн засгийн "дотоод" философижсон онолтой болох юмсан, улс орноо хөгжүүлэх зорилгодоо нийцсэн цар хүрээ сайтай эдийн засгийн онолыг төрөөс боловсруулан мөрдөх хэрэгтэй гэсэн үг ажээ. Тэрбээр, түрүү цагийн их сэтгэгчдийн онол үзлийг дулдуйдан түших хэрэгтэй гэж үзээд тэдгээр сэтгэгчдийн үзлийг авч үзжээ.
2. **Б.Даш-Ёндон.** *Орос улсын хөгжлийн товчлолыг төсөөлсөн В.И.Ленин, Г.В.Плеханов нарын онолын маргаан* - Хөгжихүйн философи. УБ., 2019. /163-171 дэх тал/ Капитал хэмээгчийн дарлалаас ангид нийгмийг цогцлоох тухай К.Маркс, Ф.Энгельсийн санааг бодит байдалд хэрэгжүүлэх практик асуудалд түүхийн хувь тавилангаар Орос орон анхлан холбогджээ. Энэ нь Орос улсын түүх-хөгжлийн амьдралаас зайлшгүйгээр урган гарчээ. Орос оронд нөхцөл нь бүрэлдэж гарцаагүй болсон социаль хувьсгалын онол, практикийн асуудлыг шийдвэрлэхэд их В.И.Ленин, түүний нам толгойлох үүрэг гүйцэтгэжээ. Лениний улстөрийн амьдрал, үйл ажиллагаа, нийгмийн зүтгэл, зохиол бүтээлийг тодруулан харуулсан зарим судлаачдын санааг энэхүү өгүүлэлд авч үзжээ. Ингэхдээ зохиогч Лениний талаар дурдсан бүхнийг гол нь хүн төрөлхтний нийгэм шинжлэл , улстөрийн эрдэм ухаанд, Манай Монголын хөгжлийн онол, үйлсэд түүний оруулсан их хувь нэмрийг тодотгон харуулахыг зорьжээ.
3. **Б.Даш-Ёндон.** *Монголын түүхэн дэх ангиуд агаад өмчийн тухай асуудалд*- Хөгжихүйн философи. УБ., 2019. /206-212 дахь тал/ Марксизмыг үндэслэгчдийн түүхэн судалгааны арга зүйг баримталж Монголын их түүхэнд ангиуд агаад өмчийн тухай асуудал хэрхэн холбогдож болохыг сонирхон судлах нь шинжлэх ухааны төдийгүй, практикийн чухал ач холбогдолтой хэмээн үзжээ. Ингээд хэд хэдэн асуудлуудыг хөнджээ.
4. **Б.Даш-Ёндон.** *Азийн үйлдвэрлэлийн арга: Монголын түүхийн диалектик* - Философи, эрхийн судлал. XXXIV боть.УБ., 2019. /37-63 дахь тал/ Азийн

үйлдвэрлэлийн арга"-ын онолын асуудал нь манай өнөөгийн Монголын цаащдын хөгжлийн замын тунгаан бодохтой холбоотой хэмээн зохиогч үзжээ. "Азийн үйлдвэрлэлийн арга"-ын онолын асуудал нь манай өнөөгийн Монголын цаащдын хөгжлийн замыг тунгаан бодохтой холбоотой хэлбэршлүүдийг Европын байдал дээр судлахдаа "азийн үйлдвэрлэлийн арга" гэсэн санааг жичид гаргаж хэлсэн нь шинжлэх ухааны үүднээс ямар учир холбогдолтой, энэ нь эрт эдүгээгийн Монголд хэрхэн холбогдох вэ? гэх мэт асуудлыг авч үзсэн.

5. **Б.Даш-Ёндон.** Хоосон чанарын гүн ухаан дахь "Буй-үгүй"-н шүтэлцээ. Хөгжихүйн философи. УБ., 2019. /213-219 дэх тал/ Энэхүү өгүүлэлдээ Өрнийн диалектик сэтгэлгээ, дорнын хоосон чанарын гүн ухаан гэсэн хоёр шугам диалектикч агуулгынхаа хувьд, тодруулбал диалектикч сэтгэлгээний хувьд эцсийн дүндээ ижил гэж үзсэн байна. Лаоз-ын "дао"-ийн, Гегелийн "туйлын санаа"-ны, Нагаржунын "хоосон чанар"-ын агуулга, хөгжил, хувирал, өөрчлөлтийг сайтар анхаарвал тэдгээрийг ижил төстэй хэмээн үндэслэхийг оролджээ.
6. **О.Хатанболд** (Ph.D). Ардчиллын мөн чанар ба Монголын ардчиллын төлөвшил, хандлага. Конрад Аденаурын сангийн сэтгүүл. Уб., 2019,
7. **Khatanbold, O.** «Analysis on the Mongolia's sustainable development vision (SDV-2030) and its Challenges and Opportunities in Mongolia: Overview». Article. In English. «Study on Pressing Issues Faced by Neighboring Countries in the Contemporary World» The 14th international conference on 'Trans-border issues in the modern world: Case of Peoples of China, Russia and Mongolia'. August 13-15, 2019. Shandong, Qingdao, China. China University of Petroleum (East China). Qingdao Huanghai University. Proceedings. pp.32-41. "Tod bicheg" Press. Edited by Chaokejiltu, Wang Jianjun. Qingdao, China ISBN 978-99978-58-62-7.
8. **Khatanbold, O.** Mongolian Youth's Internet Usage and Information Channel (Case of Qualitative Research Analysis) – 2017. In English. "Социальные и политические вызовы модернизации в XXI веки" Материалы международной научно-практической конференции. Август 6-11, 2018. Улан-Удэ. Республики Бурятия, РФ. Институт монголоведения, буддологии и тибетологии СО РАН., Бурятский государственный университет. Министерство образования и науки Республики Бурятия., Дальневосточный федеральный университет., Федеральный научно-исследовательский социологический центр РАН., Институт востоковедения РАН. Российское общество социологов. Улан-Үдэ. Стр.243-250. Изд. БНЦ СО РАН, ISBN 978-5-7925-0537-7. DOI: 10.30792/978-5-7925-0537-7-2018-243-250
9. **Khatanbold, O.** Sustainable approaches to the enthusiastic thoughts and perception on Mongolian democracy (analytic overview) – 2017. In Mongolian. *13th International Scientific Conference Proceedings on "Process of the Sustainable Development in the Neighboring Countries: Culture, Society and Education".* Institute of Philosophy, MAS.

Institute of Mongolian, Buddhist and Tibetan Studies at the Siberian branch, RAS. Buryat State University. China Petroleum University in Qingdao, China Society for Minority Ethnic Philosophy of China, PRC. UB, Mongolia. August 14-17, pp.130-138. 'Soyombo' printing LLC. ISBN 978-99978-844-5-9.

## 3.4. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

1. **Г.Чулуунбаатар** "Ардчилсан засаглалыг боловсронгуй болгох тухай асуудал ба Монгол улс" илтгэлийг бичиж Гадаад хэргийн яамнаас 2018 онд зохион байгуулсан *"Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох асуудал: Монгол Улсын жишээ"* сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал,
2. **Г.Чулуунбаатар** "Монгол дахь засаглалын зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зөвлөлдөх ардчиллыг ашиглах боломж" сэдэвт илтгэлийг НҮБ-ын ХХ, МУ-ын ЗГХЭГ, Фридрих Эбертийн сан, МУИС, Удирдлагын академийн хамтран зохион байгуулсан *"Ази дахь Зөвлөлдөх ардчилал"* сэдэвт олон улсын хурал,
3. **Г.Чулуунбаатар** "Монголын хөгжлийн бодлого: Асуудал ба шийдэлд холбогдох зарим санаа" илтгэлийг *"Монголын нийгмийн хөгжлийн философи ба бодлого"* сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал,
4. **Г.Чулуунбаатар** "Монгол төрийн соёлын бодлого ба үнэт зүйлийн судалгаа" сэдвээр үндсэн илтгэл хэлэлцүүлэв. СУИС, Олон Улсын Монгол Судлалын Холбоо хамтран 2018 оны 7 дугаар сарын 23-24-ний өдөр *"Монголчуудын соёлын ертөнц: өв, үнэт зүйл, урлаг"* Олон Улсын эрдэм шинжилгээний хурал. /Э.Сонинтогостой хамтран/
5. **Г.Чулуунбаатар** "Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал ба монгол улсын хөгжил" сэдэвт илтгэлийг бичиж Эрдэнэт хотод зохион байгуулагдсан 100 инженерийн форум,
6. **Г.Чулуунбаатар** "Социально-политические проблемы монгольской молодежи в период модернизации" сэдэвт илтгэлийг Улан-Үд хотод зохион байгуулагдсан "Институт монголоведения, буддологии и тибетологии СО РАН Бурятский государственный университет Федеральный научно-исследовательский социологический центр РАН Институт востоковедения РАН-аас зохион байгуулсан олон улсын хуралд илтгэлүүдийг тус тус бичиж хэлэлцүүлжээ.
7. **Ш.Ариунаа** "И.Кант: Хүний мөн чанарын тухай" сэдэвт илтгэлийг 2017 оны 05 дугаар сарын 27-29-ны өдрүүдэд Москва хотноо *"Евразийн ард түмний Ассамблей"-н анхдугаар их хурлын "Panel discussion Eurasia in which we will"* сэдэвт салбар хуралдаанд хэлэлцүүлж, модератороор ажилласан.

8. **Б.Даш-Ёндон** "Монголын хөгжлийн философи: Улс төрийн эдийн засгийн ухааны диалектик". /*Монголын нийгмийн хөгжлийн философи ба бодлого" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал/ - 2017*
9. **Б.Даш-Ёндон.** Хувь хүний ёс зүйн хариуцлагын асуудалд. /*Өнөөгийн Монголын нийгмийн улстөрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудал. Эрдэм шинжилгээний бага хурал - 2018/.* Нийгмийн хариуцлага гэдэг нь нилээд хийсвэр утгатай, олон тал бүхий ойлголт юм. Хийсвэрийг тодорхой болгох, олон талыг нэгдмэлд оруулж бодохын үүднээсн хариуцлага гэдэг нь нилээд хийсвэр утгатай, олон тал бүхий ойлголт юм. Хийсвэрийг тодорхой болгох, олон талыг нэгдмэлд оруулж бодохын нголоведения, буддологии и тибетологии СО РАН Бурят. Нийгмийн хариуцлага, ёс суртахуун гэж ярихын тулд юуны өмнө, хувь хүний хариуцлага, ёс зүйн асуудлыг хөндөх хэрэгтэй хэмээн үзжээ.
10. **Б.Даш-Ёндон**. "Карл Маркс ба Марксизмын урсгалууд". /*К.Марксын мэндэлсний 200 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал/ - 2019.* К.Марксын онолын тухай бодит баримтыг Монголд анхаарахаа больсон нь манай төр засаг, эрдэмтэд сэхээтний буруу гэхээсээ өмнө харин цагийн эрхээрхи гадаад нөхцөл байдалтай шууд холбоотой хэмээн цохон тэмдэглээд К.Марксын талаарх хэд хэдэн чухал үндэслэгээнүүдийг гаргаж тавьсан.
11. **А.Цанжид** "Монголын хөгжлийн бодлогын зарчмууд". /*Монголын нийгмийн хөгжлийн философи ба бодлого" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал/ - 2017.*
12. **Ж.Энхбаяр** "Нийгмийн хөгжлийн тухай өгүүлэх нь". /*Тогтвортой хөгжил: Оюуны соёл эрдэм шинжилгээний бага хурал/ - 2017.* Хөгжлийн асуудал нь нэн өргөн хүрээтэй том ухагдахуун учраас философи, ёс зүй, улстөр, эдийн засгийн гэх мэт олон талаас тайлбарлаж судлах асуудал болно. Хөгжил гэдэг ойлголт нь норматив шинжтэй, тиймээс үнэлэмжийн утгаар түгээмэл хэрэглэдэг, нийгмийн агуулгаар тун энгийнээр хэлбэл, хүн, нийгмийн хүсэл хэрэгцээ шаардлагаас урган гарч байгаа нэг шатнаас нөгөө шатанд дэвших үйл явц, тухайлбал, хүн амын амьдралын чанар нийгмийн халамж, улс төрийн оролцоог сайжруулахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, улстөрийн өөрчлөлт юм. Нийгмийн хөгжлийн асуудлыг соёлын динамик агуулгад багтаан судлах нь ач холбогдолтой гэж үзжээ. Шинэ санаа, шинэ хөгжил, шинэ үе болон бусад соёл, хүмүүстэй харилцах явцад өөрчлөгдөж байдаг өнгөрсөн үеийн өв уламжлал, одоогийн үзэл санаа, ирээдүйн итгэл найдварыг холбосон тогтолцоо учраас соёлын динамик өөрчлөлт бол хөгжлийн асуудлыг тайлбарлахад чухал үүрэгтэй болно.
13. Хатанболд О. "Доверие как фундаментальный вопрос успешного развития экономического коридора" илтгэл. Англи хэл дээр. ОХУ-ын Буриад Улсын нийслэл Улан-Удэ хотноо 2017 оны 9 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвд, Буддын судлалын хүрээлэнгээс БНХАУ, ОХУ, Монгол улсын эрдэмтдийг оролцуулсан "*Экономический коридор*

*Китай – Монголия – Россия: дорожная карта"* сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл. 276-284 дэх тал. Улан-Үдэ, ОХУ.
14. Khatanbold, O. «Mutual Understanding Between the Citizens in the Countries of China-Mongolia-Russia» сэдвээр 2019 оны 7 дугаар сарын 22-26-ны хооронд БНХАУ-ын ӨМӨЗОны 7 дугаар сарын 22-26-ны хооронд *«Хятад, Монгол, Орос гурван улсын хамтарсан Тинк Танк холбооны олон улсын форум-2019/CRMF2019/»*-ын Иргэд хоорондын ойлголцолын талаар хэлэлцэх V салбар хуралдаан.

# 3.5. АРГА ЗҮЙН МАТРИЦ

## МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ТӨСӨЛТЭЙ ХАРЬЦУУЛСАН МАТРИЦ*

### *Судалгааны тойм*

Бидний хийсэн матрицын шинжилгээгээр тогтвортой хөгжлийн онолын асуудлын тухайд авч үзвэл, чухамдаа хөгжлийн үзэл баримтлалын тухай ярихаас өмнө зайлшгүй хөндөх зүйл бол сүүлийн үед их сонсогдох болсон "ногоон эдийн засаг", "ногоон хөгжил", "ногоон өсөлт" гэх мэт ойлголтын талаарх онолын асуудал юм.Учир нь хөгжлийн бодлогыг онолын тодорхой үзэл баримтлал дээр суурилахгүй бол чиг баримжаагаа алдаж будлиантах, бодлого цэгцтэй бус болох аюултай юм. Ялангуяа манайх шиг эрдсийн баялаг ихтэй оронд уг асуудлыг ул суурьтай авч үзэж шийдвэр гаргахгүй бол баялгийн үр шимийг хүртэхээсээ илүү маргалдаж хэрэлдэх нь их байх нь. Дээр дурдсан ойлголтууд нь тогтвортой хөгжлийн тухай онолын хүрээнд багтана гэдгийг юуны өмнө цохон тэмдэглэх учиртай.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь XX зууны хоёрдугаар хагаст бий болсон бөгөөд тэр үедээ хөгжлийн болон байгаль орчны асуудалд үнэлэмжийн байдлаар хандсан нормч шинжтэй, ерөнхий ойлголтын төдий байсан гэж болно. Өнөөдөр тогтвортой хөгжлийн тухай онолын янз бүрийн сургуулиуд бий болсоны дээр тогтвортой хөгжил нь зөвхөн байгаль орчныг хамгаалах төдий асуудал биш, нийгэм-эдийн засгийн хөгжлийн бодлогын үндсэн зарчмын нэг болжээ. Цөмийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх зарчмыг эсэргүүцдэг улс орон бараг байхгүйн нэгэн адил тогтвортой хөгжлийн зарчмыг ил эсэргүүцдэг улс орон ч бас байхгүй юм. Түүнчлэн уг асуудал дэлхийн, бүс нутгийн болон тухайлсан улс орны гэсэн хүний нийгмийн аль ч төвшинд ижилхэн тавигдаж байгаа юм.

Брунтландын илтгэлд тогтвортой хөгжлийн тухай ойлголтыг анх тодорхойлсон юм (1987) юм. Тэнд тогтвортой хөгжил гэдэг бол "ирээдүй үеийнхэний хэрэгцээгээ хангах бололцоог хязгаарлахгүйгээр өнөө үеийнхэний хэрэгцээ, эрмэлзэл тэмүүллийг хангахад чиглэсэн хүмүүний дэвшлийн арга зам" мөн гэжээ. (path of human progress which meets the needs and

* *Арга зүйн харьцуулсан матрицыг төслийн гүйцэтгэгч, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн ЭШДэА, доктор (Ph.D) О.Хатанболд боловсруулав.*

aspirations of the present generation without compromising the ability of future generations to meet their own needs) Энэ бол маш ерөнхий тодорхойлолт учраас хөгжлийн бодлого боловсруулагчдад үйлдлэгийн (практикийн) тодорхой арга зам заахгүй юм. Гэвч энэхүү тодорхойлолт нь цаашдын эрэл хайгуулын арга зүйн суурь болжээ. Эдүгээ тогтвортой хөгжлийн талаар дор хаяхад 100 тодорхойлолт байгаа ажээ. Эдгээр тодорхойлолт нь байгаль орчны асуудлыг харгалзахын зэрэгцээ нийгэм-эдийн засгийн хөгжилд илүү их анхаарсан шинжтэйгээс зөвхөн экологийн асуудалд анхаарч нийгэм-эдийн засгийн хөгжлийн талыг нь орхигдуулсан зэрэг олон янзын өнгө аястай байгаа аж.

Англи хэлээр “sustainability” гэж хэлж байгаа манайхан “тогтвортой” гэж орчуулж өдгөө нэгэнт хэрэглээнд орсон үзэл санааны үндсэн суурь бол өнөө үеийнхэний үе дотроо харилцах болон ирээдүй үеийнхэнд хандах ёс суртахууны, хүмүүний зүгээс хүмүүн бус капиталд хандах, байгалийн баялагийг хүмүүний болон хүмүүний бус капиталаар орлуулах, солиход үүсэх ёс суртахууны асуудал юм. Үүнд бас хүмүүний оролцоотой болон оролцоогүйгээр дэлхий ертөнцөд болж байгаа янз бүрийн үзэгдэл, үйл явцын эргэлт буцалттай эсэх тухай асуудал бас хамаарч байгаа юм.

Тогтвортой байдлын талаарх үзэл баримтлалуудыг сул болон бат тогтвортой гэж хоёр ангилж болно. Сул тогтвортой байдлын тухай үзэл баримтлалд байгалийн болон хүний бүтээж байгаа капиталууд нь бие биеэ орлох чадвартай бөгөөд баялаггүй болсон тохиолдолд түүнийг хүний буй болгосон капиталаар орлуулж болно гэж үзнэ. Өөрөөр хэлбэл эл үзлийг баримтлагчид нийгэм- эдийн засгийн хөгжилд илүү анхаардаг гэсэн үг. Харин бат тогтвортой байдлын талыг баримтлагчид байгалийн баялгийг хүний бүтээсэн капиталаар орлуулж болохгүй гэх юмуу болсон ч маш хязгаарлагдмал хэмжээгээр орлуулж болно гэж үзнэ.Ингэхээр тэд нийгэм эдийн засгийн хөгжлөөс экологийн асуудал илүү чухал гэж үздэг гэсэн үг юм. Ийм зарчимд суурилсан экологич эдийн засаг гэдэг ухаан хэдийнээ буй болжээ.

Тогтвортой хөгжлийн асуудал нь зөвхөн үйлдвэрлэлд бус логистик, хэрэглээ, технологийн өөрчлөлт, хүний хөгжил гэх мэт олон зүйлийг багтаадаг. Тиймээс тогтвортой хэрэглээ гэх мэтийн нэр томьёо ч буй болсон байна. Дээр дурдснаас үзэхэд тогтвортой хөгжлийн бодлого нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны харилцан шүтэлцээ, уялдаа холбоог оновчтой харгалзаж боловсруулсан үйл ажиллагааны хөтөлбөрт шингэсэн байх ба ийм хөтөлбөрийг боловсруулахаас өмнө тогтвортой байдлын ямар төвшинг баримтлах вэ гэдгийг шийдсэн байх учиртай. Тогтвортой байдлын төвшин нь сулаас бат хүртэл ( эсвэл үүнийг сулаас чанга бодлого ч гэж болно) олон төвшинтэй байж болно. Хөгжлийн бодлогод тогтвортой байдлын ямар төвшинг сонгосноос байгалийн баялагийг ашиглах бодлогын шинж чанар, нийгэм эдийн засгийн бодлогын арга хэрэгсэл, хөгжлийн хурдацын талаарх шийдэл хамаарна. Тогтвортой хөгжлийн бодлого нь эдийн засаг, нийгэм, эколог гэсэн гурван зүйлийн алинийг ч максимум хэмжээнд хүргэхгүй. Өөрөөр хэлбэл тогтвортой хөгжлийн бодлого нь хүний эрүүл мэнд, боловсрол, ажлын байрны асуудлыг багтаасан нийгмийн хөгжилд бүрэн чиглэсэн ч биш, аль болох их ашиг олох, өсөлт гаргахад бүрэн чиглэсэн эдийн засгийн бодлого ч биш, мөн байгалийг одоо байгаа янзаар нь хадгалах юмуу унаган төрхөнд нь ортол сэргээх дан ганц экологийн бодлого ч биш юм. Тиймээс манай

мэтийн улс оронд түргэн хөгжихийн тулд байгалиа ямар нэг хэмжээгээр сүйтгэх үү, эсвэл байгальдаа илүү их анхаарч хөгжлийн зорилтыг арай даруухан тодорхойлох уу гэх мэтээр сонголт хийх шаардлага тулгарч байгаа юм. Хийсэн сонголтын зорилго, агуулгыг зөвхөн төр засаг, улстөрийн намууд төдийгүй нийт ард түмэн (ядахдаа олонх нь) мэдэж зөвшөөрч байвал бодлогын хэрэгжилт амжилттай болох нь мэдээж хэрэг. Тэгэхдээ тогтвортой хөгжлийн тухай хичнээн их маргаж, зөрүүтэй олон үзэл баримтлал гарсан ч гэсэн нийтээр хүлээн зөвшөөрч байгаа хэдэн зүйл бий юм. Үүнд:

- тогтвортой байдлыг хангахад тустай байгалийн сэргээгдэх нөөцийг ашиглах
- экосистемүүдийн шинж чанар болон жам ёсны үйлчлэлийг нь хамгаалах
- биологийн янз бүр байдлыг хамгаалах
- хортой хог хаягдал, ялгарлыг зөвшөөрөгдөх хэмжээнээс доош хэмжээнд барих
- байгаль орчинд эргэлт буцалтгүй өөрчлөлт оруулах үйл ажиллагаанаас татгалзах зэрэг болно.

Тогтвортой хөгжлийн онол нь эдийн засаг ямар байвал байгаль орчинд хохирол багатай бөгөөд урт удаан хугацааны хөгжил дэвшлийн баталгаа болж чадах вэ гэдэгт гол анхаарлаа төвлөрүүлж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор орчны эдийн засаг, экологийн эдийн засаг, шинэ институтч эдийн засаг, шинэ кейнсч эдийн засаг, бехавиор эдийн засаг, экологийн улстөр эдийн засгийн ухаан, нийгэм-экологийн эдийн засаг гэх мэт орчин үеийн эдийн засгийн ухааны олон чиглэлүүд буй болсон байна.

Эдийн засгийн талаас нь авч үзвэл орчны (environmental) болон экологийн (ecological) эдийн засгийн ухааны үзэл баримтлалыг товч боловч хөндөх нь зүйтэй юм. Эдгээрийн ялгаа нь капиталын төрлүүдийн ач холбогдол болон орлох чадварын асуудал дээр илэрнэ. Орчны эдийн засгийн чиглэлийнхэн нэгдүгээр байранд хүний буй болгосон капиталыг тавьж дараа нь хүний капитал, эцэст нь байгалийн нөөц баялаг буюу капиталыг байрлуулдаг.Тэгвэл экологийн эдийн засгийнхан хүний нийгэмд үзүүлэх ач холбогдолоороо байгалийн баялаг, хүний капитал, хүний буй болгосон капитал гэсэн дэс дараатай байна гэж үздэг байна. Тэд экосистемийг бүрдүүлж буй байгалийн капиталыг онцгойлон үздэг.Экосистем нь зөвхөн үйлдвэрлэл, хэрэглээнд тустай биш, ерөөс дэлхий дээр амьдрал байх эсэхэд нөлөөлнө. Тиймээс байгалийн капитал нь чухал ба бусад капитал гэсэн ангилалтай байна гэж үздэг. Байгалийн капитал нь:

- амьдралыг тэтгэн хамгаалах үйлчлэл үзүүлнэ. Дэлхий дээрх төрөл бүрийн амьд төрөл зүйлүүдэд амьдрах, байгалийн системүүдийг шинж чанараа сэргээн хадгалах боломцоо олгох
- системүүдийн өөрийгөө зохицуулах, гадны нөлөөнд зохицох боломжийг бүрдүүлэх
- бусад буюу амьдралыг хадгалах, системүүдийн зохицох чадварт нөлөөгүй боловч амьдралын чанарт нөлөө үзүүлэх үйлчлэл. Үүнд гол нь амрах, нөхөн сэргээх болон гоо сайхны нөлөөлөл багтана.

Ийнхүү капиталыг ангилах нь бодлогод тогтвортой байдлын ямар төвшинг сонгох вэ гэдэгт нөлөөлөх учиртай. Сул юмуу эмзэг тогтвортой байдлын үзэл нь (weak sustainability) хиймэл (хүний гараар бүтсэн) капитал болон байгалийн капитал нь бие биеэ орлох чадвартай гэж үздэг. Тиймээс ийм сонголт нь байгалийн баялагийг илүү чөлөөтэй ашиглаж болно гэсэн үг юм. Харин чанга юмуу бат тогтвортой байдлын (strong sustainability) үзэл нь байгалийн капиталыг хадгалах хамгаалах нөхцлийг чухалчилдаг. Үүний дагуу байгалийн капиталыг юугаар ч орлуулж болохгүй бөгөөд гарсан өөрчлөлт нь эргэлт буцалтгүй үйл явц байдаг гэж үздэг. Тэгэхээр байгалийн баялагийн ашиглалт нь маш бага хэмжээтэй байна

гэсэн үг юм. Ашиглалтын явцад маш болгоомжтой хандаж экологийн эргэлт буцалтгүй үйл явцыг өдөөхгүй байх учиртай. Ийнхүү байгалийн капиталыг чухал болон бусад гэж ялгахад хэрэглэдэг гол шалгуур бол: (i) шударга ёсны төрөл (үе дотор, үе хоорондын харилцаа болон хүмүүн бус төрөл зүйлд хандах); (ii) борлуулалтын хэмжээ хязгаар; (iii) үйл явцын шинж чанар (аль хэр эргэлт буцалтгүй) зэрэг болно.

Тогтвортой байдлын төвшин нь хөгжлийн бодлогыг хэрэгжүүлснээс байгаль орчинд үзүүлэх дарамт, байгалийн капиталыг хадгалах хамгаалах эрмэлзэлийн хүч, өнөө үеийнхэний тусын тулд байгалийн баялагийг ашиглах хэмжээ зэргийг тодорхойлно. Тиймээс бодлогод тогтвортой байдлын ямар төвшинг сонгох вэ гэдэг нь маш чухал болох талаар дээр дурдсан билээ. Маш чанга юмуу чанга төвшнийг сонгох нь өнөө үеийнхнээс ёс суртахууны өндөр чанар, зарим талаар хөгжих, сайхан амьдрах бололцоогоо ямар нэг хэмжээгээр золиослох, хойшлуулах шаардлагатай тулгарна. Ингэх нь хэдийгээр маш сайн боловч улстөрийн бодлогын хувьд бодитой биш гэж үздэг учраас тогтвортой байдлын сул төвшнийг сонгох нь илүү оновчтой гэх үзэл давамгайлдаг. Харин сул төвшний тогтвортой хөгжлийн бодлогыг нийгмийн зүгээс хүлээж авах бололцоотой учир хэрэгжүүлэхэд илүү хялбар, бодитой бодлого болно гэж үздэг. Харин манай орны нөхцөлд тогтвортой хөгжил, тогтвортой байдлын төвшин гэх мэтийн талаар олон нийтийн ойлголт хангалтгүй байгаагаас үйл ажиллагааны сонголт хийхдээ ёс суртахуунтай холбоотой дээрх асуудлын учрыг тэр бүр ухамсарлахгүй байх шиг байдаг. Нөгөө талаар байгаль нь өөрөө шууд эдийн засаг болдог (бэлчээр) учраас өвөрмөц талтай юм.

**Хоёр. Тогтвортой хөгжлийн зарчмууд**

Тогтвортой хөгжил гэдэг нь бүхэл бүтэн улсын хөгжил дэвшлийн тухай асуудлыг хөндөж байгаа болохоор түүний арга зүйн үндэс нь системч хандлага юм. Энэхүү хандлагын үүднээс хөгжлийн бодлого нь эдийн засаг, эрчим хүч, хүнс, ус, хур тундас, эдийн засгийн орон зайн байршил, ядуурал, өлсгөлөн, соёл, соёлын өв, эрүүл мэнд, боловсрол, биологийн олон янз байдал зэрэг маш өргөн хүрээтэй асуудлыг харгалздаг. Үүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд дэлхийн цаг уурын өөрчлөлтийн асуудал маш чухал болж олон улсын анхаарлыг татаж байна. Нүүрстөрөгч багатай эдийн засгийг бүй болгох нь хүн төрөлхтөний тэргүүлэх зорилт болж хувирчээ. Цаг уурын тогтвортой байдал хэмээх нэр томьёо хүртэл гарсан байна.

Монгол Улсын хувьд ядуурлын төвшин, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн хөгжил, нийгмийн салбаруудын хүн амын хэрэгцээг хангах чадвар зэрэг олон зүйлийг харгалзан үзэж тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах нь зүйтэй юм. Тогтвортой хөгжлийн гэж нэрлэх нь ч учир дутагдалтай байж мэднэ. Учир нь хөгжлийн бодлого болон тогтвортой хөгжлийн бодлого гэсэн хоёр бодлого байж болохгүй, нэг л бодлого байх ёстой.

Өнөөгийн болон ирээдүйн үе хоорондын харилцааны ёс суртахууны асуудал талаас нь авч үзвэл Монгол орны байгалийн баялаг ядахдаа зуун жилээр тоологдох хэмжээнд байгаа гэж үзвэл өнөө үеийнхнийг ядуу юмуу эсвэл бусад улс орны ард түмэнтэй харьцуулахад ядуу байдалд байлгах нь хэр шударга болохыг ч бас бодолцох хэрэгтэй.Байгалийн баялгаа хэт харамласан хөгжлийн аядуу бодлого нь үсрэнгүй хөгжиж байгаа дэлхийн бусад улс орноос,

тэр ч бүү хэл өнөөдөр манайхтай хөгжлөөрөө ойролцоо юмуу, эсвэл магадгүй хоцорч яваа улс орнуудын ард үлдэх, энэ нь улмаар үндэстний хувь заяанд сөрөг нөлөөлөх үр дагавартай ч байж болно.Бас нүүрс, төмөрлөг гэх мэт зарим нөөцийн орлуулагдах чанарыг ч харгалзан үзвээс зохино. Дэлхийн технологийн тэргүүлэгч гүрнүүд нано технологийг ашиглан гангаас олон дахин хөнгөн атлаа илүү бөх материал гарган авах зорилт тавин ажиллаж байна. Ийм нөхцөлд зарим төрлийн баялагийн зуу байтугай тавин жилийн дараах хэрэглээ, үнэ ямар байхыг одоо тааварлахад бэрх юм. Тэр ч байтугай тавин жилийн дараа зам хэрэгтэй байх эсэх нь мэдэгдэхгүй байна. Харин ус, ой, бэлчээр гэх мэт нөөц бол зайлшгүй бөгөөд экосистемийн салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд учраас эдгээр болон эдгээртэй төстэй бусад нөөцийг байгалийн чухал капиталын тоонд оруулж хамгаалах, тэдгээрт хор хөнөөлгүй технологи ашиглах шаардлага гарч байгаа юм. Тэгэхээр зарим төрлийн баялгийг ашиглах шаардлага, экосистемийг хамгаалах гэсэн өөр хоорондоо эсрэгцсэн ац асуудал үүсч байна.

Байгалийн боломжит нөөцийг ашиглахад улстөрийн шинжтэй маргаан тэмцэлд биш шинжлэх ухаанд илүү тулгуурлах, олборлох орон зайн хязгаар болон ордын тоо хэмжээг зөв тогтоох нь чухал. Байгалийн чухал ба чухал бус капиталын ялгаа талаас нь авч үзвэл чухал капиталд хортой гэж үзвэл олох ашиг орлогыг үл харгалзан олборлолт хийхгүй. Манай экосистем эмзэг гэдгийг  байнга харгалзах нь хөгжлийн бодлогын нэг онцлог байх болно. Байгалийн баялагаа түлхүү ашиглах нь зөв гэж үзвэл үүнд давж гарч болдоггүй хязгаарлалтуудыг бий болгох хэрэгтэй. Сонирхлын ямар нэг явцуу бүлэг яаж ийгээд байгальд их хор хөнөөлтэй үйл ажиллагаа явуулах боломжийг бүр таслах ёстой гэсэн үг.

Онолын хувьд тогтвортой хөгжлийн үндсэн хоёр арга зам байж болох юм. Нэгд, байгалийн ямар ч баялагийг хүний бүтээсэн зүйлээр орлуулж болно гэж үзэх. Ийм тохиолдолд байгалийн баялагийг хэрэгцээнийхээ хэрээр олборлож, энэ явцдаа түүнийг дуусcан цагт орлуулах төрөл бүрийн бүтээгдэхүүнийг гарган авах бодлого баримтлана гэсэн үг юм. Хоёрт, байгалийн баялаг бүхэлдээ юмуу эсвэл түүний тодорхой гол хэсэг нь орлуулж болшгүй шинж чанартай гэж үзэх. Ийм тохиолдолд хэрэглээгээ хязгаарлах, өөрчлөх замаар байгалийн баялгийн орлуулж болохгүй гэж үзсэн хэсгээ хадгалан үлдээх ёстой болно. Байгалийн баялгийг ирээдүй үеийнхэнд үлдээх үзэл санаа нь үе хоорондын шударга ёсны асуудал учраас эхний хувилбарт багтана гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл байгаа баялагийг одоо ашиглаад түүнийг орлуулах бүтээгдэхүүнийг бий бологох үүргийн ихэнхийг ирээдүй үеийнхэнд даатгана гэсэн үг. Хоёр дахь хувилбарыг баримталсан тохиолдолд байгалийн баялагийн орлуулагдашгүй хэсгийг ирээдүй үеийнхэн ч дуустал нь хэрэглэх боломжгүй юм.

Магадгүй хүн төрөлхтөн сансарт чөлөөтэй аялж өөр гаригуудаас эрдэс түүхий эдийг зөөвөрлөн авчрах юмуу эсвэл тэнд нь боловсруулж бэлэн бүтээгдэхүүн авчирдаг болж болно. Тэгэх ч байх. Гэвч энэ тохиолдолд мөнөөх орлуулж болох баялгийг л зөөж авчрахаас бус дэлхий хэмээх гаригийн экосистемийг бүрдүүлж байгаа тэр баялгийг зөөж авчрах боломжгүй юм. Гэвч энэ яриа бол ирээдүйн асуудал, тэр тусмаа манай орны хувьд хийсвэр шинжтэй байж болно. Ийм нөхцөлд манай орны тогтвортой, эсвэл нийтлэлжсэн, үзэл сурталжсан маягийн үг хэллэг хэрэглэвэл “ногоон хөгжлийн” онолын тулгуур зарчим юу байж болох вэ?

Юуны өмнө “ногоон хөгжил” гэдэг бол нэг яам байгуулаад тэр нь байгаль хамгаалах тухай яриад байхын нэр биш гэдгийг ойлгох учиртай. Ногоон хөгжил гэдэг бол системийн шинж юм. Нийгмийн амьдралын бүхий л талд тусгалаа олсон, нийгмийн биед нэвт шингэсэн шинж юм. Дээр дурдсныг үндэс болговол онолын хувьд ногоон хөгжлийг эрэлт нийлүүлэлт хоёрыг зохицуулах замаар буй болгож болно гэж үзэж болох юм. Нийлүүлэлтийг зохицуулах нь хүний эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг байгальд хоргүй технологиор гаргаж авах явдал юм. Эрэлтийг зохицуулах нь хүн хэрэглэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний зарим төрлөөс татгалзах юмуу хязгаарлана гэсэн үг. Ногоон хөгжлийн онолчид энэ л хоёр хязгаарын дотор оюуны эрэл хайгуул хийж байгаа бөгөөд зарим нь хоёр хязгаарт байгаа юм. Дээр дурдсан зүйлийг харгалзан үндэсний гүн ухааны үүднээс хандвал хөгжлийн хэд хэдэн философи зарчмыг баримталж болмоор санагдана. Үүний эхнийх нь **шүтэн барилдахуйн** зарчим юм. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг улс орны хөгжил, хүн амын сайн сайхан амьдралын төлөө ашиглах хоёр бол өөр хоорондоо уялдаатай. Дэлхий дахиныг хамран явагдаж байгаа орчны өөрчлөлт Монгол Улсад ч бас болж байгаа гэдэг нь бодитой юм. Тийм үед орчны өөрчлөлтөөс хамгаалахын тулд эдийн засгийн боломжтой байх ёстой. Нөгөө талаас хүн ам ядуу байгаа үед хүмүүсийн байгальд хандах зохисгүй хандлагыг өөрчлөхөд бэрхшээлтэй. Энэ бүхэн нь хөгжлийн бодлогын асуудалд туйлшрал байж болохгүйг харуулж байгаа юм.

Эрэлт, нийлүүлэлтийн аль алиныг зохистой хэмжээ, агуулгаар зохицуулж болно. Нийлүүлэлтийн талд нь үндсэндээ аливаа үйлдвэрлэл, үйлчилгээнд байгаль орчинд хоргүй технологи хэрэглэх, зайлшгүй хэрэглэх шаардлага гарвал тийм үйлдвэрлэлээс татгалзах, холбогдох бүтээгдэхүүнийг нь импортлох бодлого баримтална. Манай орны хувьд нийлүүлэлтийн талын эко гэж үзэж болох үйлдвэрлэл бол мал аж ахуй юм. Орчин үед эрчимжсэн МАА-н сөрөг тал улам бүр мэдэгдэхүйц болж байгааг янз бүрийн судалгаа харуулж байна. Манай уламжлалт МАА нь нэгэнт л МАА юм болохоор бас л дээрх сөрөг талуудыг ямар нэг хэмжээгээр агуулах боловч тэдгээр нь харьцуулшгүй бага. Ийм нөхцөлд манай орны уламжлалт МАА нь хоцрогдол биш, харин бидэнд илүү их боломж олгож байгаа эдийн засгийн чухал (суурь) салбар болж байна. Тэгэхдээ махны дотоод нийлүүлэлтийг аажмаар бууруулах, гадагш чиглэсэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нь чухал байж болох юм. Хүн амыг загас, тахианы мах, далайн гаралтай хүнс, сайн чанарын хүнсний ногоогоор хангах асуудлыг бодлогын томоохон арга хэмжээ болгон хэрэгжүүлж болно. Их нууруудын бүс нутгийг эх газрын загасны аж ахуйн томоохон төв болгох боломж бий. Эрэлтийг зохицуулахад ч боломжийн арга зам байгаа нь “улаан мах”-ны хэрэглээг мэдэгдэхүйц хувиар багасгах, хот дотор том оврын суудлын тэрэг унахыг хориглох, бензин, түлшээр ажилладаг авто машины гаалийн болон бусад татварыг нэмэгдүүлэх, хүн амын бөөгнөрлийг задлах гэх мэт олон арга хэмжээг авах хэрэгтэй юм. Хотын нийтийн тээвэр, хот хоорондын тээвэр зэргийг сайтар хөгжүүлснээр хүн бүр заавал машинтай байх хэрэгтэй юү гэдэг асуудлыг хөндөж болох юм.

Эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах иймэрхүү бодлого нь хүн амын эрүүл мэндийг сайжруулах, аж амьдралыг нь дээшлүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг өсгөх, байгаль орчноо хамгаалах зэрэг хөгжлийн бусад чиглэлд түлхэц өгнө. Ялангуяа улаан махны

хэрэглээг эрс багасгах, хүнсний ногооны хэрэглээг эрс нэмэгдүүлэх нь олон талын ач холбогдолтой юм. Улаан махны хэрэглээг хоёр дахин бууруулж чадвал махны экспортын хэмжээг төдий чинээгээр өсгөнө гэсэн үг юм. Махыг орлуулах хүнсний чанартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл хэрэглээг эрс нэмэгдүүлэх ёстой болно. Тухайлбал, өндөр чанартай хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх, эх газрын загас үржүүлгийг бий болгох. Шувууны аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээ дагалдана. Түүнчлэн хүн амд хүнсний ногоо, ялангуяа шинэ төрлийн хүнсний ногоо, загас, шувууны махаар хоол хийх, хэрэглэхийг зааж сургах явдал ч үүнд багтана.

Эдийн засаг нийгмийн амьдрал, тэгэхээр эдийн засаг, нийгмийн салбар өөр хоорондоо шүтэлцээтэй. Эдгээрийг салгаж харах, нэгийг нь онцолж нөгөөг нь орхигдуулах нь улсын хөгжлийн эрх ашигт хортой юм. Энгийн жишээ хэлэхэд л дээр дурдсан улаан махны хэрэглээг 50 хувь бууруулах нь зөвхөн экспортыг нэмэгдүүлж орлого өсгөөд зогсохгүй хүн амын эрүүл мэндэд чухал нөлөөтэй. Манай хүн амын дотор элэг, ходоод, зүрх судасны өвчин их байгааг ийм арга хэмжээ авснаар эрс бууруулна гэж үзэж болох юм. Хүн ам эрүүл болсноор эдийн засгийн өсөлтөд түлхэц үзүүлнэ. Улаан махны хэрэглээг бууруулах нь нөгөө талдаа гахай, шувуу, загас өсгөж махны хэрэглээний буурсан хэмжээг нөхөх, улмаар ажлын байр орлого, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг олон сайн талтай юм. Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэл болон дэд бүтцийн харьцааны хувьд шүтэн барилдахуйн зарчим буюу тэнцвэр, нэгний нь нөгөөд нь үзүүлэх нөлөө, дэмжлэг хооронд гажиг бий болж байгаа нь бодлого өрөөсгөлийн шинж гэж үзэж болох юм.

**Бүгдийг бус голыг нь төлөвлөх зарчим.** Өдгөөг хүртэл боловсруулж ирсэн хөгжлийн төлөвлөлтийн гол алдаа бол бүх салбарыг хамруулан бүгдийг нь нарийн төлөвлөх оролдлого юм. Зүй нь улсын хөгжилд түлхэц үзүүлэх, заавал хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг гол зарчмаар нь төлөвлөж явцын дунд нарийсгах, төлөвлөгдөөгүй салбаруудыг богино, дунд хугацааны төлөвлөлтөд тусган "марш хийх явцдаа" хэрэгжүүлэх зарчим баримталбал зохих юм. Энэхүү зарчмын хүрээнд одоогийн хөрөнгө оруулалтын бодлогыг хянаж үзэх шаардлагатай. Өнгөрсөн жилүүдэд улсын болон хувийн хэвшлийн (ялангуяа хувь хүмүүсийн) хөрөнгийг зам, эрчим хүчний шугам, барилга, орон сууц гэх мэт ерөөс мөнгө бий болгодоггүй зүйлд их хэмжээгээр зарцуулсан нь нэг төрлийн туйлшрал, хөгжлийн боломжийг алдсан хэрэг болов.

**Хамтын хүчин чармайлтын хүчийг ашиглах** зарчим. Үүнийг зарим талаар синергетикийн зарчим ч гэж нэрлэж болох юм. Энэхүү зарчмын хүрээнд эдийн засаг-бизнес болон боловсрол-шинжлэх ухааны холбоог хүчтэй болгох (тунхаг төдий биш, бодитойгоор), аймгийн түвшний, улсын хэмжээний үйлдвэрлэлийн кластерийг бий болгох, хөдөөгийн үйлдвэрлэлийн төрлүүдийн хоорондын уялдааг харгалзан "солонгоруулж", хөдөөгийн хүн амын дотор таваар мөнгөний харилцааг хүчтэй болгох, хоршооллыг хөгжүүлж үр нөлөөг нь дээшлүүлэх гэх мэт олон зорилтыг багтааж болно. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг боловсруулах, боловсруулсан бүтээгдэхүүнийг борлуулах асуудал цэгцтэй шийдвэрлэгдэж чадаагүй учраас зарим тохиолдолд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үрэгдэх, алдагдалтай үнээр борлогдох тохиолдол гарч байна. Кластерийг байгуулахдаа үүнийг онцлон харгалзах хэрэгтэй юм. Үйлдвэрлэлийн салбарын дотоодод төдийгүй бизнес болон

банк санхүүгийн салбарын уялдаа холбоог маш тодорхой болгох нь зүйтэй юм. Тодорхой банкийг тодорхой төрлийн үйлдвэрлэл-бизнес, тодорхой бүс нутагтай уях хэрэгтэй ч байж болох юм. Түүнээс гадна улстөрийн намууд хоорондын, улстөр иргэний нийгэм хоорондын хамтрах-өрсөлдөх боломжийг хайх нь туйлын чухал юм. Дэлхийн тавцанд улс орнууд, үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүд гэсэн маш олон хүчирхэг өрсөлдөгчтэй байгаа энэ үед дотоодын өрсөлдөөн, ялангуяа улс төрийн салбарын дахь өрсөлдөөнийг дэвэргэж болохгүй юм. Тийм учраас улстөрийн голлох намуудын харъяалалтай эрдэмтэд, эзэд оролцсон үндэсний эдийн засгийн зөвлөх хороо байгуулж болох юм.

**Дэвшлийг эрхэмлэх зарчим.** Ингэхгүйгээр ямагт дэлхийн хөгжлийн сүүл барих болно. Шинээр буй болж байгаа бүхнийг аль болохоор технологийн орчин үеийн түвшинд эхэлдэг байхад анхаарна гэсэн үг юм. Өнөөдөр манай оронд буй болж байгаа жижиг дунд үйлдвэрийн олонх нь технологийн хувьд болхи байгаа нь зөвхөн амиа аргацаахад л хүрэлцэх төдий юм. Тиймээс технологийн судалгаа хийх, үйлдвэрлэгчдэд сургалт, зөвлөгөө өгөх жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн хүрээлэн байгуулах хэрэгтэй юм. Улсын том сургуулиуд, ШУА-ийн хүчин чадлыг үйлдвэрлэлийн хэрэгцээтэй шууд уялдуулах хэрэгтэй юм. Манай орон бусдын араас дагаж явах уу хөөж гүйцэх үү, эсвэл угтаж нийлэх үү гэх мэт асуултын хариулт энд байгаа юм. Тийм учраас ШУА-ийн харъянд ч юмуу уран зөгнөл бус ажилч хэрэгч судалгаа хийдэг Ирээдүй судлалын хүрээлэн байгуулах хэрэгтэй байгаа юм. Энэхүү зарчмын хүрээнд хатуу ойлговол зохих нэг зүйл бол нөхцөлийг нь бүрдүүлж чадвар Монгол хүн юуг ч хийж чадна. Ялангуяа аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалаар буй болж байгаа технологийн боломжийг ашиглаж чадвал тус улсад хөгжхих ирээдүй бий.

**Усан хангамжийг эн тэргүүнд тавих зарчим.** Хөгжлийн бодлогын чухал зүйл бол тэргүүлэх асуудлуудыг тодорхойлж, тэдгээрт онцгой анхаарал тавих юм. Манай орны тухайд юуны өмнө усан хангамжийн асуудал ийм ач холбогдолтой. Ус бол зөвхөн хүн мал, үйлдвэрлэл, үйлчилгээг усаар хангах асуудал биш. Энэ бол ерөөс Монгол орны ой, амьтан, ургамал уур амьсгалын өөрчлөлтөд зохицон тэсч үлдэх, тус улсын сав шим ертөнц өнөөгийн дүр төрхөөрөө байж улс орны хөгжлийн өлгий болж чадах эсэх тухай асуудал юм. Ус бол манай орны хувьд чухамхүү экосистемийг үүсгэгч байгалийн чухал баялаг юм. Тийм учраас усны бодлого нь манай орны хөгжлийн бодлогын хамгийн чухал хэсэг мөн. Өнөөгийн байдлаар авч үзвэл хот хөдөөгийн алинд ч усны хомсдол ихээхээн байна. Хурын усаар хүн малын хэрэгцээг хангаж ирсэн уламжлалт арга нь хур орох нь багассан, хурын ус цуглуулдаг байсан хуучин уламжлал мартагдсан, хурын ус хүчиллэг болсон зэрэг олон шалтгааны улмаас үр дүн муутай болж байна. Бүхэл бүтэн багийн хүн мал ундны усгүй болон нутаг нь хуурайшиж байгааг анхаарахгүй байж болохгүй юм. Усны асуудлыг шинжилгээ судалгаанд суурилан, төрийн маш оновчтой бодлого, арга хэмжээ, олон улсын тусламж дэмжлэг авч иж бүрнээр, тэгэхдээ маш яаралтай авч үзэхгүй бол гамшгийн байдалд хүрч болох юм. ХАА, уул уурхайн үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл зэрэг манай эдийн засгийн аль ч салбар уснаас бүрэн хамааралтай юм. Усны асуудлыг шийдвэрлэхдээ маш болгоомжтой “долоо хэмжиж, нэг огтлох” зарчмаар ажиллахгүй бол говио хангай болгох гээд хангайгаа говь болгочих аюул ч бас байгаа юм.

**МАА, газар тариаланг суурь салбар гэж үзэх.** Дээр бид МАА-н талаар нэгэнт ярьсан боловч бас тодруулах зүйл байгаа юм. МАА-г, малчдыг хэрхэн дэмжих вэ гэдэг асуулт чухал юм. Малын гаралтай түүхий эд үйлдвэрлэхэд урамшил олгох, малчдын зээл хөнгөлөх гэх мэт нь тодорхой ач холбогдолтой боловч гол зүйлийг хөндөхгүй байгаа юм. Гол асуудал бол МАА-н бүтээгдэхүүнээс олж байгаа малчдын орлогыг өсгөх юм. Ингэхгүйгээр халамжийн шинжтэй арга хэмжээгээр асуудлыг шийдвэрлэж чадахгүй юм. МАА-н бүтээгдэхүүн боловсруулах технологийг сайжруулах, шилдэг технологид суурилсан том жижиг үйлдвэрүүд байгуулах, гадаадын томоохон зах зээлд бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх ажлыг тууштай хийвэл энэ зорилтыг хангаж болох юм. Үүний зэрэгцээ дотоодын зах зээлийг МАА-н гаралтай өөрийн бүтээгдэхүүнээр бүрэн хангах зорилтыг хэрэгжүүлэх хэрэгтэй нь ойлгомжтой юм. МАА-н гол бэрхшээлийн нэг нь малын хорогдол юм. Түүнийг багасгах гол арга нь мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, халдварт өвчгөөс сэргийлэх вакцинийг дотооддоо үйлдвэрлэж малыг тогтмол вакцинжуулах, үржил селекцийн ажлыг зохион байгуулалттай, зорилготой болгох явдал боловч одоогоор хангалттай биш байгаа юм. Малыг зудаас хамгаалахад тэжээл чухал гэдэг нь ойлгомжтой. Гэвч манайд хэрэглэж ирсэн уламжлалт тэжээл нь хадгалалт муу даадаг, тээвэрлэхэд овор ихтэй зэрэг дутагдалтай. Холоос тээвэрлэснээс үнэ нь өндөр. Нөгөө талаас мал өлсөөгүй, тураагүй атлаа осгож, дарагдаж үхэх нь бага биш.Тиймээс шинжлэх ухаан-технологийн инновацийн үйл ажиллагааны хүрээнд тэжээллэг чанар өндөртэй, хадгалалт даадаг, тээвэрлэхэд овор багатай тэжээл буй болгох, малыг хүйтнээс хамгаалах эм тарилга буй болгох зэрэг ажил хийж чадвал малын хорогдлыг үлэмж хэмжээгээр багасгаж болно.

Бүх нийтээр газартай ажилладаг хэвшил тогтоох. Томоохон тариалангаас гадна хотод ч, хөдөөд ч сул чөлөөтэй газрыг ашиглан айл бүр төмс, хүнсний ногоо тариалах. Газар ашиглах агротехникийн шаардлага тусгасан стандартыг нэвтрүүлэн үндсэн болон туслах аж ахуйн хэлбэрээр тариалан эрхлэх нь манай орны хүнсний хангамжийг нэмэгдүүлэх болно. Хөрс хамгаалах технологи боловсруулж нэвтрүүлэх, хөрс хамгаалалтын улсын алба буй болгох, тариаланчдад үрийн болон шатахууны хөнгөлөлт үзүүлэхийн оронд бүтээгдэхүүнд олгодог урамшууллыг дорвитой дэмжлэг болох төвшинд хүргэх зэрэг нь газар тариалангийн талаарх хөгжлийн бодлогын чухал хэсэг юм. Хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ тариалалтыг дэмжихийн тулд юуны өмнө ургацыг нь худалдан авч нөөшлөх гэх мэтээр бүтээгдэхүүн болгож зах зээлд гаргадаг үйлдвэрүүдийг бүсчлэн байгуулах нь оновчтой байж болох юм. Жижиг тариаланг дэмжих нь гахай шувуу үржүүлэх зэрэг шинэ хавсарга үйлдвэрлэл хөгжихөд хүргэж улмаар хотын төвлөрлийг багасгах ядуурлыг арилгах гэх мэтэд ч нөлөөлж болох талтай юм. Бэлчээр талхлагдаж байгаагийн зэрэгцээ хязгаар нутагт бэлчээр эзгүйдэж байгаад бас анхаарал тавих ёстой. Тиймээс Эзгүйдэж байгаа бэлчээр нутгийг ашиглахад чиглэсэн бодлого чухал юм. Онцлон тэмдэглэвэл зохих зүйл бол үндэсний уламжлалт салбараа хүчтэй хөгжүүлэх нь эдийн засгийн хараат байдлыг багасгах нэг нөхцөл болж болно.

**Хөгжлийн төв, тэнхлэгүүдийг буй болгох.** Малчид, ер нь хөдөөгийн хүн ам татагддаг хөгжлийн төвүүд байх нь иргэд өндөр чанартай үйлчилгээг авах, бүтээгдэхүүнээ борлуулах, эрхэлж буй үйлдвэрлэлдээ дэмжлэг авах боломжийг нэмэгдүүлнэ. Төвөөс гадна хөгжлийн

тэнхлэгүүд байх нь хөгжлийн төвийн давуу талуудыг ямар нэг хэмжээгээр агуулахын зэрэгцээ хүн амын бөөгнөрөл үүсгэхгүй, байгаль орчинд учруулах сөрөг нөлөө нь бага, газрыг оновчтой ашиглах, нутаг орноо бүрэн эзэмших зэрэг олон сайн талтай юм. Тиймээс мянганы зам гэж нэрлэгддэг гол гол замуудын дагуу тусгай болзолтойгоор газар эзэмшүүлэх, хөнгөлттэй үнээр, зарим тохиолдолд үнэгүйгээр хувьчлах ажил хийж болох юм. Ийм тэнхлэгийн дагуу хүмүүс суурьшихыг өөгшүүлж, тэдэнд төмс, хүнсний ногоо тариалах, тахиа, шувуу, суурин газарт үржүүлж болдог амьтан үржүүлэх бололцоог өргөн тавьж олгох хэрэгтэй юм. Төв, тэнхлэгийг байгуулахдаа усан хангамж, газар зүйн онцлогийг харгалзвал зөв байж болно. Өндөр уулын оршин суугчид уулсын хоорондуур орших том том хөндий дагуу байрлах тэнхлэгүүдэд татагддаг байж болох юм. Тухайлбал Увсаас эхлэн Өмнөговь хүртэл Их нууруудын хотгор-Хүйс-Шарга- Халиун- Бигэр- Улаан шал гэсэн томоохон тэнхлэг байж болох бөгөөд тэнд манай улсын жимс жимсгэний үйлдвэрлэлийн гол хэсэг, ямаа, тэмээний үржүүлгийн нутаг байж болно. Энэ тэнхлэгийн дагуу жимс, ногоо боловсруулах, мал аж ахуйн зарим бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл байршина. Хоёр талын уулын ашигт малтмалыг боловсруулах зарим үйлдвэрлэл ч байж болох талтай. Улаанбаатараас тал тал тийшээ хандсан тэнхлэгүүд байх нь бөөгнөрлийг задлах, хүн амын ядуу хэсэгт үйлдвэрлэл эрхлэх боломж олгох, хотын хүнсний хангамж, чанарыг сайжруулах зэрэг олон сайн талтай. Хөгжлийн төв, тэнхлэг байгуулахдаа Алтайн өвөр говийн нутаг, Халх гол мэтийн алслагдмал боловч суурьшилтай, үйлдвэрлэлийн боломжтой газруудыг дотогш нь холбох нь чухал.

**Уул уурхайг зохистой эрхлэх зарчим.** Юуны өмнө олборлолтыг хавтгайруулахгүй байхыг эрхэмлэх. Гүнзгий боловсруулалт хийх чадваргүй байгаа үедээ газар сайгүй онгичих, сорчлох, түүхий эдийг хямд зарах, байгаль орчин сүйтгэх зэрэг үндэсний баялагийг тарамдуулсан үйл ажиллагааг зогсоох. Тодорхой цөөн тооны ордод олборлолт хийж малчин ардын "сур үйлдвэрлэх" аргыг зарчим болгож эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх. Үндэсний нээлттэй хувьцаат компаниудыг энэ салбарт байгуулах.

**Том аж ахуйн нэгжийг буй болгох зарчим.** Аливаа улс орон дэлхийн ядахдаа бүс нутгийн өрсөлдөөнд тэсэж хөл дээрээ зогсох чадвартай том аж ахуйн нэгж буй болгож хөгжүүлэхэд анхаарч тэдгээр нь улсын хөгжлийн гол зүтгүүр болж байна. Манай улс ч ийм бодлогыг баримтлах хэрэгтэй. Ийм бодлогыг хэрэгжүүлэх гол арга нь том аж ахуйн нэгжүүдэд дангаар нь болон хорших байдлаар стратегийн ордыг үе шаттайгаар ашиглах боломж олгох, тэдгээрийг нүүрс, зэс, газрын ховор элемент гэх мэтээр ашигт малтмалын янз бүрийн төрлөөр мэрэгшүүлэх явдал байж болох юм.

**Хүний хөгжлийг улсын хөгжлийн шаардлагатай уялдуулах зарчим.**Хүний хөгжил, хүн төвтэй хөгжил гэх мэт яриа нь бодлого, үйл ажиллагаатай уялдахгүй, сонсоход чихэнд чимэгтэй сайхан үг байсаар байвал ямар ч үр дүн гарахгүй. Хүнийг хөгжүүлэх зорилгыг одоогийн нөхцөлд юуны өмнө:

- хүн хөгжлийн хэрэгцээнд нийцсэн соёлтой болох
- хүн эрүүл мэндээ хамгаалж сурах, түүнд нь улс туслах
- хүн улс орны эдийн засаг-үйлдвэрлэлийн өнөөгийн болон дунд хугацааны хөгжлийн хэрэгцээнд нийцсэн боловсролтой болох

- шинээр бий болж байгаа болон ойрын ирээдүйд бий болох мэргэжлээр сургалт явуулах, мэргэжилтэн бэлтгэх гэсэн дөрвөн зүйлээр илэрхийлж болох юм.

Нэг дэх зорилгын хүрээнд хүн хөдөлмөрч, арвич хямгач, сахилгатай, хуримтлуулагч, хууль ёсыг сахигч болоход түлхэц үзүүлэх бодлогыг зориуд, зорилготой хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Хүний эдгээр болон үүнтэй төстэй шинж чанаруудыг эзэмшихгүйгээр хөгжих боломж байхгүй юм.

Хоёр дахь зорилгын хүрээнд хүн амд эрүүл мэндийн соёл эзэмшүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэх, хүн амыг өндөр чанартай хүнсний ногоогоор хангах ажлыг юуны өмнө хийх.

Гуравдахь зорилгын хүрээнд дэлхийн төвшний боловсрол гэх мэт хийсвэр зүйл ярихгүйгээр улсын хөгжлийн стратеги, тэргүүлэх зорилтуудыг хангахад ямар чиглэлийн, ямар төвшний мэрэгжил, ур чадвартай мэрэгжилтэн хэрэгтэй байгааг салбар бүрээр тодорхойлж, улсын болон хувийн сургуулиудын хүч хөрөнгийг чиглүүлэх, сургуулиудыг мэрэгшүүлэх, тэргүүлэх зэргийн багш, судлаачдыг бодитойгоор урамшуулах, үйлдвэрлэл, боловсрол, шинжлэх ухааныг импорт орлох болон экспортын тодорхой бүтээгдэхүүн, мал аж ахуйн техник тоног төхөөрөмж бий болгох гэх мэтээр тодорхой хугацаанд хэрэгжүүлэх зорилготой ажиллуулах. Эл зорилтын хүрээнд нийгэмд мэдлэгийн эрэлт бий болгох хэрэгтэй байна. Үүнийг төр засаг өөрөө эхэлж аливаа шийдвэр, бодлогыг гаргахдаа эрдмийн хамт олонд урьдчилан захиалга өгч судалгаа хийлгэх, үнэлэлт дүгнэлтэд нь тулгуурлах хэрэгтэй юм.

**Институцийн чадавхийг оновчтой бүрдүүлэх зарчим.** Манай орны институцийн одоогийн байдал нь хоёр үндсэн шинжээр тодорхойлогдож байна. Үүнд нэгд, зохион байгуулалт ажлын арга барил зэрэг нь ерөнхийдөө өнгөрсөн үед бий болсон туршлагатаа шүүмжлэлгүйгээр хуулбарласан шинжтэй, хоёрт, авлигажсан шинжтэй. Тийм учраас институцийн чадавхийг сайжруулах нь улсын хөгжлийн маш чухал хэрэгцээ юм. Институцийн чадавх сайжруулах юмуу бий болгох гэдэг нь биет болон биет бус хоёр гол хэсгээс бүрддэг. Биет хэсэг буюу байгууллагыг сайжруулах нь хамгийн хялбар хийх ажил юм. Харин биет бус хэсэгт нь мэдлэг, ур чадварыг сайжруулах болон процедурыг оновчтой болгох гэсэн гол зүйлс багтана. Манай орны хувьд биет бус хэсэг нь хөгжлийн хэрэгцээнээс маш их хоцорч байна. Европын болон Азийн зарим орнуудад хаант гэх мэт хүчтэй засаглалын цэгцтэй бодлого болон ямар нэг хэмжээний дарангуйллын дор институц нь хөгжсөн юм. Харин манай орны хувьд эрх чөлөөг хязгааргүй тунхагласан нөхцөлд уг ажлыг хийх гэж оролдож байна. Энэ нь институцийн чадавхийг сайжруулах нь аль ч асуудлыг жижиг гэж орхихгүйгээр хийх маш их чимхлүүр ажил юм. Тиймээс энэ асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгуулж болох юм. Институцийн чадавх бүрдүүлэх асуудлын ач холбогдол, хийх ажлын агуулга, цар хүрээг ойлгохгүй байгаагаас яам байх хэрэгцээг үгүйсгэх нь их уршигтай байна.

**Улс төрийн өрсөлдөөнт хамтын ажиллагааг мөрдлөг болгох зарчим.** Хөгжлийн асуудлаар зохион байгуулагдаж байгаа уулзалт, зөвлөгөөн дээр ярьж байгаа зүйлээс дүгнэлт хийвэл "бүх зүйл улс төрөөс болоод бүтэхгүй байна" гэсэн сэтгэгдэл төрж байгаа юм. Бодлого байхгүй, бодлого тогтвортой бус, залгамж холбоогүй, ээлжлэн эрх барьж бий

намууд бие биенийхээ бодлогыг үгүйсгэдэг гэх мэт. Гэтэл нөгөө талаас намуудын боловсруулсан бодлогыг ажиглахад ерөнхийдөө ижил байдаг. Ийм байхаас ч өөр арга байхгүй. Учир нь манай бодит байдал, ард түмний хэрэгцээ, нутаг дэвсгэр, уур амьсгалын онцлог, урдаа барьдаг баялаг, түүх соёл маань яах ч аргагүй ижилдүү зүйлийг л бодоход хүргэж байгаа юм. Жаахан дэгсдүүлж яривал сүүлийн үед "дөрвөн жил эрх бариад л дараачийн дөрвөн жил нь шоронд суудаг болж магадгүй онигооны" байдал үүсэх янзтай.

Өнөөгийн дэлхий ертөнцийн байдал, хөгжлийн чиг хандлагыг үзвэл дэлхий хоёр туйлд хуваагдан байсан үеийн улстөрийн сэтгэлгээ хуучирч, цаашид шинэ үзэл санааг эрэлхийллэх шаардлага тулгарч байна. Ийм эрэл хайгуулын үндсэн зарчим нь ямар нэг номлолыг хэрэгжүүлэх, тэр номлолын дагуу ийм тийм байдаг гэж ярихаас илүү яавал бидэнд ашигтай вэ гэдэг асуултанд хариулт шийдэл олох л чухал юм. Дэлхий маш түргэн өөрчлөгдөж байгаа ба өнөөгийн байдлаар удахгүй гэдгийг ухамсарлах хэрэгтэй юм. Хөгжихийн тулд үндэсний хөтөч үзэл, үндэсний эрхэмлэлтэй байх учиртай. Монгол Улсын түүхэн уламжлалыг үзвэл тус улсын оршин тогтнож өдий хүрэхэд нөлөөлсөн таван эрхэмлэл байна хэмээн үзэж байна. Тухайлбал, хүнээ дээдлэх, уламжлалаа дээдлэх, төрөө дээдлэх, байгаль орчин, эх нутгаа дээдлэх, малаа дээдлэх зэрэг юм.

Орчин үед ч эдгээрийн ач холбогдол өндөр хэвээр байгаа ба шинэ нөхцөлд шинэ агуулгаар баяжуулан баримталбаас хөгжлийн хөтлөгч үзэл болох бүрэн боломжтой юм. Эцэст нь нэгэнт бид улсын хөгжлийн талаар ярьж байгаа болохоор хөгжилтэй улс гэж ямар улсыг хэлэх вэ гэдэг талаар саналаа хэлье. Одоо үед улсын хөгжил гэдгийг шинээр томьёолох хэрэгтэйг юуны өмнө тэмдэглье. Дайны аюул, байгалийн гамшиг, бохирдол, терроризм, эмчлэгдэшгүй өвчиний дэлгэрэлт, хүмүүн төрөлтний ёс суртахууны уналт, сэтгэцийн өвчин гэх мэтийн өмнө дэлхийн улс түмний хүчтэй нь ч, хүчгүй нь ч чадал мөхөсдөж байна. Ийм нөхцөлд хөгжсөн гэж ярих нь учир дутагдалтай бөгөөд хөгжил хэмээх ойлголтын агуулгыг ядууруулж буй хэрэг болно.Тиймээс хөгжсөн улс гэдэг бол хүн ардынхаа эрсдэлгүй аж төрөх нөхцлийг бүрдүүлсэн улсыг хэлнэ хэмээн хамгийн ерөнхий байдлаар томьёолж болох юм.Зөв явбал Монгол Улсад ийм хөгжсөн улс болох бололцоо бий гэдэгт итгэж байна.

Гурав. Бид энэхүү матрицын судалгаандаа "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол/, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /УИХ-ын тогтоолын төсөл/, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ-ын тогтоолын төсөл/ зэрэг бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа холбоо, нийцлийг хүснэгтээр түүвэрлэн авч, харьцуулалт хийхийг зорив.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд:

- "**Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого**" гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, засаглалын хөгжлийг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн урт хугацааны зорилго, зорилт, хүрэх

үр дүн, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг тусгасан баримт бичгийг; ...30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх "Алсын хараа" нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байна.

- "**Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл**" гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн **бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн**, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан төлөвлөсөн үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг;
- **"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"** гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтод нийцсэн, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг тус тус хэлнэ гэж заажээ.

Төлөвлөлтийг хийхдээ үндэсний, салбарын, бүс нутгийн төлөвлөлтийн зорилгыг тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлэх, тэдгээр зорилго, зорилтыг биелүүлэхэд дэмжлэг болж өгөх хөтөлбөрийг боловсруулахдаа нөөцийг хуваарилах замаар төлөвлөх ба дор дурдсан тэргүүн туршлагын зарчмуудыг чухалчилдаг. Үүнд:

- *Нэг ижил нэр томьёо хэрэглэх:* Төлөвлөлтийн үйл явцад нэг ижил, товч тодорхой нэр томьёо хэрэглэж, тэдгээрийн талаар нэгдсэн ойлголттой байх явдал чухал бөгөөд энэ нь мөн хяналт үнэлгээ хийх үйл явцыг хөнгөвчилнө.
- *Төлөвлөлтийн үе шатууд хоорондоо уялдаатай байх:* Урт, дунд, богино төлөвлөлтийг бэлтгэхдээ үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг суурь болгож, уялдуулна.
- *Төлөвлөлт, гүйцэтгэл хоёрыг тэнцвэртэй байлгах:* Төлөвлөлтийн баримт бичгүүд хоорондоо давхардаагүй байх бөгөөд төлөвлөлтийн үйл явц бүрт хэрэг гүйцэтгэлийг байнга дүгнэж байх хэрэгтэй байдаг байна.

"Алсын хараа 2050" урт хугацааны баримт бичиг болон бусад дунд хугацааны баримт бичгүүдийг харьцуулан үзэхэд:

- Дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэл нь тодорхойгүй, бусад зорилтуудаас ялгарахгүй хэт ерөнхий байна.
- Эдгээр баримт бичгүүдэд нэгдсэн нэг нэр томьёо, нэршил ашиглаагүйгээс ойлголтын зөрүүтэй байдал ажиглагдсан.
- Бүтцийн хувьд Алсын хараа-2050, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл тус бүр 9 бүлэгтэй байхад Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6 бүлэгтэй бөгөөд бүлгүүд нь салбараар хуваагдсан байна. Алсын хараа-2050, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан зорилтод хүрэх үйл ажиллагаануудыг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт салбаруудад салгаж оруулсан нь урт хугацааны баримт бичгийн зорилт хангагдаж байгаа эсэхийг тодорхойлоход хүндрэлтэй, зайлшгүй авах арга хэмжээнүүд салбар дунд орхигдох магадлалтай билээ. Судалгааг харьцангуй богино хугацаанд хийсэн тул зөвхөн техник харьцуулалт хийсэн болно.

## “АЛСЫН ХАРАА-2050” УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ТӨСӨЛТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

<table>
<tr><td colspan="2">Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого<br>/УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол/</td><td>Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл<br>/УИХ-ын тогтоолын төсөл/</td><td>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br>/УИХ-ын тогтоолын төсөл/</td></tr>
<tr><td>Зорилго, зорилт, хүрэх үр дүн</td><td>Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</td><td>Зорилго, зорилт, хүрэх үр дүн</td><td>Үйл ажиллагаа</td></tr>
<tr><td colspan="2">НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ</td><td>НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зорилго 1. Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “эх хэл, эх түүх, өв соёлыг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно.</td><td>Зорилго 1. Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, эх түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.</td><td></td></tr>
<tr><td colspan="2">ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ<br>Зорилт 1.1.Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна.</td><td>ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ<br>Зорилт 1.1.Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ.</td><td>Үндэсний бахархал, өв соёл<br>Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.<br>(“2.Хүний хөгжил” хэсгээс)</td></tr>
<tr><td>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн<br>I үе шат (2021-2030): Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлэх үе.<br>1.Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзэл, үндэсний эв нэгдэл сэргэнэ.<br>2.Өв тэгш, үндэсний ухамсарт эх оронч монгол хүнийг төлөвшүүлнэ.</td><td>1.1.1.Улс, үндэстний эх орон, газар нутаг, тусгаар тогтнолоороо бахархах үзлийг сэргээж, монголчуудын уламжлалт төрт ёсны үзэл, сургаалыг орчин үед нийцүүлэн хөгжүүлж эх оронч үзэл, үндэсний эв нэгдлийг төлөвшүүлнэ.<br>1.1.2.Монголын түүхэн их удирдагчдын намтар, төрт ёсны уламжлал судлалыг нийтэд түгээх замаар үндэсний бахархлыг бэхжүүлж, Чингис хааны тахилгыг сэргээнэ.<br>1.1.3.Газар усны нэрийг эх байдлаар нь</td><td>• Уран бүтээл, утга зохиолд үндэсний бахархлыг сэргээх агуулгыг тусгаж Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзлийг сэргээнэ.<br>• Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болсон байна.</td><td>1.Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна. (“2.Хүний хөгжил” хэсгээс) Үүнд:<br>• “Чингис хаан” хаад, язгууртны музейн шинэ барилга, бусад түүхэн газар нутагт баригдах бүй цогцолборууд;<br>• Байгалийн түүхийн музейн шинэ барилга;<br>• “Чингис хаан” хаад, язгууртны музейн шинэ барилга, бусад түүхэн газар нутагт баригдах бүй цогцолборууд;<br>• Байгалийн түүхийн музейн шинэ барилга;<br>• Үндэсний номын сангийн шинэ барилга;<br>• Үндэсний урлагийн их театрын шинэ барилга;<br>• Үндэсний археологи, палеонтологи, угсаатны зүйн музей, лаборатори;<br>• Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв”;<br>• Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театр;</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| 3.Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд үндэсний онцлог, соёлын хүрээг өргөжүүлнэ.<br>4.Түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээл, утга зохиолд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээж, биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, өвлүүлж хэвшинэ. | хэрэглэж, өөрөөр нэрлэгдэх болсон нэрүүдийг эх сурвалжид тулгуурлан хуучнаар нь сэргээж, тахилгат уул, ус, газар нутгийн уламжлалт зан үйлийг эх байдлаар нь сэргээнэ.<br>1.1.4.Үндэсний уламжлалт баяр наадам, цагаан сарыг тэмдэглэхдээ үндэсний ижилслийг баталгаажуулах бэлгэдлийн өдрүүд болгон хэвшүүлнэ.<br>1.1.5.Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааны дүрэм, журмыг үндэсний онцлогт нийцүүлэн шинэчилнэ.<br>1.1.6.Үндэсний археологийн хөгжлийг дэмжиж, үнэт зүйлсийг хадгалан, эртний Хархорум хотын туурь тэргүүтэй дурсгалуудыг сэргээн бэхжүүлж, археологи, палеонтологи, угсаатны зүйн чиглэлээр төрөлжсөн музей, сан, судалгааны төвүүд байгуулна.<br>1.1.7.Үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулан сурталчилна.<br>1.1.8.Үндэсний сонгодог урлагийн дэг сургууль буюу заах арга зүйг магадлан итгэмжлүүлж баталгаажуулан монголын үндэсний сонгодог урлаг хэмээн дэлхийд танигдах бүтээлийг дэмжинэ.<br>1.1.9.Монгол Улсад түүх, соёлын өвийг | • Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд үндэсний онцлогийг шингээсэн агуулгаар баяжуулсан байна.<br>• Соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлсэн байна.<br>• Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байна. | • Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.<br>**2**.Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлнэ. Үүнд:<br>• “Цахим соёл” хөтөлбөр;<br>• “Бүх нийтийн соёлын боловсрол” хөтөлбөр;<br>• “Сонгодог урлаг-III” хөтөлбөр;<br>• “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” хөтөлбөр;<br>• “Монгол өв ба дэлхий дахин” олон улсын хөтөлбөр.<br>**3.**Соён гэгээрлийг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инноваци шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацийн салбарыг |

| | | | |
|---|---|---|---|
| 5.Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байна. | сүйтгэгчидтэй хийх тэмцлийг орон даяар өрнүүлж, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлнэ.<br>1.1.10.Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ хийж, дурсгалт газруудыг хамгаалж, газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгэнэ.<br>1.1.11.Музейн үзмэр, эд өлгийн зүйл, урлагийн бүтээлийг бүртгэлжүүлж, даатгалын үнэлгээгээр үнэлнэ.<br>1.1.12.Археологийн үнэ цэнтэй дурсгалт газрын хамгаалалтын зэрэглэл, ангиллыг шинэчилж, соёлын өв харгалзагч эзэнтэй болгоно.<br>1.1.13.Археологийн дурсгалт газар, шашны үйл явдалд үндэслэсэн үйл ажиллагаа, фестивалийг бий болгож, палеонтологийн үнэт зүйлсийг тусгай сонирхлын үнэ цэнтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно.<br>1.1.14.Дэлхийн болон монгол сонгодог зохиолууд, үндэсний онцлогтой утга зохиолын бүтээлүүдээс бүрдсэн бичил номын сан, гэрийн номын сантай болгох аян өрнүүлж хүүхэд залууст заавал унших ном, сонсох подкаст, үзэх кино, цахим хуудас бий | | хөгжүүлж, Монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. Үүнд:<br>• Олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ;<br>• Үндэсний агуулгатай инноваци шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна;<br>("2.Хүний хөгжил" хэсгээс) |

| | | | |
|---|---|---|---|
| | болгоно. 1.1.15.Хүн амын нягтаршил, бүс нутгийн онцлогтой уялдуулан соёл урлагийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгон, барилга байгууламжийг барьж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. 1.1.16.Үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулах цуврал бүтээлч үйл ажиллагааг улсын болон хувийн номын сангуудад түшиглэн зохион байгуулна. 1.1.17.Үндэсний сонгодог урлагийн дэг сургуулийг баталгаажуулах чиглэлээр уртын дуу, морин хуур, хөөмий, бий биелгээ, цуур зэрэг хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлнэ. 1.1.18.Сонгодог урлагийн нэн шаардлагатай мэргэжлээр олон улсын нэр хүндтэй сургуульд мэргэжилтэн бэлтгэж, суралцуулна. 1.1.19.Соёл урлагийг хүүхэд, залуучууд, бүх нийтэд түгээн дэлгэрүүлэхэд шаардлагатай театр, чуулга, соёлын ордны барилгыг шинээр барьж, тоног төхөөрөмжийг шинэчилнэ. 1.1.20.Үндэсний агуулга бүхий урлагийн шинэ урсгал бүтээгч залуу уран бүтээлчдийн санал, | | |

| | | | |
|---|---|---|---|
| | санаачилгыг дэмжиж, үндэстний орчин цагийн бүтээлийн өнгө төрхийг тодорхойлно. | | |
| **НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ**<br>**Зорилт 1.2.**Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно. | | **НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ**<br>**Зорилт 1.2.**Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br>**I үе шат (2021-2030):** Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх үе.<br>1.Хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэнэ.<br>2.Нүүдлийн соёл иргэншлийг хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудтай болно.<br>3.Үндэсний сор бүтээл, брэнд, үндэсний шинэлэг бүтээл зэргийг монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээнэ.<br>4.Хүүхдийн соёлын өв, хөгжлийн төвийг байгуулна. | 1.2.1.“Гэр бүл-монгол соёлын анхдагч орчин” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж, “Монгол хүүхэд”, “Монгол гэр бүл”, “Монгол төрийн гэр бүлийн талаарх бодлого” гэсэн гуравласан холбоог үүсгэж, гэр бүлийн гишүүдийн харилцан хүндлэл, ажил үүрэг, түүний дотор эцэг эхийн үүргийн тэгш хуваарь, эх хүүхдийн халамж, хамгааллын үнэт зүйлсэд суурилсан уламжлалт ёсыг хадгална.<br>1.2.2.“Өөрсдийн язгуур соёл, түүний өвөрмөц илрэлийг аяллын бүтээгдэхүүн болгохдоо ойлгомжтой, хүртээмжтэй, өөриймсөг, жинхэнэ мөн чанараар нь хүргэхийг урьтал болгож, түүндээ санхүү, эд материал, хүн хүчний нөөцийг хангалттай зориулж, үндэсний соёлыг гайхан бишрэн, хүндлэх хандлагыг бий болгох” гэсэн гол өгөөжийг бүтээх, ялангуяа дотоодын жуулчдад үндэсний өв соёл, нүүдлийн ахуйдаа суралцах, түүгээрээ бахархах үзэл төлөвшүүлж, | • Өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц шат дараатай арга хэмжээ авсан байна.<br>• Нүүдлийн соёл, иргэншлийг судалгааны төв байгуулах ажлыг эхлүүлсэн байна.<br>• Үндэсний сор бүтээл, брэнд, үндэсний шинэлэг бүтээл зэргийг монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээнэ.<br>• Хүүхдийн соёлын өв, хөгжлийн төвийг байгуулах ажлыг эхлүүлсэн байна. | • Нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлж, бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадвар бүхий Монгол брэндийг бий болгож соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ;<br>(“2.Хүний хөгжил” хэсгээс) |

| | | | |
|---|---|---|---|
| | соёлын дархлааг нь дэмжинэ.<br>1.2.3.Боловсролын сургалтын хөтөлбөрт нүүдэлчин ахуй, зан заншил, өв соёлын агуулгыг тусгаж, бүх шатны боловсролын байгууллагын суралцагчдад үндэсний өв соёл, уламжлалт наадгайн төрлийн мэдлэг, чадвар эзэмшүүлнэ.<br>1.2.4.Хүүхэд, залуучуудын театр, Хүүхэлдэйн театр, номын сан, кино театр, дугуйлан, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх хүүхдийн хөгжлийн төвүүдийг дэмжиж, шаардлагатай тоног төхөөрөмж, номын хөмрөг, хувцас хэрэглэлээр хангана. Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.<br>1.2.5.Үндэсний ижилсэл, соёлын дархлаатай монгол хүнийг бэлтгэхэд чиглэсэн өв соёлын өргөө, соёлын төвүүд, үндэсний спортын дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжиж, соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгосон бүлэг, хамт олон, өвлөн уламжлагчдыг дэмжиж урамшуулах тогтолцоог бий болгоно.<br>1.2.6.Улс орон даяар үнэт зүйлс, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр гарсан судалгааны үр дүнгээр зорилтот | | |

| | | | |
|---|---|---|---|
| | нэвтрүүлгийн эзлэх хувийг нэмэгдүүлж, үндэсний хэмжээний цуврал лекц, ярилцлага зохион байгуулагчдыг төрөөс дэмжинэ.<br>1.2.7.“Дэлхийн нүүдлийн соёл, иргэншлийн голомт” байгууллагыг байгуулж, дэлхийн нүүдэлчдийн төв болох цогц хөтөлбөрийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.<br>1.2.8.“Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-г бүс нутгийн онцлогт тохируулан байгуулах буюу Говийн бүсэд палеонтологийн задгай музей, Хангайн бүсэд археологийн хотууд (Хүннүгийн язгууртны, буган хөшөөний цогцолбор, Өглөгчийн хэрэм, Аваргын балгас гэх мэт), Хөвсгөл, Тайгын бүсэд цаатны отог, дархад бөөгийн отог, Даян дээрхийн агуйн цогцолбор, Монголын эзэнт гүрний түүх, нүүдэлчдийн өв соёлын онцлогтой “Нүүдэлчин” олон улсын түвшний кино үйлдвэрлэлийн төвийг тус тус байгуулах ба тэдгээрийг дагасан аялал, жуулчлалын хөтөлбөрүүд бий болгож хөгжүүлнэ.<br>1.2.9.Улаанбаатар хотын хурдны тойрог замын дагуу “Соёл, урлагийн цогцолбор”, Монгол багт бүжгэн жүжгийн театр байгуулах, энэ төрлийн бүжгэн | | |

| | | | |
|---|---|---|---|
| | жүжгийн цомнол, бүтээлүүд бий болгох, урлагийн сургалт, уран бүтээлийг үндэсний өв, соёлд түшиглэн орчин цагийн бүтээл хөгжүүлэх, судалгааны инкубатор төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.<br>1.2.10.Соёлын үйлдвэрлэл, бүтээлч аялал жуулчлалыг монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан нутагшуулж, үндэсний загвартай болох, үндэсний үнэт зүйлийг бүтээх, хадгалах, хамгаалах, аялал жуулчлалын эргэлтэд оруулахад зориулсан мэдээллийн систем, цахим технологи нэвтрүүлнэ. | | |
| **ЭРДЭМ СУДЛАЛ-НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ**<br>**Зорилт 1.4.**Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон монголын түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн соёл иргэншил, шашин, гүн ухааны судалгааг хийж нийтийн хүртээл болгон хэвшүүлж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ. | | **ЭРДЭМ СУДЛАЛ-НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ**<br>**Зорилт 1.4.**Үнэт зүйлийн болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааг салбар бүрээр хийж, нийтийн хүртээл болгоно. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br>**I үе шат (2021-2030):** Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлүүдийн судалгааг салбар тус бүрээр гүнзгийрүүлэн хийж, нийтийн хүртээл болгох үе. | 1.4.1.Соёл судлал, соёлын ажилтны хөгжлийг дэмжиж мэргэжлийг нь дээшлүүлнэ.<br>1.4.2.Монгол хэл шинжлэлийн түүхэн судалгаа хийж, монгол хэлний эрдмийн хэл зүй бичнэ.<br>1.4.3.Үндэсний утга зохиол, ном судар, баримтат өвүүдийг бүртгэн, | • Үнэт зүйлийн судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, мэдээллийн сан бий болгож, судалгааны эргэлтэд оруулсан байна.<br>• Олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлж, | **4.**Хэвлэл мэдээллийн салбарыг үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх чиглэлээр хөгжүүлнэ.<br>(“2.Хүний хөгжил” хэсгээс) |

| | | | |
|---|---|---|---|
| 1.Үнэт зүйлийн суурь, хавсарга болон гүнзгийрүүлсэн судалгаа тогтворжсон байна.<br>2.Судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, судалгааны эргэлтэд оруулсан байна. | цуглуулагчдыг алдаршуулж урамшуулна.<br>1.4.4.Алтайн төрөл хэлнүүд ба монгол хэл, аялгуунуудын харьцуулсан иж бүрэн судалгаа хийж олон нийтийн хүртээл болгоно.<br>1.4.5.Археологи, палеонтологийн судалгааг үнэт зүйлийн судалгааны тэргүүлэх чиглэл болгож, үндэсний хэмжээний судалгааны төслийг хэрэгжүүлнэ.<br>1.4.6.Монгол хүний ёс суртахууны хэм хэмжээний талаарх судалгааг өргөжүүлэн хүүхэд залуус, төрийн албан хаагч, хууль, хүчний байгууллагын ажилтны ёс суртахууны нарийвчилсан судалгааг хийнэ.<br>1.4.7.Монгол Улсын түүхийн судалгааг гүнзгийрүүлэн, өмнө судлагдсан түүхийн бүтээлүүдийг нийтэд таниулан, Монгол Улсын нэгдсэн түүх бичиж хэвлүүлнэ.<br>1.4.8.Дэлхийн номын сангууд болон угсаатны зүйн музей, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хүмүүст хадгалагдаж байгаа бичгийн дурсгал, түүхэн сурвалж бичгийн өвийг бүртгэж мэдээллийн сан бүрдүүлж, эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулна.<br>1.4.9.Тахилгат уул ус, газар нутгийг олж тогтоох, тухайн тахилгат газарт хэрэглэдэг сан судар, | нийтийн хүртээл болгосон байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | түүх домог, холбогдох уран бүтээл, эдлэл хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж тогтооно.<br>1.4.10.Монголын төрт ёсны түүхтэй холбоотой Хүрэл ба түрүү төмрийн үе болон Хүнну, Сяньби, Монголын эзэнт гүрний үед холбогдох археологийн малтлат судалгааны үндэсний төсөл хэрэгжүүлнэ. | | |
| **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ** | **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ** |
| **Зорилго 2.**Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгааллалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ. | | **Зорилго 2.** Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ. | |
| БОЛОВСРОЛ<br>**Зорилт 2.1.**Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. | | **БОЛОВСРОЛ**<br>**Зорилт 2.1.** Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, мэдлэг, ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж төлөвшүүлнэ. | Боловсрол<br>**Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, мэдлэг, ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж төлөвшүүлнэ.** |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br>**I үе шат (2021-2030):** Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе.<br>1.Салбарын хүрээнд судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын | 2.1.1.Боловсролын чиглэлээр суурь болон хавсарга судалгааг тогтмол хийж хэвших ба бүх шатны боловсролын сургалтын байгууллагын байршил, хүчин чадал, нөөц, нормативын нэгдсэн зураглал, судалгаа, шинжилгээний мэдээллийн санг бий болгон, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын | • Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангасан байна.<br>• Ерөнхий боловсролын сургалтын чанарын үндэсний үнэлгээг жил бүр хийж, олон улсын үнэлгээнд хамруулсан байна.<br>• Монголын түүх, хэл соёл, зан | **1.**Яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.<br>**2.**Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.<br>**3.**Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.<br>**4.**Монголын түүх, хэл соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шудрага ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд |

| | | | |
|---|---|---|---|
| тогтолцоо болон олон талт түншлэл бэхэжсэн байна.<br>2.Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлсэн байна.<br>3.Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана.<br>4.Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, хэрэглэж хэвшсэн байна.<br>5.Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсэн байна.<br>6.Олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг дээд боловсролын тогтолцоотой болсон байна | тогтолцоог сайжруулна.<br>2.1.2.Боловсролын мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан эрх, үүргийн оновчтой хуваарилалт хийж, олон талт түншлэлийг дэмжинэ.<br>2.1.3.Мэргэжлийн холбоодтой хамтарч ажиллах, түншлэлийг бэхжүүлэн зарим төрлийн үйл ажиллагааг мэргэжлийн холбоодод шилжүүлж, бие даасан хараат бус үйл ажиллагаа явуулах зохицуулалт хийнэ.<br>2.1.4.Сургалтын байгууллагын санхүүжилтийг төгөлдөржүүлэн, суралцагч нэг бүрийг амжилттай суралцахад чиглүүлнэ.<br>2.1.5.Боловсролын мэргэжлийн байгууллагуудын дэргэд түшиц сургалт судалгаа, инновацын нэгжүүдийг бий болгож ажил олгогч, мэргэжлийн холбоод, эрдэмтэн багш, судлаачдын түншлэлийг бэхжүүлнэ.<br>2.1.6.Төрөөс хараат бус бие даасан хүний нөөцийн бодлогын үндэсний зөвлөл байгуулан салбар бүрийн мэргэжлийн холбоодтой хамтран мэргэшлийн үндэсний хүрээг тогтоож, хэрэгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн нээлттэй нэгдсэн цахим мэдээллийн систем бий болгох, техник | заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлсэн байна.<br>• Их сургуулийн эрх зүйн зохицуулалтыг хийн, гадаадын зээл тусламжаар судалгааны их сургууль төслийг хэрэгжүүлж, ахисан түвшний сургалтад түшиглэсэн судалгааны их сургуулийг хөгжүүлсэн байна.<br>• Хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад сургалтын төлбөрийн бүрэн тэтгэлэг олгосон байна.<br>• Засгийн газрын тэтгэлгээр дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, хөдөлмөрийн зах зээлийн захиалгатай уялдуулан мэргэжлээр нь томилон ажиллуулдаг болсон байна.<br>• Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг | хэрэгжүүлнэ.<br>**5.**Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлнэ.<br>**6.**Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох “Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр” хэрэгжүүлнэ.<br>**7.**Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттай шилжүүлнэ.<br>**8.**“Чадварлаг багш” хөтөлбөр хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ.<br>**9.**Суралцагчдад ээлтэй сургалтын орчин бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ.<br>• 273 цэцэрлэг ашиглалтад оруулах;<br>• 200 шинэ сургууль ашиглалтад оруулах;<br>• Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх;<br>• Жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгох;<br>**10.**Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2 дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг "Үдийн хоол" болгоно.<br>**11.**Сургалтын цахим платформыг хөгжүүлж, онлайн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим контент, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| | мэргэжлийн болон дээд боловсролын бодлого тодорхойлоход шаардлагатай мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн санд нэгтгэн хөтөлж, хэрэглэж хэвшинэ.<br>2.1.7.Боловсролын байгууллагын бүх түвшинд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, өөрийн үнэлгээний тогтолцоог чанаржуулж, соёлыг бий болгоно.<br>2.1.8.Боловсролын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн хяналт шинжилгээг олон улсын жишиг аргачлалаар хийдэг тогтолцоонд шилжиж төрөөс хараат бус бие даасан институцийг бэхжүүлнэ.<br>2.1.9.Их, дээд сургууль, политехникийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургуулийг тухайн орон нутаг, бүс нутгийн хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлнэ.<br>2.1.10.Их, дээд сургууль, политехникийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн | бодитой болгож, нийгмийн баталгааг хангасан байна.<br>• Газар зүйн мэдээллийн системд үндэслэн сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хүртээмжийг нэмэгдүүлэн, тэгш байдлыг хангах тогтолцоог бэхжүүлсэн байна.<br>• Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хоёр дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" үйлчилгээг бүрэн нэвтрүүлсэн байна.<br>• Цахим, зайн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоон, сургалтын платформыг хөгжүүлэн багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлсэн насан туршийн тогтолцоог бэхжүүлсэн байна.<br>• Боловсролын удирдлагын мэдээллийн системийг бүх түвшинд хөгжүүлж, бусад салбарын мэдээллийн сантай холбон, бодлого, төлөвлөлт, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглан, боловсролын үйлчилгээг цахимжуулсан байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | төвүүд төгсөгчдийнхөө мэргэжил дээшлүүлэх асуудлыг хариуцдаг тогтолцоог бий болгож, насан туршийн боловсролын үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэн, насанд хүрсэн суралцагчдын ажил эрхлэх ур чадвар, амьдрах чадварын сургалтын хүрээнд төдийгүй шинэ чадвар эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр бий болгож хэрэгжүүлэхэд олон талт оролцоог хангана.<br>2.1.11.Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.<br>2.1.12.Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.<br>2.1.13.Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл | | |

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллагааг зохион байгуулна.<br>2.1.14.Цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 1-3, 4-6 настай хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын хэмжээг үндэслэн жил бүр шинэчлэн тогтооно. | | |
| ЭРҮҮЛ МЭНД<br>**Зорилт 2.2.**Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ. | | **ЭРҮҮЛ МЭНД**<br>**Зорилт 2.2.** Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ. | Эрүүл мэнд<br>**Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе.<br><br>1.Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо бэхжсэн байна.<br>2.Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна.<br>3.Эрүүл | 2.2.1.Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдэл, хөгжлийн бэрхшээл үүсгэж байгаа шалтгааныг тодорхойлж, хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог санхүүжилтийн аргатай нь уялдуулан бүрдүүлж, үйл ажиллагааг хэвшүүлнэ.<br>2.2.2.Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.<br>2.2.3.Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, тэдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, | • Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлсэн байна.<br>• Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулсан байна.<br>• Оношилгоо, | **1.**Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ:<br>• Идэвхтэй эрүүл амьдрал- цогц хөтөлбөр<br>• Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх<br>• Эх, хүүхэд, нөхөн үржихүйн цогц хөтөлбөр<br>**2.**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна:<br>• Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв<br>• Зүрх судасны үндэсний төв<br>• Сүрьеэгийн эмнэлэг<br>• Геронтологийн үндэсний төв<br>• Түлэнхийн төв<br>• Халдварт өвчин судлалын салбар эмнэлэг-II<br>• Хавдар судлалын үндэсний төвийн салбар эмнэлэг- II<br>**3.**Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.<br>• Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна.<br>• Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулах, техник тоног төхөөрөмжөөр хангана.<br>• Яаралтай тусламж үйлчилгээнд агаарын үйлчилгээг (Нисдэг тэрэг) нэвтрүүлнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдсэн байна.<br>4.Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулсан байна.<br>5.Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйл буурсан байна.<br>6.Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, нийт сумыг хамарсан алсын зайн үндэсний сүлжээг бий болгож, хүн амын дундаж наслалт уртассан байна.<br>7.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, зүрх, | сургалт, сурталчилгааны загвар төвийг нийслэл хотод байгуулна.<br>2.2.4.Аймаг, дүүргийн түвшинд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна.<br>2.2.5.Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлнэ.<br>2.2.6.Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага бүр ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамруулдаг соёлыг хэвшүүлнэ.<br>2.2.7.Урьдчилан сэргийлэх анагаах ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, төгсөлтийн өмнөх болон дараах онолын, дадлага сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож хөгжүүлнэ.<br>2.2.8.Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын | эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлсэн байна.<br>• Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхийг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийсэн байна.<br>• Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг хангаж, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулсан байна.<br>• Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлсэн байна.<br>• Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна.<br>• Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн | • Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ.<br>**4.**Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж эрсдэлийн сан байгуулна.<br>**5.**"Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглана.<br>**6.**Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.<br>**7.**Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. |

| | | | |
|---|---|---|---|
| судасны өвчлөлөөс болон хорт хавдраас шалтгаалсан нас баралт буурсан байна.<br>8.Товлолт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, вируст гепатитын өвчлөл, сүрьеэгийн тохиолдлыг бууруулсан байна.<br>9.Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурсан байна. | хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.<br>2.2.9.Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах, архи, тамхи, эм, чихэрлэг ундааны онцгой албан татварын тодорхой хувийг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ.<br>2.2.10.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.<br>2.2.11.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.<br>2.2.12.Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй "Үйлчлүүлэгч төвтэй" тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн | хамгааллыг сайжруулсан байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | байгууллагуудыг дэмжинэ. | | |
| ГЭР БҮЛ<br>**Зорилт 2.3.**Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ. | | **ГЭР БҮЛ**<br>**Зорилт 2.3.** Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих үе.<br><br>1.Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.<br>2.Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшлийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.<br>3.Залуу гэр бүлийг дэмжсэн орчин, нөхцөл бүрдэж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлнэ. | 2.3.1.Хүн амын төрөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.<br>2.3.2.Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана.<br>2.3.3.Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.<br>2.3.4.Орлогын тэгш бус байдлыг багасган нийгмийн суурь | • Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлсэн байна.<br>• Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлсэн байна.<br>• Залуу гэр бүлийг дэмжсэн орчин нөхцөл сайжирсан байна.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцлийг бүрдүүлнэ | **8.**Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүхий л бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.<br>("2.Хүний хөгжил" хэсгээс) |

| | | | |
|---|---|---|---|
| | үйлчилгээг тэгш хүргэж, нийгмийн зорилтот болон ялгаатай бүлгүүдийн эрх, тэгш оролцоог хангана.<br>2.3.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ.<br>2.3.6.Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.<br>2.3.7.Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ.<br>2.3.8.Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.<br>2.3.9.Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажил, ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. (эцэг эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнаас ажиллахыг дэмжих)<br>2.3.10.Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оюутны | | |

| | | | |
|---|---|---|---|
| | хөдөлмөрийн бирж" байгуулж хөгжүүлнэ.<br>2.3.11.Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийн мэдээллийн сан бүрдүүлж, тэднийг иргэний эрхээ эдлэх боломж, нөхцөлийг техник, технологийн ололтод тулгуурлан бүрдүүлж, эх орондоо чиглэсэн бизнесийн болон сайн дурын үйл ажиллагаа, судалгаа, шинжилгээ хийх, эх нутагтаа эргэн ирж ажиллаж, хөдөлмөрлөхөд дэмжлэг болохуйц эрх зүйн орчныг бүрдүүлж, цахим хөдөлмөрийн бирж, мэдээллийн систем ажиллуулна.<br>2.3.12.Залуу гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | | |
| ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦ<br>**Зорилт 2.4.**Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ. | | **ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦ**<br>**Зорилт 2.4.** Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болон хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлнэ. | Шинжлэх ухаан, технологи, инновац<br>**Шинжлэх ухаан, технологи, инновацын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.** |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай | 2.4.1.Төрөөс хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтыг бодлого, татварын орчноор дэмжинэ.<br>2.4.2.Хувийн хэвшлийн технологийн хөгжүүлэлтийг дэмжих тогтолцоо, бүтцийг оновчтой бүрдүүлж, хөтөлбөр | • Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг үе шаттай нэмэгдүүлсэн байна.<br>• Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний | **1.**Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлнэ.<br>**2.**Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нийгэм, эдийн засгийн хөгжилд өгч буй үр өгөөжийг шалгуур болгон санхүүжүүлдэг өрсөлдөөнт тогтолцоонд шилжүүлж, нэгдсэн, төрөлжсөн, нээлттэй лабораторийг байгуулан салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.<br>**3.**Шинжлэх ухаан, технологи, инновацын |

| | | | |
|---|---|---|---|
| үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлэх үе.<br><br>1.Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр-шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчин бүрдсэн байна.<br>2.Шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх дэд бүтцийг өргөжүүлж, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоотой болсон байна.<br>3.Эрдэм шинжилгээний ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцоог шинэчилж, чадварлаг эрдэмтдийг бэлтгэх үндэсний тогтолцоог бий болгож, олон улсын томоохон судалгаанд оролцох боломжийг нэмэгдүүлсэн байна. | хэрэгжүүлнэ.<br>2.4.3.Улс орны өмнө тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд эрдэм шинжилгээний болон үйлдвэрлэл, бизнесийн байгууллагын хөрөнгө оруулалтыг дэмжиж, грант төсөл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.<br>2.4.4.Шинжлэх ухаан, инновацын салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэл бий болгож, гадаадын дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлнэ.<br>2.4.5.Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын эрх зүйн орчныг шинэчилж, инновацын үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн тусгай зориулалтын сангуудыг байгуулна.<br>2.4.6.Мэдлэгийн үйлдвэрлэл дэх хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж, шинэ мэдлэг бий болгоход гаргасан зардлын тодорхой хэсгийг төрөөс нөхөн төлдөг тогтолцоотой болно.<br>2.4.7.Шинэ мэдлэгийг бүтээгдэхүүн, үйлчилгээ болон хэрэглээнд нэвтрүүлэхэд хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, грант олгоно.<br>2.4.8.Олон улсын түвшинд судалгаа | нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлого хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлсэн байна.<br>• Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нийгэм, эдийн засгийн хөгжилд өгч буй үр өгөөжийг шалгуур болгон санхүүжүүлдэг өрсөлдөөнт тогтолцоонд шилжүүлсэн байна.<br>• Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг татварын бодлого, эдийн засгийн хөшүүргээр дэмжсэн эрх зүйн шинэчлэлт хийгдсэн байна.<br>• Шинжлэх ухаан, технологи, инновацын дэд бүтцийг бий болгож, төрөлжсөн нэлттэй лабораторийг байгуулж, шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг ашиглалтад оруулсан байна.<br>• Эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг чадвар, бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын үнэлгээний жишигт нийцүүлж, үр дүнд тохирсон цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлсэн байна.<br>• Шинжлэх ухаан, технологи, инновацын | чиглэлээр шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартад нийцүүлнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| | хөгжүүлэлтийн ажил явуулахад шаардагдах материаллаг орчин, чанар, үйлчилгээний стандарт бий болгоно.<br>2.4.9.Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай шинжлэх ухааны парк, инновацын татваргүй бүсийг хамтын оффист түшиглэн байгуулна.<br>2.4.10.Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ.<br>2.4.11.Тоон технологи ашиглан мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чиглэсэн инновацын үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.<br>2.4.12.Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд суурилсан шагнал, урамшууллын тогтолцоог бий болгоно.<br>2.4.13.Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог бий болгоно.<br>2.4.14.Шинэ бүтээлийн эдийн засаг, нийгмийн ач | статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгосон байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | холбогдлыг үнэлэн, үр өгөөжийн тодорхой хувиар шагнах санхүүгийн тогтолцоог бүрдүүлнэ.<br>2.4.15.Шинжлэх ухаан, технологийн санг олон улсын адил төстэй сангуудын жишиг, хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөн зохион байгуулна.<br>2.4.16.Эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургуулийг сургалт, судалгаа хөгжүүлэлт, инновацын төв болгон хөгжүүлнэ.<br>2.4.17.Аж ахуйн нэгж, олон нийтэд инновац, гарааны бизнес эхлүүлэх боловсрол олгох, инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, технологи, танин мэдэхүйн төрөл бүрийн агуулга бүтээх ажлыг дэмжинэ.<br>2.4.18.Тэргүүлэх чиглэлээр судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхэлдэг эрдэм шинжилгээний ажилтны чадвар, бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын үнэлгээний жишигт нийцүүлж, үр дүнд тохирсон цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ.<br>2.4.19.Олон улсын жишигт нийцсэн докторын дараах судалгаа, сургалтын тогтолцоог бий болгон хөгжүүлнэ.<br>2.4.20.Эрдэмтэн, судлаачид олон улсын | | |

| | | | |
|---|---|---|---|
| | томоохон судалгаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, оролцоог дэмжинэ.<br>2.4.21. Оюуны өмчийн хараат бус, кодлогдсон технологийн дагуу бүртгэж эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлж, оюуны өмчийн зуучлал, зөвлөх үйлчилгээ, арилжааг хөгжүүлнэ. | | |
| ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН<br>**Зорилт 2.5.**Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана. | | **ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН**<br>**Зорилт 2.5.** Эрүүл баталгаат орчин бий болгоно. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Эрүүл баталгаат орчин бий болгох үе.<br><br>1.Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдөж, эрүүл баталгаат амьдрах орчныг бий болгоно.<br>2.Агаар, ус, хөрс, дуу чимээний бохирдлыг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчинтой болно.<br>3.Эрүүл мэндийн болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгож бэхжүүлнэ.<br>4.Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын | 2.5.1.Орон сууцны нэг хүнд ногдох талбайн хэмжээг нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ.<br>2.5.2.Орон сууцны чанар, стандартыг хангаан, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.<br>2.5.3.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.<br>2.5.4.Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.<br>2.5.5.Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ.<br>2.5.6.Ногоон байгууламжийн | • Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадвартай болж, хүнсний аюулгүй байдал хангагдана.<br>• Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг олон улсын түвшинд хүргэж, шинэчилсэн байна.<br>• Агаар, ус, хөрс, дуу чимээний бохирдлыг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлсэн байна.<br>• Эрүүл мэндийн болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгож бэхжүүлнэ.<br>• Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.<br>• Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар | |

| | | | |
|---|---|---|---|
| тогтолцоог бэхжүүлнэ.<br>5.Инновац нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж аюулгүй, тэжээллэг хэрэгцээт хүнсээр хангадаг болно. | усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.<br>2.5.7.Агаар орчны бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулна.<br>2.5.8.Агаар болон орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр болон хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.<br>2.5.9.Сайжруулсан түлш, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлж, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.<br>2.5.10.Хог хаягдлын цогц менежмент 3R-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах загвар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлнэ.<br>2.5.11.Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон бусад хот, суурин газрын ариутгах татуургын байгууламж, үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор өргөтгөж, шинэчилнэ.<br>2.5.12.Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг | хэрэгжүүлсэн байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | хэсэгчилсэн бие даасан инженерийн хангамжид холбох, бичил дэд төвүүдийг байгуулах төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.<br>2.5.13.Орчны эрүүл мэндийн үзүүлэлтийн шаардлага, стандарт, тохирлуудыг олон улсын стандартад ойртуулан тохируулж, шинэчилнэ.<br>2.5.14.Илчлэг, транс тос, чихэр, давсны агууламж өндөр хүнс, чихэрлэг ундааны үйлдвэрлэл, худалдааг татварын бодлогоор хязгаарлах, хүнсний аюулгүй байдлын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.<br>2.5.15.Үрийн сан, хөрс хамгаалалт, хөрс боловсруулалт, тариалалт, усалгаа, хураалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, жижиглэн худалдааг хамарсан төмс, хүнсний ногооны мөшгөлтийн мэдээллийн тогтолцоог бий болгон хүнсний аюулгүй байдлыг бүрэн хянана.<br>2.5.16.Малын бэлчээр, усалгаа, тэжээл, вакцин хэрэглээний аюулгүй байдлыг ханган үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, түүний хяналт мэдээллийн тогтолцоог бий болгоно.<br>2.5.17.Импортын хүнсний бүтээгдэхүүнийг шинжлэх, хяналтын лабораторийг байгуулж, | | |

| | | | |
|---|---|---|---|
| | чадавхжуулах, бүртгэлийн хяналтыг чангатгана.<br>2.5.18.Хүнсний боловсруулах үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо, хүнсний аюулгүй байдлын чанарын удирдлагын тогтолцоо, хүнсний хэлхээний (дамжлагуудын) хяналтын тогтолцоо, стандартыг нэвтрүүлнэ.<br>2.5.19.Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад хүргэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.<br>2.5.20.Органик, баяжуулсан, зохицуулах үйлчлэлтэй, инновац нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.<br>2.5.21.Хил дамнасан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт шинжилгээ хийх, лаборатори байгуулах, тандалт, хариу арга хэмжээний нөхцөлийг сайжруулна.<br>2.5.22.Өрхийн хүнсний баталгаат байдал алдагдахаас зорилтот, эмзэг | | |

| | | | |
|---|---|---|---|
| | бүлгийн хүн амыг хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг бэхжүүлнэ.<br>2.5.23.Малын эрүүл мэндийг хамгаалах Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | |
| **ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | | **ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | |
| **Зорилго 3.**Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ. | | **Зорилго 3.** Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ. | |
| НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БА ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ<br>**Зорилт 3.1.** Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ. | | **НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БА ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ**<br>**Зорилт 3.1.** Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ. | Хөдөлмөр, нийгмийн хамгаалал<br>**Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.**<br>("2.Хүний хөгжил” хэсгээс) |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх үе.<br><br>1.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.<br>2.Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.<br>3.Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, | 3.1.1.Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд даатгуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.<br>3.1.2.Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.<br>3.1.3.Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.<br>3.1.4.Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, | • Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.<br>• Иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болж, дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэлийг | **1.**Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.<br>**2.**Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.<br>**3.**Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэнэ.<br>**4.**Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.<br>**5.**Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлнэ.<br>**6.**“Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд |

| | | | |
|---|---|---|---|
| нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.<br>4.Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна.<br>5.Зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно.<br>6.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно. | санхүүгийн зах зээлийг дэмжинэ.<br>3.1.5.Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна. Нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ.<br>3.1.6.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно.<br>3.1.7.Тэтгэврийн нөөц санг ашигт малтмалын орд газрын орлогын өгөөж болон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлнэ.<br>3.1.8.Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.<br>3.1.9.Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ.<br>3.1.10.Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, үйлчилгээг зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ. | хийгдсэн байна.<br>• Нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болсон байна.<br>• Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.<br>• Нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн байна. | хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.<br>**7.**Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна.<br>**9.**Томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцүүлнэ.<br>**10.**Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангана.<br>**11.**Хүүхдийн мөнгийг тэдний хүнс тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх үйл ажиллагаа, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулдаг тогтолцоо бий болгоно. |

| | | | |
|---|---|---|---|
| | 3.1.11.Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг блокчейн технологид суурилан боловсронгуй болгож, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг сайжруулна.<br>3.1.12.Зорилтот бүлгийн өрхийг хөгжүүлэх, хамгаалах, тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх орон нутгийн онцлогт нийцсэн шинэ төрлийн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.<br>3.1.13.Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.<br>3.1.14.Эхний ээлжид эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтална.<br>3.1.15.Зорилтот бүлгийн өрхийн боловсролгүй, ажил эрхлээгүй өрхийн тэргүүлэгч, насанд хүрсэн гишүүдийг мэргэжилтэй ажилтан болгох бодлогын хүрээнд мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулна.<br>3.1.16.Сургуулийн бага ангид сурч байгаа зорилтот бүлгийн өрхийн хүүхдийн ном, сурах бичгийн түрээсийн тогтолцоо, эргэлтийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, хүүхдийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлж, | | |

| | | | |
|---|---|---|---|
| | дотуур байранд амьдрах хоол, унааны зардлын тодорхой хувийг улсаас төлнө.<br>3.1.17.Зорилтот бүлгийн өрхийн хүүхдийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамргадах, боловсролтой болох боломжоор хангах, мэргэжлийн, дипломын сургалтын тэтгэлэгт хамруулах замаар ядуурлаас ангид боловсролтой, мэдлэгтэй монгол хүнийг бэлтгэхэд анхаарна.<br>3.1.18.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ. | | |
| ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН БАЙР<br>**Зорилт 3.2.**Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | | **ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН БАЙР**<br>**Зорилт 3.2.** Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоог бүрдүүлэх үе.<br><br>1.Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоотой болсон байна.<br>2.Төлбөрийн | 3.2.1.Нийслэл, түүний дагуул, хаяа хот, тосгон, орон нутагт, хүн амын орлогод нийцсэн, ногоон хөгжлийн загварт тохирсон орон сууц нийлүүлэлтийг бодлогоор дэмжинэ.<br>3.2.2.Худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны зураг төслийг боловсруулж, норм, стандарт, холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.<br>3.2.3.Хот, суурин газрын хөгжлийн төлөвлөлтийн дагуу | • Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулдаг тогтолцоо бий болсон байна.<br>• Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлж эхэлсэн байна. | **6.**Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.<br>**7.**Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150,000 өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барина.<br>**8.**Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, жилийн 4-6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулна.<br>(“3.Эдийн засгийн бодлого” хэсгээс) |

| | | | |
|---|---|---|---|
| чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоо бэхжсэн байна. | орон сууцжуулах хөтөлбөр, төслийг үе шаттай хэрэгжүүлж, иргэдийг орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон байртай болоход дэмжлэг үзүүлнэ.<br>3.2.4.Төр, орон нутаг, хэвийн хэвшлийн оролцоотой 60,000 айлын "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.<br>3.2.5.Хот, суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.<br>3.2.6.Орон сууцны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд татварын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тухайн орон сууцны тодорхой хувийг бага, дунд орлоготой иргэдэд түрээслүүлэх, хямд үнээр борлуулах замаар орлогод нийцсэн орон сууцаар хангана.<br>3.2.7.Зайлшгүй орон байраар хангагдах шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг төрийн өмчийн халамжийн түр орон сууцаар хангадаг тогтолцоог нэвтрүүлнэ.<br>3.2.8.Орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай | • Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоотой болсон байна.<br>• Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоо бүрдсэн байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | бүхий тохилог орчныг бүрдүүлэх стандарт хэрэгжүүлж, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.<br>3.2.9.Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоно.<br>3.2.10.Орон сууцны зээлийн даатгалын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар иргэдийн орон сууцны ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ.<br>3.2.11.Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй орон сууцны хэрэгцээг хангахад чиглэгдсэн хуримтлалтай дүйцүүлэх хөрөнгө оруулалт, хөнгөлөлтийн санг хослуулсан ипотекийн зээлийн уян хатан, олон хувилбарт бодлогыг хэрэгжүүлнэ.<br>3.2.12.Ногоон орон сууцыг нэвтрүүлэх бодлогын болон санхүүгийн дэмжлэгийн тогтвортой тогтолцоог бүрдүүлнэ.<br>3.2.13.Гэр хорооллын дундын болон захын бүсийг тэргүүн ээлжинд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл, санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр, эсхүл хувийн хэвшлийн орон сууцаар шууд | | |

| | | | |
|---|---|---|---|
| | солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно.<br>3.2.14.Гэр хорооллын өрхийн газрыг өөрсдийн нь идэвх, санаачилга, оролцоонд тулгуурлан дахин зохион байгуулах, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, ногоон байгууламж, тоглоомын талбай бий болгох үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, улсын төсөв болон бусад хуулиар хориглоогүй эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг бий болгоно.<br>3.2.15.Орон сууцны төсөлд ухаалаг, байгалийн нөөцийн хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологи бүхий дэд бүтцийг улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаад, дотоодын зээл, тусламж, концессын гэрээгээр барьж байгуулах, нэвтрүүлэхийг банк, санхүүгийн тогтолцоогоор дэмжинэ. | | |
| ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ГАРААНЫ БИЗНЕС<br>**Зорилт 3.3.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | | **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ГАРААНЫ БИЗНЕС**<br>**Зорилт 3.3.** Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-** | 3.3.1.Аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэгчдийг | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2030):** Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх үе.<br><br>1.Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөл бүрдсэн байна.<br>2.Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшсөн байна.<br>3.Бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхиүлэн дэмжиж, ядуурлын түвшин буурч, нийгмийн дундаж давхарга өргөжсөн байна.<br>4.Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.<br>5.Малчин, тариаланчдын 75 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл болон бусад төрлийн | санхүүгийн болон зах зээлтэй холбох, өртгийн сүлжээний кластер байгуулж зохион байгуулалттай ажлын байр бий болгох төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбоно.<br>3.3.2.Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шууд худалдаалах төвийг сумдад байгуулж, борлуулалтын сүлжээг бий болгоно.<br>3.3.3.Жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, нийтийн өмчийн хадгалалт борлуулалтын цогцолбор байгуулна.<br>3.3.4.Хоршоонд гишүүнээр элсэн ажиллах хүсэлтэй ажилгүй, зорилтот бүлгийн өрх, иргэдийн саналыг нэгтгэн бүртгэж, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулна.<br>3.3.5.Орон нутгийн иргэний бие даасан, бүтээлч байдлыг дэмжих зорилгоор “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” аяныг өрнүүлж, сум бүрд аяныг удирдан зохион байгуулна.<br>3.3.6.Салбарын тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай мэдээллийн сан бүхий мэдээллийн системийг бий болгоно.<br>3.3.7.Хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон | • Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөл бүрдсэн байна.<br>• Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшсөн байна.<br>• Малчид, тариаланчид бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болсон байна.<br>• Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ. | |

| | | | |
|---|---|---|---|
| санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин өрх, тариаланчдын бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгосон байна.<br>6.Малчид, тариаланчид бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болсон байна. | нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.<br>3.3.8.Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.<br>3.3.9.Малчид, тариалан эрхлэгчид, ногоочдын аж ахуй эрхлэх газрыг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно.<br>3.3.10.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.<br>3.3.11.Бүтээлч санаачилга, хүсэл тэмүүллийг дэмжих үр нөлөө бүхий экосистемийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.<br>3.3.12.Хүн амын бүтээлч санаачилга, хандлага, ур чадвар, зан үйл болон үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.<br>3.3.13.“Залуу энтрепренершип” үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.<br>3.3.14.Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд | | |

| | | | |
|---|---|---|---|
| | бүтцийг хөгжүүлнэ. 3.3.15.Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ. 3.3.16.Үндэсний томоохон аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бичил, жижиг, дунд бизнестэй холбох ханган нийлүүлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. 3.3.17.Төрийн худалдан авалтаар бичил, жижиг, дунд бизнесийг дэмжиж, шаардлагатай түүхий эд, тоног төхөөрөмжөөр хангаж, хэрэгцээтэй хүний нөөцийг бэлтгэн, мэргэжилтэй ажилчдын мэдээллийн сан бүрдүүлнэ. 3.3.18.Томоохон аж ахуйн нэгж, төрийн худалдан авалтын гэрээг үндэслэн бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид зээлийн барьцаа шаардахгүйгээр зээл олгох нөхцөл бүрдүүлнэ. 3.3.19.Зээлийн батлан даалтын санг сурталчлах, үйл ажиллагааг нь өргөжүүлж сайжруулна. 3.3.20.Бичил, жижиг, дунд бизнест чиглэсэн санхүүгийн урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ. | | |

| | | | |
|---|---|---|---|
| | 3.3.21.Санхүүгийн байгууллагын нийлүүлж байгаа зээлийн бүтээгдэхүүнийг бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй, нийцтэй болгох талаар санхүүгийн салбарынхантай хамтран ажиллана.<br>3.3.22.Бизнесийн үйл ажиллагааг албан хэлбэрт шилжүүлэхэд дэмжлэг болох үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.<br>3.3.23.Экспорт, импортын зах зээлтэй холбоотой мэдээллийг цахимжуулж, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжинэ. | | |
| ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖСЭН САНХҮҮЖИЛТ<br>**Зорилт 3.4.**Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж, эрсдэлээс хамгаална. | | **ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖСЭН САНХҮҮЖИЛТ**<br>**Зорилт 3.4.** Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлэх үе.<br><br>1.Зорилтот санхүүжилт, хөнгөлөлт, хүртээмжтэй үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн байна. | 3.4.1.Бага, дунд орлоготой иргэдэд ээлтэй банк санхүүгийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.<br>3.4.2.Бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх замаар эрэлтэд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн (итгэлийн зээл, лизинг санхүүгийн шинэ төрлийн олон хэлбэрийн үйлчилгээ) бий болгоно.<br>3.4.3.Бага, дунд орлоготой иргэдийн өрхийн хүүхдүүдийн шинжлэх ухаан, технологи, инженер, | • Зорилтот санхүүжилт, хөнгөлөлт, хүртээмжтэй үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн байна.<br>• Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулсан байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| | математикийн боловсрол эзэмшихэд зориулсан тэтгэлэг бий болгоно. | | |
| ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ<br>**Зорилт 3.5.**Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ. | | ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ<br>**Зорилт 3.5.** Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ. | Биеийн тамир, спорт<br>**Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.**<br>("2.Хүний хөгжил" хэсгээс) |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үе.<br><br>1.Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.<br>2.Биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо боловсронгуй болсон байна.<br>3.Биеийн тамир, спортын салбарт цахим үйлчилгээ нэвтэрч, үндэсний нэгдсэн мэдээллийн сан бүрдсэн байна.<br>4.Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөгжил, чадавхжуулалт, дэмжлэгийг | 3.5.1.Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.<br>3.5.2.Улсын хэмжээнд иргэдийн спортын төрөлжсөн наадмыг 4 жил тутамд зохион байгуулна.<br>3.5.3.Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд, заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлнэ.<br>3.5.4.Хүн амын идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт, сурталчилгаар нэмэгдүүлнэ.<br>3.5.5.Олон улсын шаардлага, стандартад нийцсэн орчинд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.<br>3.5.6.Биеийн тамир, спортын үйлчилгээний төрөл, | • Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.<br>• Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдсэн байна.<br>• Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.<br>• Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилт дээшилсэн байна. | **1.**Хүн амыг хөдөлгөөний дутагдал, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.<br>**2.**Монгол Үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.<br>**3.**Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина. |

| | | | |
|---|---|---|---|
| нэмэгдүүлнэ. | гүйцэтгэлтэй уялдсан хараат бус магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлнэ.<br>3.5.7.Биеийн тамир, спортын санхүүжилтийг боловсронгуй болгож, хувь хүний хэрэгцээг хангасан байдал, чанартай үйлчилгээ, гарц болон гүйцэтгэлд тулгуурлан санхүүжүүлнэ.<br>3.5.8.Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн нэгдсэн бааз, платформ бий болгоно.<br>3.5.9.Биеийн тамир, спортын технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.<br>3.5.10.Биеийн тамир, спортын үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, шилжилт хөдөлгөөн, тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.<br>3.5.11.Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ. | | |

| | | | |
|---|---|---|---|
| | 3.5.12.Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.<br>3.5.13.Биеийн тамир, спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэжлээр хүний нөөц бэлтгэх, орон нутгийн хэрэгцээг хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | |
| **ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ** | | **ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ** | **ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** |
| **Зорилго 4.**Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно. | | **Зорилго 4.** Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно. | |
| ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ<br>**ЗОРИЛТ 4.1.** Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно. | | **ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ**<br>**Зорилт 4.1.** Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ. | Санхүү, төсвийн зохицуулалт<br>**Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.** |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр | 4.1.1.Гадаадын зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зардал, үр ашгийн тооцоолол хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх | • Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, өрийн дарамтыг бууруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна. | **1.**Инфляцын зорилтот түвшин, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, валютын нөөцийн хүрэлцээтэй байдлыг нэмэгдүүлэх макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.<br>**2.**Эдийн засгийн эрсдэлээс сэргийлж, эдийн засаг өсөлттэй үед төсвийг тогтворжуулж, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлэх, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх үе.<br><br>1.Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, өрийн дарамтыг бууруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна.<br>2.Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна.<br>3.Гадаад валютын албан нөөц эрсдэл даахуйц хэмжээнд хүрч өссөн байна.<br>4.Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлт тасралтгүй нэмэгдсэн байна.<br>5.Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадвар дээшилсэн байна.<br>6.Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна. | тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлнэ.<br>4.1.2.“Ирээдүйн өв сан”-д орлого төвлөрүүлэх, баялгийн сангийн хөрөнгийг оновчтой удирдан, эрсдэл даах эдийн засгийг бүрдүүлнэ.<br>4.1.3.Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.<br>4.1.4.Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг барагдуулж, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авна.<br>4.1.5.Ил тод байдал, хамтын ажиллагаанд тулгуурлан гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.<br>4.1.6.Улсын төсвийн сахилга бат, санхүү, мөнгө, зээлийн бодлого, зохицуулалтын удирдлагыг сайжруулна.<br>4.1.7.Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг үе шаттай бууруулж, улмаар ашигтай болгож, хуримтлал үүсгэж, төсвийн тогтвортой байдлыг хангана.<br>4.1.8.Хөгжлийг дэмжих бодлого, төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгааны институт | • Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна.<br>• Гадаад валютын албан нөөц нэмэгдсэн байна.<br>• Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлт тасралтгүй нэмэгдсэн байна.<br>• Бизнесийн таатай орчинг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадвар дээшилсэн байна.<br>• Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна. | **3.**Банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд хийж, банк, санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжих, эрсдэл даах чадамжтай болгоно.<br>**4.**Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.<br>**5.**Иргэдийг санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг шинээр бүрдүүлэх замаар мөнгө хүүлэлтийг таслан зогсооно.<br>**6.**Иргэн, хуулийн этгээд хөрөнгийн биржийн арилжаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан, цахим арилжааны дэд бүтцээр шууд оролцох боломжийг бүрдүүлнэ.<br>**7.**Банк санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрхзүйн шинэчлэл хийнэ.<br>**8.**Хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэн Засгийн газрын өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ.<br>**9.**Гадаад худалдааг дэмжсэн гаалийн үйлчилгээг хялбаршуулж, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн хураахад чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.<br>**10.**Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлнэ.<br>**11.**Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ.<br>**12.**Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай хэмжээний нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон чөлөөт бүсийг хөгжүүлж, хил дамнасан худалдааны байнгын сүлжээг байгуулна.<br>**13.**Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ.<br>**14.**Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, эрхзүйн орчныг тодорхой болгоно.<br>**15.**Дотоодын давхар даатгал хөгжих, урт |

| | | | |
|---|---|---|---|
| | байгуулж ажиллуулна.<br>4.1.9.Эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.<br>4.1.10.Татварын шинэ хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.<br>4.1.11.Тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний импортын татвар, зохицуулалтыг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан хүрээнд үр ашигтай хэрэгжүүлнэ.<br>4.1.12.Инфляцыг зорилтот түвшинд хадгалж, эрсдэл даахуйц гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхийг дэмжсэн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ.<br>4.1.13.Төв банкны гадаад өрийг бууруулах зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын банктай байгуулсан “СВОП” хэлцлийн хүрээнд үүссэн өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэнэ.<br>4.1.14.Макро эдийн засгийн зорилттой нийцүүлж, төсөв, мөнгөний бодлогыг харилцан уялдаатайгаар хэрэгжүүлнэ.<br>4.1.15.Санхүүгийн системийн эмзэг байдлыг бууруулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.<br>4.1.16.Дамжин өнгөрүүлэх тээвэр, худалдаа, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг тээвэр, | | хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ.<br>**16.**Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, тендэр шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгана.<br>**17.**Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.<br>**18.**Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулна. |

| | | | |
|---|---|---|---|
| | логистик, хилийн дэд бүтцийн хамт байгуулан эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангана.<br>4.1.17.Алт цэвэршүүлэх үйлдвэр болон бусад технологийн түүхий эдэд суурилсан гадаадын томоохон хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн экспоненциал өсөлтийг бий болгоход анхаарч ажиллана.<br>4.1.18.Эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах замаар бизнес эрхлэгчид шинээр хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болгох таатай орчныг бүрдүүлнэ. Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн бодлого хэрэгжүүлнэ.<br>4.1.19.Орчин үеийн технологи ашиглах ур чадвартай ажилчид бэлтгэж, бүтээмжид тохирсон цалин олгоно.<br>4.1.20.Экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудын бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг дэмжинэ.<br>4.1.21.Төсөв, мөнгө, зээл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлт болон бүтцийн өөрчлөлтийн ололтыг цаашид тогтвортой хадгална.<br>4.1.22.Хадгаламж, хуримтлалыг нэмэгдүүлэх дадлыг | | |

| | | | |
|---|---|---|---|
| | бий болгоно.<br>4.1.23.Хуримтлалын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зээлийн хүүг бууруулах замаар үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.<br>4.1.24.Макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хадгалж, ажилгүйдлийг нам түвшинд тогтвортой хадгална.<br>4.1.25.Зээлийн хүүг хөгжингүй орнуудын түвшинд хүргэж, тогтвортой хадгална.<br>4.1.26.Байгальд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай, хэмнэлттэй эдийн засгийн бүтцийг бий болгох бодлого баримтална гм. | | |
| ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД<br>**Зорилт 4.2.**Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. | | **ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД**<br>**Зорилт 4.2.** Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе.<br><br>1.Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын | 4.2.1.Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.<br>4.2.2.Хөдөө аж ахуй, тээвэр логистик, төрөлжсөн аялал жуулчлалын салбарыг | • Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна.<br>• Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна.<br>• Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байна.<br>• Бүтээлч үйлдвэрлэл (соёл урлаг, кино | Уул уурхай, хүнд үйлдвэр<br>**Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ.**<br>**1.**Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.<br>• Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулна.<br>• “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын өмчлөлийн асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэлт хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ.<br>• Цагаансуваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулна.<br>• Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг |

| | | | |
|---|---|---|---|
| түвшин нэмэгдсэн байна.<br>2.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна.<br>3.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байна.<br>4.Бүтээлч үйлдвэрлэл (соёл урлаг, кино урлаг, дуу хөгжим, дизайн, архитектур)-ийн хөгжлийн бодлогын суурь тавигдсан байна.<br>5.Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна.<br>6.Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн байна.<br>7.Эдийн засгийн хөгжлийг дэмжих эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлсэн байна.<br>8.Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг | бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих замаар хөгжүүлнэ.<br>4.2.3.Эдийн засгийг төрөлжүүлэх, аж үйлдвэржүүлэх, бүс нутгуудын хөгжлийг дэмжих хууль, эрх зүйн болон хөрөнгө оруулалтын оновчтой зохицуулалтыг бий болгоно.<br>4.2.4.Худалдааны зохицуулалтын хуулийг баталж, импортын тарифын зохицуулалтаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.<br>4.2.5.Олон улсын зах зээлийн үнийн нөлөөлөлд бага өртдөг эко цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортын таатай орчныг бүрдүүлэх төрийн бодлогын хэрэгжилтийг хангана.<br>4.2.6.Эрчимтэй хөгжиж байгаа дэвшилтэт технологийн түүхий эдийн талаар тусгайлсан бодлого боловсруулж, гадаадын өндөр технологийн хөрөнгө оруулалтыг татна.<br>4.2.7.Барилгын материал, мал, амьтны гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.<br>4.2.8.Газрын гадаргын, үерийн болон борооны усыг хуримтлуулах, гол мөрний урсцад | урлаг, дуу хөгжим, дизайн, архитектур)-ийн хөгжлийн бодлогын суурь тавигдсан байна.<br>• Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна.<br>• Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн байна.<br>• Эдийн засгийн хөгжлийг дэмжих эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлсэн байна.<br>• Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна.<br>• Олон улсын чанартай тээвэр, логистикийн төвүүдийг байгуулсан байна.<br>• Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлсэн байна. | бууруулна.<br>• Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ.<br>• Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна.<br>**2.**Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.<br>• Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана.<br>• Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна.<br>• Дорноговийн Сайхандулааны Цагаан толгойн цахиурын ордыг ашиглалтад оруулна.<br>**3.**Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.<br>**4.**Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.<br>**5.**Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.<br>**6.**Уул уурхайн салбарын институцыг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.<br>**7.**Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.<br>• Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.<br>• Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулна.<br>• Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэж, экспортыг нэмэгдүүлнэ.<br>• Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна.<br>• Үнэт металлын сорьц тогтоох салбар лаборатори байгуулж, үнэт металлыг сорьцлох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл, ажиллагааг өргөжүүлж иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.<br>**8.**Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.<br>• Газрын тос, уламжлалт бус газрын тосны |

| | | | |
|---|---|---|---|
| бүрэн хангасан байна.<br>9.Үндэсний тээвэр, логистикийн тогтолцоог хөгжүүлсэн байна.<br>10.Иргэний нисэхийн дэд бүтэц, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлсэн байна. | тохируулга хийх замаар аж үйлдвэрийн салбарын усны хэрэгцээг хангана.<br>4.2.9.Хур борооны усыг хуримтлуулах, хэмнэлттэй, үр ашигтай технологи нэвтрүүлэх замаар хөдөө аж ахуйн салбарын усны хэрэгцээг хангана.<br>4.2.10.Хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээг хэвшүүлж усны аюулгүй байдлыг хангах, эрдэс баялгийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг цэвэрлэх байгууламжтай байх шаардлага тавьж хэрэгжүүлнэ.<br>4.2.11.Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.<br>4.2.12.Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө.<br>4.2.13.Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байх зарчмаар хөгжүүлж, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжинэ.<br>4.2.14.Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, | | эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө.<br>• Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.<br>• Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.<br><br>**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр**<br>**Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.**<br>**5.**Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.<br><br>**Эрчим хүч**<br>**Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.**<br>**1.**Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ.<br>• Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг 46 МВт-аар, Эрдэнэтийн Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар тус тус өргөтгөж шинэчилнэ.<br>• Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.<br>• Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөнө.<br>• Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.<br>• Төвийн болон зүүн бүсийн нүүрсний орд газруудыг түшиглэн 300-400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.<br>• 160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барина.<br>• Амгалангийн дулааны станцын хүчин чадлыг хосолмол 50МВт-аар нэмэгдүүлнэ.<br>**2.**Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ-руу байгалийн хий дамжуулах хоолойн ТЭЗҮ-ийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана.<br>**3.**Төвлөрсөн хот, сум, суурин газарт дулааны |

| | | | |
|---|---|---|---|
| | байгуулна.Үүнд:<br>УУЛ УУРХАЙН ОРДУУД:<br>• Таван толгойн нүүрсний орд;<br>• Оюутолгойн далд уурхай;<br>• Дорноговийн цахиурын орд;<br>• Цагаан суваргын орд;<br>• Хармагтайн орд;<br>• Литийн орд;<br>• Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ.<br>ХҮНД ҮЙЛДВЭР:<br>• Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр;<br>• Нефть-хими, кокс-хими, металлургийн үйлдвэр;<br>• Нүүрс угаах үйлдвэр;<br>• Нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк;<br>• Ган төмөрлөгийн үйлдвэр;<br>• Жонш баяжуулах үйлдвэр;<br>• Алт цэвэршүүлэх үйлдвэрийг тус тус барьж байгуулна.<br>4.2.15.Говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулна.<br>4.2.16.Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна.<br>4.2.17.Гадаад, дотоод зах зээлд чиглэсэн гүн боловсруулалтын технологид суурилсан хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.<br>4.2.18.Боловсруулах салбарын бүтээгдэхүүн | | эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлж, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна. (Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Дундговь, Говьсүмбэр, Төв, Сүхбаатар, Хэнтий аймагт дулааны станц барина.)<br>**4.**Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, инновац, шинэ техник технологи нэвтрүүлж, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ.<br>**5.**Бүс нутгийн эрчим хүчний сүлжээг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбож, уул уурхай, хүнд үйлдвэрийн мега төслүүдийн цахилгаан хангамжийг үе шаттайгаар шийдвэрлэж, ухаалаг систем бий болгоно. (Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.)<br>**6.**Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах ногоон үйлдвэрлэлийн төслүүдийг хэрэгжүүлнэ. (Салхины цахилгаан станцын 15 МВт-ын хоёр, нарны цахилгаан станцын 35 МВт-ын дөрвөн төсөл хэрэгжүүлнэ.)<br>**7.**Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн орон нутагт хэрэгжүүлэх иргэний болон үйлдвэрлэлийн барилга байгууламжийн томоохон төслийн эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, дэд бүтцийн ТЭЗҮ, зураг төслийг хийнэ. (Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ.)<br><br>## Тээвэр, логистик<br>("4.Эдийн засгийн бодлого" хэсгээс)<br>**Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан *"Үндэсний тээвэр логистикийн сүлжээ"*-г байгуулна.**<br>**1.**Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ.<br>• Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж дуусгах, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг |

| | | | |
|---|---|---|---|
| | үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлнэ.<br>4.2.19.Импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ.<br>4.2.20.Хөдөө аж ахуйн салбарыг байгальд ээлтэй, хариуцлагатай, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.<br>4.2.21.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, малын, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.<br>4.2.22.Ноолуурын салбарыг дэмжиж, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.<br>4.2.23.Мал, амьтны гаралтай арьс, шир, ангийн үс, ноосыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.<br>4.2.24.Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.<br>4.2.25.Бүтээлч үйлдвэрлэл болон мэдээлэл технологийн үйлдвэрийг эдийн засгийн бүтцэд тогтвортой хөгжлийн салбар болгон | | эхлүүлнэ.<br>• Улаанбаатар төмөр замд техникийн болон парк шинэчлэлийг эхлүүлж, 200 км гол замд их засвар хийнэ.<br>• Богдхан төмөр зам болон баруун бүсийн босоо тэнхлэгийн төмөр замын ТЭЗҮ-г хийж дуусгана.<br>• Азийн авто замын сүлжээний АН-3 буюу Улаанбаатар-Дархан, Дархан-Алтанбулаг, Налайх-Баян чиглэлийн авто замыг 4 эгнээтэй болгож, Азийн авто замын сүлжээний АН-4 буюу Цагааннуур-Улаанбайшинт, Өлгий хотыг тойрсон хатуу хучилттай авто замыг барьж дуусгана.<br>• Томоохон суурин газруудыг хилийн боомттой холбосон хатуу хучилттай авто замын төслийг хэрэгжүүлнэ.<br>• Аялал жуулчлалыг хөгжүүлэх болон нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий зарим сум, суурин газрууд руу чиглэсэн 2022 км авто замыг барьж байгуулна.<br>**2.**Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын төлбөр хураах, хяналт механизмыг бүрдүүлэх замаар авто замын сангийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн авто замын санг бие даасан үйл ажиллагаанд шилжүүлнэ.<br>• Олон улсын болон улсын чанартай 14,918.7 км авто замын сүлжээнд их засвар, ээлжит засвар, арчлалтын ажлыг норм, нормативын дагуу гүйцэтгэнэ.<br>• Онги, Түргэн, Байдраг, Хэрлэн, Ерөө, Орхон, Гичгэнэ, Чигэстэй голуудын нийт 1306.8 урт метр төмөр бетон гүүрэнд их засварын ажлыг хийнэ.<br>• Авто замын ашиглалтын бэлэн байдалд хяналт тавих, төлбөр хураах цэгийн тоог нэмэгдүүлж бүрэн цахимжуулна.<br>**3.**Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| | хөгжүүлнэ.<br>4.2.26.Бүтээлч аж үйлдвэрийг дэмжих институц, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэхжүүлнэ.<br>4.2.27.Бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг өндөр хөгжилтэй оронд бэлтгэж, энэ чиглэлээр гадаад, дотоод хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.<br>4.2.28.Бүтээлч үйлдвэрлэлийн салбарын дотоод төрөлжилтийг хангах бодлогод тулгуурлан гадаад зах зээлд байр сууриа олсон брэндүүдийг бий болгоно.<br>4.2.29.Мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлэн хөгжүүлэх институцийн тогтолцоог бүрдүүлнэ.<br>4.2.30.Мэдээлэл технологийн судалгаа, шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, зөөлөн болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ.<br>4.2.31.Мэдээллийн технологийн кластерыг хөгжүүлж, гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлнэ.<br>4.2.32.Төрийн үйл ажиллагааг цахимжуулахад үндэсний программ хангамжийн компаниудыг түлхүү оролцуулна.<br>4.2.33.Мэдээллийн технологи болон цахим худалдааны | | |

| | | | |
|---|---|---|---|
| | салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, хөрөнгө оруулагчдын санаачилгыг дэмжинэ.<br>4.2.34.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.<br>4.2.35.Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо болон хөндлөн гол тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бүхий ухаалаг нэгдсэн систем байгуулна.<br>4.2.36.Эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын эх үүсвэрийг барьж байгуулан импортын эрчим хүчний хараат байдлыг бууруулна.<br>4.2.37.Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлыг 30 хувьд хүргэх, гадагш урсгалтай гол, мөрний урсцын 10 хувийг эрчим хүчний үйлдвэрлэл болон бусад хэрэгцээнд ашиглана.<br>4.2.38.Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн орчин үеийн дэвшилтэт технологийг түшиглэн орон нутгийн дулаан хангамжид ашиглана.<br>4.2.39.Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, | | |

| | | | |
|---|---|---|---|
| | хүртээмжийг сайжруулах зорилгоор дулааны эх үүсвэр, дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл хийнэ.<br>4.2.40.Зүүн хойд азийн орнуудтай хамтран азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний санаачилгыг хэрэгжүүлнэ.<br>4.2.41.Эрчим хүчний салбарт инновац, дэвшилтэт техник, ухаалаг технологийг нэвтрүүлж, санхүүгийн бие даасан, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.<br>4.2.42.Эх үүсвэрийн чадлын балансгай уялдуулан нар, салхи, ус, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрийг ашиглана.<br>4.2.43.Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тогтвортой хөгжлийн салбар болгон хөгжүүлнэ.<br>4.2.44.Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.<br>4.2.45.Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлнэ.<br>4.2.46.Зарим тусгай хамгаалалттай газар нутгийг байгальд ээлтэй эко аялал | | |

| | | | |
|---|---|---|---|
| | жуулчлалын зориулалтаар төлөвлөн хөгжүүлнэ.<br>4.2.47.Монгол Улсын соёл, аялал жуулчлалын төвүүдийг зорилтот зах зээлийн орнуудад байгуулж, гадаад сурталчилгааг сайжруулан, аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай аялал жуулчлалыг хөгжүүлнэ.<br>4.2.48.“Их Түмэн голын санаачилга” хөтөлбөр болон Торгоны зам, Цайны замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээ, худалдааг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.<br>4.2.49.Холимог тээврийн салбарт инновац, дэвшилтэт техник технологи, цахим шилжилтийг нэвтрүүлж, салбарын аюулгүй, найдвартай байдлыг хангана.<br>4.2.50.Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлэн, авиа компанийн өрсөлдөөнийг дэмжинэ. | | |

| | | | |
|---|---|---|---|
| **БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА**<br>**Зорилт 4.4.**Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө | | **БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА**<br>**Зорилт 4.4.** Хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах эсэх талаар урьдчилсан судалгаг эхлүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе.<br><br>1.Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улсын эдийн засгийн коридор бий болж, гадаад харилцааны тэнцвэртэй байдал хангагдсан байна.<br>2.Гуравдагч хөршид хүрсэн эдийн засаг бий болсон байна.<br>3.Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө. | 4.4.1.Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай хэмжээний нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон чөлөөт бүсийг хөгжүүлнэ.<br>4.4.2.Бараа, үйлчилгээг худалдах, тээвэрлэх, хянах, хөрөнгө оруулах, зах зээлд нэвтрэх нөхцөлүүдийг ил тод болгох, бүртгэл ба мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан удирдлага ба хяналтыг бий болгоно.<br>4.4.3.Эдийн засгийн коридорын хүрээнд "Талын зам" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойг барих асуудлыг гурван талт хэлэлцээрийн үр дүнд шийднэ.<br>4.4.4.Эдийн засгийн коридор бий болгох гурван талт хэлэлцээрийг боловсронгуй болгож, Монгол Улс тээвэр, логистик, хот байгуулалт, хил | • Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын эдийн засгийн коридорыг хөгжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлсэн байна.<br>• Гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлсэн байна.<br>• Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх бэлтгэл ажлыг хангаж, худалдааг хөнгөвчилнө. | **ТОГТВОРТОЙ, НЭГДМЭЛ ГАДААД БОДЛОГО**<br>Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчинг улам бэхжүүлнэ.<br>**1.**Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, цахимаар үзүүлэх үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ.<br>**2.**Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч буй хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.<br>**3.**Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, МЕГА төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ.<br>**4**ОХУ, БНХАУ-тай Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны хүрээнд улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, худалдаа, соёл, хүмүүнлэг зэрэг бүхий л салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлнэ.<br>**5.**АНУ, Япон, Европын Холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.<br>**6.**НҮБ, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн түвшинд хамтын ажиллагаа идэвхтэй үргэлжлүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг |

| | | | |
|---|---|---|---|
| | дамнасан худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ.<br>4.4.5.Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулж, тус бүсэд бага овортой, өртөг өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.<br>4.4.6.Олон улсын агаарын карго тээврийн логистикийн төв байгуулж, ачааны төвлөрөл бий болгоно.<br>4.4.7.Нисэх буудлыг түшиглэсэн олон худалдааны төв байгуулж, худалдааны аялал жуулчлалыг хөгжүүлнэ.<br>4.4.8.Улс орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулна.<br>4.4.9.Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх, худалдааг хөнгөвчлөх замаар урт хугацаанд өрсөлдөх чадвар бүхий цөөхөн салбарт эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, экспортын боломж, зах зээлээ тэлэх бодлого явуулна.<br>4.4.10.Цөөхөн улс орон, цөөн зах зээлээс хараат байдлаасаа ангижрахын тулд тээврийн өртөг зардлаа бууруулах, нэмэгдсэн өртөг бүтээх, үүний тулд аж | | хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.<br>**7.**Монгол Улсын гадаад бодлого, харилцааны нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах, төр, засгийн байгууллагын гадаад харилцааг нэгдсэн байдлаар зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.<br>**8.**Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж буй иргэдийн тоо зэргийг харгалзан Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно.<br>**9.**Дипломат албанд сахилга, хариуцлагыг эрс нэмэгдүүлж, хар тамхи тээвэрлэх болон хууль бус бусад аливаа үйлдлийг таслан зогсооно.<br>**10.**Монгол Улсын түүх, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ олон улсад сурталчлах, таниулах “Монгол Үндэстний үнэлэмж” хөтөлбөр, хилийн чанадад байгаа иргэд монгол хэл, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ хадгалан тээх “Дэлхийн монголчууд II” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| | үйлдвэржилтийн томоохон төслүүдэд хөрөнгө оруулах чадвартай, харилцан ашигтайгаар хамтран ажиллана.<br>4.4.11.Гадаад, дотоод зах зээлүүдтэй холбогдох зорилгоор тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, дэд бүтцээ үр өгөөжтэй байлгахын тулд дамжин өнгөрөх тээврийн гэрээ хэлэлцээрүүдийг сайжруулж хэрэгжүүлнэ.<br>4.4.12.Дотоодын боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад өрсөлдөөнөөс хамгаалах бодлого зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.<br>4.4.13.Америкийн Нэгдсэн Улс, Европын Холбооны зүгээс Монгол Улсад үзүүлэх худалдааны хөнгөлөлт эдлэх эрх зүйн зохицуулалт хийж, малын гаралтай бэлэн экспортын бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.<br>4.4.14.Зүүн хойд азийн орнуудын эдийн засаг, худалдааны интеграцад Монгол Улс идэвхтэй оролцож “Түмэн гол” төслийг хэрэгжүүлэхэд Монгол Улс идэвх санаачилгатай оролцоно.<br>4.4.15.Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан стратегийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд худалдааны хамтын | | |

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллагааг өргөтгөх замаар хөрөнгө оруулалт, технологийн хэлбэрт шилжүүлнэ.<br>4.4.16.Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар худалдааг нэмэгдүүлнэ.<br>4.4.17.Зүүн өмнөд азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн хэлэлцээрт нэгдэн орж худалдаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн интеграцад нэгдэх ажлыг эхлүүлнэ.<br>4.4.18.Зүүн хойд азийн аж үйлдвэржсэн улсууд болох Япон, Бүгд Найрамдах Солонгос Улстай худалдааны хамтын ажиллагааны хүрээг өргөтгөж технологийн хамтын ажиллагааны хэлбэрт шилжүүлнэ. | | |

| **ТАВ.ЗАСАГЛАЛ** | | **ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** |
|---|---|---|
| **Зорилго 5.**Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно. | **Зорилго 5.** Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн | |

| | | | |
|---|---|---|---|
| | | шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно. | |
| УХААЛАГ ЗАСАГЛАЛ<br>**Зорилт 5.1.**Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана. | | **Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн**<br>**Зорилт 5.1.** Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх үе.<br><br>1.Улсын Их Хурлын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирч парламентын засаглал бэхэжсэн байна.<br><br>2.Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, залгамж чанартай, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ. | 5.1.1.Засаглалын хэлбэрийн гажуудлыг засаж, ардчилсан парламентын тогтолцоог бэхжүүлэх чиглэлд эрх зүйн болон бодлогын шинэчлэл хийнэ.<br>5.1.2.Улсын Их Хурлын гишүүдийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хуульд заасны дагуу эгүүлэн татах улс төрийн эерэг соёл, хандлагыг бүрэн төлөвшүүлнэ.<br>5.1.3.Улсын Их Хурлын гишүүнд тавих ёс зүй, сахилга хариуцлагын хууль баталж, намууд сонгуульд нэр дэвшигчдээ тодруулахдаа ёс зүй, сахилга хариуцлагын үндсэн шалгуураар гишүүд, дэмжигчдээр нээлттэй хэлэлцүүлдэг улс төрийн зөв соёлыг төлөвшүүлнэ.<br>5.1.4.Үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдааг бүрэн хангах | • Эрх мэдлийг тэнцвэржүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулсан байна.<br>• Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, залгамж чанартай, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдсэн байна. | • Орон тооны гишүүдээс бүрдсэн Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн сахилгын хороог байгуулах замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлж, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн харьяанд шилжүүлнэ.<br>• Үндсэн хуулийн Цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно.<br>• Хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэнэ.<br>• Эх газрын эрх зүйн хэв шинж, философид суурилсан Монгол Улсын өөрийн онцлогт нийцсэн, хүний эрхийг дээдэлсэн, эдийн засгийг өсөлтийг дэмжсэн урт хугацааны “Эрх зүйн шинэтгэл II” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.<br>• Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.<br>• Хувийн өмч, хөрөнгө оруулалт, |

| | | | |
|---|---|---|---|
| 3.Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө.<br><br>4.Улс төрийн намуудыг улс орныхоо төлөө бодлогын нам болгох нийгэм, улс төрийн соёлыг төлөвшүүлнэ.<br><br>5.Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдэж, иргэдийн улс төрийн боловсрол дээшлэн, иргэд, сонгогчдын хариуцлага сайжирна. | тогтолцоог бүрдүүлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцээгүй тохиолдолд Улсын Их Хурал батлахгүй байх зохицуулалтыг бий болгоно.<br>5.1.5.Улсын Их Хурлаас гаргаж байгаа бодлого нь нотолгоонд суурилсан байх тогтолцоог бүрдүүлж, батлан гаргаж байгаа нийт бодлогын 70 хувиас доошгүйг судалгаанд суурилж боловсруулна.<br>5.1.6.Засгийн газрын бүтцийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.<br>5.1.7.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулах тогтолцоонд шилжинэ.<br>5.1.8.Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.<br>5.1.9.Шүүх үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно. | | оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж, цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.<br>• Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.<br>• Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.<br>• Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ, хязгаарыг тодорхойлж, хуулийн төслийн боловсруулалтын чанарын үр нөлөөг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах байнгын механизмыг бүрдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.<br>• Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.<br>• Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулна.<br>(4.4.1-11)<br><br>• НҮБ, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.<br>(4.5.8) |

| | | | |
|---|---|---|---|
| | 5.1.10.Ёс зүй, цогц чадамжтай шүүхийн хүний нөөц бэлтгэх суурь тогтолцоог бий болгож, төгөлдөржүүлнэ. 5.1.11.Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж, шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгон үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлнэ. 5.1.12.Улс төрийн намуудыг улсын төсвөөс тодорхой шалгуурын дагуу санхүүжүүлж, зарцуулалтыг олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай болгоно. 5.1.13.Улс төрийн намуудын дотоод ардчиллыг бүх түвшинд сайжруулж, ардчиллын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлж, төрийн бодлогод иргэдийн оролцоог дэмжиж, бодлогын нам болгож төлөвшүүлнэ. 5.1.14.Улс төрийн намууд улс орны эдийн засаг, нийгмийн өмнө тулгарч байгаа голлох асуудал, түүнийг шийдвэрлэх урт хугацааны бодлого боловсруулж батлахад зөвшилцөлд хүрэх тогтолцоог бүрдүүлж, хөгжлийн бодлогын тогтвортой байдлыг хангана. 5.1.15.Улс төрийн намыг хатуу гишүүнчлэлгүй болгоно. 5.1.16.Улсын Их Хурлын сонгуулийг холимог системээр | | |

| | | | |
|---|---|---|---|
| | явуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.<br>5.1.17.Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийг зэрэг явуулах нөхцөлийг бүрдүүлж хэвшүүлнэ.<br>5.1.18.Сонгуулийн байгууллагын бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлж, сонгуулийн үед санал хураах үйл явцын аюулгүй байдлыг хангаж, зөрчил, маргаангүй сонгууль явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.<br>5.1.19.Иргэд, сонгогчдын улс төрийн мэдлэгийг дээшлүүлэх шат дараалсан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.<br>5.1.20.Шаардлагатай тохиолдолд улс орны эдийн засаг, нийгмийн өмнө тулгарч байгаа бэрхшээлүүд, түүнийг шийдвэрлэх арга замын талаар асуулга боловсруулан сонгогчдоор эрэмбэлүүлэх, сонголт хийлгэх замаар иргэдийн оролцоог хангана. | | |
| УХААЛАГ БҮТЭЦ<br>**Зорилт 5.2.**Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна. | | **Зорилт 5.2.** Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бий болгоно. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br>I үе шат (2021-2030): Төрийн захиргааны | 5.2.1.Яам, агентлаг, төрийн захиргааны бусад байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг үндэсний | • Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцлыг арилгах шинэчлэл хийгдэж эхэлсэн байна. | • Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцлыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ.<br>(4.2.2) |

| | | | |
|---|---|---|---|
| байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгаар оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог төлөвшүүлэх үе.<br><br>1.Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурласан захиргааны оновчтой, уян хатан, үр дүнтэй, үр ашигтай бүтэц тогтсон байна.<br><br>2.Хөгжлийн бодлогод нийцсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оновчтой хуваарилалт бий болж, орон нутгийн бие даасан байдал хангагдана.<br>3.Урт хугацааны хөгжлийг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулна.<br><br>4.Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо хангагдаж, хамтын ажиллагаа бэхжих нөхцөл бүрдэнэ. | урт хугацааны бодлогын үзэл баримтлал, чиг үүргийн шинжилгээнд тулгуурлан Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэдэг тогтолцоог бэхжүүлнэ.<br>5.2.2.Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой хуваарилах санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий нэгжийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцэд бий болгоно.<br>5.2.3.Төрийн захиргааны төв байгууллагын харьяанд тухайн салбарын бодлогын болон техник технологийн судалгаа, шинжлэх ухааны үндэстэй тооцоолол, төлөвлөлтийг хийж, мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий судалгааны алба (төв, хүрээлэн, институт гэх мэт) ажиллуулж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана.<br>5.2.4.Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд үзүүлэх төрийн үйлчилгээг тодорхойлж, шат дамжлагыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.<br>5.2.5.Засаг захиргааны түвшин бүрд тухайн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай захиргаа, санхүүгийн эрх мэдлийг олгоно.<br>5.2.6.Бие даан хөгжих боломжийг | • Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн оновчтой зохицуулалт хийгдсэн байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| 5.Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүй, бодлогын орчин бүрдэнэ. | бүрдүүлсэн орон нутгийн өмч, татварын боловсронгуй тогтолцоо бүхий эдийн засаг, санхүүгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлнэ.<br>5.2.7.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж байгуулах, өөрчлөх, нэгтгэх, татан буулгах асуудлыг урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэдэг байх тогтолцоог бүрдүүлнэ.<br>5.2.8.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх, эдийн засгийн хувьд бие даан хөгжих боломжийг хангахуйц засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарилалт хийнэ.<br>5.2.9.Улсын Их Хуралд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн байнгын хороо, Засгийн газрын бүтцэд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг байгуулж, аймаг, нийслэл, сум, дүүрэгт хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан нэгжийг бий болгоно.<br>5.2.10.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны | | |

| | | | |
|---|---|---|---|
| | тогтвортой байдлыг хангаж, эрх зүй, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгож, бодлогын судалгаа хийх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ.<br>5.2.11.Улсын нэгдсэн төсвийг урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан боловсруулж, батлах тогтолцоог бүрдүүлж бэхжүүлнэ.<br>5.2.12.Төв банкны мөнгөний бодлого нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх улс төр, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.<br>5.2.13.Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.<br>5.2.14.Гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх төрийн чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлэх тогтолцоог нэвтрүүлнэ.<br>5.2.15.Иргэний нийгмийн байгууллагууд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.<br>5.2.16.Иргэдийн эрх зүйн болон улс төрийн мэдлэг, соёлыг дээшлүүлж, хариуцлагатай иргэн | | |

| | | | |
|---|---|---|---|
| | болгож төлөвшүүлнэ.<br>5.2.17.Цахим ардчиллыг хөгжүүлж, төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих зэргээр цахимаар оролцох тэгш боломжийг бүрдүүлнэ.<br>5.2.18.Хөрөнгө оруулалт, өмчийн эрхийг хамгаалах, тогтвортой байдлыг хангах бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгож, хувийн өмчийг бүрэн хамгаалсан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.<br>5.2.19.Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.<br>5.2.20.Банк, санхүүгийн тогтолцоог хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих бодлогод нийцүүлэн шинэчилж, хөрөнгө оруулалт, зээлийн таатай орчныг бүрдүүлнэ.<br>5.2.21.Төрийн бодлого, татварын хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг хамгаалах, татах таатай орчныг бүрдүүлнэ.<br>5.2.22.Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг нэгтгэн хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд шилжүүлнэ. | | |

<table>
<tr>
<td colspan="2">ЦАХИМ МОНГОЛ (ИРГЭН, ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ)<br><br>**Зорилт 5.3.**Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.</td>
<td>**Зорилт 5.3.** Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ.</td>
<td>Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.</td>
</tr>
<tr>
<td>**Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>I үе шат (2021-2030): Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе.<br><br>1.Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбоно.<br><br>2.Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болж хөгжинө.<br><br>3.Цахим хэлбэрт шилжсэнээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ шат дамжлагагүй, шуурхай болно.<br><br>4.Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал буурах, үйлчилгээний үр дүн сайжирна.<br><br>5.Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл</td>
<td>5.3.1.Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.<br>5.3.2.Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлж хэвшүүлнэ.<br>5.3.3.Цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологийн салбарын стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батална.<br>5.3.4.Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөж, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлнэ.<br>5.3.5.Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.<br>5.3.6.Интернэтийн хурдыг нэмэгдүүлж,</td>
<td>• Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хүн амыг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбоно.<br>• Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болсон байна.<br>• Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран, үйлчилгээний үр дүн сайжирсан байна.<br>• Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөл бүрдсэн байна.</td>
<td>• Төрийн байгууллага дахь мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, төрийн цахим үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай авдаг “Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж, нэгдсэн стандартад оруулна.<br>• Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана.<br>• Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.<br>• Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.<br>• Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг өргөжүүлж, багтаамжийг нэмэгдүүлнэ.<br>• Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.<br>• Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.<br>• Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.<br>• Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.<br>• Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.<br>(4.1.1-10)</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| явцад иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөл бүрдэж, мэдээллийн ил тод байдал нэмэгдэнэ. | орон нутгийн түвшинд иргэд интернэт ашиглах чадварыг сайжруулна.<br>5.3.7.Орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж шийдвэр гаргах бүх түвшинд ашиглана.<br>5.3.8.Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.<br>5.3.9.Цахим бизнес, цахим болон зайн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.<br>5.3.10.Ерөнхий сайдын дэргэд цахим засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны “цахим засгийн хороо (зөвлөл)” байгуулж, бодлогын нэгдсэн удирдлагаар хангана.<br>5.3.11.Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.<br>5.3.12.Цахим төлбөр тооцооны системийг төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн системтэй холбоно.<br>5.3.13.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэдэд төрийн | | |

| | | | |
|---|---|---|---|
| | үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоог дэмжиж хэрэгжүүлнэ.<br>5.3.14.Нэг иргэн-нэг бүртгэл хөтөлбөрийг эрчимжүүлж, төр иргэнээс нэг удаа мэдээлэл авдаг тогтолцоонд шилжүүлнэ.<br>5.3.15.Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үүлэн тооцооллын дэд бүтцийг өргөтгөж хөгжүүлнэ.<br>5.3.16.Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сүлжээг бий болгоно.<br>5.3.17.Төрийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой хэрэглээг нэвтрүүлж, байгууллага хооронд сайн туршлага хуваалцах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.<br>5.3.18.Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлнэ.<br>5.3.19.Иргэд төрийн байгууллагын албан тушаалтнуудтай цахим хэлбэрээр харилцах соёлыг хэвшүүлнэ.<br>5.3.20.Тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянах тогтолцоог бүрдүүлж, хэвшүүлнэ.<br>5.3.21.Мэдээллийн | | |

| | | | |
|---|---|---|---|
| | нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, хүнд суртал, авлига үүсэх эрсдэлээс хамгаална.<br>5.3.22.Хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох, төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.<br>5.3.23.Мэдээллийн технологийн аудитын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэн төрийн байгууллагын үйлчилгээ болон мэдээллийг цахим хэлбэрээр хүргэж байгаа байдалд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх үйл ажиллагааг хэвшүүлнэ. | | |
| ЧАДВАРЛАГ, ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБА<br>**Зорилт 5.4.**Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ. | | **Зорилт 5.4.** Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ. | **Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.** |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх үе. | 5.4.1.Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, ажлын үр дүнгээс хамаарч шатлан дэвших зохицуулалтыг боловсронгуй болгоно.<br>5.4.2.Төрийн албан хаагчийн цалин хөлс, | • Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшсэн байна.<br>• Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоо боловсронгуй | • Төрийн анхан, дунд шатанд буй авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.<br>• Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцлыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ.<br>• “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд зөвшөөрлийн цахим бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрөөс олгох зөвшөөрлийн |

| | | | |
|---|---|---|---|
| 1.Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшсөн байна.<br><br>2.Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоо боловсронгуй болсон байна.<br><br>3.Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдэж, ёс зүйтэй төрийн алба төлөвшинө.<br><br>4.Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчин бүрдсэн байна.<br><br>5.Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшсөн байна. | шагнал, урамшуулал олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.<br>5.4.3.Төрийн байгууллагын бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулна.<br>5.4.4.Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг нэгдсэн зарчим, бодлого, арга зүйгээр шинэчлэн тодорхойлно.<br>5.4.5.Төрийн албанд хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагаас чадварлаг хүний нөөцийг тодорхой хугацаанд шилжүүлэн ажиллуулах тогтолцоог бүрдүүлнэ.<br>5.4.6.Төрийн жинхэнэ албан тушаалд томилоход мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын үр дүн, улс болон салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг харгалздаг уян хатан тогтолцоог бэхжүүлнэ.<br>5.4.7.Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран шатлан дэвших зарчмаар төрийн албанд ажиллах нөхцөл, | болсон байна.<br>• Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдсэн байна.<br>• Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчин бүрдсэн байна.<br>• Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшсөн байна. | тоог цөөлж, олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.<br>• Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.<br>• Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.<br>• Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.<br>• Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.<br>• Шийдвэр гаргах түвшин **дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр,** эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүдийн үр дүнтэй оролцох манлайлан ажиллах тэгш боломжийг хангана.<br>• Үндэсний стандартуудыг **олон улсын түвшинд нийцүүлж шинэчилнэ.** (4.2.1-9) |

| | | | |
|---|---|---|---|
| | баталгааг бүрэн хангасан улс төрийн, хууль, эрх зүйн, эдийн засгийн тогтолцоог бэхжүүлнэ.<br>5.4.8.Төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр томилох, сургаж хөгжүүлэх бодлого, зохицуулалтыг чадахуйн зарчимд нийцүүлнэ.<br>5.4.9.Төрийн албан хаагчийн нэр хүндийг дээшлүүлж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах зохистой тогтолцоог төлөвшүүлнэ.<br>5.4.10.Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний салшгүй чухал хэсэг болгон үнэлэх тогтолцоог хэвшүүлж, сэтгэл гарган үйлчлэх соёл бий болгоно.<br>5.4.11.Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлж, ёс зүйн алдаа гаргасан төрийн удирдах албан тушаалтан сайн дураараа ажлаасаа чөлөөлөгддөг байх хандлага, ёс зүйг төлөвшүүлнэ.<br>5.4.12.Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, чиг үүргийн онцлогт тохирсон үе шаттай, тасралтгүй сургалтын тогтолцоог төлөвшүүлнэ.<br>5.4.13.Төрийн албаны сургалтын байгууллагын сургалт-судалгааны материаллаг орчин, хүний нөөц, | | |

| | | | |
|---|---|---|---|
| | технологи, арга зүйн чадавхыг бэхжүүлж, олон улсын жишигт нийцүүлэх шинэчлэл хийнэ.<br>5.4.14.Төрийн албаны сургалтад мэдээллийн технологид суурилсан олон хувилбарт аргуудыг нэвтрүүлнэ.Танхимын сургалтаас гадна цахим болон зайн сургалт, ажлын байранд сургах, цахим сургалтыг төрийн албаны орчин үеийн шаардлагад нийцүүлэн оновчтой ашиглах тогтолцоог бүрдүүлнэ.<br>5.4.15.Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээнд суурилсан, түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх иргэн төвтэй төрийн үйлчилгээний стандарт боловсруулж, нэвтрүүлнэ.<br>5.4.16.Төр-үйлчилгээний чанарын хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжинэ.<br>5.4.17.Төрийн үйлчилгээний зардал, үр ашгийн тооцоо гаргаж, төрийн бодлого, шийдвэрт тусгаж хэрэгжүүлдэг, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, санхүүжилт, үр нөлөөний байдалд хөндлөнгийн үнэлгээ хийж, иргэд, олон нийтэд мэдээлдэг тогтолцоонд шилжүүлнэ. | | |

| | | | |
|---|---|---|---|
| ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН НИЙГЭМ<br>**Зорилт 5.5.**Иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ. | | **Зорилт 5.5.** Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх үе.<br><br>1.Хүний эрхийг хангасан бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ.<br><br>2.Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоо төлөвшинө. | 5.5.1.Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөгжүүлнэ.<br>5.5.2.Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлж, хөгжүүлнэ.<br>5.5.3.Хүний эрхийн Үндэсний Комисс хараат бусаар үйл ажиллагаа явуулж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж, үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэнэ.<br>5.5.4.Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.<br>5.5.5.Хүний эрхийг хангахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж хамтран ажиллана.<br>5.5.6.Төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагын үйл | • Хүний эрхийг хангасан хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ.<br>• Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоо төлөвшсөн байна. | • Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.<br>• Шийдвэр гаргах түвшин **дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр,** эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүдийн үр дүнтэй оролцох манлайлан ажиллах тэгш боломжийг хангана.<br>(4.2.7-8) |

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллагаанд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн хяналт шалгалт, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.<br>5.5.7.Засаглалын үйл ажиллагаанд иргэд эрх тэгш оролцон үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломж, чадавхыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлнэ.<br>5.5.8.Нийгмийн бүлгүүд засаглалын үйл явцад тэгш оролцох боломжийг хангасан тогтолцоог бүрдүүлнэ.<br>5.5.9.Хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ. | | |
| АВЛИГАГҮЙ ЗАСАГЛАЛ<br>**Зорилт 5.6.**Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна. | | **Зорилт 5.6.** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе.<br><br>1.Нийгмийн бүх түвшинд шударга | **Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**<br>5.6.1.Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаар монгол хүний ахуй, соёл, зан төлөвт нийцүүлэн бүх шатны боловсролын хөтөлбөрт тусган, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж, шударга ёсны тогтолцоог төлөвшүүлнэ.<br>5.6.2.Төр, иргэний нийгэм болон бизнесийн | • Нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.<br>• Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига албан тушаалын гэмт хэрэг буурсан байна.<br>• Төрийн бүх шатанд авлигыг таслан зогсоох хөтөлбөр хэрэгжүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгосон байна. | • Төрийн анхан, дунд шатанд буй авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.<br>(4.2.1) |

| | | | |
|---|---|---|---|
| ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.<br><br>2.Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига албан тушаалын гэмт хэрэг буурсан байна. | байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга ёсны тогтолцоог эрхэмлэсэн соёлыг хэвшүүлнэ.<br>5.6.3.Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно.<br>5.6.4.Авлигатай тэмцэх болон шүүх, прокурорын байгууллагын авлига, албан тушаалын гэмт хэргийг шалган шийдвэрлэх чадавхыг бэхжүүлж, албан хаагчдыг мэргэшүүлж, үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэнэ.<br>5.6.5.Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна.<br>5.6.6.Авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн | | |

| | | | |
|---|---|---|---|
| | зохицуулалтыг боловсронгуй болгоно.<br>5.6.7.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, стандартыг тогтоон мөрдүүлнэ.<br>5.6.8.Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна. | | |
| ЗУРГАА. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ | | | |
| **Зорилго 7.**Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана | | **Зорилго 7.** Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана. | |
| ЗЭВСЭГТ ХҮЧИН<br>**Зорилт 7.1.**Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ. | | **Зорилт 7.1.** Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ. | **Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.** |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе.<br><br>1.Орон нутгийн | **Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**<br>7.1.1.Боловсролын бүх шатанд цэрэг-эх оронч хүмүүжил олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, тусгай анги танхим байгуулна.<br>7.1.2.Орон нутгийн хамгаалалтын тайван цагийн үндсэн арга хэмжээг зохион байгуулах чадавх, сургалтын тогтолцоог бэхжүүлж, томилгоот | • Мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, алба хаагчдын амьдрах нөхцөл шинэчлэгдэж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хувь нэмэгдсэн байна.<br>• Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилсэн байна.<br>• Энхийг дэмжих ажиллагаа болон | 1. Хугацаат цэргийн алба хаасан иргэдэд төрийн албанд орох, шатлан дэвших, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж хүртэх давуу эрх олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.<br>2. Зэвсэгт хүчний байгууламжийг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэн, мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчнийг бэхжүүлнэ;<br>3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ;<br>4. Зэвсэгт хүчний бүтцэд барилга-инженерийн, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний цэргийг байгуулна;<br>5. Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр хангах бодлогыг дэс дараатайгаар |

| | | | |
|---|---|---|---|
| хамгаалалтын тогтолцоо бэхжиж, батлан хамгаалах чадавх дээшилсэн байна.<br><br>2.Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн болон тусгай техник, тоног төхөөрөмжийг шинэчилж, зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавх дээшилнэ.<br><br>3.Дайчилгааны хууль, эрх зүйн орчин, төлөвлөлт боловсронгуй болж, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо нэмэгдэж, чанар нь сайжирсан байна.<br><br>4.Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаа болон улс орны бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлнэ.<br><br>5.Батлан хамгаалах төсвийн тогтвортой өсөлтийг хангаж, зарим төрлийн зэвсэглэл, техникийн эд ангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээг хангадаг болно. | нэгжийн бэлтгэлжилтийг хангана.<br>7.1.3.Орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлж, мэдээллийн нэгдсэн тогтолцоог байгуулна.<br>7.1.4.Мэргэшсэн чадварлаг байнгын бүрэлдэхүүнтэй, хөдөлгөөн, гал, цохилтын өндөр боломжтой хуурай замын цэргийн нэгтгэл, анги, салбарын тоог нэмэгдүүлж, зэвсэгт хүчний ачаа, тээврийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай техник, хэрэгслээр хангана.<br>7.1.5.Агаарын цэргийн командлалыг хөгжүүлж, агаарын хил, орон зайг хянах, улсын онц чухал, стратегийн ач холбогдолтой объектыг хамгаалах чадавхыг нэмэгдүүлж, агаарын цэргийн зенит пуужингийн хороо, радиотехникийн батальон болон радио электрон тэмцлийн батальон шинээр байгуулна.<br>7.1.6.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбаруудыг туулах чадвар сайтай тусгай зориулалтын хуягласан техник, хэрэгслээр хангана.<br>7.1.7.Цэргийн удирдлага, холбоо мэдээллийн хэрэгслийг шинэчилж, аюулгүй байдлыг хангах, кибер халдлагатай тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ.<br>7.1.8.Дайчилгааны нөөц бий болгох | улс орны стратегийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлнэ.<br>• Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэн, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн хангалт, бэлэн байдал дээшилсэн байна. | хэрэгжүүлнэ;<br>6. Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, Зэвсэгт хүчний олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ;<br>7. Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ;<br>8. “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, “Оюутан-цэрэг” сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлнэ;<br>9. Цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулна.<br>• |

| | | | |
|---|---|---|---|
| | батлан хамгаалахын нөөцийн менежментийн урт, дунд хугацааны бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.<br>7.1.9.Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын төвийг бүсчлэн байгуулна.<br>7.1.10.Энхийг дэмжих ажиллагааны анги, салбаруудыг орчин үеийн зэвсэглэл, техникээр хангаж, түргэн байрлах хүчин, шуурхай ажиллагааны бүлгүүд болон зэвсэгт хүчний 2 дахь батальон, инженерийн ротыг энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлнэ.<br>7.1.11.Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагааны газар оронд болон олон улсын цэргийн хүчний командлалын өндөр албан тушаалд ажиллах хүний нөөцийг бэлтгэх, үүрэг гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.<br>7.1.12.Төсвийн тухай хуульд батлан хамгаалах төсвийг тогтвортой өсгөхөд чиглэгдсэн зүйл, заалт тусгаж, улсын төсвийн зарлагын дунд эзлэх хувийг хуульчлан тогтооно.<br>7.1.13.Батлан хамгаалах салбарт инновацын тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, мэргэшсэн инженер, техникийн алба хаагчдыг үе шаттай бэлтгэх сургалтын тогтолцоог бий | | |

| | | | |
|---|---|---|---|
| | болгож, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.<br>7.1.14.Батлан хамгаалах салбарт нийцсэн технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, технологи дамжуулах төв, экосистем, шинжлэх ухааны парк байгуулж, батлан хамгаалахын болон иргэний зарим бүтээгдэхүүнийг зохион бүтээж, туршина.<br>7.1.15.Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, хөрөнгийн зориулалтыг төсөл хөтөлбөр санхүүжүүлэхэд зарцуулна. | | |
| **ХҮН, НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ**<br>**Зорилт 7.3.**Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ. | | **Зорилт 7.3.** Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үе.<br><br>1.Хууль сахиулах | **Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**<br>7.3.1.Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй дулааны цахилгаан станц, зарим аймгийн төв болон хүн амын суурьшилд, иргэдийн хөдөлгөөний нягтаршилт ихтэй сумдын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг хамгаалалтад авч, иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.<br>7.3.2.Хорих | • Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлсэн байна.<br>• Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт | **Амар тайван, аюулгүй нийгэм**<br>• Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэргийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.<br>• Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг,байгуулж,хуульд заасны дагуу мэдээллээр хангана.<br>• Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.<br>• "Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх чадавхыг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.<br><br>2.Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.<br><br>3.Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлж, улсын хэмжээний гамшгийн эрсдэлийн түвшнийг бүрэн тодорхойлно. | байгууллагын тогтолцоог бүсчилсэн хэлбэрээр хөгжүүлнэ.<br>7.3.3.Орон нутаг дахь цагдан хорих байрыг үе шаттайгаар шинэчлэх, олон улсын стандартад нийцсэн цагдан хорих, баривчлах байрыг шинээр барьж ашиглалтад оруулна.<br>7.3.4.Хорих ял эдлүүлэх орчин, нөхцөлийг хүний эрхийг хангасан түвшинд хүргэх замаар “Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага”-ын цогцолбор барилга, байгууламжийг ашиглалтад оруулна.<br>7.3.5.Хорих анги, цагдан хорих, баривчлах байр, “Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага”-д хоригдож, хүмүүжиж байгаа суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл, аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүний эрхийг дээдэлсэн орчин, нөхцөл бүрдүүлнэ.<br>7.3.6.Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна.<br>7.3.7.Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн | бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсэн байна.<br>• Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлнэ. | • Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулж, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн хохирол барагдуулалтыг нэмэгдүүлнэ.<br>• Шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангана.<br>• Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж буй баримтыг эх нутагт нь байршуулж, үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын баримтыг эдийн засгийн эргэлтэд оруулна.<br>• Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.<br>• Ачаа болон нийтийн зорчигч тээвэрлэлтийн зориулалттай тээврийн хэрэгсэл автомашины камертай байх стандартыг тогтоож, баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг үе шаттайгаар хязгаарлах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдал хангаж, замын тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна.<br>• Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлж, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна.<br>• Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон санхүүгийн системийг хөгжүүлнэ.<br>• Иргэдийн эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтүүдийг өндөр нарийвчлалтай тодорхойлж, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрсдэлд суурилсан хяналтаар чанд мөрдүүлнэ.<br>• Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна.<br>• Салбар дунд ашиглах “Агаарын аврах хүчин” байгуулна. |

| | | | |
|---|---|---|---|
| | худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг нийгмийн байгууллага, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.<br>7.3.8.Нийслэл, орон нутгийн төвүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын камерын нэгдсэн төв бий болгож, мэдээлэл, харилцаа холбоо, барилга байгууламжийн дэд бүтцийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.<br>7.3.9.Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлж, мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг бий болгон олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлнэ.<br>7.3.10.Улаанбаатар хотод төвлөрсөн, орон нутаг дахь цагдаагийн байгууллага бүрд стандартын шаардлага хангасан эрүүлжүүлэх байрыг үе шаттайгаар барьж ашиглалтад оруулна.<br>7.3.11.Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн | | • Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, хүрээлэн буй орчны эрүүл аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хэмжил зүйн эталоныг хөгжүүлнэ.<br>(Амар тайван аюулгүй нийгэм 4.2-16) |

| | | | |
|---|---|---|---|
| | хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.<br>7.3.12.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах шууд чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдын ашиглах төхөөрөмжийг шинэчилж, сайжруулна.<br>7.3.13.Тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд болон хилийн боомтыг хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг илрүүлэх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, түүхий эд (перкурсор)-д хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц, нохойн сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.<br>7.3.14.Гамшгийн үеийн үйл ажиллагааг орон нутгийн зөвлөлөөс мэргэжлийн түвшинд гүйцэтгэх үндэсний чадавхыг бэхжүүлж, орон нутагт анги, салбарыг үе шаттайгаар байгуулна.<br>7.3.15.Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлнэ.<br>7.3.16.Аюулын төрөл бүрээр гамшгийн эрсдэлийг үнэлэх арга, аргачлал, загварчлал боловсруулж, эрсдэлийн үнэлгээ | | |

| | | | |
|---|---|---|---|
| | хийнэ.<br>7.3.17.Инновацад суурилсан техник, технологийн шинэчлэлийг сайжруулж, кибер гэмт хэргээс хамааралтай цахим нотлох баримтыг бэхжүүлэх, үнэлэх, хиймэл оюун ухааныг ашиглах чадамжийг хөгжүүлж, энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.<br>7.3.18.Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх нэгжийн бүтэц, орон тоог өргөжүүлж, чадавхыг нэмэгдүүлэх, уг гэмт хэргийн улмаас хууль бусаар гадагш гарсан хөрөнгийг царцаах, буцаан авах талаар хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, сургалт, мэдээлэл солилцох арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна. | | |
| ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ХӨГЖИЛ<br>**Зорилт 7.4.**Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ. | | • **Зорилт 7.4.** Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ. | Шүүхийн хараат бус, шүүгчийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ. |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br><br>**I үе шат (2021-2030):** Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлж, хүний нөөцийн чадавхыг | **Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**<br>7.4.1.Салбарын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлнэ.<br>7.4.2.Нийгмийн харилцаа, эдийн засгийн хөгжлийн | • Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулсан байна.<br>• Гэмт хэргийн хохирол барагдуулах боломж, нөхцөлийг дээшлүүлсэн байна.<br>• Шүүхийн шинжилгээний байгууллагын бие | • Орон тооны гишүүдээс бүрдсэн Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн сахилгын хороог байгуулах замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлж, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн харьяанд шилжүүлнэ.<br>• Үндсэн хуулийн Цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг |

| | | | |
|---|---|---|---|
| бэхжүүлэх үе.<br><br>1.Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, салбарын алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлсэн байна.<br><br>2.Салбарын хөгжил, удирдлагын тогтолцоог бэхжүүлж, байгууллагуудын барилга, байгууламж, дэд бүтцийг системтэйгээр шинэчилнэ.<br><br>3.Салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлсэн байна.<br><br>4.Шүүхийн шинжилгээний байгууллагын техник, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадамж дээшилсэн байна. | өөрчлөлттэй уялдуулан салбарын бүтэц, зохион байгуулалт, орон тооны асуудлыг оновчтойгоор шийдвэрлэнэ.<br>7.4.3.Алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.<br>7.4.4.Салбарын алба хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ.<br>7.4.5.Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад иргэнд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгож, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эмнэлгийн түргэн тусламжийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагааны шуурхай байдлыг хангана.<br>7.4.6.Салбарын алба хаагчдын дүрэмт хувцас, зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар, стандартыг судлан тогтоож, лаборатори, үйлдвэр байгуулна.<br>7.4.7.Салбарын автомашин, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг үе шаттайгаар шинэчилнэ. | даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлсэн байна.<br>• Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгосон байна.<br>• Мал хулгайлах гэмт хэргийг бууруулсан байна.<br>• Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчин бүрдүүлсэн байна. | хангах тогтолцоог боловсронгуй болгоно.<br>• Хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэнэ.<br>• Эх газрын эрх зүйн хэв шинж, философид суурилсан Монгол Улсын өөрийн онцлогт нийцсэн, хүний эрхийг дээдэлсэн, эдийн засгийг өсөлтийг дэмжсэн урт хугацааны “Эрх зүйн шинэтгэл II” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.<br>• Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.<br>• Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж, цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.<br>• Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.<br>• Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.<br>• Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ, хязгаарыг тодорхойлж, хуулийн төслийн боловсруулалтын чанарын үр нөлөөг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах байнгын механизмыг бүрдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.<br>• Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.<br>• Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулна. |

| | | | |
|---|---|---|---|
| | 7.4.8.Ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын бодлогыг хангах зорилгоор “Цахим хяналтын төв”-ийг байгуулж, пробацийн тогтолцоог хөгжүүлнэ.<br>7.4.9.Иргэний үнэмлэх, гадаад паспортын бичилт хийх үйлдвэрийг өргөтгөж, бэлдэц үйлдвэрлэх дотоодын үйлдвэр байгуулна.<br>7.4.10.Бүртгэлийн байгууллагын мэдээллийн баазыг бэхжүүлэх, хадгалалтыг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий сервер, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилнэ.<br>7.4.11.Салбарын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх, дадлага зохион байгуулах хүчин чадал бүхий сургалтын төв байгуулна.<br>7.4.12.Оюуны өмчийн газрын байр, сургалтын төв, хөгжлийн төвийн цогцолбор барилгыг барьж олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг хөгжүүлнэ.<br>7.4.13.Хууль зүйн туслалцааны төв болон орон нутаг дахь улсын бүртгэлийн хэлтэс, шүүхийн шинжилгээний албаны ажиллах орчныг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг | | (4.4.1-11) |

| | | | |
|---|---|---|---|
| | нэмэгдүүлнэ.<br>7.4.14.Үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна.<br>7.4.15.Төрийн тусгай алба хаагчдын эмнэлгийг олон улсын стандартад нийцүүлнэ.<br>7.4.16.Иргэдэд эрх зүйн албан бус боловсрол олгох чиглэлээр сургалт үйл ажиллагаа зохион байгуулна.<br>7.4.17.Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх зорилгоор санхүүжилтийг нэмэгдүүлж, орчин үеийн техник, технологи болон программ хангамжийг нэвтрүүлнэ.<br>7.4.18.Үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.<br>7.4.19.Монгол Улсын түүх, соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг нээн илрүүлж, худалдан авах ажлыг зохион байгуулна.<br>7.4.20.Улсын бүртгэлийн мэдээллийн сан газар зүйн өөр байршилд нөөц сантай болгоно.<br>7.4.21.Криминалистик, шүүх эмнэлэг болон тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг | | |

| | | | |
|---|---|---|---|
| | сайжруулна. | | |
| Мэдээллийн аюулгүй байдал<br>**Зорилт 7.5.**Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно. | | • **Зорилт 7.5.** Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ. | |
| **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**<br>**I үе шат (2021-2030):** Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлэх үе.<br>1.Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ.<br><br>2.Сансрын технологийг судлан шинжлэх, эзэмших, ашиглах чадамж, дэд бүтцийг бэхжүүлж, сансрын технологид суурилсан үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.<br><br>3.Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдэж, технологийн хараат | **Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**<br>7.5.1.Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах халдлагыг илрүүлэх, таслан зогсоох чадавх бий болгож, кибер гэмт хэрэгтэй тэмцэнэ.<br>7.5.2.Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, төрийн албан хаагч, иргэдийн технологийн мэдлэг, инновацыг ашиглах чадавхыг дээшлүүлнэ.<br>.5.3.Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг хөгжүүлж, кибер аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг олон улсын ба бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэнэ. | • Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ.<br>• Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдэж, технологийн хараат байдал буурч, кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавх дээшилсэн байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| байдал буурч, кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавх бэхэжсэн байна.<br><br>4.Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн сан бүрдүүлж, төрийн болон албаны нууц задарч үрэгдэхээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, төрийн нууц задруулах, үрэгдүүлэх гэмт хэрэг, зөрчил үүсэх эрсдэл багассан байна. | 7.5.4.Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах оролдлоготой тэмцэх чадавх бүхий үндэсний компьютерын онцгой бэлэн байдлын багийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.<br>7.5.5.Цахим мэдээллийг ангилах, тодорхойлох, үнэлэх, төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байх талаар холбогдох хууль, дүрэм, журамд тусган онц чухал дэд бүтэц бүхий байгууллагуудад цахим халдлагатай тэмцэх баг бий болгож мэргэшсэн хүний нөөц бэлтгэж, хөгжүүлнэ.<br>7.5.6.Цахим мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлнэ,<br>7.5.7.Төрийн албан хаагч, иргэдийн технологийн мэдлэг, инновацыг ашиглах чадавхыг дээшлүүлнэ.<br>7.5.8.Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ.<br>7.5.9.Кибер аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг олон улсын ба | | |

| | | | |
|---|---|---|---|
| | бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэнэ.<br>7.5.10.Нийгмийн сүлжээ, цахим хуудас, телевизийн нэвтрүүлэг, нийтлэл хэлбэрээр дамжуулан олон нийтийн цахим мэдлэг боловсролыг дээшлүүлэн интернэтийн зохистой, соёлтой хэрэглээг нийтэд төлөвшүүлж, кибер орчинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.<br>7.5.11.Сансрын технологид суурилсан гарааны шинэ компаниуд, сансрын аялал жуулчлалын симуляци хийх нээлттэй баазын судалгаа хийж, гадаад улс орнуудтай хамтран хиймэл дагуул хөөргөж, газрын станц байгуулах хөрөнгө оруулалт татах арга хэмжээг авна.<br>7.5.12.Сансрын технологийн үндэсний мэргэжилтэн бэлтгэх их сургуулийн хөтөлбөр боловсруулж, сансар судлал ба өндөр технологийн институт байгуулан хөгжүүлнэ.<br>7.5.13.Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын сүлжээ ашиглан үндэсний харилцаа холбооны сүлжээний ашиглалт, хяналтын менежментийг бүрдүүлэх, уялдуулах сайжруулах сүлжээг өргөтгөн байгуулж | | |

| | | | |
|---|---|---|---|
| | ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж ажиллах, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.<br>7.5.14.Сансрын технологийг судлан шинжлэх лаборатори байгуулж, үндэсний хиймэл дагуулыг үйлдвэрлэж нэвтрүүлнэ.<br>7.5.15.Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамж, криптографийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах тогтолцоог бэхжүүлнэ.<br>7.5.16.Тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлж, тоон гарын үсгийг бүх нийтийн хэрэглээ болгох, тоон гарын үсэгт суурилсан цахим үйлчилгээний нууцлал, хамгаалалтыг хангана.<br>7.5.17.Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний хамрах хүрээг өргөтгөж (төв болон орон нутаг), хамгаалагдсан интернэт болон интернэт сүлжээнд төрийн захиргааны байгууллагуудыг бүрэн хамруулах замаар төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгож, хөгжүүлнэ.<br>7.5.18.Төрийн байгууллагуудын цахим халдлага | | |

| | | | |
|---|---|---|---|
| | зөрчилтэй тэмцэх компьютерын онцгой бэлэн байдлын баг байгуулж, мэдээллийн урсгалыг хянах замаар эмзэг байдлыг бууруулж, цахим форенсикийн үндэсний төвийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчилнэ.<br>7.5.19.Төрийн байгууллага болон Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчдийн газруудыг тусгай хэрэглээний сүлжээнд бүрэн хамруулах, шифр харилцаа нэвтрүүлж, тусгай хэрэглээний радио давтамжийн зурвасын ашиглалт, давтамж хоорондын нөлөөлөлд хяналт тавих техникийн нөхцөлийг бүрдүүлнэ.<br>7.5.20.Онцгой болон гамшгийн нөхцөл байдлын үед ашиглах зорилгоор нийслэл, аймгийн төвүүдийг холбосон богино долгионы радио холбооны сүлжээ болон хөдөлгөөнт холбооны төвүүдийг өргөтгөж, шинэчилнэ.<br>7.5.21.Мэдээлэл холбооны дэд бүтцэд холбогдоогүй алслагдсан цэгүүдийг холбосон мэдээлэл дамжуулах, солилцох сүлжээг байгуулна.<br>7.5.22.Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамж, криптографийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах | | |

| | | | |
|---|---|---|---|
| | тогтолцоог бэхжүүлнэ. 7.5.23.Төрийн нууцыг хууль бусаар олж авах, задруулах, үрэгдүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чадавхыг дээшлүүлж, алба хаагчдыг мэргэшүүлнэ. 7.5.24.Үндэсний дата төвийн мэдээллийн систем, сүлжээ, өгөгдлийн сангийн хамгаалалтыг сайжруулна. 7.5.25.Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах халдлагыг илрүүлэх, таслан зогсоох чадавх бий болгож, кибер гэмт хэрэгтэй тэмцэнэ. 7.5.26.Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож, хөгжүүлнэ. 7.5.27.Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын сүлжээ ашиглан үндэсний харилцаа холбооны сүлжээний ашиглалт, хяналтын менежментийг бүрдүүлэх, уялдуулах сайжруулах сүлжээг өргөтгөн байгуулж ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж ажиллах, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ. 7.5.28.Төрийн нууцын программ хангамжийг боловсруулж, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд | | |

| | | | |
|---|---|---|---|
| | нэвтрүүлж, төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулна. | | |

## 3.6.СҮҮЛИЙН 10 ЖИЛД ХИЙГДСЭН ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГАА, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГААН ДАХЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УЯЛДАА, ҮР НӨЛӨӨ*

Бид тогтвортой хөгжлийн талаар авч үзэхийн өмнө ардчилал, ардчиллын чанар, засаглалын асуудлыг тусгайлан судлах шаардлагатай. Учир нь аливаа хөгжлийг тууштай хэрэгжүүлэх, түүнийг залгамж хийгээд байнгын тасралтгүй хөгжлийн үйл явцыг үргэлжлүүлэхэд ардчилын чанар, түүний хөгжил, бэхжилт

* *Энэхүү мэдээллийн багцыг төслийн гүйцэтгэгч, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн ЭШДэА, доктор (Ph.D) О.Хатанболд бэлтгэн боловсруулсан.*

чухал үр нөлөөтэй юм. Энэ утга, агуулгаараа бид энэхүү бүлгийн тэргүүн хэсэгтээ ардчиллын чанар, түүний хөгжилд гүйцэтгэх үүрэг, үр нөлөөг тодруулан авч үзэхийг зорьлоо. Чингэхдээ юун түрүүнд ардчиллын чанар гэж юу болох, ардчилал, хөгжил хоёр хоорондоо холбогдох боломжтой эсэх, ардчиллын чанарын ач холбогдол тогтвортой хөгжилтэй хэрхэн уялдаж болохыг судлан шинжлэхийг зорив.

Ардчиллын чанарыг ярихаасаа өмнө, бид юун түрүүнд засаглалын талаар товч дурдах нь зүйтэй болов уу. Засаглал гэдэг нь анх [*kubernbo*] буюу *'залуурдах, жолоодох'* гэсэн утгатай грек үгнээс гарч латин болон бусад хэлэнд шилжсэн[1] бөгөөд монгол хэлнээ засаглал[2], засаглал[2], удирдлага хэмээн янз бүрээр хөрвүүлэн хэрэглэж байна.[3] «Засаглах» гэдгийг толь бичигт «үйл ажиллагаа, харилцаа, бодлого, чиг үүргийг чиглүүлэх, хянах», «хязгаарлалт хийх, зохицуулах, чиглүүлэх, захирах» хэмээн тодорхойлсон бол «засаглал»-ыг «төр засаг, хяналт, эрх мэдэл» гэсэн нь бий. Учир нь, засаглалын үзэл баримтлал төрийн удирдлагын шинжлэх ухаанд 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхнээс нэвтэрч эхэлсэн бөгөөд «засаглал» хэмээх үг гарал үүслийн хувьд эртний улбаатай боловч «сайн засаглал», «ардчилсан засаглал» гэсэн ойлголт хөгжлийн бодлого судлалын хүрээнд харьцангуй саяхнаас л «моод» болон орж ирсэн.[4] Үүнээс үзвэл, засаглалын тодорхойлолт нь өргөн буюу явцуу утгатай, нарийн тодорхой, эсвэл тодорхой бус байж болно. Явцуу тодорхойлолт нь заавал нарийн тодорхой байх албагүй. Өргөн утгатай тодорхойлолт нарийн тодорхой, эсвэл явцуу тодорхойлолт тодорхой бус байж болно. Тодорхойлолт нь хэдий чинээ нарийн тодорхой байна, үзүүлэлт гаргахын тулд ашиглах үзэл баримтлалын хүрээг боловсруулахад төдий чинээ хялбар[5] байдаг. Энэ бол хүний хүсэл зориг засгийн газрын эрх мэдлийн үндсэн суурь болох ёстойн дээр эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг авчрах бодлого ба улс төрийн мажоритор систем хоорондын бодит болон хийсвэр зөрчил нь өнөөг хүртэл мөнхийн сэдэв байсаар[6] ирсэн. Чингэхлээр, эдийн засгийн хөгжил болон улс төрийн тогтвортой байдал нь ашиг шимтэй өргөн уудам нутагт тааруу хүн амтай байсны үр дүн биш бөлгөө. Энэ бол хөгжлийн амжилттай бодлогын үндэс нь угтаа шударга байдал ба өмчийг албадан хураах, өмчөөсөө татгалзах эрсдэлгүй бөгөөд зах зээлд оролцогчдын хооронд эдийн засгийн ашигтай солилцоо явагдах нөхцөлийг бүрдүүлсэн тийм шударга ба тэгш эрхт систем юм. Угтаа үр дүнтэй засгийн газар маш чухал, учир нь түлхүүр хүчин зүйлийг тайлбарлагч нэлээн хүчтэй хамаарал бүхий хувьсагч нь хувь хүн эсвэл нэг байгууллага дангаар хийж

[1] Даваадулам Ц. Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг. УБ., 2010, 46 дахь тал.
[2] Сайн засаглалыг хангах төсөл. НҮБХХ. Засаглалын нэр томъёоны тайлбар. УБ., 2003, 20-21 дэх тал.
[3] Чимид Б. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ., 2006, 173-206 дахь тал.
[4] Weiss T. Governance, Good Governance and Global Governance: Conceptual and actual challenges, Third World Quarterly, 21 (5). 2000. pp. 795-814
[5] МХЗ-9 төсөл, НҮБХХ. ФСЭХ. Засаглалын үнэлгээг төлөвлөхүй: арга зам, ашиг тус, өртөг зардал. Хэрэглэгчийн гарын авлага. Орч. Цэрэннадмид Ч. Ред. Доржсүрэн П. УБ., 2010, 44 дэх тал.
[6] Марк Платннер. Либералчлалаас либерал ардчилал руу. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). УБ., 2005, 13 дахь тал.

эс чадах хамтын үйлдлийг тусган харуулж буй.[1] Аливаа ард түмэн өөрсдийн өмнө бий болсон асуудлуудын талаар тодорхой буюу рационал санаа бодолтой байдаг бөгөөд тэрхүү санал бодол нь ардчилсан оронд өөрсдийн санаа бодлоо баталгаажуулахын тулд түүнийг хэрэгжүүлэхээр ажиллах, цаашлаад өөрсдийн төлөөлөгчөө сонгодог нь бидний өнөөг хүртэл баримталж ирсэн сонгодог онолын эргэлзээг тайлах гэсэн оролдлого юм. Нэг үгээр хэлбэл, ард түмний гол үүрэг бол төр засаг болоод гүйцэтгэх засаглалыг бүрдүүлэх эсвэл түүний үүргийг хэрэгжүүлэх завсрын нэгэн байгууламжийг бүрдүүлэхэд оршдог.

Тодруулбал, ардчилсан арга гэдэг нь хувь хүмүүс ард олны саналын төлөөх өрсөлдөөнт тэмцлээр шийдвэр гаргах эрх мэдлийг олж авдаг явдлаар илэрхийлэгдсэн улс төрийн шийдвэр гаргах институционал журам юм. Тэрхүү институционал журам нь ард түмэн өөрөө засаглах эрхийг бодитой хянах бүх талын бололцоог хангах явдал болохоос ардчиллын үзэл санааг хүлээн авч тунхагласнаар бий болдог зүйл огт биш. Фрэнсис Фукуямагийн үзэж буйгаар, аливаа улс оронд ардчилсан үйл явц бодитой хэрэгжихдээ: *(i) ардчиллын үзэл санааг хүлээн авч дэлгэрүүлэх; (ii) улс төрийн шинэ ардчилсан бүтцийг бий болгох; (iii) ардчиллыг хөгжүүлэх эдийн засгийн таатай нөхцөл бүрдүүлэх; (iv) иргэдийн оролцоо, иргэний нийгмийн зохистой төлөвшлийг хангах; (v) иргэдийн улс төрийн боловсрол, соёлыг төлөвшүүлэх зэрэг цогц үйл ажиллагааг* шаарддаг байна. Энэ бол, өөр хоорондоо холбоотой эдгээр үйл явцын бодит хэрэгжилт ардчиллыг хөгжүүлэх талаар хүрсэн төвшин, ардчиллын үзэл санааны үнэ цэнийг харуулж, тухайн орон ардчилсан орон мөн, бишийг тодорхойлоход арга зүй үнэ цэнэтэй хэвээр байна. Профессор Самуэль Хантингтон нийгэм ба ардчиллын хэмжээний талаар авч үзэхдээ, аль нэг улс төрийн нэгжийг тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ эсвэл ардчиллын хэлбэрээр ялгалгүйгээр тухайн иргэн өөрийгөө засаглалын ардчилсан бус дэглэмтэй оронд ардчилсан өөрчлөлт болж байна гэж төсөөлж болно. Чингэхдээ иргэд байнга цугларж, тэрхүү цугларалт бүрээрээ дээд засаглалаа хэрэгжүүлж чадахуйц жижиг хэмжээтэй байлаа ч гэсэн улс орноо хэдэн арав байтугай хэдэн зуун жижиг улсууд болгон задраахыг хэзээ ч хүсэхгүй[2] нь ойлгомжтой. Тиймээс ардчилсан орнуудын иргэд нь засаглалынхаа тогтолцооны бодит нөхцөлд өөрсдийн төлөөлүүлсэн төлөөлөгчдөд асар их эрх мэдлийг шилжүүлж, улмаар шийдвэр гаргах маш чухал хариуцлагыг нарийн механизмаар дамжин эрхээ захиргааныхан, түшмэд, албан тушаалтнуудад олгосноор ард түмний зүгээс хянах боломж хязгаарлагдмал байгаа хэдий ч улс төрийн дээдсийг ардчилсан нийгэм дэх дарангуйлагч болгохгүйн тулд улс төрийн сонгууль явуулж тэдэнд ард түмний санал бодолд нухацтай хандах цаг нэгэнт ирснийг харуулах

---

[1] Ричард Ролл., Жон Р.Талбот. Улс төрийн эрх чөлөө, эдийн засгийн чөлөөт байдал ба хөгжил цэцэглэлт. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). УБ., 2005, 266 дахь тал.

[2] Huntington P. Samuel. How countries Democratize. Political science quarterly, New Haven., 1991, Vol. 106.

нийгэм, улс төрийн томоохон шалгуур бүхий үнэлэлт дүгнэлт өгөхөд хүргэдэг. Гэвч зарим нэг бодит, идеал үзэл үйл ажиллагааг өөрийн орны онцлогт тохирсон ардчилал, засаглалыг хэрэгжүүлж бодит амьдрал дээр уг онолын үзэл санааг үр дүнтэй хэрэгжүүлбэл зохилтой. Түүхэн шинэ эриний мөн чанар нь хүний сэтгэл санааны өөрчлөлт буюу дотоод хүчин зүйлүүд, механик маягын гадаад өөрчлөлтүүдийн нийлбэрийн үр дүн юм. Гадаад өөрчлөлтүүдийн дотроос хамгийн гол нь засаглалын шилжилт бөгөөд энэ нь хойноосоо сэтгэл санааны өөрчлөлтийг дагуулдаг жамтай. Чухамдаа захирна гэдэг нь нийгмийн хүсэл зоригт тулгуурласан эрх мэдлийн ердийн илэрхийлэл юм. Нийгмийн хүсэл зоригоос гадуур засаглал ертөнцөд хэзээ ч байгаагүй билээ. Тиймээс ч, засаглалын асуудал өнө эртнээс судлаач, мэргэдийн анхаарлыг татсаар ирсэн бөгөөд эдүгээ нэлээд цэгцэрсэн онол, үзэл баримтлал бий болсон байна.

Бидний өгүүлэн буй энэ сэдвийн хүрээнд нэн тэргүүнд ардчиллын чанарыг хамгийн товч байдлаар тайлбарлахад дараах дүр зураг бидэнд нэн тэргүүнд ажиглагдана.

Хүн төрөлхтний хөгжлийн түүхийг дарангуйллаас эрх чөлөө рүү тэмүүлсэн түүх гэж үзэхүл, ардчиллын шинж чанарыг тодорхойлохын тулд түүний эсрэг улс төрийн дэглэм болох дарангуйлалтай юуны түрүүнд жишиж харьцуулах нь зөв билээ. Австрийн нэрт философич Карл Попперийн хэлсэнчлэн: *«…бид сонголтоо хийхдээ ардчиллын эргэлзээ төрүүлдэг сайн тал гэхээсээ илүү дарангуйллын ерөөс эргэлзээ төрүүлдэггүй гажигийг тод хардаг. Энэ нь ардчиллыг сонгох хангалттай нөхцөл болно»*[1] Ардчилал ба дарангуйллын суурь ялгааны утга санааг олон эрдэмтэн судлан харьцуулж, энгийн загварт оруулсан байдаг. Энд, тухайлбал, Роберт А.Даль, Ж.Бондель, Э.Френкель нар улс төрийн системийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн хоорондын хамаарал, эрх мэдлийн хуваарилалт зэрэг олон асуудлыг логик, арга зүйн үүднээс задлаж тодорхойлсон загварынхаа хэлбэрийг гаргасан нь бий.[2] Харин Самуэль Р.Хантингтон, Клемент Х.Мүүр нар, «*Хүн амын дийлэнх нь оролцох боломж бүхий өрсөлдөөнт сонгуулиар улс төрийн системийн гол гол удирдагчид нь сонгогдож байгаа нөхцөлд ардчилал оршин байна*»[3] гэсэн бол, Хуан Ж.Линц «*Засгийн эрхийг тодорхой хугацаанд барих эрхийг ёслон батлах үүднээс удирдагчдын хооронд чөлөөт өрсөлдөөн явуулахын тулд эвсэн нэгдэх, мэдээлэл хүртэх, харилцаанд орох зэрэг үндсэн эрх чөлөөнд тулгуурлан улс төрийн хүсэл зоригоо чөлөөтэй тодорхойлох боломж бүрдүүлж буй бол*» улс төрийн системийг ардчилсан[4] хэмээн үзнэ гэжээ. Тэгвэл,

[1] Поппер Карл. Нээлттэй нийгэм түүний дайсан. ННФ. «Адмон» ХХК. УБ., 2003. 67 дахь тал.

[2] Dahl A. Robert. Poliarchy: Participation and Opposition. New Heaven-London, 1978.//Голосов Г.В. Сравнительная поитологояв Новосибирск, 1995, стр. 51. Ernst Fraenkel. Strukturanalyse der modernen Demokratie. Hamburg, 1973, p. 404.

[3] Democracy exists where the principal leaders of a political system are selected by competive elections in which the bulk of the population have the opportunity to participate. Samuel P. Huntington, Clement H. Moore. Authoritarian Polities in Modern Soceity. The dynamics of Established One-Party-Systems. NY-London, 1970, p.509.

[4] When it allows the free formulation of political preferences, through the use of basic freedoms of assocation, information, and communication, for the purpose of free competition between leaders to validate at regular intervals … to rule. Juan J. Linz. Totalitarian and Authoritarian Regimes. Handbook of Political Sceince #3. Macropolitical Theory, Reading/Mass, 1975, p.182.

Сеймур Мартин Липсет «*Цогцолбор шинж бүхий нийгэм дэх ардчилал бол засаглаж буй эрх баригчдыг өөрчлөн солих үндсэн хуульд тулгуурласан тогтмол боломжийг хангаж буй улс төрийн систем мөн бөгөөд улс төрийн албан тушаалд өрсөлдөгч нарын дотроос сонголт хийх замаар хүн амын хамгийн их боломжит хэсэгт шийдвэрийн ихэнхэд нөлөө үзүүлэх эрх олгодог социал механизмыг хэлнэ*» [1] хэмээн тодорхойлсон. Эдгээр тодорхойлолтын утга нь улс төр судлаач Аренд Лийпхарт, Роберт А.Даль, Жиованни Сартори нарынхтай төстэй гэж үзэх үндэстэй юм.[2] Эл үүднээс, улс төрийн шинжлэх ухаанд «*Ардчилал судлал*» хэмээх судалгааны бие даасан чиглэл хөгжиж, нийтийн анхаарал татсан асуултанд хариулахыг оролдож байна. Харин орчин үеийн судалгаа нь прагматик шинж давамгайлсаны дээр ардчиллын философи, арга зүйн тухай сэдэв прагматик асуудлуудтай харьцуулахад бага яригддаг. Орчин үед ардчиллын чанарын шалгуур нь агуулгын хувьд, (i) иргэдийн ашиг, сонирхлыг хангаж ажилладаг хууль ёсны дэглэм; (ii) эрх чөлөө, улс төрийн тэгш байдлын орчин; (iii) засаг төрийг иргэд хараат бус, бие даасан байдлаар хянах, үнэлж дүгнэх эрх; (iv) төрийн албан тушаалд сонгогдох, томилогдоход оролцох, өрсөлдөх боломж; (iv) улс төрийн хариуцлага тооцох бололцоо; (v) төрийн институт бүрийн босоо, хэвтээ чиглэлд хариуцан тайлагнах, харилцан хяналттай, тэнцвэртэй байдал гэсэн багц үзүүлэлтийг багтаадаг.

Чингэхлээр, ардчиллын мөн чанар бол олон нийтийн санаа бодлын илэрхийлэл, тэдний хүчин чармайлт, сонгох, сонгогдох эрх, төрийн болон хууль тогтоох үйл хэрэгт оролцох эрхээр хэмжигдэнэ.[3] Энэ бүх зарчим, сорилт туршилтууд нь төрийн болон хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх, шүүх засаглалын эрх хэмжээ, эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэржилтийг хангахын сацуу улс төрийн байнгын өндөр төвшинд бий болдог далд явуулгыг эсэргүүцэх боломж үндэсний хэмжээнд хөндлөнгөөс таслан зогсооход энэ бүх зарчим, сорилт туршлагууд хэрэглэгдэх учиртай. Өнгөрсөн гучаад жилийн туршид дэлхийн ихэнх оронд ардчилал түгэн дэлгэрсэн бөгөөд эрдэмтдийн анхаарлын гол нь улс төрийн дэглэмийн шилжилтийг тайлбарлахаас эхлээд ардчилсан дэглэмийн мөн чанарын асуудалд төвлөрлөх болсон. 1990-ээд оны эхэн үед ардчиллын тухай зохиол бүтээлүүдэд гол төлөв ардчилал руу шилжих шилжилтийн талаар бичдэг байсан бол, орчин үед олонх эрдэмтэд, улс төрчид, ардчиллын төлөөх идэвхтнүүд, иргэний нийгмийнхэн ардчиллын чанар, түүнийг хэрхэн бий болгох вэ гэдэгт голлон анхаарах болсон.

---

[1] Democracy in a complex soceity may be defined as a political system which supplies regular constitutional opportunities for changing the governing officials, and a social mechanism which permits the largest possible part of the population to influence major decisions by choosing among contenders for political office. Seymour M. Lipset. Political Man. The Social Bases of Politics. London, 1983, p. 27.

[2] Arend Lijphart. Democracies. Patterns of Majorritarian and Consensus Democracies in Twenty-One-Countries. New Heaven-london, 1984, Dahl A. Robert. Polyarchy. Participation and Opposition. New Heaven-London, 1978, Giovanni sartori. Demokratiethorie. Darmstadt, 1992.

[3] Charles de Gaulle, excerpted from «The Bayeux Manifesto» [address delivered 16 June 1946]. Parliamentary versus Presidential Government. Edited by Arend Lijphart. Oxford University Press. 1992. pp. 139-141.

Нөгөө талаар, ардчилал гэдэг бол олон нийт нь олон нийтийн маягаар буюу олон иргэд оролцон олон нийтийн маягаар хамтрах хэлбэр бөгөөд тэдгээр хүмүүсийн хамтран амьдрах хэлбэрийн гол утга чанар нь иргэн бүр өөрийн хувийн хаялбараас үүдэн гарсан өвөрмөц үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж байдагт оршдог аж. Тэрхүү иргэн бүрт өөрийгээ чөлөөтэй илэрхийлэх баталгаа олгож чадахуйц эрх чөлөөт орчинг бүтэц байгууламж буюу институци болгож тогтоосон нөхцөлд л ардчилал үүсдэг.[1] Чингэхдээ улс төрийн ертөнцийн нийтийн хүрээний шинж чанараар илрэх ертөнцийн нээлттэй мөн чанар эхлээд олон хаялбарт талбар гаргаж өгдөг орон зай маягаар өөрөө ил тод болдог үзэгдэл ажээ. Улс төрийн ертөнц нээлттэй байх арга, орон хэмжээ болох димензион маягаар ардчилсан үзэл бодлын маргаан хэлэлцүүлгийг дамжин хоёр дахь удаагаа нээгддэг. Уг мэтгэлцээн явагдаж байх тохиолдолд л, ертөнцийн нээлттэй байдлын шинж чанар хадгалагдах төдийгүй ардчиллын эх үүсвэр олон нийтийн оролцооны маягаар хамгийн анх бий болж өөрөө нээлттэй болдог. Нарны гэрэлд ургамлын навч нахиа урган дэлгэрч байдгийн нэгэн адилаар ардчилал үүсч хөгжихийн хирээр нээлттэй байдлын хэм хэмжээ нэмэгдэн улс төрийн ертөнцийн "нахиалалт" явагдаж эхэлдэг. Түүний энэ үндсэн ойлголтын туршлага нь түүнд өөрт нь агуулагдаж буй хүний эрхэм чанарын субъектив биш ухамсараар дамжин соёлын бүх хүрээний гишүүдэд ойлгомжтой болдог гэдгийг ч хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болохыг доктор Ч.Ган-Өлзий[2] онцолсон байдаг.

Онолын энэхүү шинэ урсгал, арга барилын шинэчлэл, бодит байдалд тулгуурласан судалгааг голчлон үзэж, улмаар дараах ойлголтуудаас үүдэлтэй шинэ суддагдахуунуудыг тодруулах болсон. Тухайлбал, (i) ардчиллыг гүнзгийрүүлэх нь ёс суртахуун сайн үйл төдийгүй зайлшгүй хийх ёстой зүйл; (ii) хэрэв ардчилал нь өргөн цар хүрээтэй бөгөөд урт хугацаанд үргэлжлэх хууль ёсыг бий болгохыг эрмэлзэж байвал ардчиллын чанарыг сайжруулах шинэчлэл хийх нь туйлаас чухал; (iii) мөн олон нийтийн стэгэл хангалуун бус байдал, бодит үнэний тухай гайхашрал зэрэг хуримтлагдсан асуулуудаа шийдвэрлэхийг хүсч байгаа тохиолдолд урт удаан хугацаанд оршин тогтнож буй ардчилалд ч мөн шинэчлэл хэрэгтэй. Энэ бол олон нийтийн зүгээс төр засаг, улс төрчдөд итгэх итгэл алдарсан, улс төрийн нам нь олон нийтээс холдсон, улс төрчид, төр засгийн хүмүүс нь авлигад автсан гэдэг ойлголт түгээмэл болсон, мөн тэд хувийн сохирхол ихтэй, түүндээ хэт автсан, хариуцлагагүй болсон зэргийг хэлж буй болно. Өөрөөр хэлбэл, ардчиллын чанар бол эрх чөлөө, хуулийг дээдлэх ёс, хариуцлагын хэвтээ болон босоо тогтолцоо, хариу өгөх үүрэг, тэгш эрх, оролцоо, өрсөлдөөн, ил тод байдал, үр дүнтэй төлөөллийг багтаасан хэмжүүр юм.[3]

[1] Ган-Өлзий Ч Батын. Улс төрийн ертөнцийн өөрийгөө нээн харуулах гоц чанарыг судлахуй. ФСЭЗХ. ШУА. УБ., 2006, 39-41 дэх тал.
[2] Ган-Өлзий Ч Батын. Нийтийн хүрээний өөрөө тодрох гоц чанар. Философийн хүрээлэн. ШУА. УБ., 2015, 145 дахь тал.
[3] Даймонд Ларри., Морлино Леонардо. Ардчиллын чанар: Товч агуулга. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). УБ., 2005, 60-61 дэх тал.

Тиймээс ардчилал болон дарангуйлал хоёрын үндсэн ялгаа нь гэвэл ардчиллын үед хүмүүс нээлттэй байж чаддаг бол нөгөө тохиолдолд ул суурьтай, ухаалаг байхыг хүсдэг зүйл юм.

Өөрөөр хэлбэл, ардчилсан нийгэм бол шударга хариуцлагатай, бүх талын оролцоог хангасан, бүх иргэдийнхээ эрх, эрх чөлөөг дэмжин хамгаалдаг, нээлттэй ил тод, тохиолдож болох сорилт бэрхшээлийг үл харгалзан хүлээн зөвшөөрөгдсөн, эрх зүйн хэм хэмжээ болон хариуцлагын зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улмаар ардчилалд ямар шалгуурууд хэрэгтэй вэ гэдгийг тодруулдаг. Угтаа энэ бол боломж мөн учраас ардчилал үр ашигтай оролцоо, саналаа тэгш эрхтэйгэрэ өгөх, мэдээлэлд тулгуурлан ойлгох ойлголтыг бий болгож гэмээ нь аливаа хэлэлцэх саналуудыг бүрэн дүүрэн хянах хяналтын тогтолцоог бий болгодог. Чингэхдээ нийгмийн амьдралд оролцож, улмаар мөнхүү оролцоог дараах байдлаар нөхцөлүүлдэг. (i) төрийн засаглалд болон орон нутгийн өөрөө удирдах засаглалыг санал хураах замаар хурлын төлөөлөгчдийг сонгох, (ii) парламент нь зөвхөн улсын хэмжээний хуулиудыг тогтоох; (iii) засаглалын эрх хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван хоорондоо ижил тэнцүү эрхтэйгээр хуваарилагдана. Нөгөө талаар, ардчиллын чанар олон намын тогтолцоонд суурилсан үндсэн хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж, улс төрийн шийдвэрийг олонхиор гаргахдаа цөөнхийн сонирхлыг хүндэтгэн үзэх учиртай. Нөгөөтээгүүр, ардчилал нилээн сайн хөгжсөн орнуудад ч мөн адил ард түмэн нь эдийн засгийн болон нийгмийн үр дагаварт сэтгэл дундуур байдаг. Тэд нийгмийн шударга ёс, улс төрийн өргөн оролцоо болон хүчирхийллийг эв найрамдлаар шийдэхийн төлөө ардчиллын төлөө тэмцэж ялсан. Нөгөө талаар, тэд зөв ч бай, буруу ч бай ардчиллын үр дүнтэй хөгжлийг авчирна хэмээн итгэж, найддаг. [1] Энэ бол урд нэгэнтээ дурдсан ардчиллын найман хэмжүүрээр ардчиллын чанарыг хэмихийн өмнө ардчилал чухам юу болохыг ухаж мэдэх нь чухал. Угтаа ардчилал бол, нэн тэргүүнд (i) насанд хүрэгчдийн бүх нийтээрээ сонгох эрх, (ii) дахин болдог, чөлөөт, өрсөлдөөнтэй, шударга сонгууль, (iii) нэгээс илүү улс төрийн нам ба (iv) мэдээллийн эх сурвалжуудыг сонгох боломж юм. Дээрх гурван шаардлагыг бүрэн хангасан улс төрийн дэглэм нь эдгээр үндсэн хэм хэмжээг нэгэнт хангаж чадсан байвал үлгэр жишээ ардчиллын гурван зорилго болсон улс төрийн ба иргэний эрх чөлөө, олон нийтийн бие даасан байдал *(төрийн бодлого ба түүнийг боловсруулагчад хяналт авах),* мөн улс төрийн эрх тэгш байдал *(эрх ба эрх мэдлийн)* ба сайн засаглалын стандарт хэм хэмжээ *(ил тод байдал, хууль ёс, мөн хариуцлагын дүрэм гм)* зэргийг хэрхэн хэрэгжүүлснээр ардчиллын чанар[2] тодорхойлогдоно.

---

[1] Сен Амартия. Ардчиллын сул талыг шийдвэрлэснээр ардчиллыг гүнзгийрүүлэх нь. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). УБ., 2005, 16 дахь тал.

[2] Диамонд Ларри., Морлино Леонардо. Ардчиллын чанар: Товч агуулга. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). УБ., 2005, 62 дахь тал.

Тиймээс ардчилал нь нийгмийг шинэчлэлд хүргэдэг. Учир нь ардчилсан тогтолцоо нь алдаа дутагдал гаргасан эсвэл хэрэгцээгүй болсон бодлого ба улс төрчдийг тогтмол тайван аргаар халж өөрчлөх боломж олгох замаар нийгмийн болон үе хоорондын шинэчлэлийг хийж өгдөг бөгөөд ингэхдээ ардчилсан бус дэглэмийн үед гол боловсон хүчнийг зайлуулснаас үүдэн гардаг шиг томоохон төрийн хямрал үүсгэхгүйгээр шинэчлэлийг хийх чадвартай шударга төрийг эрхэмлэдэг ард түмэнд үйлчилдэг төр юм. Тэрхүү төр засаг нь олон нийтийн өмнө хариуцан тайлагнадаг байх нь нэг талаас эрх зүйн хувьд хариуцан тайлагнах буюу төрийн бүх албан тушаалтнууд хуулийг чандлан сахиж шүүхийн өмнө хариуцлага хүлээдэг байх явдал нөгөө талаас засгийн газар бодлого үйл ажиллагааныхаа төлөө парламент болон олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг байх буюу улс төрийн хувьд хариуцан тайлагнадаг, харгис догшин, ёс суртахуунгүй дарангуйлагчдын засаглалыг эсэргүүцдэг, ямагт ард түмний язгуур эрх ашгийг хамгаалдаг хэрэгслүүр болно. Нөгөө талаар, ардчилсан нийгэмд хүчирхэг иргэний нийгэм, үр өгөөжтэй улс төрийн аль аль нь хэрэгтэй байдаг. Үүнээс иргэний нийгмийн тухай олон тодорхойлолтоос ардчиллыг дэмжигчдийн дундаас хүлээн зөвшөөрөгддөг нэг тодорхойлолт нь: Төр, гэр бүл хоёрын хоорондох орон зайд үйл ажиллагаагаа явуулдаг, өөрсдийн сонирхол, үнэт зүйлсээ хамгаалах, хөгжүүлэх хүсэл бүхий иргэний нийгмийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, төрөөс ангид, хараат бус байгууллагуудыг бүрдүүлдэг альтернатив сонголт юм.

Энэ бүхнээс үзвэл, ардчилал нэгэнт тогтсон бол түүнийг хэрхэн тогтоон барих вэ гэсэн асуудал бидний өмнө тулгарах нь тодорхой юм. Мэдээж хэрэг үүнд зориулсан жор гэж байхгүй нь адил барууны ардчилсан орнууд язгууртнуудын хариу үйлдэл, цэргийн дарангуйлал, мөн фашизмын гарт орж үе үе ухралтад орж байсны эцэст урт удаан хугацааны дараа тогтвортой байдалд хүрч чадсан. Ардчилал шинээр тогтоосон зарим нэгэн улс орон ардчиллыг тогтвортой хөгжүүлэх тааламжгүй нөхцөл байдалтай тулгардаг. Нэг талаас нийгмийн хуваагдмал байдал нь чөлөөт улс төрийн оролцооны нөхцөлд тохирохооргүй, хэт гүнзгийрсэн байж болно. Гэхдээ хүмүүс тааламжгүй нөхцөл байдлын өмнө хүчин мөхөс гэж үзвэл алдаа болно.[1]

Ардчилсан институциудийг бэхжүүлж, улмаар ирээдүйд өртөж болзошгүй тэдний дарамт шахалтуудын эсрэг сөрөн зогсоход чиглэсэн арга хэмжээг авах нь зүйтэй. Чингэхлээр, хөгжлийг зүгээр л чанарын өөрчлөлт юм гэж хэлээд орхичихож болохгүй. Хөгжил бол чанарын өөрчлөлт мөн гэж хэлэн нь үнэндээ хөгжлийн тухай тодорхойлолт хараахан биш. Ийм болохоор тогтвортой хөгжил, бүтээлч хөгжил гэдэгт тодорхойлолт өгөхөөсөө өмнө ерөөсөө "хөгжил" гэдэг

[1] Дэвид Бийтхам ба бусад. Ардчиллыг тодорхойлохуй: 80 асуулт хариулт. Орч Г.Батбаяр. Ред. Жаргалсайхан Б. УБ., 2005, 32, 35 дахь тал.

ойлголтдоо тодорхойлолт өгч, энэ үндсэн дээрээ хөгжлийн хэбэр дүрсийн (тогтвортой, бүтээлч гм) тухай яривал авалцдаа сайтай болох ажгуу. Тэгвэл энэхүү дэвшүүлсэн урт хугацааны бодлогыг ханган биелүүлэхийн тулд биднээс юу шаардагдаж буй болон бид юу хийх ёстой асуудал гагцхүү ардчиллын чанарт, ардчилсан эгэх хариуцлага, ёс суртахуунтай үйл ажиллагааг шаарддаг. Тиймээс л, бид ардчиллын чанар, түүний тогтвортой байдал нь тогтвортой хөгжлийг бий болгож, ханган биелүүлэхэд хэрхэн нөлөөлж, бас хамаарч болохыг тодруулах нь энэ бүлгийн гол зорилго оршино. Нөгөөтээгүүр, нийгмийн өмнө тулгарч байгаа эдийн засаг, нийгэм, улс төрийн шинжтэй бэрхшээлтэй асуудал буюу эдийн засгийн зогсонги байдал, материаллаг болон нийгмийн дэд бүтцийн доройтол, ардчилалд татан оролцуулах явдал болон иргэний нийгмийн орон зай үгүйлэгдэж байгаа нь хямрал мөргөлдөөн зэрэг шинэ шинэ асуудлууд тулгарч[1] байна.

Тиймээс, бид ардчиллын чанар, түүний хөгжилд гүйцэтгэх үүрэг, үр нөлөөг дараах байдлаар томъёолон гаргах оролдлогыг энэхүү бүлэгтээ хийж буй. Үүний нэн тэргүүний авч үзэх асуудал бол ардчиллын чанар өнөөгийн Монгол Улсад ямар хэмжээнд буйг тодруулах явдал хэмээн үзэж, эл асуудлын үндэслэлийг эхлэн тодорхойлохоос бидний шинжилгээний ажил эхлэх учиртай гэж ухан онолын дэлгэрэнгүй санааг сэдвийн эхэнд тэмдэглэсэн нь буй. Тухайлбал, Амартия Сэний нэгэнтээ нотолсноор ардчиллыг тогтоохын тулд ядуурал, өлсгөлөнгийн асуудалтай холбогдуулж юуны түрүүнд авах арга хэмжээ нь тарчиг байдал, өлсгөлөнгөөс хамгаалах явдал юм. Ихэнхдээ өлсгөлөн тарчиг байдал зах зээлийн эдийн засгийн үед болон зах зээлийн бус социалист эдийн засгийн үед тохиолддог бөгөөд Засгийн газар тарчиг амьдралаас сэргийлэхийн тулд түргэн арга хэмжээ авах хэрэгтэй болдог аж. Түүнийхээр, ардчилал бол ард түмнийг хүндэлдэг ба тэдний асуудалд хариу өгдөг тул оршин тогтносоор байна. Иймд туслам болон хөрөнгө оруулдаг донор орнууд, олон улсын байгууллага, компаниуд ардчиллыг зүрх сэтгэлдээ хүлээн авах хэрэгтэй. Дарангуйлагчдад мөнгө олгох нь буруу бөгөөд зарим тохиололд хор хөнөөл учруулдаг. Тиймээс дарангуйлагчид зөвхөн улс төрийн намуудыг хориглох, чөлөөтэй үг хэлэхийг хориглоод зогсохгүй, ард түмнийхээ эрүүл мэнд, сайн сайханд хор хохирол учруулдаг. Чухамдаа, ардчиллыг сонгон авсан засгийн газар хууль ёсны эрх чөлөө нь улс төрийн шударга ёс, сайн сайхан амьдралын суурь[2] болох учиртай. Чингэж гэмээ нь, ардчилал хүний амьдралыг эрх чөлөөтэй болгож, тэгээд зогсохгүй тэднийг урт удаан амьдруулж, амьдралыг нь улам дэвжээн дээшлүүлдэг ажгуу.

---

[1] Сэлим Жахан. Мянганы хөгжлийн зорилгод хүрэх нь: түншлэл ба оролцоо. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл. УБ., 2003, 175 дахь тал.

[2] Ричард Ролл., Жон Р.Талбот. Улс төрийн эрх чөлөө, эдийн засгийн чөлөөт байдал ба хөгжил цэцэглэлт. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). УБ., 2005, 292, 293 дахь тал.

Аливаа ард түмэн өөрсдийн өмнө бий болсон асуудлуудын талаар тодорхой буюу рационал санаа бодолтой байдаг бөгөөд тэрхүү санал бодол нь ардчилсан оронд өөрсдийн санаа бодлоо баталгаажуулахын тулд түүнийг хэрэгжүүлэхээр ажиллах, цаашлаад өөрсдийн төлөөлөгчөө сонгодог нь бидний өнөөг хүртэл баримталж ирсэн сонгодог онолын эргэлзээг тайлах гэсэн оролдлого юм. Нөгөө талаар, ард түмний гол үүрэг бол төр засаг болоод гүйцэтгэх засаглалыг бүрдүүлэх эсвэл түүний үүргийг хэрэгжүүлэх завсрын нэгэн байгууламжийг бүрдүүлэхэд оршдог. Тодруулбал, ардчилсан арга гэдэг нь хувь хүмүүс ард олны саналын төлөөх өрсөлдөөнт тэмцлээр шийдвэр гаргах эрх мэдлийг олж авдаг явдлаар илэрхийлэгдсэн улс төрийн шийдвэр гаргах тэрхүү институционал журам юм. Энэхүү өөр хоорондоо холбоотой үйл явцын бодит хэрэгжилт ардчиллыг хөгжүүлэх талаар хүрсэн төвшин, ардчиллын үзэл санааны үнэ цэнийг харуулж, тухайн орон ардчилсан орон мөн, бишийг тодорхойлоход арга зүй үнэ цэнэтэй хэвээр байна. Тиймээс эрх тэгш байдлын зарчимд төр засгийн бодлогоор хүмүүсийн ашиг сонирхолд адил тэгш хандахыг шаардаад зогсохгүй тэдний үзэл бодол ч адил тэгш үнэ цэнэтэй байхыг шаарддаг. Энэ утгаараа бүх нийтийн хэрэгцээ, жирийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахдаа ардчилсан төр засаг бусад төрлүүдээсээ илүү юм. Бодлогын талаар хүмүүс хэдийчинээ их ярьж хэлнэ, тэд өөрсдийн санал бодол, хүсэл зоригийг төдийчинээ ихээр бодлогод тусгуулах боломжтой байдаг. Хэрэв төрийн эрх баригчид бодлогоо олон нийтийн нөлөө буюу хяналтад өртөхгүй байхаар зориуд далд санаа агуулж боловсруулсан бол тухайн бодлого нь ард түмний хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, өөртөө үйлчилсэн, ялзарсан бодлого байх болно. Цаашилбал, Адам Смит болон түүнийг залгамжилсан европын олонх эдийн засагчдын заасанлан хувийн баялаг гэдэг үгийн явцуу утганд бидний багтаасан ажил хэргийн холбоо сүлбээний хамтаар хүний хөдөлмөрийн чадварыг хангахад шууд нөлөөлдөг бүх хүч, чадвар, даддлыг орлуулан тодорхойлж болох талтай. Гэвч нийгэм дэх явцуурлын учир шалтгааныг судалснаар нийгэм өөрөө яагаад ялзран дампуурч байгааг ойлгох тухай Альфред Маршаллын[1] дэвшүүлсэн эл санаа өнөө хүртэл ач холбогдолоо алдаагүй хэвээр байна.

Үүнээс үзэхүл, нийгмийн асуудал бол, аль ч утгаараа эцсийн дүндээ хүний асуудал мөн бөгөөд нийгэм бол хүний нийгэм, хүн бол нийгмийн хүн мөн. Энэ бодит байдлаас үүдүүлэн нийгмийн хүмүүн бүтцийг сонирхож үзэх хэрэгтэй болно. Тэгвэл, нийгмийн хүмүүн бүтцийн төрх байдлыг шинжлэх ухааны үүднээс *(i) нийгмийн бодит хүмүүн бүтэц, (ii) нийгмийн хийсвэр хүмүүн бүтэц* хэмээн ангилж болох бөгөөд энэ бол нийгмийн бодит хүмүүн бүтцийн үндэс нь гагцхүү ард түмэн мөн. Түүнээс гадна ард түмэн бол бодитой гэж үзэх үндэстэй бөгөөд эл

[1] Маршалл Альфред. Эдийн засгийн ухааны зарчмууд. Орч. Энхээ Ч. Ред. Батбаатар Ц. «Монсудар» хэвлэлийн газар. УБ., 2011, 248 дахь тал.

ард түмэн гэдэг ойлголтыг дотор нь үндэстэн, угсаатан, анги давхраа, хувь хүн хэмээн судалж болдог. Харин ард түмэн бол нийгмийн бодит хүмүүн бүтэц дэх хийсвэр, гэхдээ хамгийн бодитой хэлбэр. Учир нь хийсвэр гэдэг нь бусад бүтэцтэйгээ мөн л адилаар ямар нэгэн жишээн дээр «энэ бол ард түмэн» гээд шууд заагаад хэлчихэж болдоггүй аж. Тэгэхлээр үүний хамгийн бодитой гэдгийн учир нь ард түмэн түүхийг бүтээдэг, улс орны түүхийг хэн бүтээтэгд вэ гэвэл гагцхүү ард түмэн бүтээдэг болохоос бөөн түмэн улс орны түүхийг бүтээдэггүй хэмээн доктор Б.Даш-Ёндон «Хөгжихүйн философи» (Уб., 2019) эрдэм шинжилгээний үгүүлэл, илтгэлийн эмхэтгэлдээ тэмдэглэсэн байна. Түүнийхээр, ард түмэн чин шударгаар засаглалаа тогтоохыг демократия гэдгийг бүгд мэдэх авч, чухамдаа дарангуйлагч биш, бөөн түмэн биш, хөөрсөн түмэн биш чухам ард түмэн нв улс орон, нийгэмд хэрэгтэй шударга засаглалыг тогтоох хувь зохиолтой, бас үүрэгтэй аж. Тэрбээр, мөн нийгмийн бодит хүмүүн бүтэц улмаар өөр талаасаа илэрч болох бөгөөд түүнийг нь бид нийгмийн хийсвэр хүмүүн бүтэц гэдэг томъёогоор илэрхийлж, улмаар түүний хүмүүн бүтцийн үндэс нь бөөн түмэн хэмээн тайлбарласан[1] байна. Чингэхлээр «хөгжил» хэмээх ойлголтын мөн чанарыг нийгмийн ямар нэгэн шалгуур бүхий төрх байдал, шинж чанарыг тэмдэглэхээс тухайн зүйлд бий болж байгаа болон эрдэм мэдлэгт суурилан боловсрогдох ёстой үндэсний шинж чанартай үзэл баримтлал юм. Тэрхүү үзэл баримтлал нь загварчлалаас хамаагүй илүү амилаг, уудам чөлөөтэй, өргөн бололцоо олгох зам зассан сэтгэлгээний дүн мөн[2] ажээ. Түүний ийнхүү тайлбарласан нь тогтвортой хөгжлийг үргэлжүүлэн бэхжүүлэх, улмаар түүнд тулгамдаж буй асуудал бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд ард түмнийг улс орны хөгжил, тэдний өөрсдийн амьдралд ямар нэгэн загварчлал, хэвшмэл байх тунхаглал бүхий хий хоосон хэвийг ашиглаж болохгүйг бидэнд ойлгуулахыг оролдсон гэлтэй.

Тодруулбал, улс орны соёлын нэгдмэл байдал бол ард түмний хэтийн зорилт, төлөв байдал, тухан үндэстний итгэл найдвар, хүсэл тэмүүллийн үндсэн дээр эдийн засгийн бие даасан, тогтвортой байдлыг цаашид хөгжүүлэхэд чиглэгдэх явдал мөн төдийгүй үүний гол хандлага бол эдийн засгийн үндэс суурь болсон улс хоорондын улс төрийн хүсэл зориг, хүмүүс (ард түмэн) хоорондын итгэлцлийг нэмэгдүүлэх асуудал юм. Сүүлийн жилүүдэд олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцсэн төрийн байгууллагуудын тэргүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагаанд институтууд болон олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагаанд иттэх итгэл буурах хандлага бий болсоор байгаа нь шийдвэр гаргах, бодлого боловсруулах үйл явцад тулгарч буй гол сорилт болж байна.

[1] Даш-Ёндон Б. Хөгжихүйн философи (эрдэм шинжилгээний үгүүлэл, илтгэл). Ред. Чулуунбаатар Г., Баяртсайхан Н. ШУА. Философийн хүрээлэн. УБ., 2019, 244-245 дахь тал.
[2] Даш-Ёндон Б. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). Нэмж засварласан II хэвлэл. ред. Чулуунбаатар Г. ШУА. Философийн хүрээлэн. УБ., 2017, 94-95 дахь тал.

Улс төрийн ардчилсан үйл явцыг бүтээлчээр оролцуулахад чадварлаг институциудыг бэхжүүлэх, улмаар тэрхүү институцийн талаарх зөв ойлголттой хувь хүмүүс, бүлгүүдийг улс төрийн чөлөөт мэтгэлцээнд оролцуулж, санал өгөх, хангалттай мэдлэгтэй болгох нь нэн чухал. Энэ утгаараа чадавхийг бэхжүүлэх гол зорилго бол институциудын шинэчлэлтэй уялдуулан нийгэм дэх амьдралын түвшинг дээшлүүлэх явдал мөн. Нийгмийн хөтөлбөрүүдийн санхүүжилт нь хүний хөгжлийн болон иргэд, олон нийтийн мэдлэг боловсрол, ур чадварыг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулж, түүнд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ. Ер нь *хүмүүс засаглал, нийгэм, бүс нутаг, улс орнуудын амьдралд хэрхэн оролцох талаар суралцах хэрэгтэй, учир нь нийгэм улс төрийн аливаа тулгамдаж буй асуудлуудыг чадавхийн хувьд шууд шинжилгээ хийх чадавхаар нийгмийн өөрчлөлтийг зохион байгуулахад шууд чиглүүлэх* нь механикаар, автоматаар хийх боломжгүй зүйл. Тиймээс, аливаа улс орны тогтвортой хөгжлийн гол нөхцөл, шийдвэрлэх хүчин зүйлийн нэг гол зорилт бол үр нөлөө бүхий тогтвортой засаглал билээ. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал боловсрон хөгжихөд засаглалын судалгаа чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхнээс засаглалын судалгаа идэвхижиж, төрийн удирдлагын шинжлэх ухаанд шинэ үзэл баримтлал нэвтэрч эхэлсэн байна. Мөн энэ үед эдийн засаг, байгаль экологийн салбарын асуудлуудыг голлон дэвшүүлж тогтвортой хөгжлийн үзэл баримтлал боловсрогдож байлаа. Нэг үгээр хэлбэл, засаглалын болоод тогтвортой хөгжлийн үзэл баримтлалууд нэгэн зэрэг нэг нь нөгөөгөө харилцан баяжуулах байдлаар хөгжиж эхэлсэн гэж үзэж болно. Харин цаашдынхаа явцад энэ харилцаа, уялдаа холбоо нь тэр бүр сайн хангагдаж чадаагүйг үйл явцын өрнөлтөөр харагдана.

Энэ бол *эдийн засаг, нийгэм, институцийн тогтвортой х*өгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг чухал үндэс мөн бөгөөд тэрхүү тогтвортой засаглалыг хангахад төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулж, тогтвортой байдлыг хангах, төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлж, хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх нь эдийн засгийн бие даасан тэнцвэртэй хөгжлийг бататгахад оршино.[1] Аливаа улсын Засгийн газар тогтвортой хөгжлийн асуудалд хандахдаа зөвхөн нэг өнцгөөс нь биш, харин үндсэн тулгуур гурван баганы хоорондын харилцан хамаарлыг тооцож цогц хандаж баймааж л тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг зөв хэрэгжүүлж чадна гэсэн үг мөн. Чингэхлээр тогтвортой хөгжлийн тулгын гурван чулууг холбож хөгжлийн нэг нэгдмэл үйл явц болгодог тэр хүчин зүйл бол хүн, хүний хөгжил, итгэл юм.

[1] УИХТГ. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030: үндэслэл, хамрах хүрээ. УБ., 2016 85 дахь тал.

Хэрэв, тогтвортой хөгжлийн тодорхойлолтын гол төвд хүн, түүний жам ёсны хүрээлэл, хүн, байгаль ба эдийн засаг гурвын хамтран бүтээж буй ахуй, түүний тогтвортой төлөв байдаг гэж үзвэл бид дараах зүйлийг тодруулах нь зүйтэй. Энэхүү оршихуй үндсэн чиглэл нь философийн урьдчилсан тодорхойлолтоос эхлэн тогтвортой чанарыг байнга дагалдуулаххөгжил, нэг талын өсөлтийг зогсоох тогтвортой ажилбаруудыг хүртэлх оюуны ертөнцийн бүх хүрээ, үе шатыг хамрах тул тогтвортой хөгжил бол философийн түлхүүр асуудлын нэг ямагт байсаар иржээ. Эдүгээ цагт хүмүүнд өөрт нь байдаг, түүний ахуйн "өөрийн" чанар болох байгаль, эдийн засаг ба нийгэм (их гэр бүл) гэсэн гурван асуудалд хэдийгээр олон шинжлэх ухааны судалгааны тусгагдахуун (объект) болсон боловч философийн үндсэн асуудал, судлагдахуун хэвээр байсаар ирсэн талаар профессор Батын Ч.Ган-Өлзий нэгэнтээ дурдсан байна. Түүнийхээр бол, хүмүүсийн хувийн харилцаа, ёс зүйн зөн билиг гоо сахйны эргэцүүлэл зэрэг нь зөвхөн шинжлэх ухааны байр сууринаас ойлгож үл болох ухаарлын чинадын хэмжүүр бий гэдгийг бидний ухамсарт битүүхэн дохиолсоор байдаг бэлгэ чанартай хүний ахуйн "өөрийн" тал холбоотойн сацуу философийи ба тусгай шинжлэх ухаануудын харилцан холөоонд үүсч, тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэх суурь ерөнхий зүй тогтлыг гаргах өгөх мэдлэг, мэдээлэл нь тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс болох төдийгүй цаашдын тодорхой судалгааны хувьд арга зүйн ач холбогдолтойг тэмдэглэсэн[1] байна. Тэрбээр, мөн хөгжлийг хүн рүү эргүүлж, оюунлаг болгох нь түүний үнэс болгож эдийн засгийн болон улс төрийн өсөлтийн үзүүлэлт, шалгууруудыг голлон авч үздэг хандлагаас татгалзан өөрчлөлтийн суурь үндэс болгон хүний өөрийнх нь хүч чадал, боломж, билэг чанар, зохистой байрлуулан тавих чадварын өсөлт, тухайн ард түмнйи соёл, уламжлалыг хүлээн авч, оюуны ертөнцөд хадгалан дэвшүүлэх инноваци, шинэ технологийг чухалчлах философи хэрэгтэйг онцолжээ.

1980-аад оноос нийгмийн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгдэх болсон нийгмийн капитал хэмээх ойлголтоор бол хүмүүсийн бүлгээр хамтран ажиллах чадвар хийгээд нийтээрээ сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрч, даган мөрдөж байгаа хэм хэмжээ, үнэлэмж дээрээ тулгуурлаад хамтын зорилгодоо хүрэхийн тулд хүмүүсийн хамтран ажиллаж буй бүхий л тохиолдол нийгмийн капиталын үндэс төдийгүй зохистой хөгжлийн тулгуур болсон. Тодруулбал, Фрэнсис Фукуяама мөн нийгмийн капиталыг эдийн засгийн хөгжил, тогтвортой чөлөөт ардчиллыг хангах чухал нөхцөл хэмээн үзсэний зэрэгцээ нийгмийн капитал хөгжийн хэтийн бодлогын цар хүрээнд хэрхэн тодорхойлогдож байгааг сайтар ойлгохыг[2] чухалчилсан. Тэрбээр 1990-ээд оны сүүлчээс хөгжлийн асуудлыг

[1] Батын Ган-Өлзий Ч. Хүмүүний ахуйн тогтвортой төлөв. ШУА. Философийн хүрээлэн. Хүмүүний ертөнц ба тогтвортой хөгжил. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. Ред. Пүрэвсүрэн Б., Энхбаяр Ж. УБ., 2018, 67, 69, 71 дэх талууд.
[2] Фукуяама Фрэнсис. Нийгмийн капитал ба хөгжил: хөгжлийн шинэ асуудал. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). УБ., 2005, 317 дахь тал.

нэлээд ул суурьтай эргэн харах болсон бөгөөд чингэхдээ иргэншилтийн хүчин зүйлсийг эдийн засгийнм өсөлт, хөгжлийн загваруудад тусгахын чухлыг тэмдэглэж байв. Нийгмийн капитал гэдэг нь ердөө л тухайн бүлэг хүмүүс, нийгмийн хүрээнл тогтсон хэм хэмжээ, үнэлэмж, эдийн засгийн амьдралд ямар үүрэгтэй облохыг ойлгох арга хэрэглүүр юм. 1990-ээд он зарим нэг утгаараа хөгжиж буй болон шилжилтийн эдийн засгийн асуудлуудад хандах гол чиглэлийг тодорхойлсон «Вашингтоны зөвшилцөл»-ийн дуулиантай хамт эхэлсэний сацуу эл зөвшилцөлийн агуулга нь хөгжиж буй болон шилжилтийн эдийн засгийг төрийн үр ашиггүй оролцооноос ангижруулах зорилготой эдийн засгийн дэс дараатай бодлого бөгөөд үндсэндээ олон улсын санхүүгийн байгууллагуудын бодлогын чиглэл болж байв. Гэхдээ энэхүү зөвшилцөл нь Зүүн европ, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улс орнууд, түүнчлэн Латин Америк, Ази, Өмнөд Ази мөн бусад хөгжиж буй орнуудад эл бодлогын хэрэгжилт харилцан адилгүй үр дүн үзүүлсэн[1] хэмээн онцлон тэмдэглэсэн нь бий.

Нөгөө талаар хөгжлийн явцад нийгмийн капитал ардчилалд чухал түшиг тулгуур нь болж ирсэний хамтаар сүүлийн үед ардчилал, хөгжлийн уялдаа холбооны талаарх олон нийтийн үзэл бодолд үндсэн өөрчлөлт гарч байгааг Амартия Сен[2], Жозеф Стиглиц, Альфред Маршалл[3] зэрэг хүмүүсийн бүтээл ч үүнийг бэлхнээ гэрчилнэ. Эдийн засгийн хувьд хурдацтай хөгжиж буй зарим улс орнуудын хувьд, ардчилал нь эдийн засгийн өсөлтөд гарцаагүй сайн нөлөө үзүүлдэг гэдэгтээ бус харин ардчилалтай нэгэн адил засаглалыг хууль ёсны баталгаагаар хангаж чадахуйц өөр хувилбар ховор буйд л байгаа юм. Төрийн сүр хүч нь түүнийг хүрээлсэн иргэдийнх нь дэмжлэгт байдаг бөгөөд гаднаасаа хүчтэй мэт харагдаж байсан олон улс орон үнэн хэрэгтээ иим хууль ёсны баталгаа сул байснаас тун хэврэг улс болохоо харуулсныг ЗХУ, Сухатогийн удирдаж байсан Индонезийн жишээ бидэнд бэлхнээ харуулсан. Чингэхлээр өнөөгийн ардчилал дийлэнх хөгжиж буй улс орнуудын хувьд бодит байдал нэгэнт болсон: гэхдээ улс төрийн тогтолцооны хөгжил эдийн засгийн өсөлттэй зэрэгцэж явдаг гэдэгт итгэх хэрэггүй. Гагцхүү ардчилал амжилттай хөгжихөд нийгмийн капитал шийдвэрлэх үүрэгтэй. Үүнийг нийгэм судлаач Эрнест Жилннер иргэний нийгэм байхгүй бол ардчилал байхгүй хэмээн ил тод хэлсэн нь байдаг. Нөгөө талд, захиргаадалтын засаглал нийгмийн задрах тал руу нь илүүтэй урамшуулж байхад нийгмийн капитал хувь хүмүүс нэгдэн нягтарч өөрсдийн эрх ашгийг хамгаалах мөн зохион байгуулалттайгаар нийтлэг хэрэгцээ шаардлагаа урагшлуулах үндэс нь болдог. Олонх хөгжиж буй улс орнуудын хувьд чөлөөт ардчилал, эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх, өсөлтийг хангах суурь нөхцөл нь байдаг бол, эл улс төрийн

[1] Фрэнсис Фукуяама. Нийгмийн капитал ба хөгжил: хөгжлийн шинэ асуудал. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). УБ., 2005, 317 дахь тал.
[2] Сен Амартия. Хөгжил бол эрх чөлөө. Орч. Энхбаатар А. Мөнхжаргал Э. Ред. Мөнхтуяа Ч. УБ., 2014.
[3] Маршалл Альфред. Эдийн засгийн ухааны зарчмууд. Орч. Энхээ Ч. Ред. Батбаатар Ц. «Монсудар» хэвлэлийн газар. УБ., 2011.

тогтолцооны бат бэх байдал, боловсроннгүй байх зэрэг чанар нь нийгмийн капиталаас шууд хамаарч байдаг. Ардчилал нь бат бэх суурьтай байх тусмаа хөгжлийн аливаа сорилтуудыг даван туулах чадвартай байх агаад, чингэхэд нийгмийн капитал нь эдийн засгийн зорилтуудад хүрэхийн тулд хүмүүс зохион байгуулалтад орох чадавхид шууд нөлөөтэй, нийгэмд институциуд бий болох, хууль ёсыг дээдэлсэн тогтолцоо бүрдэх үйл явцыг хөхиүлдэг ба мөн хөгжлийг тэтгэсэн улс төрийн тогтолцооны[1] баталгаа болох ардчиллын тулгуур мөн бөлгөө. Нэг талаар, нийгмийн капитал бол харьцангуй энгийн томъёолол бүхий бодлогоор эдийн засгийн өсөлт хөгжилтөд хүрнэ гэсэн гэнэн хүлээлтээс биднийг авардаг. Өөрөөр хэлбэл, нийгмийн капиталыг хамгийн бодитой арга зам нь бодлогыг макро түвшинд бус микро түвшинд хүргэх явдал мөн бөгөөд үүнийг боловсронгүй болгон хөгжүүлэхэд амжилттай хэрэгжүүлж болох хамгийн тохиромжтой түвшин бол санхүүгийн микро түвшин юм. Тэгэхлээр нийгмийн капитал, ардчилал, эдийн засгийн шинэчлэлийн хоорондын уялдаа холбооны талаарх асуудлыг илүү тодорхой болгох хэрэгтэй.[2] Чингэхийн тулд нийгмийн капитал нь ардчиллын амжилтанд шийдвэрлэх үүргийг гүйцэтгэж байсан бөгөөд ардчилал нь ихэнх хөгжиж буй орнуудын улс төрийн амьдралын салшгүй онцлог шинж байсаар байх болно.

Харин Альфред Маршалл (Alfred Marshall «Principles of Economics», 1890)-ын үзэснээр эдийн засгийн ямар ч асуудлыг шийдэхэд гол хүндрэл учруулах үндэс болдог цаг хугацааны хүчин зүйл нь мөн чанараараа туйлын тогтвортой зүйл бөгөөд хугацааг урт ба богино үеэр хуваагдаг хатуу хуваарь байгальд байхгүй, тэдгээр нь бие бие рүүгээ ажиглагдамгүйгээр шилждэг учир аль нэг асуудалд хэтэрхий богино мэт санагдсан үе нөгөө нэг асуудалд асар урт мэт харагддаг[3] хэмээжээ. Үүнээс ухвал, капиталыг бүрдүүлдэг болон амьжиргааны зайлшгүй хэрэгцээтэй учраас капитал болдоггүй зүйлсийг нарийн заагласан хил хязгаар бодит амьдралд байддагүй нь өгөөжтэй хийгээд өгөөжгүй хөдөлмөрийг заагланялгаж болдоггүйтэй адил, хөгжлийн явц тасралтгүй хэмээх төсөөллийг тодорхойлох нэгэн ороддлого хэмээн ойлгоход хүргэж байна. Энэ нь аливаа баялаг нь бидний олж эзэмшихийг хүссэн байгаа зүйлсээс, өөрөөр хэлбэл хүний хэрэгцээг шууд ба шууд бус замаар хангадаг зүйлсээс бүрэлдэх боловч үүнийг бүгдийг нь баялаг гэж тооцдоггүй. Чухамдаа, бидний хүсдэг бүх зүйлс буюу баялгийг материаллаг буюу хувийн, материаллаг зүйлс болон түүнийг эзэмших, захиран зарцуулах, одоо ба хэтдээ ашиг олох бүх эрхээс бүрдэхийг[4] бид ухаарах

[1] Фукуяама Фрэнсис. Улс төрийн тогтолцооны эх сурвалж. Орч. Гомбосүрэн Ц. «Монсудар» хэвлэлийн газар. УБ., 2014, 47 дахь тал.
[2] Фукуяама Фрэнсис. Нийгмийн капитал ба хөгжил: хөгжлийн шинэ асуудал. АШБСТО-ын олон улсын V бага хурал. Ардчиллын чанар: судалгааны өгүүллийн эмхэтгэл. (The Quality of Demoracy: A Reader). УБ., 2005, 317 дахь тал.
[3] Маршалл Альфред. Эдийн засгийн ухааны зарчмууд. Орч. Энхээ Ч. Ред. Батбаатар Ц. «Монсудар» хэвлэлийн газар. УБ., 2011, ix дэх тал.
[4] Маршалл Альфред. Эдийн засгийн ухааны зарчмууд. Орч. Энхээ Ч. Ред. Батбаатар Ц. «Монсудар» хэвлэлийн газар. УБ., 2011, 51, 53 дахь талууд.

хэрэгтэй болж буй. Тиймээс, хөгжил бол хоорондоо нягт уялдаатай үндсэн эрх чөлөөнүүдийг өргөтгөх нэгдмэл үйл явц гэдгийг ойлгох эрс шийдэмгий онцлогуудын нэгдэл мөн бөгөөд тэрхүү нэгдэл нь нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээнүүд, заримдаа хүйсийн тэгш байдал, хүүхэд хүмүүжүүлэх аргууд, гэр бүлийн тоо болон төрөлт, хүрээлэн буй орчинд хандах байдал зэргээрээ нийгмийн үзэгдэл, үйл явцуудаар илэрдэг нийгмийн хэмжүүрүүдэд нөлөөлдөг. Энэ утгаараа гол үнэт зүйлс ба нийгмийн ёс суртахуунт чанарын төлөв байдал нь авлига байх, эсэх болон эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцаанд орших итгэлцлийн түвшинд шууд хамааралтай. Үнэт зүйлийг олж авах зорилгоор эрх чөлөөг ашигладаг ч эдгээр үнэт зүйлийн агуулгад нээлттэй хэлэлцүүлэг, бүлэг хоорондын шууд холбоо нөлөөлдөг, мөртлөө эд ч бас өөрсдөө нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох эрхийн хэрэгжилтээс[1] хамааралтай болохыг дурдах нь зүйтэй. Үнэн чанартаа, аливаа зүйлийн үнэ орон зай, цаг хугацаа бүрт өөр өөр байдагчлан өөрчлөлт бүрийг дагаад сорилт бэрхшээл, ололт амжилт дагалдан байдаг. Энэ бол хөгжлийг хангахад ардчиллын тогтвортой байда чухал төдийгүй бэрхшээл сорилт бүрийг даван туулснаар илүү туршлагажиж, улмаар амжилтыг ахиулах, хөгжлийг хурдасгах гол хөдөлгүүр болох хэрэгсэл гэж үзэж болхоор байна. Тиймээс, бид ардчилал, хөгжил хоёр хоорондоо хэрхэн холбогдож буйд анхаарал хандуулах учиртай. Үүний тулд, бид үндэсний хэмжээний тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах хэрэгцээ, шаардлага түүнд тулгарч буй сорилт боломжийг дараах хэсэгт тодруулахыг зорив. Монгол Улс Азийн пост-социалист орнуудаас ганцаараа ардчиллын замыг тууштай сонгож, улмаар улс төр, эдийн засгийн шилжилтийг хооронд нь уялдуулж, тодорхой утгаар зэрэгцүүлж, бас тайван замаар хийсэнээрээ онцлогтой. Ийнхүү ганц хэмээн онцлохын учир нь Хятад, Хойд Солонгос, Вьетнам, Лаос зэрэг Азийн социалист байсан орнууд нь бидэнтэй адид замыг сонгоогүй шалтгаан нь тухайн орнууд (Хойд Солонгосоос бусад) бүгд л зах зээлийн эдийн засгийн харилцаа, нээлттэй эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх замаар харьцангуй амжилттай хөгжиж ирсэн. Чингэхлээр, аливаа улсын хөгжлийг хэмжих шалгуур юунд орших вэ гэдэг нь гагцхүү тэдний сонгосон засаглал уу аль эсхүл хөгжлийн төлөөх чинхүү сэтгэлээр төрийн залгамж чанараа үргэлжлүүлэн авч явсан зорилго уу гэдгийг олж тогтоох нь чухал санагдана. Үнэндээ, ардчилал, зах зээлийн замыг сонгон авсан л бол өөрийн улсын үндэсний онцлогт нийцүүлж, хөгжлийнхөө зам, загварыг бүтээхийн учир агуулгаа өнөөгийн Япон, Өмнөд Солонгос, Тайланд зэрэг Азийн өндөр хөгжилтэйд тооцогдох дорнын соёлтой, ардчилсан тогтолцоотой улс орнуудын өнөөдрийн дүр зургаас харж болохоор байна. Эндээс урган гарч буй чухал санаа бол, нийгмийн өнөөгийн шинж, ардчилал, засаглалын

[1] Сен Амартия. Хөгжил бол эрх чөлөө. Орч. Энхбаатар А. Мөнхжаргал Э. Ред. Мөнхтуяа Ч. «Монсудар» хэвлэлийн газар. УБ., 2014, 17 дахь тал.

төлөв байдал хэрхэн төлөвшиж буйг тодруулахдаа үндэсний онцлогоо түлхүү шингээсэн, олон улсын хэмжээний ерөнхий арга зүйн ололттой талуудтай хослуулах замаар орчин цагийн хөгжлийн хурдыг улс төр, эдийн засгийн харилцааны өвөрмөц онцлог бүхий дотоод гүний брдит байдлыг бүрэн тусгасан үндэсний онцлогтой нийгэм, соёлын болон улс төр-эрх зүйн нээлттэй, шударга, ёс зүйтэй, тэгш эрхийн зарчмыг шингээж, ардчилсан легитимт чанарыг дээдэлсэн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоосон, нэгдмэл улсын мөн чанарыг агуулсан хөгжлийн замыг сонгох нь өнөөгийн Монгол Улсын хөгжлийн гарцын суурь илэрхийлэмж мөн.

Гэхдээ бидэнд тулгарч буй сорилт, бэрхшээл багагүй байсаар байна. Үүний нэг нь нийгмийн хөгжлийн суурь болох хувьсал, өөрчлөлтийн үйл явц хэт удаашралтай эсхүл тогтонги байдалтай явагдаж буй нь эцэстээ эргэлзэж тээнэгэлзсэн аль эсхүл хэт туйлширсан байр суурь, сөрөг хандлагууд газар авах боллоо. Хэдийгээр зарим үр дүн нэлээд хугацаанд тогтвортой байж дараагийн илүү сайн үйлийн үндэс суурь болж байгаа авч, зарим нэг тодорхой хугацаанд тогтвортой байх боломж цаащдаа хүсээгүй, хүн нийгэмд хэрэггүй муу бүхний эхлэл болох явдал ч байсаар байна. Үүнийг шүүмжлэлт талаас нь авч үзэхүл, өнөөгийн нийгмийг улс төр, засаглал, ардяилал, зах зээлийн эдийн засгийн харилцаа, байгалийн баялагийн ашиглалт зэрэг нь эл улс орны хөгжилд, тухайлбал, жирийн монгол хүний хөгжил, түүний эрүүл, аюулгүй, нээлттэй, ил тод байх Үндсэн хуульд заасан бүхий л эрхийн хүрээнд хангалттай сайхан амьдарч, бас тэднийг амьдруулж, хөгжүүлж, хамгаалж чадаж байна уу гэтэл зөрчилтэй, ээдрээтэй дүр төрх, мөн чанар оршсон хэвээр л байна.

Тэгвэл энэ бүхний эхлэл юунд байв гэдгийг оношлох ахул, бид төр улсынхаа хувьд оршин хөгжсөн түүхийнхээ бүхий л үед нүүдлийн болон суурин иргэншлийг хослуулан хөгжиж ирсэн бөгөөд энэ нь бидний өнөөгийн монголын нийгмийн харилцааны дахин давтагдашгүй, язгуурын онцлог шинжтэй холбоотой мэт. Бидний мэдэхээр, суурин иргэншил гэхээр хүн ам төвлөрсөн хот, суурин, харин нүүдлийн хэмээх төсөөлөл маань байгалийн хишиг даган нүүж, сууж амьдардаг хүмүүсийг ойлгосоор ирсэн өнгөц мэт төсөөллийг энд онцлох нь чухал биш санагдана. Гагцхүү нүүдэл, суурьшлын хослол бүхий өвөрмөц тогтолцоо, шинж байдлыг онцлох явдал юм. Тодруулбал, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хурдацтай өсөн хөгжиж буй байдал, шашин, соёл, зан заншил, ёс зүйн хийгээд ёс суртахууны боловсрол, сэтгэл зүй, төр ёс, аж ахуй эрхлэх уламжлалт арга ухаан, үр хойч ирээдүйгээ өсгөх сурган хүмүүжүүлэх ур ухаан, гэр бүл, айл хотлоороо, нутаг олон, төрөл саднаараа хамтарж ажиллаж амьдрах зэрэг нийгмийн харилцааны хамгийн энгийн төрөл, шинжүүдийг мөнхүү хоёр иргэншил хослуулан хөгжүүлэх аваас дээр дурдсан зүйлсийн бүхий л үр дагаврыг

харгалзан үзэхгүйгээр үндэсний онцлогоо шингээсэн давтагдашгүй онцлогыг бүтээж үл чадна. Цаашлаад төр, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх үзэл онол, хандлагын хүрээнд ээдрээтэй зөрчил бий болсон нь өнөөгийн бидний оршин амьдарч буй нийгмийн шинж төрхийг харуулж буй маш энгийн үзүүлэлт юм. Харин нөгөө чухал зүйл нь эдийн засаг мөн бөгөөд эдийн засаг бол нийгмийн хөгжлийн үндэс мөн гэдэгтэй хэн ч маргахгүйтэй адил эдийн засгийн гол хөшүүрэг нь юу байхыг тодруулах нь зүйн. Угтаа тэрхүү хөшүүрэг нь ард түмэндээ юу өгч, ард түмэн нь эдийн засгийнхаа гол хөшүүргийг ажиллуулахад яаж оролцож байна вэ гэдгийг давын өмнө ярих асуудал мөн. Үүнийг тус хамтын бүтээлд тусгайлан авч үзэж буй тул өөрийн санаагаа ийнхүү товчлон сонордуулав.

Нөгөө талаар Монгол Улс Үндсэн хуулийнхаа дагуу парламентын засаглалтай орон болович хагас Ерөнхийлөгчийн засаглалын олон шинжийг хадгалсан, нутгийн удирдлагын тогтолцоо нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хосолсон хэлбэр бүхий улс төрийн тогтолцоотойгоор сүүлийн 30 гаруй жил явсаар ирлээ. Үнэн чанартаа, энэ тогтолцоо нь оновчтой эсэхэд эргэлзэх явдал намжихгүйн дээр ээлжит сонгуулийн өмнө улс төрчид, улс төрийн намууд, судлаачдын дунд сонгуулийн хууль болж бүтэхгүй байгаа асуудлыг ярих, шүүмжлэх явдал тасрахгүй явагдсаар ирсэн. Цаашлаад, ард түмэн нам, улс төрчдийн хатгаасаар гэр бүлээс эхлээд нутаг ус, айл саахалт, ах дүүсээрээ, эсхүл насны бүлэг, хөрөнгө чинээгээрээ талцан хуваагдах явдал үлэмж олширсоор байгаа нь эрүүл, зөв үзэл бодолтой, эгэл жирийн амьдралтай хүмүүс улс төрөөс залхах, түүнээс хүнийсэх явдал нэмэгдсээр байгаагийн шалтгаан нь улс төрийн сонгуульд ялсан олонхын шийдэж болох, болохгүй асуудлын хүрээ өнөөдөр хүртэл төлөвшин тогтоогүй байна. Тэдгээрт хамгийн түгээмэл яригдаж буй санаа бодлыг дараах байдлаар хураангуйлан үзэж болно.




Яг үүнтэй адилаар 1990 оноос хойш сүүлийн 30 орчим жилийн хугацаанд Монгол Улсыг хөгжүүлэх нэгдсэн бодлого, үзэл баримтлал боловсруулах ажил үе үеийн засгийн газар, ерөнхийлөгч, УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд тасралтгүй хийгдэж өдгөө парламентаар батлагдсан үндсэн баримт бичиг, хугацаа нь дуусаагүй хэрэгжиж буй олон арван бодлогын баримт бичгүүд бий. Тодруулбал,

**Монгол Улсын XXI зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг 1994-1998 онд боловсруулсан.**

Монгол Улсын Засгийн газраас 1998 оны 5 дугаар сард баталснаас хойш хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 2002, 2006, 2010 онд тус тус гүйцэтгэж, хэрэгжилтийн тайланг гаргасан.

- 2011 онд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлах нэг чухал суурь үндэслэл болсон гэж үзсэн нь бий. Үүнээс улбаалан, «Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр» (1998) -ийн залгамж болгон «Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого» (2008-2016)-ыг батлан хэрэгжүүлсэн.

**Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт**

ҮХЦБ-ыг тодорхойлохдоо Монгол Улсын Үндсэн хууль (1992), Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал (1996), Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (1998), Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөр (2005), «Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал», «Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал»-ыг

- «Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг», «Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын илтгэл», «Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал», «Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт» (2005), «Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр» зэрэг Монгол Улсын төр, засгийн бодлогын 304 баримт бичигт томъёолсон үзэл баримтлал, үндсэн зорилт, агуулгыг багтааж, тэдгээрийн нэгдмэл байдлыг хангах зарчим эдгээр баримт бичигт тусгагдсаар ирсэн байдаг.

**2000 оны 9 дүгээр сард Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейд оролцсон 189 орны ЗГ-уудын баталсан Мянганы тунхаглал**

Монгол Улсын дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүний хувьд Монгол Улсын Их Хурлаас МХЗ-уудыг хөгжлийн харьцуулах үзүүлэлт болгон 2005 онд баталсан бөгөөд 2008-2021 оны МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ)-ын суурь болгон ашигласан.

- *«Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх»* есдүгээр зорилгыг шинээр нэмж тодорхойлсон цөөн орны нэг нь Монгол Улс бөгөөд ардчилсан засаглал, хүний эрхэд онцгой анхаарал хандуулснаар бусад МХЗ-уудыг хангахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх үндэс болсон. Монгол Улсын МХЗ-уудад 2008 онд дахин тодотгол хийж 9 дэх зорилгын хүрээнд 24 зорилт, 67 шалгуур үзүүлэлттэй баталсан.

Гэвч эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилт, уялдаа холбоог хангах, дараа дараагийн шатны баримт бичгийн уламжлал, нэн ялангуяа мэргэшиж туршлага хуримтлуулсан хүний нөөцийн залгамж холбоог хангах талаар хангалтгүй ажилласаар ирсэн хэмээн шүүмжлэлтэй хандахад буруудахгүй болов уу. Учир нь, Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл-2011[1]-д тогтвортой байдлыг байгаль орчны эмзэг байдлыг бууруулах, мэдээлэлтэй, уян хатан зохицуулалтыг бэхжүүлэх нь тогтвортой байдлыг дэмжих үйлстэй нягт холбоотой хэмээн тодорхойлсон бол, төр засгийн бодлого, үйл ажиллагааг хянах нь гол толь болсон тогтвортой хөгжлийг нийтээр хүлээн зөвшөөрсөн. Үүнээс тун удалгүй, НҮБ-аас дэлхийн улс орнуудын итгэлцэл дор нэгдмэл байж одоо хий=гээд ирээдүйн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлан ойлгож, Тогтвортой хөгжлийн төлөө хамтран зүтгэж, дэлхийн бүх хүмүүст илүү сайхан амьдрах боломжийг бий

[1] МУ-ын Засгийн газар, НҮБХХ. Шведийн олон улсын хөгжлийн агентлаг (SIDA). Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл-2011. Уб, 2011, 11 дэх тал.

болгохын тулд дэлхийн удирдагч нар болон оролцогч талууд хамтарсан хүчин чармайлт гаргах зорилгын дор нэгдэж 17 зорилго бүхий «*Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030*»-ыг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

Зах зээл, засаг захиргаа, хууль тогтоох байгууллага, улс төрийн намууд, төрийн бус байгууллагууд, шүүх засаглал, ОНМХ, нийгэмлэгүүд зэрэг чиг үүргээ гүйцэтгэж буй олон төрлийн нийгмийн институц хувь хүний эрх чөлөөг өргөжүүлэх болон хамгаалах замаар л хөгжлийн үйл хэрэгт хувь нэмрээ оруулдаг. Тэгэхээр, хөгжлийг задлан шинжлэх нь эдгээр институцууд болон тэдгээрийн харилцан үйлчлэлийн олон талт утга учрыг нэгтгэж ойлгохыг шаарддаг. Үнэт зүйлсийн төлөвшил, нийгмийн ёс зүйн үүсэл, хувьсал зэрэг нь зах зээл болон бусад институцуудын чиг үүрэгтэй хамруулж авч үзэхийг шаарддаг хөгжлийн үйл явцын хэсэг юм. Нэг үгээр янз бүрийн үйл ажиллагаанууд болон институцуудтай холбоотой олон янз байдал бол эрх чөлөөний чухал шинж чанар мөн боловч, эрх чөлөө бол үйл явцжсан зорилтуудыг ч, суурь боломжуудыг ч мөн хамарсан, нэг төрөл бус ойлголт гэдгийг ямагт санах нь зүйтэй.

- Монгол Улс ч үүнийг тойролгүй дэлхийн тогтвортой байдлын хөгжлийн зорилго дээр тулгуурлан үндэсний урт хугацааны бодлогоо хуульчлан баталсан анхны орнуудын нэг болж, Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр «Хөгжлийн бодлого төлөвлөлт»-ийн тухай хуулийг, мөн 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр «Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030» үндэсний урт хугацааны хөтөлбөрийг тус тус баталсан нь Монгол Улс 2030 он гэхэд ардчилсан засаглалаа бэхжүүлж, экологийн тэнцвэрт байдлыг хангаn, ядуурлын бүх хэлбэрийг устгаж, дундаж давхарга давамгайлсан орон болох зорилтыг дэвшүүлсэн. *Эх сурвалж: Parliament of Mongolia. (SGH) Mongolia Sustainable Development Vision 2030. UB, Mongolia. 2016, pp. 5-6. http://www.legalinfo.mn/annex/details/7105?lawid=11725*

**Монгол Улсын тогтворттой хөгжлийн үзэл баримтлал - 2030**




- 2020 оны 4 дүгээр сарын 5-нд эхэлсэн 7 дахь удаагийн УИХ-ын бүрэн эрхийн сүүлчийн Хаврын чуулганаар Монгол Улсын Ерөнхий сайдын 52 дугаар захирамж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 65 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын дэд хэсэг, яам, агентлаг, эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор боловсруулсан «Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого»-ыг батлах тухайн УИХ-ын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 83.3 хувийн саналаар 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр бүхэлд нь баталлаа. *Эх сурвалж: Монгол Улсын Их Хурал. 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр. http://www.parliament.mn/c/he*

**«Алсын хараа-2050» Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого**




Эцэст нь хэлэхэд, парламентын сонгууль бүрийн өмнө улс төрийн намууд улс орноо хөгжүүлэх талаарх баримтлах бодлогыг 5-30 жил хүртэл хугацаагаар төлөвлөж түүнийгээ УИХ-аар батлуулж олон нийтэд сүр дуулиантай зарладаг. Гэсэн хэдий ч сонгууль болсны дараагаа ялсан, ялагдсан аль нь болохын ялгаагүйгээр нөгөө баталсан урт хугацааны бодлогын баримт бичгүүд хаачсан нь үл мэдэгдэх байдлаар мэдэгдэхгүй, бүдгэрэн алга болохын сацуу батлагдаад нэг жил өнгөрөөгүй байхад л баталсан төрөөсөө эхлээд бүх хүн тэдгээрийг хэрэгжүүлэх нь бүү хэл мартах, үгүйсгэх явдал гардаг. Эндээс дүгнэх ахул,

иргэнээсээ эхлээд улс төрчид, улс төрийн нам, нийт үндэстнээрээ итгэл үнэмшлийн хэмжээнд, нэгэн дуу хоолой, үзэл бодлоор зангигдан ойлгон ухамсарлаж, басхүү баримталдаг бол сонгуульд ялалт байгуулсан эрх баригчид дур зоргоороо өөрчлөөд байх боломжийг бүх талаар хаасан хөгжлийн тэргүүлэх чиглэлгүйгээр хөгжих нь бидний өмнө тулгарч буй хамгийн том сорилт, бас сэтгэл эмзэглүүлэх явдал болж байна.

## 3.7. НЭГ СЭДЭВТ ХАМТЫН БҮТЭЭЛ

Урт хугацааны хөгжлийн субъектив хүчин зүйлийг судлах онол-философи арга зүй боловсруулах, урт хугацааны хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийн практик асуудал болон нийгмийн хөгжилд засаглалын үзүүлэх нөлөөллийг шинжлэн тодорхойлох зорилгын хүрээнд энэхүү нэгэн сэдэвт хамтын бүтээл туурвисан. **“Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн шинжилгээ”** УБ., 2019 /Редактор Б.Даш-Ёндон/. Бүтээлийн шинэлэг тал: тус бүтээлд хөгжлийн субъектив хүчин зүйлийг судлах онол-философийн арга зүй, тухайн тохиолд практикийн учир холбогдол, улмаар нийгмийн хөгжилд засаглалын үзүүлэх нөлөө зэрэг асуудлыг шинжилснээрээ онцлогтой. Өнөө цагийн нийгмийн хөгжил жолоодлого шаарддаг болжээ. Эл жолоодлого нь ороомог дахь зогсонгийг арилгах, дэвшин дээшлэхүйг нь хангах, ухарч буцахуйг зогсооход оршино; энэ обьектив шаардлагаас болж нийгмийн хөгжилд субъектив хүчин зүйлийн нөлөөллийн асуудал гарч ирдэг байна. Энэ нь цаанаа обьектив хийгээд субъектив хүчин зүйлийн харилцан хамаарлын тухай философийн бас практикийн асуудал юм. Нийгмийн амьдрал, хөгжлийн асуудлыг судлахдаа **метафизикч либерализмын** үүднээс бус, **диалектикч философийн** үүднээс хандах нь арга зүйн гол зарчим гэж үзжээ. Тус хамтын бүтээлийн нэгдүгээр бүлгийн §1-ийг академич Г.Чулуунбаатар, §2, §3-ийг доктор (Sc.D) Б.Даш-Ёндон, §4-ийг доктор (Ph.D) Ш.Ганхуяг магистр Б.Цэрмаа нар, §5-ийг доктор (Ph.D) Ж.Энхбаяр, хоёрдугаар бүлгийн §1-ийг доктор (Ph.D) М.Гантуяа, §2-ийг доктор (Sc.D) А.Цанжид, §3-ийг доктор (Ph.D) Б.Батхишиг, §4 доктор (Ph.D) Д.Гантөмөр, §5-ийг доктор (Ph.D) Б.Пүрэвсүрэн, гуравдугаар бүлгийн §1-ийг академич Г.Чулуунбаатар, §2-ийг доктор (Ph.D) О.Хатанболд, §3-ийг доктор (Sc.D) А.Цанжид, §4-ийг доктор (Ph.D) Ж.Энхбаяр, §5-ийг доктор (Ph.D) Д.Батмөнх нар бичсэн байна. Төслийг хэрэгжүүлэхэд оролцсон эрдэмтэн судлаач бүр хөндсөн сэдэвтээ олон чухал санаа дэвшүүлсэн.

**Хамтын бүтээлд дор дурьдсан үндсэн чиглэлээр шинэлэг бөгөөд хөгжлийн бодлогод чухал ач холбогдол бүхий санал дүгнэлтүүд хийжээ. Үүнд:**

Улсын хөгжлийн тухай асуудлыг авч үзэх талаар “хөгжил бол юм үзэгдлийн найрсан зохицсон дэвшлийн үйл явц” гэсэн нийгмийн философийн шинэлэг үзэл баримтлалыг дэвшүүлж, түүнийгээ суурь болгож Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн үндсэн чиглэл, гол хүрээг тодорхойлсон арга зүйн үндэслэлийг дэвшүүлсэн;

- “Тогтвортой хөгжилд шилжихийн тулд ногоон эдийн засгийн бодлогыг нийтлэг үүрэг хэмээн хүлээн авч, урт хугацааны бодлогыг үндэснийхээ

тогтвортой хөгжлийн төлөвлөгөө, стратеги, тэргүүлэх зорилттой уялдуулан зохистой арга хэлбэрээр сонгон хэрэгжүүлж болно;

- Улсынхаа тогтвортой хөгжлийг хангахын тулд нэгд, уул уурхайн үйлдвэрлэлийг зохистой, зохион байгуулалтай болгож, байгаль орчин болон бусад салбарт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, хоёрт, бэлчээрийн даац хэтэрч, доройтож байгааг анхаарч, мал аж ахуйн хөгжлийг найдвартай, чанартай, үр ашигтай болгох, гуравт, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, хөнгөн, хүнсний болон хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэх гэсэн гурван нэгдмэл зорилтыг хэрэгжүүлэх хэрэгтэй;
- Монгол орныхоо соёл, байгалийн нөөц дээр тулгуурласан уул уурхай, МАА, газар тариалан болон аялал жуулчлалын салбаруудыг дэлхийд өрсөлдөх чадвартайгаар бодитойгоор хөгжүүлж эдийн засгийн тулгуур бүтэц өөрөө батжиж, олон тулгуурт мэдлэг шингэсэн үйлдвэрлэлүүд сууриараа хөгжих тогтолцоог бий болгох хэрэгтэй;
- Монгол хүний үнэ цэнэтэй давуу талыг хүн төрөлхтний ололттой талуудаар баяжуулах стратегийн индикатор салбараа хэрхэн ашиглах асуудалд анхаарч ажиллах. *"Монголын нийгмийн оюун санааны чиг баримжаа болох ёс суртахуун, улс төр, эрх зүй, урлаг, шашин, соёл, эдийн засгийн үнэт зүйлсийн өөрчлөлт, хандлагыг шинэ нөхцөл байдалтай уялдуулан тодорхойлох, өнөөгийн монголчуудын үнэт зүйлсийн мотивацийн хүрээ, өөрчлөлтийг орчин үеийн үнэлэмжийн судалгааны онол, арга зүй, аргачлалд тулгуурлан нарийвчлан судлах шаардлагатай"*[1] байна хэмээн дүгнэжээ.
- Өрсөлдөх давуу талаа тодотгож, өндөр чанарыг бий болгохын тулд Олон улсын жишиг бүхий шалгуур үзүүлэлтэд үндэслэн тогтвортой аялал жуулчлалын стандартыг Монголын онцлог нөхцөлд нийцүүлэн, олон талын эрх ашгийг хангахуйц, тэдний оролцоотойгоор боловсруулан нэвтрүүлж, хяналт үнэлгээ, хөгжүүлэлтийг тогтмол хийх нь тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх суурь хүчин зүйл гэж тодорхойлж байна;
- Бүс нутгийн нөхцөл байдал, хүчний харьцаа, олон улсын зах зээлийн эрэлт хэрэгцээ ч түргэн өөрчлөгдөж, хэрэглээний стандарт дэлхий даяар ижилсэх хандлагатай байгаа өнөөгийн нөхцөлд бүс нутгийн хэрэгцээ, техник технологийн хамгийн сүүлийн үеийн хөгжлөөр баримжаалах зайлшгүй шаардлагатай;
- Аялал жуулчлалыг зөвхөн жуулчдын тоо хэмжээний механик өсөлтөөр юм уу, эсвэл хувийн хэвшил зах зээлийн хуулиар өөрөө хөгжинө хэмээн урсгалаар хандах биш, харин салбарын бодлого, төлөвлөлт, хэмжүүрээр тооцон жуулчдыг хүлээн авах, байрлуулах, аялуулах, амраах

[1] Чулуунбаатар Г., Сонинтогос Э. Монгол төрийн соёлын бодлого ба үнэт зүйлийн судалгаа. //Монголын соёл, урлаг судлал. Боть XXVIII. -УБ.,2018. 36 дахь тал.

үйлчилгээний үйлдвэрлэлийн нэгж технологийг тооцсон шинжлэх ухааны үндэстэй суурь судалгааны үндэстэй хөгжүүлэх нь үр нөлөөтэй;

- Монгол Улс урт хугацаанд үр өгөөжтэй хөгжих хамгийн гол субъектив хүчин зүйл бол төрийн нэгдмэл бодлого, түүний залгамж шинж, салбар хоорондын уялдаа зохицол, энэ бүхэнд зохистой үйлчлэх улс төр, эрх зүйн орчин, засаглалын тогтвортой байдал мөн.
- Урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд нөлөөлөх засаглалын томоохон хүчин зүйл бол төрийн албыг тогтвортой, хариуцлагатай байлгах явдал мөн;
- Иргэний нийгмийн төлөвшил нь засаг болон эдийн засгийн бүтцэд шууд болон шууд бусаар нөлөөлж, хөгжлийн зөв зам голдрилдоо ороход тустай бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад засаг төр дангаараа ажиллаад хүчрэхгүй, харин иргэд хийгээд иргэний нийгмийн оролцоотой л хөгжлийн тогтвортой бодлого, зорилтоо гүйцэтгэж чадна.

### 3.8. НОМ ТОВХИМОЛ

1. **Ж.Энхбаяр** (Ph.D). *"Жан-ФрансуаЛиотар. Постмодерн нөхцөл: Мэдлэгийн тухай тайлан"* номын орчуулгыг нэмэн засварлаж дахин хэвлэв. Францын философич Жан Франсуа Лиотарын энэхүү бүтээл нь хэмжээгээр бага болович агуулгын хувьд том юм. Зохиогчийн бүтээлдээ дэвшүүлэн тавьсан асуудал, орчин үеийн нийгмийн, соёлын, эпистемологийн задлан шинжилгээ нь хэвлэгдсэн даруйдаа нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбар бүрийн мэргэжилтэн, судлаачдын анхаарлыг татаж улмаар зохиогч бээр постмодернист философийн эхлэлийг тавьсан хэмээн алдаршжээ. Тус бүтээлд "хамгийн өндөр хөгжсөн нийгмүүд дэх мэдлэгийн нөхцөл болон мэдлэгийг дамжуулагч болох боловсролын асуудлыг голлон хөндсөн.
2. **Б.Даш-Ёндон** *"Гегелийн философийн үндсэн агуулга" – УБ., 2018* товхимлыг бичиж хэвлүүлэв. Хүн төрөлхтний их сэтгэгч Г.В.Ф.Гегелийн (1770-1831) философийн танин мэдэхүйн онолын утга агуулгын талаар сонирхож мэдэх нь хүний танихуйд, философичдын, нийгэм агаад байгаль шинжлэлийн эрдэмтдийн сэтгэн бодож, бүтээн туурвихад чухал ач холбогдолтой хэвээр байна. Тус бэсрэгхэн товхимолд Германы их сэтгэгч Г.В.Ф.Гегелийн философийн үндсэн агуулгыг К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленининий шинжилгээнд дулдуйдан харуулах гэж оролджээ. Үүнээсээ үүдэн эдүгээ манайд гарч буй түүх бичлэгийн зарим гажуудлын зах зухыг хөндсөн байна.
3. **Ц.Ганбат** (Ph.D) Жульетто Кьезагийн*Эзэнт гүрнүүдийн дайн: Өрнө ба дорно. – УБ., 2019* номыг орос хэлнээс орчуулж, редактороор төслийн удирдагч академич Г.Чулуунбаатар ажиллаж хэвлүүлсэн. Жульетто Кьеза энэхүү бүтээлээ өөрийг нь дэмжигч, эсвэл эсэргүүцэгчтэй хүүрнэх амьд ярианы хэлбэрээр бичсэнээрээ нилээд онцлогтой. Тус ном нь хэдий хочлолын нийтлэлийн зарим нэг хаялгатай авч түүнд сэтгэл хөдлөлийн тэсрэлтийг бус, харин нэг-цорын ганц үндэстнээр толгойлуулсан дэлхийн дэг байхыг эсэргүүцсэн оюун санааны бослогыг илтгэсэн аж. Тэр нь эн түрүүнд, Америк манлайлал нь ёс суртахуунлаг болон зүй зохист, эсэх үндэслэгээг шүүн цэгнэсэн эрүүл саруул бодрол тунгаалт аж. Зохиогч энэхүү номондоо улстөрийн зах зээлд улайсах цог, дэлхийн ирээдүйн төлөөх үзэл санаа, байр сууриа өгүүлжээ: Америкийн Нэгдсэн Улсад өөрт нь бодит нэгэн эд, мөн чанарын хувиар байдаггүй ардчиллыг хэрхэн экспортлох юм бэ? Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөө, түүний эрх ашиг болон Америкийн эрх ашгийн солбилцол юунд хүргэх вэ? АНУ дахь 9 дүгээр сарын 11-ний үйл явдлын урьдчилсан нууц нөхцөл юу байв? Усам бен Ладен гэгч хэн байв? Ойрхи Дорнодод самуун яагаад намжихгүй байна? Иракт цөмийн зэвсгийг үе үе яагаад хайдаг вэ? Стратегийн нөөцөө сэргээн бэхжүүлж, бие даасан алхам

явуулснаар Путин юу золиосолж байна? “Шинэ Оросын анхны ардчилсан ерөнхийлөгч” гэх хэлц яагаад утгагүй бөгөөд хуурамч вэ? гэх мэт олон асуудлыг хөндөж тавьснаараа нилээд онцлогтой бүтээл ажээ.

4. **Б.Даш-Ёндон.** *Хөгжихүйн философи. - УБ., 2019 /20.6 х.х/* өгүүллийн эмхтгэлийг хэвлүүлсэн.

Монгол Улсын хөгжлийн бодлого, ялангуяа урт хугацааны хөгжлийн бодлогын философи үндэслэлийн асуудлыг нийгмийн болон улс төрийн философи, улс төрийн эдийн засгийн ухааны хүрээнд судлан боловсруулж өөрийн орны онцл огт тохирсон хөгжлийн замналыг тодорхойлоход чиглэсэн өгүүлэл, илтгэлүүд ийн эмхэтгэл. Зохиогч энэхүү эмхтгэлдээ монголынхоо хөгжлийн асуудал хөндөж социаль философийн чиглэлээр бичсэн, орчуулсан зарим өгүүллээ эл эмхтгэлд оруулжээ. Эдгээрийн нилээд нь урьд өмнө хэвлэгдэж байсан бөгөөд заримыг нь шинээр бичсэн байна. Мөн хөгжлийн философид хамаарах олон асуудлыг тоо, баримтаар баяжуулсан нь хойч үеийнхэнд олон санаа, мэдлэг нэмэхэд хувь нэмэр оруулж буй юм.

# 3.9. БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

## НЭГ СЭДЭВТ БҮТЭЭЛ-1

1. "Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн шинжилгээ". УБ., 2019.

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ-14

1. **Г.Чулуунбаатар.** Ардчилсан засаглалыг боловсронгуй болгох тухай асуудал ба монгол улс. /*"Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох асуудал: Монгол Улсын жишээ" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал/ - 2018*
2. **Г.Чулуунбаатар.** Монгол дахь засаглалын зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зөвлөлдөх ардчиллыг ашиглах боломж – /*Ази дахь Зөвлөлдөх ардчилал/* - сэдэвт олон улсын хурал.
3. **Г.Чулуунбаатар**. Монголын хөгжлийн бодлого: Асуудал ба шийдэлд холбогдох зарим санаа. /*Монголын нийгмийн хөгжлийн философи ба бодлого" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал/ - 2017*
4. **Г.Чулуунбаатар.** Монгол төрийн соёлын бодлого ба үнэт зүйлийн судалгаа. СУИС, Олон Улсын Монгол Судлалын Холбоо хамтран 2018 оны 7 дугаар сарын 23-24-ний өдөр,**"Монголчуудын соёлын ертөнц: өв, үнэт зүйл, урлаг"** Олон Улсын эрдэм шинжилгээний хурал. /Э.Сонинтогостой хамтран/.
5. **Г.Чулуунбаатар.** Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал ба монгол улсын хөгжил. /*Эрдэнэт хотод зохион байгуулагдсан 100 инженерийн форум/ - 2018.*
6. **Г.Чулуунбаатар.** Социально-политические проблемы монгольской молодежи в период модернизации. /*Институт монголоведения, буддологии и тибетологии СО РАН Бурятский государственный университет Федеральный научно-исследовательский социологический центр РАН Институт востоковедения РАН-аас зохион байгуулсан олон улсын хурал/*
7. **Ш.Ариунаа.** И.Кант: Хүний мөн чанарын тухай. /*"Евразийн ард түмний Ассамблей"-н анхдугаар их хурлын "Panel discussion Eurasia in which we will" сэдэвт салбар хуралдаан/ - Москва.,*
8. **Б.Даш-Ёндон**. Монголын хөгжлийн философи: Улс төрийн эдийн засгийн ухааны диалектик. /*Монголын нийгмийн хөгжлийн философи ба бодлого" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал/ - 2017*
9. **Б.Даш-Ёндон.** Хувь хүний ёс зүйн хариуцлагын асуудалд. /*ӨнөөгийнМонголын нийгмийн улстөрийн хариуцлага, ёс зүйн зангилаа асуудал. Эрдэм шинжилгээний бага хурал/ - 2018*

10. **Б.Даш-Ёндон**. "Карл Маркс ба Марксизмын урсгалууд" . */К.Марксын мэндэлсний 200 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал/ - 2019.*
11. **А.Цанжид** "Монголын хөгжлийн бодлогын зарчмууд". */Монголын нийгмийн хөгжлийн философи ба бодлого" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал/ - 2017.*
12. **Ж.Энхбаяр** "Нийгмийн хөгжлийн тухай өгүүлэх нь"**.** */Тогтвортой хөгжил: Оюуны соёл эрдэм шинжилгээний бага хурал/ - 2017.*
13. **Хатанболд О. "Доверие как фундаментальный вопрос успешного развития экономического коридора"** илтгэл. Англи хэл дээр. "Экономический коридор Китай – Монголия – Россия: дорожная карта" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017. Улан-Үдэ, ОХУ
14. **Khatanbold, O.** Mutual Understanding Between the Citizens in the Countries of China-Mongolia-Russia. */Хятад, Монгол, Орос гурван улсын хамтарсан Тинк Танк холбооны олон улсын форум-2019/CRMF2019/-ын Иргэд хоорондын ойлголцолын талаар хэлэлцэх V салбар хуралдаан/.*

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ-9**

1. **Б.Даш-Ёндон.** Монголын хөгжлийн бодлого дахь улстөрийн эдийн засгийн ухаан: зах зээлийн асуудал - Хөгжихүйн философи. УБ., 2019.
2. **Б.Даш-Ёндон.** Орос улсын хөгжлийн товчлолыг төсөөлсөн В.И.Ленин, Г.В.Плеханов нарын онолын маргаан - Хөгжихүйн философи. УБ., 2019.
3. **Б.Даш-Ёндон.** Монголын түүхэн дэх ангиуд агаад өмчийн тухай асуудалд- Хөгжихүйн философи. УБ., 2019.
4. **Б.Даш-Ёндон.** Азийн үйлдвэрлэлийн арга: Монголын түүхийн диалектик - Философи, эрхийн судлал. XXXIV боть.УБ., 2019.
5. **Б.Даш-Ёндон.** Хоосон чанарын гүн ухаан дахь "Буй-үгүй"-н шүтэлцээ**.** Хөгжихүйн философи. УБ., 2019.
6. **О.Хатанболд** (Ph.D). Ардчиллын мөн чанар ба Монголын ардчиллын төлөвшил, хандлага. Конрад Аденаурын сангийн сэтгүүл. Уб., 2019,
7. **Khatanbold, O.** Sustainable approaches to the enthusiastic thoughts and perception on Mongolian democracy (analytic overview) – 2017. *13th International Scientific Conference Proceedings on "Process of the Sustainable Development in the Neighboring Countries: Culture, Society and Education".*
8. **Khatanbold, O**. Mongolian Youth's Internet Usage and Information Channel (Case of Qualitative Research Analysis) – 2017. "Социальные и политические вызовы модернизации в XXI веки"
9. **Khatanbold, O.** «Analysis on the Mongolia's sustainable development vision (SDV-2030) and its Challenges and Opportunities in Mongolia: Overview». «Study on Pressing Issues Faced by Neighboring Countries in the Contemporary World».

## НОМ ТОВХИМОЛ-4

1. **Ж.Энхбаяр** "Жан-Франсуа.Лиотар. Постмодерн нөхцөл: Мэдлэгийн тухай тайлан". УБ., 2017
2. **Б.Даш-Ёндон.** Гегелийн философийн үндсэн агуулга. УБ., 2018

**3.** Жульетто Кьеза "Эзэнт гүрнүүдийн дайн: Өрнө ба дорно". Орчуулсан Ц.Ганбат – УБ., 2019

4. **Б.Даш-Ёндон.** Хөгжихүйн философи. Өгүүллийн эмхэтгэл. УБ., 2019.

## БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ-1

1. "Монгол улсын хөгжил дэх мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхайн зохистой хамаарлын тулгамдсан асуудлууд" – УБ., 2019

ТАЙЛАН БИЧСЭН:

ТӨСЛИЙН УДИРДАГЧ, АКАДЕМИЧ Г.ЧУЛУУНБААТАР

2020 оны 09 дүгээр сарын 30

# ХАВСРАЛТ

# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ

# ӨГҮҮЛЭЛ


Бүдрагчаагийн ДАШ-ЁНДОН
ХӨГЖИХҮЙН ФИЛОСОФИ
(ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮГҮҮЛЭЛ, ИЛТГЭЛ)
УЛААНБААТАР
2019 он

## ГАРЧИГ

**Уншигчдад зориулсан угтал үг:** Г.Чулуунбаатар ........ 5
**Редакторын зурвас:** Н.Баяртсайхан ........ 7
**Зохиогчийн Оршил үг:**
Хөгжил бол амьд организмын оршин тогтнох арга мөн ........ 9

**Нэг. МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ**

1. Соёмбо: Монголын үндэсний гүн ухаан, нийгмийн шинэ байгууламжийн асуудалд ........ 16
2. Монгол Улсын хөгжил дэх мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхайн зохистой хамаарлын асуудлууд ........ 26
3. Монголын хөгжлийн философийг боловсруулах асуудалд ........ 29

**Хоёр. УЛСТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН УХААН**

1. Монголын хөгжлийн философи: улстөрийн эдийн засгийн ухаан дахь диалектик........ 38
2. Улстөрийн эдийн засгийн ухааны философийн асуудалд........ 44
3. Азийн үйлдвэрлэлийн арга: Монголын түүхийн диалектик........ 59
4. Монголд улстөрийн эдийн засгийн ухаан хэрэгтэй........ 86
5. Монголын хөгжлийн бодлого дахь улстөрийн эдийн засгийн ухаан: зах зээлийн асуудал........ 90
6. Улстөрийн эдийн засгийн ухаан: орчин үеийн мөнгө, санхүүгийн диалектик. ........ 105
7. Диалектика современных денег и финансов: политэкономический аспект ........118
8. “Азийн үйлдвэрлэлийн арга”-ын тухай онолын эх сурвалж........ 131

**Гурав. ФИЛОСОФИЙН ТҮҮХ, ТҮҮХИЙН ФИЛОСОФИ**

1. XX зууны эхний мөчлөгийн Монгол-Оросын харилцааны философи-түүхийн тойм........ 142
2. Философско-историческое обозрение Монголо-Российских отношений первой четверти XX в........ 153
3. Орос улсын хөгжлийн товчлолыг төсөөлсөн В.И.Ленин, Г.В.Плеханов нарын онолын маргаан........ 163
4. В.Инжаннашийн «Хөх судар» дахь түүх бичихүйн гүн ухааны сэтгэмж ........ 172
5. Карл Маркс ба марксизмын урсгалууд ........ 192

# МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ДАХЬ УЛСТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН УХААН: ЗАХ ЗЭЭЛИЙН АСУУДАЛ

**«Улс төрийн эдийн засгийн ухаан»** хэмээх нийгмийн эдийн засаг-философийн мэдлэгийн томоохон салбар байдгийг монголчууд бид бараг мартах шахаад байгаа бололтойдог. Эл мэдлэг ухааныг мартах нь нийгмийг танин мэдэхүйн нэгдмэл онолоос "ходоод"-ыг нь авч хаяна гэсэн үг болохсон билээ.

Миний бие Монголын хөгжлийн философийг боловсруулах асуудлыг хөндөн судлах явцдаа Монголд **өөрийн гэсэн улстөрийн эдийн засгийн ухаан** хэмээх мэдлэгийн салбарыг шинэ утга агуулгатайгаар боловсруулах нь зайлшгүй болох тулгарчээ гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Энэ санаа бол Монгол Улс эдийн засгийн "дотоод" философижсон онолтой болох юмсан, улс орноо хөгжүүлэх зорилгодоо нийцсэн цар хүрээ сайтай эдийн засгийн онолыг төрөөс боловсруулан мөрдөх хэрэгтэй байна гэсэн л үг. Түүнээс биш ямар нэгэн байдаггүй зүйлийг байлгая гэж хий санаанаасаа элдэв юм зохиох гэсэн оролдлого биш билээ. Энд түрүү цагийн их сэтгэгчдийн онол үзлийг дулдуйдан түших хэрэгтэй.

Эртний их сэтгэгч философичдын дотроос Аристотель анх удаа нийгмийн амьдрал дахь хөдөлмөрийн хуваарь, бараарын аж ахуй, арилжаа, мөнгө, өртөг хуваарилалт зэрэг үзэгдлүүдийг цогцолбороор нь, ингэхлээр, философийн үүднээс шинжлэн судалсан байна. Аристотель бол өртгийн хэлбэрүүдийг анх удаа шинжилсэн аугаа их судлаач мөн хэмээн К.Маркс бичжээ. Аристотелийн тэр цогцолбор шинжилгээний дүн нь яван явсаар **улстөрийн эдийн засгийн ухаан** гэх мэдлэгийн эх сурвалж болжээ гэхэд давруулсан хэрэг болохгүй бизээ.

Өрнө дахинд феодалын ёс задарч "цус балчигт умбуулсан" (К.Маркс) капитализм гэгч хөгжиж эхлэн хүмүүсийн дийлэнх олонхийн аж амьдрал улам хүнд хэцүү байдалд орсон XVII зууны үеэс нийгэм-философийн ухааны хөгжлийн дагууд улстөрийн эдийн засгийн ухаан хэмээх мэдлэгийн тодорхой салбар үүсчээ.

Монгол орчуулгаар хэлбэл, "**Улстөрийн эдийн засгийн ухаан**" гэдэг нэр томьёог анх Францын эдийн засагч Антуан Монкретьен (1575-1621) 1615 онд хэвлүүлсэн **«Нийгмийн аж ахуйн хуулиуд. Улстөрийн эдийн засгийн ухааны шаштир»** гэдэг номондоо хэрэглэжээ. Энд улстөрийн эдийн засгийн ухаан гэдэг үгээ нийгмийн аж ахуйн хуулиудтай холбосныг уншигч анхааран бодох буйзаа. Энэ цагаас цаашлан явсаар Өрнөдөд: **«Улстөрийн эдийн засгийн ухааны зарчмын тухай шинжилгээ»** (Жеймс Стюарт, 1767), **«Улстөрийн эдийн засгийн ухааны системийн тухай»** (Адам Смит, 1776), **«Улстөрийн эдийн засгийн ухааны шаштир»** (Жан Батист Сей, 1803), **«Улстөрийн эдийн засгийн ухаан ба татвар оноолтын эх»** (Давид Никоров, 1817), **«Улстөрийн эдийн засгийн ухааны бүрэн курс»** (Жан Батист Сей., 1828-1830), **«Улстөрийн эдийн засгийн ухааны шийдвэрлэгдээгүй зарим асуудлын тухай туршлага»** (Жон Стюарт Милл,

# ОРОС УЛСЫН ХӨГЖЛИЙН ТОВЧЛОЛЫГ ТӨСӨӨЛСӨН В.И.ЛЕНИН, Г.В.ПЛЕХАНОВ НАРЫН ОНОЛЫН МАРГААН

Капитал хэмээгчийн дарлалаас ангид нийгмийг цогцлоох тухай К.Маркс, Ф.Энгельсийн санааг бодит байдалд хэрэгжүүлэх практик асуудалд түүхийн хувь тавилангаар Орос орон анхлан холбогджээ. Энэ нь Орос улсын түүх-хөгжлийн амьдралаас зайлшгүйгээр урган гарчээ. Орос оронд нөхцөл нь бүрэлдэж гарцаагүй болсон социаль хувьсгалын онол, практикийн асуудлыг шийдвэрлэхэд их В.И.Ленин, түүний нам толгойлох үүрэг гүйцэтгэжээ.

Их Ленин (Владимир Ульянов)-ий улстөрийн амьдрал, үйл ажиллагаа, нийгмийн зүтгэл, зохиол бүтээл нь хүмүн төрөлхтөнд мартагдашгүй өв болон үлджээ. Үүнийг тодруулан харуулах үүднээс эхлээд зарим судлаачдын санааг авч үзье.

Зөвлөлт-Оросын эрдэмтэн **С.Н.Земляной** (1949-2012) **«Ленин ба Оросын "гурав дахь зам"»** гэдэг сонирхолтой үгүүлэлдээ (**С.Н.Земляной. Георг Лукач и западный марксизм. М. 2017** номноос үзнэ үү) Горбачев, Яковлев, тэднийг тойрон хүрээлэгчдийн гунигт үед Ленинийг гутаах гэж зарим зохиогч яаж сүржигнэж байсныг эхлэн товч сануулжээ. Тэд: Ленин сифилисээр өвдсөн; Ленинийн судсанд еврейн цус урсаж буй; нас барсан савхин хүрэмтэй хүний төмөр авдарнаас олдсон үнэт эрдэнэсийг Свердлов Ленинтэй хувааж авах гэж оролдсон; өөрийнх нь тухай М.Горькийн бичсэн найраглалаас аль хэсгийг нь уншиж өгөхөд бие нь их муу байсан Ленин хэрхэн уйлсан; Ленин **"Их хуралд бичсэн захидал"**-аа дуудаж бичүүлснийг сонсоод Сталин Крупская-г хэрхэн доромжилж харааж загнасан гээд [illegible] ч их донгодцогоосондоо; би бол үүнээс өөр зүйлийг мэдэж байна; Ленин муу хүн байсан уу, сайн хүн байсан уу, зээлсэн өрөө нөхөддөө зохих ёсоор төлж байсан нь үгүй юу гэх мэт юмыг тааварлаж ярихыг би огт сонирхохгүй байна.

С.Н.Земляной ингэж хэлээд цааш нь В.И.Ленинийн талаар томоохон сэтгэгчдийн хэлсэн бодит дүгнэлтүүдийг чухалчлан сануулжээ. Юуны түрүүнд **Бертран Расселаас** иш татсан байна. Б.Рассел Зөвлөлт Орос Улсын жолоодогч Ленин нас барсан тухай мэдээг сонсоод 1924 оны хоёрдугаар сард хэвлүүлсэн товч тэмдэглэлдээ: "Ленин өөд болсноор дайн байлдаанаас төрж гарсан гав ганцхан [illegible] аугаа суут хүнээ дэлхий ертөнц маань алдлаа. Бидний энэ зуун нэг нь шинжлэх ухааны салбарт, нөгөөх нь үйл үйлдлийн салбарт синтез бий болгосон асар их ажлыг хийж чадсан Ленин, Эйнштейний зуун болж түүхэнд орно" хэмээн бичсэн ажээ. Нээрээ үнэхээр, энэ хоёрын нэг нь **нийгэм** шинжлэлийн онол-практикт, нөгөөх нь **байгаль** шинжлэлийн онол-практикт үнэхээр давтагдашгүй гавьяа нэмэр оруулсан гэдэг нь одоо улам ч тодорхой болсоор байна.

Ер нь улстөрийн зүтгэлтний танин мэдэхүйн онол, чадвар нь түүний практик үйл ажиллагаагаар илэрдэг билээ. Ленин "Октябрийн эргэлт"-ийг (Ленинийн өөрийнх нь нэр томъёо) толгойлж, большевикууд засгийн эрхийг авч Оросын хөгжлийг

6. Академич Жигжидийн Болдбаатар ба Монголын түүхийн философи..... 196
7. Монголын түүхэн дэх ангиуд агаад өмчийн тухай асуудалд.................... 206
8. Хоосон чанарын гүн ухаан дахь "буй-үгүй"-н шүтэлцээ.......................... 213

## Дөрөв. УЛСТӨР, ЁС ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын онолын асуудалд ..... 220
2. Монголын хүний чин хүслэнгийн асуудалд (монгол хүнд юу хэрэгтэй вэ)........................................................................ 232
3. Улстөрийн хариуцлага........................................................................ 237
4. Нийгмийн хүмүүн бүтэц дэх хөөрсөн түмэн ............................................. 244
5. Төв үзэл ба орчин үеийн Монголын улстөрийн сэтгэлгээний асуудал..... 252
6. Монгол Ардын Намын үзэл баримтлал, зохион байгуулалт, хөгжлийн түүхэн тоймоос............................................................................ 264
7. «Ямбы нь ч эдэлнэ, ялы нь ч үүрнэ» хэмээх хэлц үгний тухайд ............... 271
8. Хувь хүний ёс зүйн хариуцлагын асуудалд .............................................. 275

## Тав. ОРЧУУЛГА

1. В.Я.Владимирцов. Түвд, Монгол дахь буддизм.......................................... 280
2. Монгол үгсийн сангийн хувирал, баяжилтын асуудалд («Коммунист намын тунхаг»-ийн орчуулгаар............................................ 302
3. Карл Маркс. Эрэлт........................................................................... 309
4. Ань Цинянь. Зөвлөлтийн философийг хятад эрдэмтэн үзэхүй нь ............ 313

# МОНГОЛЫН ТҮҮХЭН ДЭХ АНГИУД АГААД ӨМЧИЙН ТУХАЙ АСУУДАЛД

*Танин мэдэхүйд өөрийгөө алдаанаас*
*сэргийлэх гэсэн хүсэл элдэв бүхнээс хортой.*
*Г.В.Ф.Гегель*

Европт зүгширсэн нийгэм-эдийн засгийн формацийн онолын (марксизмын) үүднээс хандвал анги, өмч хэмээгч нь тухайн нийгмийн үйлдвэрлэлийн шинж чанар, түүнийг тодорхойлдог үйлдвэрлэх хүчний хөгжил, үе шатуудтай нь холбоотой байна. Марксизмыг үндэслэгчдийн түүхэн судалгааны арга зүйг баримталж Монголын их түүхэнд ангиуд агаад өмчийн тухай асуудал хэрхэн холбогдож болохыг сонирхон судлах нь шинжлэх ухааны төдийгүй, практикийн чухал ач холбогдолтой юм. Энэ сэдвийг авч үзэхэд дараах асуудлууд аяндаа хөндөгдөх болно. Тухайлбал, Монголын **түүхийн аль ч үед**:

1. Малчин ардууд ангийн бүрэн шинж чанартай байсан уу?
2. Феодалын хэмээх анги байсан уу?
3. "Нүүдлийн феодализм" гэж байж болох уу?
4. Өмчийн асуудал ямар байдалтай байсан бэ?
5. Манжийн дарлалд орохоос өмнө, орсны дараа үед ч Монголд ангиуд байсан уу?
6. 1911 оны эрх чөлөөний хөдөлгөөн ангийн шинж чанартай юу?
7. 1921 оны ардын хувьсгал ангийн шинж чанартай юу?
8. Тухайн цагийн Монголын лам нарыг анги хэмээн үзэж болох уу?

Эдгээр нь, эцсийн дүндээ нийлээд Монголыг Азийн үйлдвэрлэлийн арга бүхий орон мөн байсан уу? гэсэн асуулт болох юм.

Оросын эрдэмтэн нангиадач, монгол судлаач Н.Я.Бичурин 1828 онд бичсэн **«Монголын тухай тэмдэглэл»** номондоо "Монгол түмний эх удмыг олж гаргавал гэвэл бүрхэг сүүмгэр эрт дивангарын цаг руу орно гэсэн үг. Энэ ард түмэн манай эринээс өмнө хорин таван зууны (2500 жилийн) тэртээгээс Хятадын хойт хязгаарын залгасан цөл нутагт малаа маллан амьдарч иржээ"[1] хэмээн бичжээ.

Хүн төрөлхтөн дотроос түрүүлж соёлч боловсон байдалд хүрсэн гэгдэх Европын болон Дорны хүн ард, улс орон, үндэстнүүдтэй монголчуудын удам судар, энэ эртнээс улбаатай их түүхийг он цаг, хүмүүсийн ахуй байдал, аж төрөх ёсны хувьд жишин судлах бодит үндэс эндээс харагдаж байна.

***

Ангиудын тухай санаа, капитализмыг судлахтай холбоотойгоор, анх хөрөнгөтний түүхчид, эдийн засагчдын дунд үүссэн байна, тэхдээ хөрөнгөтний

[1] Н.Я.Бичурин. Монголын тухай тэмдэглэл. Орчуулсан Б.Даш-Ёндон. УБ., 2019. 141-р тал

STUDIA PHILOSOPHIAE ET JURIS
INSTITUTI PHILOSOPHIAE
ACADEMIAE SCIENTIARUM MONGOLICI

TOMUS XXXIV FASCICULUS 1-20

# ФИЛОСОФИ, ЭРХИЙН СУДЛАЛ

**XXXIV БОТЬ**

Улаанбаатар
2019

# ХОЁР. УЛС ТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН УХААН

## АЗИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГА: МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДИАЛЕКТИК

**Б.Даш-Ёндон**
*Доктор (Sc.D), профессор*
*ШУА-ийн Философийн хүрээлэн, Философийн салбар*

***Abstract:*** The study of Marx's theory of the Asian method of production is of great methodological importance in the study of the dialectic of the historical path and development of Mongolia. The author believes that this theory encompasses not only agricultural, but also copro-pod production. From the latter mode of production, it is possible to derive the features of the life course of the Mongols, and the further dialectics of the development of Mongolia.

***Түлхүүр үгс:*** Азийн үйлдвэрлэлийн арга, диалектик, Монголын түүх, [illegible]

**"Азийн үйлдвэрлэлийн арга"**-ын онолын тухай миний хувьд, энэ [illegible] сонирхож буйгийн учир гэвэл, эл асуудал, гайхалтай нь, манай [illegible] Монголын цаашдын хөгжлийн замыг тунгаан бодохтой холбоотой хэмээн санагдаад байгаад оршино.

Бид түүхээ мэдэх нь чухал гэцгээдэг, энэ үүднээсээ судалдаг, сайн ч бичигдэдэг. Гэтэл зарим сонирхуушттай мөч анзаарагдаагүй байж [illegible]. Жишээ нь, **"Азийн үйлдвэрлэлийн арга"** гэж К.Марксын томъёолсон тэр зүйл юу байв, К.Маркс хүн төрөлхтний нийгмийн [illegible] өсөж хөгжсөн хэлбэршлүүдийг Европын байдал дээр судлахдаа **"Азийн үйлдвэрлэлийн арга"** гэсэн санааг жичид гаргаж хэлсэн нь шинжлэх ухааны үүднээс ямар учир холбогдолтой, энэ нь эрт эдүгээгийн Монголд хэрхэн холбогдох вэ? гэх зэргээр бодогдоно. "Азийн үйлдвэрлэлийн арга" гэж К.Марксын томъёолсон санааг хожмын нь эрдэмтэд бас их анхаарсан байна.

Чингис хааны үеэс өмнө Монголын нутаг дэвсгэр дээр оршин байсан том том улс орнуудын, бас Чингисийн үеийн агаад Манжийн [illegible] үеийн монголчуудын амьдрал ахуйн байдал, өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн арга, түүнд багтдаг үйлдвэрлэх хүч, үйлдвэрлэлийн


Бүдрагчаагийн ДАШ-ЁНДОН
ХӨГЖИХҮЙН ФИЛОСОФИ
(ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮГҮҮЛЭЛ, ИЛТГЭЛ)
УЛААНБААТАР
2019 он

6. Академич Жигжидийн Болдбаатар ба Монголын түүхийн философи ..... 196
7. Монголын түүхэн дэх ангиуд агаад өмчийн тухай асуудалд .................... 206
8. Хоосон чанарын гүн ухаан дахь "буй-үгүй"-н шүтэлцээ .......................... 213

## Дөрөв. УЛСТӨР, ЁС ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын онолын асуудалд ..... 220
2. Монголын хүний чин хүслэнгийн асуудалд (монгол хүнд юу хэрэгтэй вэ) .......................................................................... 232
3. Улстөрийн хариуцлага ............................................................................ 237
4. Нийгмийн хүмүн бүтэц дэх хөөрсөн түмэн ............................................ 244
5. Төв үзэл ба орчин үеийн Монголын улстөрийн сэтгэлгээний асуудал..... 252
6. Монгол Ардын Намын үзэл баримтлал, зохион байгуулалт, хөгжлийн түүхэн тоймоос ............................................................................ 264
7. «Ямбы нь ч эдэлнэ, ялы нь ч үүрнэ» хэмээх хэлц үгний тухайд ............... 271
8. Хувь хүний ёс зүйн хариуцлагын асуудалд ................................................ 275

## Тав. ОРЧУУЛГА

1. В.Я.Владимирцов. Түвд, Монгол дахь буддизм ........................................ 280
2. Монгол үгсийн сангийн хувирал, баяжилтын асуудалд («Коммунист намын тунхаг»-ийн орчуулгаар ............................................ 302
3. Карл Маркс. Эрэлт ..................................................................................... 309
4. Ань Цинянь. Зөвлөлтийн философийг хятад эрдэмтэн үзэхүй нь ............ 313

# ХООСОН ЧАНАРЫН ГҮН УХААН ДАХЬ "БУЙ-ҮГҮЙ"-Н ШҮТЭЛЦЭЭ

Өрнийн философи сэтгэлгээн дэх **метафизикч** арга нь "**байгаа л байгаа, үгүй л бол бол үгүй**" хэмээн сэтгэх зарчимд суурилдаг бөгөөд үүнийг нь хэлбэрт (формаль) логик "дэмждэг". Өрнөдөд танин мэдэхүйн хөгжлийн явцад диалектикч логик бүрэлджээ. Хэлбэрт логик "байгаа", "үгүй" хоёрыг эрс сөргүүлдэг бол диалектикч логик энэ хоёрын авцалдаа шүтэлцээг чухалчилдаг байна.

Дорнын сэтгэлгээнд ч гэсэн "буй", "үгүй" хоёрын асуудлаар янз бүрийн үзэл бодол бүхий урсгалууд байсан ажгуу. Энэ тухайд Нагаржуна:

«Буй хэмээх ба буй үгүй хэмээх,

Буй хийгээд үгүй хэмээх тэр ч буй»[1] гэжээ. Өөрөөр хэлбэл, буй-г шүтсэн, эсхүл үгүй-г шүтсэн, бас буй үгүй хоёр хамтдаа гэж нэгтгэсэн ийм гурван үзэл байжээ. Түүний дээр "буй ч бус, үгүй ч бус хамтдаа" гэсэн үзэл байсан аж.

Нагаржуна ийм үзлүүдийг хааж няцаагаад "... **буй бус, үгүй бус, буй үгүй бээр бус**" гэсэн томьёолол гаргаж, "**энэ завсарт хамаг элдэв зүйл хурсан буюу**"[2] хэмээн хоосон чанарын тухай санааныхаа цөмийг тодорхойлжээ.

Хоосон чанарын гүн ухаан нь "**бодис хоосон**" буюу "хоосон чанартай" гэдэг үндэслэлд суурилдаг. Өрнийн диалектикч сэтгэхүйд "хоосон чанар"-ын категори томьёологддоггүй ч баригдаж тэмтрэгдэж байгаа юмыг "**юу ч биш**" (Гегель), "мөнгө бол харилцаа" (К.Маркс), "тавaар бол харилцаа" (Ленин) гэх зэргээр хийсвэрлэдэг нь утгаа эдгээр нь хоосон гэсэн утга бүхий амой. Өрнө, Дорно дахь эл хоёр шугам диалектикч агуулгынхаа хувьд, тодруулбал, диалектикч сэтгэлгээний хувьд эцсийн үндсэндээ адил ижил ажгуу. Ф.Энгельс "Диалектикч сэтгэхүй... хүнд, чингэхдээ түүний хөгжлийн нилээд дээд шатнаа (буддынхан, грекчүүд) байж болох юм"[3] гэж хэлснийг анхаарахгүй өнгөрч боломгүй.

Лаоз-ын "дао"-ийн, Гегелийн "туйлын санаа"-ны, Нагаржунын "хоосон чанар"-ын агуулга, хөгжил, хувирал, өөрчлөлтийг сайтар анхаарвал тэдгээрийн ижил төс нь бүр ч ойлгомжтой болно. Эдгээрийн аль аль нь суут сэтгэгчдийн диалектикч сэтгэлгийн өндөр дээд түвшин юм.

---

[1] Нагаржуна: Дундад үзлийн ухааны чуулган. 66-р тал

[2] Мөн ном. 65-р талд үзнэ үү.

[3] Ф.Энгеьс. Диалектика природы. М., 1965. с.191


RUSSIA
Study on Pressing Issues Faced by Neighboring Countries in the Contemporary World
the 14th China-Mongolia-Russia International Seminar
August 15-20, 2019
CHINA

# 目 录

Encountered Policies and Challenges to the Developing the Economic Corridor in the Three Countries ............ CHULUUNBAATAR Gelegpil 1
On the problem of basic concepts of justice in the light of the theoretical discourse of trans-civilization borrowing of different cultures and traditions ............ GAN-ULZII Ch. Batyn11
Structural Changes in the population and Domestic Migration of the 'Kazakh ethnics' in the Western Aimags in Mongolia ............ PUREVSUREN Byambakhishig 13
The problems of ageing population in neighboring countries Russia, Mongolia and China ............ TSETSENBILEG Tseveen 26
the modern Patterns of political cultures in Mongolia: ............
At the intersection of East and West ............ BAASANSUREN Dugarja29
............
analytical review on the State of Democracyin the modern world order............ KHATANBOLD Oidov 32
ANALYSIS OF THE FACTORS IMPACTING ON CONSTRUCTION MATERIALS INDUSTRY ............ UNDARMAA Z.,42
Increasing employee satisfaction through the attitude of the organizational culture ............ NASANDELGER 48
Analysis on the Mongolia's Sustainable Development Vision (SDV-2030) and its challenges and opportunities in Mongolia............ KHATANBOLD Oidov 59
The formation of the Political culture for the Mongolian youth............ KHISHIGDAVAA Ayush 67
ETHICAL ISSUES OF ADVOCATE............ DOLGORSUREN Mendbayar 79
К истории «Нового Шелкового пути»: борьба геополитических проекций............ Базаров Борис Ванданович90
ЖЕЛЕЗНОДОРОЖНОЕ СТРОИТЕЛЬСТВО КАК ФАКТОР ФОРМИРОВАНИЯ ТРАНСГРАНИЧНОГО ЭКОНОМИЧЕСКОГО ПРОСТРАНСТВА РОССИЯ – МОНГОЛИЯ............ Plekhanova Anna Maksimovna 98
Гуманитарное сотрудничество России, Монголии, Китая в современный период............ Innokentii G. Aktamov 105
Traditions of Chinese state craft and the Great Silk Road(Based on the materials of the chronicle "Jin shu" and the treatise of Fu Xuan "Fu-zi")............ Tsyrenov Chingis Tsybikdorzhievich 113
The socio-political processes in the transboundary area of Russia and Mongolia in the context of globalization and regionalization............ Zhalsanova Valentina Gurozhapovna 120
SUBURBAN DEVELOPMENT IN THE POST-SOCIALIST COUNTRIES (CASE OF ULAN-UDE AND ULAANBAATAR)............ Anatoliy S. Breslavsky 126
............
ВОЗМОЖНОСТИ ГИС-ПРОГРАММ В ФОРМИРОВАНИИ ГЕОГРАФИЧЕСКИХ КОМПЕТЕНЦИЙ............ A.D. Gombozhapov 139
Монгольский мир в зоне экономического коридора Китая, Монголии и России ............ Badaraev Damdin 143
Community of Human Destiny Needs Neighbouring Countries to Practice Together............ Tsgjiltu 149
人类命运共同体需要相邻国家一同践行............朝克吉勒图 149
人类命运共同体视域下新时代理想人格的基本特质............张瑞涛 153
一带一路是联结中蒙俄经济发展的纽带和桥梁............宝音满达胡 163
破解“三大治理难题”的中国智慧：习近平新时代治国理政内容论纲............张业蕾 夏从亚 167
新时代党的基层组织建设的“变”与“不变”............刘雨晴 张荣华 173
论文化相对主义视阈下发展中国家的国际文化策略............吕前昌 179
论马克思主义的“三大解放”理论............李友仕 高远 183
改变中国近代屡遭侵略历史命运的大决战............宋海儆 189
全球信息网络化对党内法规文化建设的影响及对策分析............宗 芳 198
生态文明建设与政治发展 ............赵国营 203

# Analysis on the Mongolia's Sustainable Development Vision (SDV-2030) and its challenges and opportunities in Mongolia[1]

(OVERVIEW)

*KHATANBOLD Oidov*
*(Ph.D), Academic researcher*
*Department of Political Sciences & Legal Studies, Institute of Philosophy*
*Mongolian Academy of Sciences*
khatanboldo@gmail.com
*(Mongolia)*

## *Defining the research background*

The 21st century brought with it new hopes, opportunities and aspiration. The Millennium Declaration, endorsed by 189 governments at the United National General Assembly in September 2000, reflected those aspirations. World leaders made an unprecedented commitment to work together to ensure a more peaceful, prosperous and just world. The Millennium Development Goals advances a global vision to improve the human condition and strengthen efforts to reduce poverty, enhance human rights and democracy, and promote protection of the environment.

Despite being global goals, the MDGs were adopted by countries and aligned with their national priorities to local realization. Mongolia is the one of the countries after Albania to have a 9th MDG on "Strengthening human Rights and fostering Democratic Governance" that emphasizes democratic governance and human rights as necessary conditions for the achievement of all MDGs. The targets were revised in 2008 and there are total 24 targets with 67 indicators for the nine MDGs.[2]

Historically, Mongolia's MDGs are strongly embedded at the policy level in Mongolia. The Parliament adopted the MDGs as development benchmarks in 2005 and then as the framework for the MDG-based Comprehensive National Development Strategy[3] (CNDS) of 2008-2021. The first phase included aligning the country's development objectives with the MDG targets. As part of the implementation process of the MDGs and CNDS, the government has launched a number of initiatives to enhance strategic and economic planning and their coordination and management. The government established an independent agency responsible for economic development planning and introduced several changes in financing and budgeting systems. After that adoption of the CNDS in 2009 the Government of Mongolia established a specialized agency –

---

[1] This analytical paper is presented under the basic studies project sponsored by the Ministry of Education, culture, science ans sport of Mongolia entitled «The subjective factor analysis for the Long-term Development Policy in Mongolia» (2017-2019) implemented by the Department of Philosophy at the Institute of Philosophy from Mongolian Academy of Sciences.

[2] State Great Khural (Parliament of Mongolia). Parliament's Resolution #13, January 31, 2008. UB, Mongolia. // State Great Khural (Parliament of Mongolia). Parliament's Resolution #25, April 21, 2005. UB, Mongolia. http://www.legalinfo.mn/law/details/6660?lawid=6660

[3] State Great Khural (Parliament of Mongolia). Parliament's Resolution #12, January 31, 2008. UB, Mongolia. http://www.legalinfo.mn/law/details/6660?lawid=6660


СОЦИАЛЬНЫЕ И
ПОЛИТИЧЕСКИЕ
ВЫЗОВЫ
МОДЕРНИЗАЦИИ
В XXI в.

Институт монголоведения, буддологии и тибетологии СО РАН
Бурятский государственный университет
Министерство образования и науки Республики Бурятия
Дальневосточный федеральный университет
Федеральный научно-исследовательский социологический центр РАН
Институт востоковедения РАН
Российское общество социологов

# СОЦИАЛЬНЫЕ И ПОЛИТИЧЕСКИЕ ВЫЗОВЫ МОДЕРНИЗАЦИИ В XXI в.

МАТЕРИАЛЫ
международной научно-практической конференции

Улан-Удэ, 6–11 августа 2018 г.

Улан-Удэ
Издательство БНЦ СО РАН
2018

*Лагойда Н. Г.* Жилищная проблема молодых семей и ее особенности в Республике Бурятия………………... 230
*Фэн Ц.* Ценностные ориентации современной китайской семьи…………………………………………………233
*Башкуева Е. Ю.* Социологические методы в исследованиях проблем модернизации здравоохранения и охраны здоровья населения Республики Бурятия………………………………………………………………. 235
*Кривоносова Л. А.* Экспертиза социальных программ регионального развития……………………………...239
*Голубев В. С.* К вопросу о практике социального управления…………………………………………………. 241
*Хатанболд О.* Использование Интернета и информационных каналов монгольской молодежью (случай качественного исследовательского анализа)…………………………………………………………….. 243
*Цэдэндамба С.* К вопросу изучения религиозности монгольских буддистов……………………………... 251
*Комбаев А. В., Цыремпилова Э. В.* Имидж вуза: изучение и способы формирования…………………………. 254

DOI: 10.30792/978-5-7925-0537-7-2018-243-250

*Oidov Khatanbold (Ph.D)*
Ulaanbaataar, Mongolia
khatanboldo@gmail.com

# MONGOLIAN YOUTH'S INTERNET USAGE AND INFORMATION CHANNEL (CASE OF QUALITATIVE RESEARCH ANALYSIS)

The paper issued on responding the challenges and clarified opportunities to the reforms such as political, economical and social reforms, which were relatively silent and stable reforms that formed a good sample of democratic development. We are used by the case of qualitative research analysis for the survey on Mongolian youth political participation and democracy understanding in this paper. The central assets that identifies of youth's internet usage, information gathering and information source to their needs in order to achieve their full potentials including prior knowledge, technical skills, and institutional or organizational capacities, in regarding the ability to prevent, manage and resolve conflicts.

**Keywords:** youth, internet usage, information needs, communities, reforms, information channel and democratic development etc.

*Ойдов Хатанболд*
Улан-Батор, Монголия

# ИСПОЛЬЗОВАНИЕ ИНТЕРНЕТА И ИНФОРМАЦИОННЫХ КАНАЛОВ МОНГОЛЬСКОЙ МОЛОДЕЖЬЮ (СЛУЧАЙ КАЧЕСТВЕННОГО ИССЛЕДОВАТЕЛЬСКОГО АНАЛИЗА)

Статья подготовлсна в ответ на возникающис вызовы и для разъяснсния возможности для политичсских, экономичсских и социальных реформ, которые сформировали хорошую базу для демократического развития. Мы используем случай качественного анализа исследований для исследования монгольского участия молодежи в политической жизни и понимания демократии. Использование Интернета молодежью, сбор информации и источник информации для удовлетворения их потребностей, включая предварительные знания, технические навыки, может привести к навыкам предотвращения, управления и разрешения возникающих конфликтов.

**Ключевые слова:** молодежь, использование Интернета, информационные потребности, сообщества, реформы, информационный канал и демократическое развитие

*Defining the circumstantial concerns*

Since its democratic transition in 1990s, Mongolia has undergone number of reforms such as political, economical and social reforms, which were relatively silent and stable reforms that formed a good sample of democratic development. This success was one of the most powerful evidence that not every developing country in Asia should implement the reform both in political and social fields as it was realized in many other countries. However, being a democratic country is not only based on the adoption of democratic views and principles. Even in our society, freedom and democratic principles are the most important value to be proud of, it is still required to improve the implementation mechanisms and methods for promoting democratic culture nationwide.

During this period of 20 years, while Mongolia is in its democratic development phases, a new generation of youth that has no decent knowledge or experiences about previous society has now grown up and reached at the age of elections. They constitute 40 percent of total population of Mongolia. Due to population window phase, the roles and responsibilities of youth in current society tend to be more increased. In last few decades, information technologies tend to have a more impact on daily life, socialization process and social participation of youth than traditional social factors. Accordingly, nature of characteristics of issues and challenges faced by youth are also different and changed. In order to promote the development of democratic society in Mongolia, it has a paramount importance to study and explore current state of youth understanding, concept and tendency toward democracy and political participation.

The paper attempted to identify a baseline data on youth, in terms of their understanding towards internet access and usage, information gathering channel, for the very first time and survey instruments such as questionnaire and other tools are developed by the Mongolian youth in the political participation and democracy understanding which is comparable to other survey results conducted in different categories. These are the main features of this paper aimed to identify the following scopes of the research results of (i) the characteristics of youth internet usage, social media demands and information approaches; (ii) youth demands of gathering a mandatory information based on in-depth expert interviews; (iii) challenges to gathering the information and its media-sharing causalities; (iv) comparison to the qualitative analysis with national survey findings; (v) conclusions and recommendation.

*(i) The characteristics of youth internet usage, social media demands and information approaches*

Beyond traditional media, there are many media sources for youth such as internet, social media network etc. Youth are interested in entertainment and information related to their hobby. Most children and youth do not intrest in economy, law and international information and not putting effort to receive, they do not have it analysed or to have their own view and postion on the issue even if they do receive such information.

Youth have opportunity to receive information, but information need is not quite satisfied. This is all due to dissemination process of all these information are not systematic and objectively, aslo it is due to the fact that most youth not interested in information which is useful for them or beneficial for human development, unable to receive, distinguish them and analyse; as well as being


RUSSIA
"Process of the Sustainable Development in the Neighbouring Countries: Culture, Society and Education"
13th International Scientific Conference
August 14-17, 2017
CHINA
INDIA

# SUSTAINABLE APPROACHES TO THE ENTHUSIASTIC THOUGHTS AND PERCEPTION ON MONGOLIAN DEMOCRACY
## (Analytic overview)

KHATANBOLD[1] Oidov, Ph.D
(Mongolia)

**Abstract:** Political life should not be forced to involve the people, or except to interfering on this process, that they have own rights or freedom to approaching their dislikes. Though, the lack of active participation of the people that democracy was weakens and withers. Any democratic society or any communities, and number of private organizations, associations and voluntary groups could be worked in together to solving the challenges. Most of them are more engaged in policy issues in the country, but few of them work under government-control and funded from there. In association with individual voluntarily connections to the various non-government organizations are affected by the freedom that exercises on *"the basis of democracy"*. Unknown, the people who have same views and interests that they have been united one to one in the any political discussions, which is being increased by the possibilities or opportunities in regarding to receive their feedback. Democracy is based on the major approaches of open debate, convince for a compromise and negotiation one to one. Most of the debate about democracy policy questions was affected by opinions and conflict of interests, that regards to be difference in being right to express discrepancy to listening. So, that democracy is required too many different views of the people in society, pluralism, diversities regards that citizens' equality assumption must be calculated in advance.

Any kind of democratic principles are related to the union of collective decision - making. There is a significant relationship between the democracy at the level of statehood and other social institutions' level of democracy. As for an author of this paper is responsible for researching of an accurate democracy and a proper perception and values that will be a research priorities, and except that democracy is not only planting soil of the country, but there most important thing to do is planted correctly for the country's human traditional rods brain, thoughts, mind, thinking.

***Keywords:*** *democracy, determination, assessment, justice, understanding, relationship, democratic principle, social relations, social values, socio-political, political and social involment*

** ** **

Rationale

Contextual determination of the concept and perception on democracy of Mongolians, at first, defining the reasons for the issue of the political sciences or imagination on *'Democracy studies'* has been developed by the independent research direction, and it can be attempted to answer that question of public attention. In association with democracy research philosophy and methodology in relatively common nature of mankind, or that is 'Yes', every single model of the democracy is required to similar development of democracy character, or there is a distinctive national style or type of differences of democracy development and religion and way of life which is affected by the factors to building the model. The people, specifically, politicians who have western view on *"classic"* definitions would like to call such a complete answer to this question seems to be able to give.

There are many definitions and reviews of democracy such developed or generated by the politicians and political scholars. Democracy, itself requires more unique individual in the system that is not a mechanical sum of belongings. In this sense, that smoothly implementation of its advantages of democracy and common values of the quality ascertain number of positive patterns to be observed. In particular, democracy is being more enriched the lives of citizens and their political freedom and economic needs, off-duty and learning, also such as the practice of democracy. By means that political freedom is a part of human freedom and that exercise of civil and political rights as the person who lived in the society, which must be an integral part of the good life.

The political and social involvement for human life and well-being of all its own that's worth

1 Academic Secretary of the Institute of Philosophy from the Mongolian Academy of Sciences.

is important situated. The instrumental importance of democracy is existed on politically voice expressed that should be noticed others notifications in requiring to expression of the views for the people. Along with detailed studies on democracy, that requited to study on the practice of democracy, while a person who are the opportunity to learn from one another, and social values and priorities is construction of helps. Logically, democracy is naturally worth that lives of citizens and political decisions such is the instrumental importance and required to constructive spiritual importance as well.

Hereof, democracy was born from its life, or social relations among people of developing, or have limited wide multitude of phenomena, and in fact, that is a collective actions, and the work of someone else, which can't be owned by someone or any political force that is also not merchandise. The people are its author. Anyone does not take away the rights of its author. The political force is the only servant to the people that supports to the development of democracy as a slave. They have rights such is replaced that servant of them. Even killing our disposal, but they are needed. The electoral mechanism is performed in the democratic society.

From the Asian barometer survey, that East Asian youth generally have lower levels of satisfaction with democracy; they do not prefer alternatives to the system. Less developed societies in the region especially show high levels of preference for democracy. In most societies, youth hardly differ from older cohorts. The notable exceptions are Japan and South Korea, where youth have lower levels of preference for democracy. It seems youth there are less satisfied with democracy and they do not reject alternative systems of government.[1] The attitude might be skepticism about the current function of the prevailing political systems. Dissatisfaction with the existing political systems might propel youth to call for change and reform of the systems. Indeed, people in the Philippines, Mongolia, Japan, and South Korea, including young adults, prefers changes in their political systems. By contrast, people in Vietnam, Thailand, Malaysia, and Cambodia are pretty satisfied with their political systems and oppose extensive reform.[2]Taken together, in most societies, there are only minorities, including the youth, who prefer other forms of government, suggesting that the prevailing system of government remain resilient with low levels of citizen dissent. Similarities of the research findings in the internationally, the majority of Mongolians are considered that democracy is the ideal as an effective democratic political system.

*Figure 1.Dismayed Youth in the Quality of Governance in Mongolia[3]*
*(Political Attitudes of East Asian Youth through Asian Barometer Survey)*




*Sources: A Report exploring political attitudes of East Asian Youth through Asian Barometer Survey. International Conference Paper-Proceedings on the Democratic Citizenship and Youth in East Asia. UNDP*

The quality of governance, which Mongolians in general are dissatisfied with governance compared with citizens in other societies. Mongolian youth are even more dismayed about

1 Asia Barometer Survey, UNDP. Democratic Citizenship and Youth in East Asia. Draft report. p. 57.
2 Ibid. p. 58.
3 Ibid. p. 41.

# Эрдэм шинжилгээний илтгэл

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн Хүрээлэн үүсч хөгжсөний 45 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулж буй

## “Монголын нийгмийн хөгжлийн философи ба бодлого"

эрдэм шинжилгээний бага хуралд хүрэлцэн ирэхийг урьж байна.

**Хэзээ:** 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 14:00 цагт

**Хаана:** Төрийн Ордон: “Жанжин Д.Сүхбаатар” танхим-д (Б)

**Санамж:** Үндэсний болон албаны хувцастай, иргэний үнэмлэхтэй ирнэ үү.

### ХӨТӨЛБӨР

**00** Бүртгэл

**30** **Мэндчилгээ:**
УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Ё.Баатарбилэг
УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа
**Нээлтийн үг:**
Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Ерөнхийлөгч, Академич Д.Рэгдэл
Дурсгалын зураг авахуулах

**00** ***“Философийн хүрээлэнгийн судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагааны замнал: Туулж өнгөрсөн хийгээд өнөөгийн байдал, хэтийн төлөв”***
Ш.Ариунаа, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D), профессор

**20** ***“Монголын хөгжлийн бодлого: Асуудал ба шийдэлд холбогдох зарим санаа”***
Г.Чулуунбаатар, ШУА-ийн тэргүүн дэд ерөнхийлөгч, Академич

**35** ***“Монголын хөгжлийн философи: Улс төрийн эдийн засгийн ухааны диалектик”***
Б.Даш-Ёндон, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор

**50** ***“Монголын нийгмийн эдийн засгийн тулгамдсан асуудал, гарц”***
Р.Амаржаргал, УИХ-ын гишүүн асан

**05** Цайны завсарлага

**20** ***“Монголын ардчилсан нийгэм дэх эрх зүйт төрийн хөгжил, хандлага”***
Д.Лүндээжанцан, УИХ-ын гишүүн, доктор (Sc.D), профессор
Ц.Баянмөнх, Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

**6:45** ***“Монголын хөгжлийн бодлогын зарчмууд”***
А.Цанжид, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, доктор ( Ph.D), профессор

**7:00** **Дурсамж, хүндэтгэлийн үг**

**17:50** **Хаалт**
Ш.Ариунаа, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D), профессор

*Хурлын үеэр хүрээлэнгийн түүхийг харуулсан гэрэл зураг болон бүтээлийн үзэсгэлэн ажиллана.*

*Урилга*

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО:**
**АСУУДАЛ БА ШИЙДЭЛД ХОЛБОГДОХ ЗАРИМ САНАА**

*Академич Г. Чулуунбаатар*

Эдүгээ манай орчин цагийн утга зохиолын хэлэнд "Улс", "Төр" хэмээх хоёр үгийг хооронд нь холбож, эртний грекийн "Полис" буюу хот улс гэсэн үгийн гарлаар орос хэлний *"Политика"*, Англи хэлний *"Policy"* гэсэн үгтэй утга дүйлгэж "улс төр", "бодлого", "улс төрийн бодлого" гэсэн нэр томьёо хэвшин тогтоод байгаа билээ. Энэ нь чухамдаа "улс эс оршивоос төр үл орших" тухай санаа юм. Тэгэхлээр бид юуны өмнө "бодлого" хэмээх ойлголтоор улсаа хөгжүүлэх төрийн бодлогын тухай ярьж буй хэрэг.

"XX зууны дунд үеэс АНУ-д бодлогын ухаан *(Policy Sciences)* хэмээгдэх шинжлэх ухааны салбар үүсч цаашдаа бодлого судлал, бодлогын шинжилгээ, төрийн бодлого гэх мэтээр олон дэд салбар болон хөгжиж байна. Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд бодлогын судалгаа, бодлого судлалын цөөн биш төвүүд бий болж төрийн бодлогыг шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, түүний хэрэгжилтийг оновчтой зохион байгуулахад бодитой хувь нэмэр оруулах болжээ.

Манайд ч бодлогын судалгааны анхны ном бүтээлүүд гарч бодлогын судалгааны чадавхийг институтчилах эхний алхмууд хийгдсэн боловч төр, засгийн анхаарал сул, дэмжлэг нь тууштай биш байгаагаас олигтой зүгширч өгөхгүй өдий хүрлээ. (Хүснэгт 1) Энд мэдээжээр олон шалтгаан бий. Бас олон хүчин зүйл нөлөөлж байгаа.

| **Бодлогын судалгааны ном бүтээлүүд** | **Төрийн байгууллагад шууд үйлчлэх чиг үүрэг бүхий байгууллагууд** |
|---|---|
| **Янг Е., Квин Л. "Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь" УБ., 2003 он *Бодлогын шийдвэр гаргагчдад зориулсан гарын авлага* ** | 1990-1993 УБХ-ын дэргэдэх Төр, нийгэм судлалын академи, ЗГ-ын ХЭГ-ын дэргэдэх Судалгааны төв |
| **П.Доржсүрэн, Я.Бямбасүрэн. "Төрийн бодлого" УБ., 2006 он *Удирдлагын академийн сургалтын хэрэгцээнд*** | 1993-1996 УИХ-ын дэргэдэх Судалгааны төв |
| **Ён Юл Ли, проф.Чад Андерсон. "Бодлогын шинжилгээ" УБ.2010. А.Цанжидын орчуулга *Дипломын дараахь шатны сургалтанд зориулсан сурах бичиг*** | 1996-2003 онд УИХ-ын ТГ-ын Судалгааны нэгж |
| **ННХ, Соросын сангийн тэтгэлгээр хийсэн 10 гаруй цуврал судалгааны тайлан. 2000 оноос** | 2003- 2008 УИХ-ын дэргэдэх Төрийн бодлогын судалгааны төв |
| **УИХ-ын Судалгааны төвийн "Бодлогын шинжилгээ" цувралууд 2003 оноос** | 2008-Одоо УИХ-ын ТГ-ын Судалгааны нэгж |

Тэр бүрийг нэг бүрчлэн ярих боломжгүй учраас би энэхүү товч яриандаа Монголоо хөгжүүлэх бодлогын философид холбогдуулан хөгжлийн бодлогын олон улсын жишиг баримжаа, хөгжлийн бодлогын үзэл баримтлалын сонголт гэсэн 2 чиглэлээр зарим санаа хэлэхийг оролдлоо. Чингэхдээ "айлаас эрэхээр авдраа уудал" гэсэн ардын ухаанаар юуны өмнө өөрөө өөрийгөө танихаас, тунхаглалын ерөнхий томьёоллыг иргэдийнхээ итгэл үнэмшил, ёс суртахууны үнэлэмж болгохоос эхлэх ёстой гэсэн ерөнхий зарчмыг баримталсан болно.

## АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТУХАЙ АСУУДАЛ БА МОНГОЛ УЛС

*Илтгэгч: / Г.Чулуунбаатар,*
*ШУА-ийн тэргүүн дэд ерөнхийлөгч,*

**Оршил**

Монгол улс бол ардчиллын замыг сонгож хөгжсөн туршлага, сургамжаараа бүс нутгийн төдийгүй дэлхий дахины улс орнуудын сонирхлыг татаж буй орны нэг билээ. 1990 оны түүхэн өөрчлөлтөөр улс төрийн тоталитари дэглэмийг халж, засаглалын ардчилсан тогтолцоонд тайван замаар, нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан харьцангуй их бүрэн байдлаар шилжиж чадсан Ази тивийн анхны орон гэдгээрээ дэлхий дахинд илүү өргөн хүрээнд танигдаж эхэлсэн юм.

Өнгөрсөн 30-аад жилийн туршид өрнөсөн Монголын нийгмийн хөгжлийн замналыг ардчилал, ардчилсан засаглалыг бэхжүүлхийн төлөө алдаа, оноооны аль алийг нь дагуулсан ээдрээтэй замаар сонгосон чиг шугамаасаа хазайлгүй, тууштай хөгжсөн он жилүүд хэмээн үзэж болно. Монгол улс хөгжлийн зам, улс төрийн дэглэм, засаглалын хэлбэрийн сонголтыг ард түмнийхээ шууд оролцоотойгоор, тэдний санаа бодол, шаардлагад нийцүүлэн хийж чадсанаараа онцлог юм. Анхны сонголтын энэ зарчимын үзэл санаа эдүгээ хүртэл тууштай үргэлжилж, бодлого шийдвэр, засаглалын үйл явцад иргэдийн оролцоо, санаа бодлыг тусгадаг улс төрийн соёл болон төлөвшиж байгаа гэж үзэх боломжтой. Ардчиллын жилүүдэд болж өнгөрсөн Ерөнхийлөгчийн, парламентын, ИТХ-ын төлөөлгчдийн, баг, хорооны гээд олон удаагийн сонгуулийн дүн, түүнд оролцсон иргэдийн оролцооноос үүнийг харж болно.

**Нэг. Онол, арга зүйн шинэ хандлага ба Монгол улс**

Сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд холбогдох онол арга зүйн шинэ хандлагууд бий болж хөгжлөө. Ардчилсан өөрчлөлтийн жилүүдэд манай засаглалын тогтолцоонд: а\. Төрийн захиргааны шинэ удирдлага, б\.Сайн засаглал ,в\. Ардчилсан засаглал, г\ Төрийн албаны мерит зарчим гэсэн онол, үзэл баримтлалын орчин үеийн шинэ хандлагууд бодитой хэрэгжиж байгаа. Эдгээрийг тус бүрд нь задалж ярих шаардлагатай боловч энэ удаад хурлын зорилгод нийцүүлэн зөвхөн ардчилсан засаглалын асуудлыг товч хөндөж байна.

Монголчууд ардчилал, засаглалынхаа үйл явцыг боловсронгуй болгох талаар санаачилгатай ажиллаж, НҮБ болон бусад олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр "ардчилсан засаглал"-ын үзэл санаа зарчимуудыг хэрэгжүүлэх талаар багагүй амжилтад хүрсэн гэж ерөнхийд нь дүгнэж болно. Хэдий тийм боловч Монгол улсын ардчилсан засаглал, түүний үндсэн институтүүдийн харилцан тэнцвэртэй байдал, шийдвэр гаргах үйл явц, авигатай тэмцэх зэрэг цөөн биш үзүүлэлтээр хүссэн хэмжээнд хүрч чадахгүй байна.

# МОНГОЛ ДАХЬ ЗАСАГЛАЛЫН ЗАРИМ ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ЗӨВЛӨЛДӨХ АРДЧИЛЛЫГ АШИГЛАХ БОЛОМЖ

*Г.Чулуунбаатар, Удирдлагын академийн профессор,*
*ШУА-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, академич*

## Оршил

Монгол улс бол ардчиллын замыг сонгож хөгжсөн туршлага, сургамжаараа бүс нутгийн төдийгүй дэлхий дахины улс орнуудын сонирхлыг татаж буй орны нэг билээ. 1990 оны түүхэн өөрчлөлтөөр улс төрийн тоталитари дэглэмийг халж, засаглалын ардчилсан тогтолцоонд тайван замаар, нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан харьцангуй их бүрэн байдлаар шилжиж чадсан Ази тивийн анхны орон гэдгээрээ дэлхий дахинд илүү өргөн хүрээнд танигдаж эхэлсэн юм.

Өнгөрсөн 30-аад жилийн туршид өрнөсөн Монголын нийгмийн хөгжлийн замналыг ардчилал, ардчилсан засаглалыг бэхжүүлхийн төлөө алдаа, оноонь аль алийг нь дагуулсан ээдрээтэй замаар хөгжсөн он жилүүд хэмээн үзэж болно. Монгол улс хөгжлийн зам, улс төрийн дэглэм, засаглалын хэлбэрийн сонголтыг ард түмнийхээ шууд оролцоотойгоор, тэдний санаа бодол, шаардлагад нийцүүлэн хийж чадсанаараа онцлог юм. Анхны сонголтын энэ зарчимын үзэл санаа эдүгээ хүртэл тууштай үргэлжилж, бодлого шийдвэр, засаглалын үйл явцад иргэдийн оролцоо, санаа бодлыг тусгадаг улс төрийн соёл болон төлөвшиж байгаа гэж үзэх боломжтой. Ардчиллын жилүүдэд болж өнгөрсөн Ерөнхийлөгчийн, парламентын, ИТХ-ын төлөөлөгчдийн, баг, хорооны гээд олон удаагийн сонгуулийн дүн, түүнд оролцсон иргэдийн оролцооноос үүнийг харж болно.

Эртний Афинчуудын санамсаргүй түүвэр сонголт\сугалаа\, зөвлөлдөн хэлэлцэх гэсэн хоёр зарчимаас эхтэй ардчиллын сонгодог хэлбэрийн гол үзэл санаа 1990-ээд оноос орчин үеийн ардчиллыг төгөлдөржүүлэх үндсэн арга хэрэгсэл болгон ашиглах байдлаар сэргэж эхэлсэн билээ. Үүнийг зөвлөлдөх ардчилал хэмээн томьёолдог болжээ. Монгол улс сүүлийн жилүүдэд засаглалыг боловсронгуй болгох зорилгоор Зөвлөлдөх ардчиллын механизмыг ашиглах эхлэлийг тавиад байна.

Миний бие энэхүү товч илтгэлдээ Монгол дахь ардчилсан засаглалын төлөвшлийн явц, түүнд хийсэн олон улсын болон үндэсний судлаачдын үнэлгээ, дүгнэлтээс гарч буй засаглалын тулгамдсан асуудлын тухай тойм мэдээлэлд тулгуурлан тэдгээрийг шийдвэрлэхэд зөвлөлдөх ардчиллын механизмыг ашиглах боломжийн тухай хувийн санаа бодлыг илэрхийлж, цаашид анхаарах зөвлөмжийн шинжтэй зарим санааг дэвшүүлж хэлэлцүүлхийг зорьлоо.

Ардчилсан засаглалыг боловсронгуй болгоход чиглэсэн ажлын хүрээнд бодлогын шийдвэр гаргах, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах үйл явцад иргэдийн оролцоог хангах, олон нийнийн санаа бодлыг тусгах асуудал чухал байр суурь эзэлдэг. Энэ талаар Монгол Улс ялангуяа хууль эрх зүйн хүрээнд хэд хэдэн тодорхой алхам хийж буйг тэмдэглэе.

Тухайлбал, 2015 онд шинэчлэн найруулж баталсан Хууль тогтоомжийн тухай хуулиар аливаа хууль, томоохон шийдвэрийн төслийг судалгаа хийхгүйгээр, мөн олон нийтийн хэлэлцүүлэг зохиохгүйгээр өргөн барих, хэлэлцэх боломжгүй байхаар зохицуулалт хийсэн. Мөн 2015 онд баталсан Нийтийн сонсголын тухай хуульд төрийн байгууллага, албан тушаалтан энэ хуульд заасан асуудлаар нийтийн сонсголыг зохион байгуулж төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангах тухай нарийвчлан зааж өгсөн байна. Хамгийн сүүлд 2017 онд шинээр баталсан Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулиар эрх бүхий байгууллага, албан тушаалтан нийтийн эрх ашгийг хөндсөн томоохон

# МОНГОЛ ТӨРИЙН СОЁЛЫН БОДЛОГО БА ҮНЭТ ЗҮЙЛИЙН СУДАЛГАА

***Г.Чулуунбаатар (Монгол)***
***Э.Сонинтогос (Монгол)***

***Abstract:*** *Study of Mongolia`s values is counterpart of the studies of Mongolian spiritual life. In this paper we consider the results of some studies of axiology and Mongolia`s values in Mongolia and some ideas for improvement of state cultural policy.*

***Keyword:*** *cultural policy, national culture, value, axiology*

**Нэг. Соёлын бодлогын үзэл баримтлал, зарчим, хандлага**

Монголчуудын үнэт зүйлсийн тухай сэдэв бол Монгол Улсын төр засгийн анхаарлын төвд ямагт байж ирсэн амин чухал асуудлын нэг юм. Орчин үед соёлын талаар төрөөс баримтлах бодлогын суурь зарчимууд Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгалаа олсон гэж үзэж болно.

Үндсэн хуулийн *“Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” (7.1), “Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн” (7.2), “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн” (8.1), “Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” (9.1)* гэсэн заалтуудаар соёлын үнэт зүйлсийн гол хүрээ, үндсэн агуулгыг тодорхойлжээ гэж үзэж болох юм.

Үндсэн хуулийн 12-р зүйлд “*Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн”, “Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ”* гэж заасан нь монголын ард түмний үндэсний үнэт зүйлсийн тогтолцоог цогц байдлаар тодорхойлсон гэж ойлгогдож байна.

Үндсэн хуулийн энэхүү үзэл баримтлалыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал *(*2010*)*-д нарийвчлан тодруулсан байдаг. Уг үзэл баримтлалын 1.1.2 дахь заалтад “*Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана”* гэж монголчуудын язгуур эрх ашгийг илэрхийлсэн нь үндэсний үнэт зүйлсийн тогтолцоог тодорхой зааж өгсөн байна. Мөн 1.1.6-д “*Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин* ***чухал дархлаа*** *мөн*” хэмээн соёлын үнэт зүйлийн гол хүрээг дэлгэрүүлэн заажээ.

Монгол улсын Соёлын тухай хуулийн (1996 он) 1.3.2-т монголын биет ба биет бус соёлын өв, урлагийн бүтээлийг үнэт зүйл хэмээн тусгайлан тодорхойлж өгчээ. Энд “*соёлын үнэт зүйл гэдэгт гоо сайхны үзэл баримтлал, эх хэл, бичиг үсэг, аман аялгуу, уламжлалт технологи, газар усны нэр, зан заншил, бэлгэ тэмдэг, ардын аман зохиол, ном, судар, шашдир, угийн бичиг, им, тамга, хадны зураг, бичээс, гар урлал, урлагийн бүх төрлийн болон соёл судлалын бүтээл, судалгааны арга барил хамаарна*”[1] гэсэн бүй. 2016 оны хавар Монголын парламент “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хэмээх урт хугацааны бодлогын баримт бичиг, саяхан Засгийн газраас

[1] http://www.legalinfo.mn/law/details/454. 2018.07.07.

# СОЦИАЛЬНО- ПОЛИТИЧЕСКИЕ ПРОБЛЕМЫ МОНГОЛЬСКОЙ МОЛОДЕЖИ В ПЕРИОД МОДЕРНИЗАЦИИ

*Г.Чулуунбаатар. Академик, доктор (Sc.D),*
*первый Вице-президент МАН*

**Аннотация:** *В данном докладе рассматриваются общее состояние и изменининя социально- политического облика молодежи Монголии на основе результатов проведенных в последный период исследования молодежи. Также освещаются некоторые теоретические подходы методологии исследования.*

**Ключевые слова:** *Социальный облик, политическия активность, изменения социально- политического облика*

**Некоторые методологические соображения**

В совреннную эпоху глобализации и модернизации в трудах ученых представленны интересные концепции будущего человеческого общеcва. Наиболее яркое отражение они нашли О.Тофлера, З. Бзежински, Ф.Фукуяма, С.Хантингтона. Поскольку научная общественность уже знакома с основными концепциями данных ученых нет необходимости делать допольнителные коментарии.

Здесь только обсудим некоторые идей ученых относительно социально-политических аспектах процессов изменения социального и политического облика монгольской молодежи.

Современная основная концепция социально-политического облика молодежии основывается на признании универсальных демократических ценностей вне зависимости от континента и страны проживания. Я предлагаю в методологическом плане следующий набор показателей ценностей с помощью которого можно определить основные характеристики социально-политического облика молодежии Монголии.

В нем:

- Национальная способность к компромиссу и мирному урегулированию в спорох.
- Национальные истоки демократических ценностей, способность впитывать их и развиваться на основе традиций и инноваций.
- Возможность всестороннего охвати и развития политической, экономической, социальной, культурной и интеллектуальной сфер.
- На основе оптимального сочетания универсальных и фундаментальных национальных ценностей в правовых этнических рамках, предоставлении возможности для свободного выражения собственного мнения, всестороннего развития плюрализма мнений, свободы обьединений и свободы информаций:

***ЭРДЭНЭТ -40***

***1000 инженерийн зөвлөлгөөн***




# АЖ ҮЙЛДВЭРИЙН ДӨРӨВ ДЭХ ХУВЬСГАЛ БА МОНГОЛ УЛС

Activate Windows

## АГУУЛГА

1. ***АЖ ҮЙЛДВЭРИЙН ДӨРӨВ ДЭХ ХУВЬСГАЛЫН ТУХАЙ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ***
2. ***МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛД ХОЛБОГДОХ ЗАРИМ АСУУДАЛ***
3. ***ЭРДЭНЭТЭД ҮЙЛДВЭРТ ХОЛБОГДОХ ЗАРИМ САНАА***



Бүдрагчаагийн ДАШ-ЁНДОН

ХӨГЖИХҮЙН ФИЛОСОФИ

(ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮГҮҮЛЭЛ, ИЛТГЭЛ)

УЛААНБААТАР
2019 он

## ГАРЧИГ

**Уншигчдад зориулсан угтал үг:** Г.Чулуунбаатар .............................................. 5
**Редакторын зурвас:** Н.Баяртсайхан ............................................................ 7
**Зохиогчийн Оршил үг:**
Хөгжил бол амьд организмын оршин тогтнох арга мөн ........................................ 9

### Нэг. МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ

1. Соёмбо: Монголын үндэсний гүн ухаан, нийгмийн шинэ байгууламжийн асуудалд ........................................ 16
2. Монгол Улсын хөгжил дэх мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхайн зохистой хамаарлын асуудлууд ........................... 26
3. Монголын хөгжлийн философийг боловсруулах асуудалд ........................ 29

### Хоёр. УЛСТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН УХААН

1. Монголын хөгжлийн философи: улстөрийн эдийн засгийн ухаан дахь диалектик........................................ 38
2. Улстөрийн эдийн засгийн ухааны философийн асуудалд........................... 44
3. Азийн үйлдвэрлэлийн арга: Монголын түүхийн диалектик........................ 59
4. Монголд улстөрийн эдийн засгийн ухаан хэрэгтэй.................................... 86
5. Монголын хөгжлийн бодлого дахь улстөрийн эдийн засгийн ухаан: зах зээлийн асуудал........................................ 90
6. Улстөрийн эдийн засгийн ухаан: орчин үеийн мөнгө, санхүүгийн диалектик. ........................................ 105
7. Диалектика современных денег и финансов: политэкономический аспект ........................................118
8. “Азийн үйлдвэрлэлийн арга”-ын тухай онолын эх сурвалж...................... 131

### Гурав. ФИЛОСОФИЙН ТҮҮХ, ТҮҮХИЙН ФИЛОСОФИ

1. XX зууны эхний мөчлөгийн Монгол-Оросын харилцааны философи-түүхийн тойм........................................ 142
2. Философско-историческое обозрение Монголо-Российских отношений первой четверти XX в........................................ 153
3. Орос улсын хөгжлийн товчлолыг төсөөлсөн В.И.Ленин, Г.В.Плеханов нарын онолын маргаан.................................... 163
4. В.Инжаннашийн «Хөх судар» дахь түүх бичихүйн гүн ухааны сэтгэмж ........................................ 172
5. Карл Маркс ба марксизмын урсгалууд ........................................ 192

# МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ: УЛСТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН УХААН ДАХЬ ДИАЛЕКТИК*

Монголын хөгжлийн философийг, ингэхлээр, монголоо хөгжүүлэх шинжлэх ухааны нэгдсэн бодлогын үндсийг боловсруулах гэдэг нь чухамдаа хүн төрөлхтний их сэтгэлгээн дэх өнө эртний түүхтэй **Улстөрийн эдийн засгийн ухаан** (УТЭЗУ)-ы мэдлэгийг **өөрийнхөө** улс орны нөхцөлд **сэргээн** судалж хэрэгжүүлнэ гэсэн санаа юм. Энэ эрдэм ухааныг чухам **сэргээх** хэрэгтэй байна.

Эхэнд тэмдэглэж хэлэхэд, ухаандаа, Би **одоогоор, энд** бодож сэтгэж байхад **түрүүчийн** бүх юм хэрэггүй болсон, надад зөвхөн, ирээдүй л байна, үүнээ л үндэс болгон амьдрах ёстой хэмээн санавал, өнгөцөөр харахад үнэн ч юм шиг, харин, хэрэг дээрээ, ингэж санах нь амьдралын диалектикийг эрс үгүйсгэсэн хэрэг болно, ингэснээр сүйрэл, уналтаа үүсгэх урьдач нөхцлийг бүрдүүлж байгаа нь тэр ажээ. Нийгмийн амьдралын томоохон бүх үзэгдлийг шинжилж, мөн чанарыг нь үнэн зөв ойлгон ухаарахад **диалектик сэтгэлгээ** нэн чухал, бүүр шийдвэрлэх учир холбогдол бүхий үүрэгтэй нь хүн төрөлхтний танин мэдэхүйн түүхээр нэгэнт нотлогджээ.

УТЭЗУ бол философид, гол нь **диалектикч философид** суурилсан эрдэм мэдлэг юм. Хүмүн төрөлхтний оюун эрдмийн түүхэнд нийгмийн эдийн засгийн амьдралын салбарыг философижсон сэтгэлгээний үүднээс судалснаар УТЭЗУ хэмээх эрдэм мэдлэг үүсчээ. **

Өнөө цагт энэ мэдлэгийг **төрийн эдийн засгийн бодлогын философижсон ухаан** хэмээн үзэж судлан хөгжүүлэх хэрэгцээ бий болжээ хэмээн бодогдож байна.

Нийгмийн эдийн засгийн амьдралын тухай диалектикч суурь мэдлэгийн үндсийг анх Эртний грекийн их сэтгэгч, нэр мөнхөрсөн аугаа философич Аристотель тавьсан ажээ.

Их Аристотель **"Улстөр"** хэмээх алдарт бүтээлдээ **өмч, өмчийн харилцааны** учрыг анхлан философийн үүднээс шинжлэн дүгнэжээ. Тэрвээр, "өмч бол гэр орны эд хогшлын хувь хэсэг нь", гэхдээ энэ өмч гэдэг нь зүгээр л байж байгаа эд баялаг биш, харилцаанд ороогүй эд баялаг бол өмч биш гэсэн дүгнэлтэд хүрчээ. Эд баялаг ямар нэгэн харилцаанд орж байгаа бол өмч гэгдэнэ. Энэ санаагаа тайлбарлаж Аристотель хувь хэсэг гэдэг нь юмны хагасыг нь ч юмуу, жижиг тасархайг нь хэлж буй хэрэг биш, харин **нөгөө талгүйгээрээ** сэтгэгдэшгүй тэрхүү хэсэг юм гэжээ. Тэгвэл, тэрхүү нөгөө тал нь юу вэ? Энэ нь өмчийн эзэн, тодруулбал, өмчийг

* Философийн хүрээлэнгийн 45 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд толилуулсан илтгэл

** УТЭЗУ хэмээх эрдэм мэдлэгийн талаар миний бие өмнө нь "Нийгмийг танихуй: түүх-хөгжлийн философи". УБ., 2014, "Нагаржунын гүн ухаан, ёс зүй (шүтэн барилдахуйн онол)" УБ., 2016, "Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус)" 2 дахь хэвлэл, УБ., 2017 зохиолуудаа хөндөж байсан билээ.


МОНГОЛ
АРДЫН НАМ
ЁС ЗҮЙ
ӨНӨӨГИЙН МОНГОЛЫН НИЙГМИЙН УЛС ТӨРИЙН ХАРИУЦЛАГА,
ЁС ЗҮЙН ЗАНГИЛАА АСУУДЛУУД
эрдэм шинжилгээний бага хурал

# ХУВЬ ХҮНИЙ ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛД

*Философийн ухааны доктор (Ph.D.),*
*профессор Б.Даш-Ёндон*




Нийгмийн хариуцлага гэдэг нь нэлээд хийсвэр утгатай, олон тал бүхий ойлголт юм. Хийсвэрийг тодорхой болгох, олон талыг нэгдмэлд оруулж бодохын үүднээс энэ категорийг улстөр, ёс суртахуун, эдийн засаг, эрх зүйн талаас нь сайтар судалж онол, практикийн дүгнэлт гаргаж хэрэгжүүлэх нь одоогийн нийгэмд чухал учир холбогдолтой болж байна.

Нийгмийн хариуцлага гэж байлаа ч гэсэн түүний эзэн субъект нь хувь хүн. Нийгмийн хариуцлагыг олон ангилж үзлээ ч тэдгээрийн эзэн субъект нь хувь хүн. Товчилбол, эцсийн дүндээ хариуцлагын утга нь хувь хүний улстөр-ёс суртахууны категори дээр төвлөрнө. Энэ нь эдийн засаг, эрх зүйн асуудлуудыг ч дотроо шингээжээ. Ингэхлээр, нийгмийн хариуцлага, ёс суртахуун гэж яригдвал энэ нь, юуны өмнө, хувь хүний хариуцлага, ёс зүйн асуудлыг хөндөх учиртай ажээ.

Ёс суртахуун хэмээх оюун санааны энэхүү гоц үзэгдлийг түүхнээ философичид олон талаас нь судалсаар иржээ. Энэ явцад ёс суртахууны асуудлыг нийгмийн буюу олон нийтийн агаад хувь хүний гэж ангилан судлах болсон байна. Эндээс, хувь хүний ёс суртахуунтай холбогдож болох ганц нэг асуудлыг хөндөж үзье. Хувь хүний ёс суртахуун нь **хариуцлага** хэмээх **ёс зүйн** ачааг бодит байдал дээр нь үүрч явдаг аж. **Ёс зүй** гэдэг нэр томъёо эдүгээ хоёр утгатайгаар хэрэглэгдэж байна: нэгд, ёс суртахууныг судалдаг эрдэм ухаан; хоёрт, ёс суртахууны шаардлагуудын биелэлтийг, ингэхлээр ёс суртахууны хариуцлагыг тэмдэглэх ойлголт. Ёс зүйн энэ **хоёрдахь** утгаар нь парламентын гишүүний ёс зүй, улстөрчийн ёс зүй, багшийн ёс зүй, эмчийн ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүй, эрдэмтний ёс зүй гэх мэтээр яригддаг байна. Эдгээрийн цаана тухайн субъектүүдийн **хариуцлагын** тухай багцлагдсан шаардлагууд томъёологддог.

Хувь хүн маань хэдүйвээр нийгмийн бүтээгдэхүүн мөн боловч бас нийгмийг бүтээгч бөлгөө. Бүтээгдэхүүн нь чухал уу, бүтээгч нь чухал уу? Нийгэм, хувь хүний шүтэлцээн дэх амьдрахуй, хөгжихүйн үйл үйлдэлд хувь хүнээс тогтдог хүмүүс зонхилох тал нь болдог байна. Харсаар байтал тодорхой эзэнгүй хариуцлага гэж үгүй, тодорхой хүнгүй ёс зүй гэж үгүй. Хариуцлагатай, ёс суртахуунтай нийгмийг цогцлоохад

**...Ёс зүй гэдэг нэр томъёо эдүгээ хоёр утгатайгаар хэрэглэгдэж байна: нэгд, ёс суртахууныг судалдаг эрдэм ухаан; хоёрт, ёс суртахууны шаардлагуудын биелэлтийг, ингэхлээр ёс суртахууны хариуцлагыг тэмдэглэх ойлголт. Ёс зүйн энэ хоёрдахь утгаар нь парламентын гишүүний ёс зүй, улстөрчийн ёс зүй, багшийн ёс зүй, эмчийн ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүй, эрдэмтний ёс зүй гэх мэтээр яригддаг байна...**


Бүдрагчаагийн ДАШ-ЁНДОН
ХӨГЖИХҮЙН
ФИЛОСОФИ
(ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮГҮҮЛЭЛ, ИЛТГЭЛ)
УЛААНБААТАР
2019 он

## ГАРЧИГ

**Уншигчдад зориулсан угтал үг:** Г.Чулуунбаатар ........................................ 5
**Редакторын зурвас:** Н.Баяртсайхан ........................................ 7
**Зохиогчийн Оршил үг:**
Хөгжил бол амьд организмын оршин тогтнох арга мөн ........................................ 9

### Нэг. МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ

1. Соёмбо: Монголын үндэсний гүн ухаан, нийгмийн шинэ байгууламжийн асуудалд ........................................ 16
2. Монгол Улсын хөгжил дэх мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр, уул уурхайн зохистой хамаарлын асуудлууд ........................................ 26
3. Монголын хөгжлийн философийг боловсруулах асуудалд ........................................ 29

### Хоёр. УЛСТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН УХААН

1. Монголын хөгжлийн философи: улстөрийн эдийн засгийн ухаан дахь диалектик ........................................ 38
2. Улстөрийн эдийн засгийн ухааны философийн асуудалд ........................................ 44
3. Азийн үйлдвэрлэлийн арга: Монголын түүхийн диалектик ........................................ 59
4. Монголд улстөрийн эдийн засгийн ухаан хэрэгтэй ........................................ 86
5. Монголын хөгжлийн бодлого дахь улстөрийн эдийн засгийн ухаан: зах зээлийн асуудал ........................................ 90
6. Улстөрийн эдийн засгийн ухаан: орчин үеийн мөнгө, санхүүгийн диалектик. ........................................ 105
7. Диалектика современных денег и финансов: политэкономический аспект ........................................118
8. “Азийн үйлдвэрлэлийн арга”-ын тухай онолын эх сурвалж ........................................ 131

### Гурав. ФИЛОСОФИЙН ТҮҮХ, ТҮҮХИЙН ФИЛОСОФИ

1. XX зууны эхний мөчлөгийн Монгол-Оросын харилцааны философи-түүхийн тойм ........................................ 142
2. Философско-историческое обозрение Монголо-Российских отношений первой четверти XX в. ........................................ 153
3. Орос улсын хөгжлийн товчлолыг төсөөлсөн В.И.Ленин, Г.В.Плеханов нарын онолын маргаан ........................................ 163
4. В.Инжаннашийн «Хөх судар» дахь түүх бичихүйн гүн ухааны сэтгэмж ........................................ 172
5. Карл Маркс ба марксизмын урсгалууд ........................................ 192

# КАРЛ МАРКС БА МАРКСИЗМЫН УРСГАЛУУД*

Эрхэм хүндэт эрдэмтэн, судлаачид аа!

Их сэтгэгч, эрдэм ухааны аугаа зүтгэлтэн, улстөрийн бодлоготон Карл Марксын мэндэлсний 200 жилийн ойд зориулсан эл эрдэм шинжилгээний хуралд хүрэлцэн ирсэн Та бүхнийхээ амгалан айлтгаж, сайн сайхны ерөөл дэвшүүлье. Тус хурлыг зохион байгуулж буй МАН-ын дэргэдэх Стратеги академи, Удирдлагын академи, Философийн хүрээлэнгийн удирдлагад гүн талархал илэрхийлье.

Тус хурлын хөтөлбөрөөр надад оногдсон эл сэдвээр илтгэхдээ би Карл Марксын суут онол ерөөсөө **тийм-ийм** учир утгатай хэмээн ерөнхийд нь сурталчлан тайлбарлах зорилго тавиагүй гэдгээ урьдчилан хэлье. Яагаад гэвэл, К.Марксын онолыг ерөнхийд нь тайлбарлах гэх нь мэдээжийн бодит **баримтыг** зүгээр л тоочин хэлнэ гэсэн хэрэг болох байх. К.Марксын онол ингэтлээ бодит байдал, бодит баримт болжээ. Учир явдал уг нь ийм, гэтэл монголчууд бид эл бодит баримтыг анхааралгүй болиод олон он жилийг үдлээ. Одоо, бодит баримтыг эргэж бодолцох нь, сэргээн сэтгэх нь олон талын учир холбогдолтой болж байна. Монголд анхаарахаа больсон нь манай төр засаг, эрдэмтэд сэхээтний буруу гэхээсээ өмнө харин цагийн эрхшээл гадаад нөхцөл байдалтай шууд холбоотой амой гэдгийг цохон тэмдэглэе.

Миний бие энэ илтгэлийнхээ гол санааг доор хэлэх гэж буй хэд хэдэн дэд хэсгийг ангилан илэрхийлье.

**Нэгэн зүйл:** Карл Маркс бол хүн, харин бурхан биш. Тэрвээр **хүмүүн** учраас тэхдээ аугаа ихтэн учраас хүний төлөө бүхий л сэтгэл оюунаа зориулжээ. Тэ… хийсвэр уриа лоозон тавихаар бус, эрдэм ухааны бодит судалгаагаар, улстөрийн идэвхтэй үйл ажиллагаагаар энэ зорьсон руугаа зүтгэжээ. К.Маркс эрдмээ оройгүй, гэлээ ч эрдмийн төлөө, энэ эрдмээ жирийн хүн ардын төлөө зориулахын тулд бүх бэрхшээлийг даван зүтгэх ёстой гэсэн санаа зоригийг хатуу барьж ядуу цангах, хөөгдөж цөлөгдөх, үр хүүхдээ өлбөрүүлэх зэрэг энгийн хүн бүрт байж боломгүй гэмээр бүхий л зовлон шаналалыг амсан туулжээ. Тэрвээр "Капитал" бүтээлээ туурвихад судалгааны амьдралынхаа бүхэл бүтэн 24 жилийг зарцуулжээ. К.Марксын онол бол нийгэм шинжлэл дэх түрүүчийн нь ололттой харьцуулашгүй бүүр эргэлтийн шинжтэй учир холбогдолтой юм. Эргэлтийн агуулга нь Карл Маркс материалист диалектикч философид суурилсан **улстөрийн эдийн засгийн ухааны** суурь үндсийг тавьсанд оршино.

Хүмүүс бид материаллаг үйлдвэрлэлийнхээ бүтээгдэхүүний үнэ цэнийг өөрийн өртгөөр нь тооцож цаашаагаа наймаалцдаг байна. Харин К.Марксын оюуны аугаа бүтээлийн үнэ цэнийг торго цэмбэ, ноосон эдлэл, хөвөн даавууны шингээлт, үүнийг зарагдахуун болгодог материаллаг бүтээлийн өртгөөр хэмжих ямар ч аргагүй юм. К.Марксын социаль үзэл санаа, онолын агуулга нь хүн төрөлхтний дотор мал шиг

* К.Марксын мэндэлсний 200 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд толилуулсан илтгэл.

# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: ОЮУНЫ СОЁЛ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ



УЛААНБААТАР 2017

## ГАРЧИГ

Өмнөх үг........................................................................................5

**1. Ш.Ариунаа**

*Орчин үеийн оюуны соёл: Урлагийн философи* ........................6

**2. Ч.Ган-Өлзий**

*Тогтвортой хөгжлийн оюуны соёлын суурь онтологи: Хайдэггерийн тайлал* .....9

**3. Ж.Энхбаяр**

*Нийгмийн хөгжлийн тухай өгүүлэх нь* ........................17

**4. Б. Галиндэв**

*Нийгмийн эрсдэл ба ёс суртахууны асуудал*........................23

**5. Р.Дарьхүү**

*Тогтвортой хөгжил ба хүний хөгжил*........................31

**6. И.Лхам. Г.Уянга**

*Боловсрол-тогтвортой хөгжлийн үндэс болох нь* ........................39

**7. Б.Буяндэлгэр**

*Спортын философийг Монголд хөгжүүлэх асуудалд*........................46

**8. Д.Оюунгэрэл**

*Хүний хөрөнгө: Ёс суртахуун* ........................56

**9. Б.Жаргалсайхан**

*Монгол хүний ёс суртахуун, сэтгэл зүйн язгуур шинж,*
*түүнийг хөгжүүлэх нь* ........................61

**10. Б.Наранбаатар**

*Нийтлэг нөөцийн эзэмшил дэх ёс зүйн асуудал* ........................74

**11. Д.Баасансүрэн, А.Хишигдаваа**

*Сонгуулийн үйл явц ба улс төрийн соёлын харилцан шүтэлцээ*........................81

**12. Б.Нарантунгалаг**

*Тогтвортой хөгжилд боловсролын үүрэг* ........................90

**13. Ч.Ичинхорлоо**

*Нийгмийн гоо сайхны соёл тогтвортой хөгжлийн үндэс болох нь* ........................96

**14. П.Мягмарсайхан**

*Экогуманизмын зарим асуудал* ........................102

**15. Ж.Бямбасүрэн**

*Улс орны хөгжлийн эзэн нь хүн мөн* ........................107

**16. Д.Чулуунгэрэл**

*Когнитив соёл судлалын онцлог*........................113

# НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

*Ж.Энхбаяр-доктор (Ph.D)*
*ШУА-ийн Философийн Хүрээлэн*

Хөгжил гэдэг ойлголт нь норматив шинжтэй, тиймээс үнэлэмжийн утгаар түгээмэл хэрэглэдэг, нийгмийн агуулгаар тун энгийнээр хэлбэл хүн, нийгмийн хүсэл, хэрэгцээ шаардлагаас урган гарч байгаа нэг шатнаас нөгөө шатанд дэвших үйл явц, тухайлбал, хүн амын амьдралын чанар, нийгмийн халамж, улс төрийн оролцоог сайжруулахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, институцийн өөрчлөлт юм. Ерөөс хүний нийгмийн түүх бол өөрчлөгдөн хөгжиж ирсэн түүх юм. Гал гаргаж сурсан, дугуйг бодож олсон, өвчний эсрэг вакцин бүтээсэн, ургацыг нэмэгдүүлэх бордоо үйлдвэрлэсэн гээд нийгмийн хөгжлийг хурдасгагч олон технологийн ололтуудыг дурдах ёстой. Бордоо үйлдвэрлэж эхэлсэн нь орчин үеийн нийгмийн амьдралыг бий болгосон XX зууны технологийн маш чухал инновацийн нэг байлаа. Ургацын гарц нэмэгдсэнээр хоол тэжээлийн хомсдол арилж, хүмүүс шим тэжээлтэй, элбэг дэлбэг хоол ундтай болсноор хүүхдийн эндэгдэл багасч, хүний дундаж наслалт нэмэгдэн, бүтээлч чадвар өссөн юм. Хотжилт явагдаж, амьдралын шинэ хэв маягт шилжсэн, үйлдвэржилт хөгжсөн, улс төрийн ардчилал хүчээ авсан гээд олон зүйлийг дурдах ёстой.

Сүүлийн 50-60 жилд хөгжлийн эрин үе тохиож, НҮБ, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан зэрэг дэлхийн улс төр, санхүү, мөнгөний бодлогын асуудлыг зохицуулдаг байгууллагууд байгуулагдан хөгжлийн асуудлыг байнга ярих болж бодлогын баримт бичгүүд гаргаж иржээ. Тухайлбал, НҮБ жил бүрийн хүний хөгжлийн илтгэлийг бэлтгэж хэвлүүлдэг уламжлалтай болсон хийгээд хамгийн сүүлд мянганы хөгжлийн зорилтыг баталж улс орнуудыг хөгжлийн тодорхой түвшинд хүргэх үүрэг хүлээлгэн даяараа хамтран ажилласан билээ. Дэлхийн банк, ОУВС болохоор улс орнуудыг хөгжлийн янз бүрийн үзүүлэлтээр, жишээлбэл, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, боловсрол, эрүүл мэнд, насжилт зэргээр хүний хөгжлийн индекс гаргаж, зам харилцаа, мэдээлэл холбооны гэх мэт тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжиж хөгжлийн түвшинг эрэмбэлж ирлээ. Хөгжлийн тухай ярих дэлхий даяараа хамтдаа хэлэлцдэг гол сэдэв болж хувирав. Нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил хоёрыг шууд адилтгаж болохгүй, зарчмын ялгаатай нэг зоосны хоёр тал юм. Эдийн засагт өсөлт ярьдаг, үүнийг хөндлөн шугаман дахь тоон өөрчлөлтөөр илэрхийлж, харин хөгжлийг нь босоо шугамаар гарах чанарын өөрчлөлтөөр илэрхийлж болох юм. Хөгжил нь байгаа зүйлээ өөрчлөх, байхгүй зүйлийг бий болгох, харин өсөлт бол байгаа зүйлд хамаатай. Гэхдээ нийгмийн хөгжлийн гол прадигм нь эдийн засгийн өсөлт болоод байгааг дурдалтай. Нийгмийн институтуудууд, салбарууд ч салгахын аргагүй хоорондоо холбоотой, тиймээс эдгээрийн хөгжил нь ижил зарчим, хуулиар явах бөгөөд нэгдмэл нэр томъёо хэрэглэгдэнэ. Дээр дурдсан байгууллагуудын гол баримталдаг онол нь хөгжил бол эрх чөлөө мөн гэсэн



ХЯТАДМОНГОЛОРОСЫНТИНКТАНКНЫОЛОНУЛСЫНФОРМЫН
2019ОНЫХУРЛЫНГАРЫНАВЛАГА

ХЯТАД МОНГОЛ ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР
ЧӨЛӨӨТЭЙ ХӨГЖИЖ ,ХАМТРАН АЖИЛЛАЖ ХАМТДАА ХОЖЬЁ

# ГАРЫН АВЛАГА

2019 оны 07 сарын 23-24-ний өдөр
БНХАУ・Хөх хот

Tuesday

23/7

# САЛБАР ФОРУМ ГУРАВ

## 6-р СЭДЭВ: ИРГЭДИЙН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН СУУРИЙГ ХАМТДАА ТАВИХ

07 сарын 23-ны өдрийн 14:00-18:30 Гүө Бинь арын байрны Гүө Жянь танхим
Даргалагч: В.Батцэнгэл МУИС-ийн шинжлэх ухааны сургуулийн газарзүйн танхимын эрхлэгч Профессор, доктор(PhD)
Дүгнэлт: Бүрэнжаргал БНХАУ-ын Улаанхад дээд сургуулийн дэд захирал, Профессор

Илтгэл тавигч/ хүн бүр 12 минут/

16:15–18:15

Ма Юунжень БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн захирал асан

Монгол үндэсний хуулийн үзэл баримтлалын Хятад Монгол Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтд оруулах бодит ач холбогдол

О.Хатанболд ШУА-ийн Философийн Хүрээлэн

Хятад-Монгол-Орос гурван орны иргэдийн харилцан ойлголцол

Ян Гуанли БНХАУ-ын Гуандун мужийн ардын засгийн ордны Хөгжлийн судлалын төвийн худалдаа санхүүгийн газрын дарга

Өвөрмонголын хилийн дагуу бүс нутгийг нээлттэй бодлого хэрэгжүүлж "Бүс ба зам"-д хурдацтай орсон туршлага ба Гуандун мужд өгөх сэнхрүүлэл

*Ц.Саранцацрал МУИС-ийн Европ судлалын тэнхимийн профессор*

Хүмүүнлэгийн салбар дахь төсөл, хөтөлбөр нь иргэд хоорондын ойлголцол, ардын дипломатын гүүр болох нь

Бойкова Е.В. ОХУ-ын ШУА-ийн дорно дахины судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Хятад Монгол Оросын эдийн засгийн коридорын хүрээнд Хятад Монгол Оросын гурван талын хамтын ажиллагааны чухал хүчин: эрдэм шинжилгээний дипломат харилцаа


2017 CMRF
CHINA MONGOLIA RUSSIA FORUM

中蒙俄智库国际论坛·2017

ХЯТАД, МОНГОЛ, ОРОСЫН ТИНК ТАНКЫН ОЛОН УЛСЫН ФОРУМ · 2017

МЕЖДУНАРОДНЫЙ ФОРУМ ЭКСПЕРТНЫХ ЦЕНТРОВ КИТАЯ, МОНГОЛИИ И РОССИИ·2017

中蒙俄经济走廊：发展蓝图

ХЯТАД, МОНГОЛ, ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР: ЗАМЫН ЗУРАГ

ЭКОНОМИЧЕСКИЙ КОРИДОР КИТАЙ–МОНГОЛИЯ–РОССИЯ: ДОРОЖНАЯ КАРТА

论坛论文集

ОЛОН УЛСЫН ФОРУМЫН ЭМХЭТГЭЛ

СБОРНИК МАТЕРИАЛОВ ФОРУМА

УЧРЕДИТЕЛЬ: АССОЦИАЦИЯ ЭКСПЕРТНЫХ ЦЕНТРОВ КИТАЯ, МОНГОЛИИ И РОССИИ

ОТВЕТСТВЕННЫЕ ОРГАНИЗАТОРЫ: ИМБТ СО РАН; ЦИПР АРВМ КНР

18–22 СЕНТЯБРЯ 2017
г. УЛАН-УДЭ, РЕСПУБЛИКА БУРЯТИЯ, РОССИЙСКАЯ ФЕДЕРАЦИЯ

**Ariunaa Sh.** Economic Corridor – Supporting Inter-Cultural Communication..........271
**Wuyun**. The Current Situation and Prospect of Cooperation in News Media between China and Mongolia..........273
**Khatanbold O.** Trust as Fundamental Issues on Successful Development of the Economic Corridor..........276
**Petrova E. V.** Problems of Cooperation of the Subjects of the Baikal Region (Irkutsk Oblast, Republic of Buryatia and Zabaikalsky Krai) with Mongolia and China: Attitudes and Opinions of Local Populations (A Sociological Study)..........284
**4.3. PRACTICAL EXPERIENCE AND PERSPECTIVES OF HEALTH SAVING**
**Tugdumov B. V., Rinchinova O. S., Bartanova E. A.** Traditional Medicine of Buryatia – the Property of Russia...290
**Si Qingge**. On the Internationalization of Mongolian Medicine Industry under the China-Mongolia-Russia Economic Corridor..........293
**Bartanova E. A.** Integrative Rehabilitation Technology..........296
**Dambueva I. K.** Gene Pool of the Mongolic-Speaking Ethnoses of Russia, China, Mongolia and Adaptation to the Environment..........297
**Li Cen, Zhang Ming, Geng Lujing, Bi Hongtao, Yang Hongxia, Du Yuzhi, Xiao Yuancan, Wei Lixin.** Traditional Tibetan Medicine Zuotai: Transformation, Leaching and Absorption of Mercury..........300
**Bashelkhanova T. S.** The Effectiveness of the Application of the Herbal Medicines "Taban Arshan" for Treatment of Gonoratoses..........305
**Cao Rong**. Research on Mongolian Culture Identity and Consumption Demand of Mongolian Public Medical Service..........306
**Hasibagen.** Clinical Features and Advantages of Mongolian Medicine..........309

**FORUM DECLARATION AND RECOMMENDATIONS**
**Declaration of the Forum (in Russian and Chinese)**..........313
**Recommendations**..........314

媒体代表团成员由蒙古国记者协会主席嘎拉日德带队,蒙古通讯社、蒙古祖国电视台、蒙古对外之音等媒体代表组成。媒体团首先参观了民贷天下，对民贷天下绿色开放的办公环境表示欣赏[蒙古国新闻媒体代表团，2016]。

**二、中蒙两国新闻媒体合作前景**

中蒙两国地缘相邻、文缘相同、人缘相亲，尤其是内蒙古蒙古族和蒙古国人民同根同族,语言文化相同，有着交流合作的坚实基础，展望未来前景似锦。当前，中蒙两国新闻媒体的合作与交流日益广泛，为进一步促进两国人民之间的了解和友谊，为推进两国全面战略伙伴关系做出了积极贡献。今后两国新闻媒体围绕推进中国“一带一路”战略与蒙古国“发展之路”倡议的对接，特别是围绕“中蒙俄经济走廊”建设互联互通方面的要求，一要进一步拓宽合作领域、合作空间和合作渠道，深化合作内容，使双方媒体合作进一步务实、常态化和可持续发展，共同为构建中蒙两国全面战略伙伴关系营造良好舆论氛围。二要把握好中蒙关系发展的前进方向，阐述好推进“中蒙俄经济走廊”建设的重要意，传播好“中蒙俄经济走廊”建设中的相关新闻，阐释好中蒙俄经济命运共同体，宣传好“亲、诚、惠、容”理念,进而消除误解赢得共识。三要推进中国“一带一路”战略与蒙古国“发展之路”倡议的对接发挥好其社会功能，为政策沟通、设施联通、贸易畅通、资金融通、民心相通等五个合作重点起到监视、解释、劝说和推动作用，共同为“互联互通”建设传递正能量。

结语

1、大众媒体在现代社会发展中，发挥着重要的政治影响力（“媒体政治功能”），突出表现在设置政治议程、形成公共舆论、改变政治关系、影响公共政策、实施政治监督、塑造政治文化等方面。充分发挥媒体政治功能已成为共识。

2、中蒙两国新闻媒体必须进一步加强交流与合作，为推进中国“一带一路”战略与蒙古国“发展之路”倡议的对接、为促进“中蒙俄经济走廊”建设发挥好“媒体政治功能”。

3、近年来中蒙两国新闻媒体的交流与合作取得长足进展，各种交流互访不断，合作得到深化发展为两国和两国人民间搭起了一座桥梁，为两国各领域合作的发展创造了良好的舆论环境 ，进而为构建两国全面战略伙伴关系做出了贡献。


参考文献：

第二届中蒙新闻论坛在呼和浩特举行（2011.10.20），文档存取方式：www.chinanews.com：。

中国国际广播电台蒙古语部2016年工作总结。

内蒙古新闻出版广电局着力加强对外文化交流融入国家“一带一路”战略，文档存取方式：www.nmg.gov.cn

第二届中蒙新闻论坛在呼和浩特举行（2011.10.20），文档存取方式：www.chinanews.com

内部资料：内蒙古广播电视台蒙古语卫视对外交流合作工作总结，2016年。

第六届中蒙新闻论坛在内蒙古举行，中国新闻光电报，2015年10月16日。

蒙古国新闻媒体团山东考察采访活动圆满结束(2015.10.21)， 文档存取方式：http://news.sdchina,com

蒙古国新闻媒体代表团到内蒙古考察采访(2016.3.21)，文档存取方式：www.northnews.cn

蒙古国媒体代表团考察内蒙古“绿色发展”(2016.6.4) 文档存取方式：www.people.com.cn

蒙古国媒体代表团到贵州参观访问(2016.11.4)，文档存取方式：www.people.com.cn

蒙古国媒体代表团考察民贷天下（2016.11.15），文档存取方式：www.gmw.cn


## TRUST AS FUNDAMENTAL ISSUES ON SUCCESSFUL DEVELOPMENT OF THE ECONOMIC CORRIDOR


**Khatanbold Oidov**

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

khatanboldo@gmail.com



The paper issued on responding the challenges and clarified opportunities to the successful development in the economic corridor as fundamental specters of the sustainable government responsiveness and accountabilities are reflected as negatively and positively. Within the framework of capacity building that requires to categorizing its development, empowerment and strengthening-all describe an increase in the ability of social organization to achieve the goals that are institutionally set up. Though, capacity building goes well beyond the provision of basic needs, in regarding the matter of development at all levels of society and includes *institutional development, community development and economic development.* The central assets that identifies of *individuals, organizations, communities and governments* need in order to achieve their full potentials including prior knowledge, technical skills, and institutional or organizational capacities, in regarding the ability to prevent, manage and resolve conflicts.

The paper focused on how to build political capacity and the ability of individuals and institutions (organizations) to implement sustained and succeeded development strategies of the economic corridor. The focuses such above-mentioned illuminate the challenges and opportunities of the sustainable economic corridor based on three levels of institutional sectoral and individual responsiveness and capabilities. Structure and level of economic corridor although touches to fundamental things to forming economy. Sometimes left beyond the economy we have to solve the crucially specters of politics (treaties, commitment etc.), culture (national values, norms and behavior etc).

We essentially solve the major factors of facial negative impact to weakness mechanism of coherent relationship between such mentioned levels of individuals, *organizations, communities and governments*. There is lack of expectation and cooperation and cultural coherent respective of people's attitudes and public trust to the further advancement of economic independence and sustainability. However, our major approach is trust as fundamental issues on the roots of economy. Such we researched findings repeatedly evince that a trend of the past years, in order to identifying the declines of public trust in government institutions and public organization activities, regarding to activities of the government priorities to serve the institutional accountabilities in the face of public demands in connection with decision or policy making participation.

Development is the process by which vulnerabilities are reduced and capacities increased no one develops anyone else relief programs are never neutral in their development impact. In association with capacity building is the idea of building the capacities of governments in developing countries, so they are able to handle the problems connected to environmental, economic and social transformations. While developing a government's capacity whether at the locally, regionally or nationally in acceptation with better governance that is leading to sustainable development and democracy.

Rationale of the economic corridor is part of a developmental process, and organizations repeat phases at different stage in towards capacity. While, we talk about capacity building than we have to initiate the effective interventions on the capacity in addressing the unique needs of an organization in its particular stage of development at that specific time. This paper was initiated by the comparative data analysis in the latest survey findings and current state of public trust in the individuals, organizations, communities and government in Mongolia as categorizing that fundamental factors to the sustainable development of economic corridor.

**Keywords:** individuals; organizations; communities; economic corridor; sustainable economic corridor.

**Оршил**

Аливаа улс орнуудын харилцан хамтын ажиллагаа түүний дотор зорилтод хөгжлийн төлөөх томоохон төслүүд, олон талт хамтын ажиллагааг өргөн хүрээнд үр өгөөжтэй, харилцан ашигтай, ил тод, хариуцлагатай амжилттай хэрэгжүүлэхэд тухайн оролцогч талууд (3 улс)-ын бодлого хийгээд институтуудын тогтвортой, тодорхой байдал, иргэд олон нийтийн итгэл найдвар, салбар хоорондын харилцан уялдаатай итгэлцэл, үр нөлөөнөөс шууд хамаарч байдаг билээ.

ОХУ, Монгол Улс, БНХАУ гурван улсыг холбосон "Эдийн засгийн коридор" байгуулах хөтөлбөр болсүүлийн жилүүдэд тогтмол зохиогдож, улмаар гурван улсын төрийн тэргүүнүүдийн уулзалт, түүний хүрээнд өрнөсөн олон талт үйл явцын[7] эхний үр дүн юм. Үүнийг талууд өндрөөр үнэлж, "Эдийн засгийн коридор"-ыг Монголын тал *"Талын зам"*, БНХАУ *"Торгоны зам"*, ОХУ-ын хувьд *"ЕвроАзийн эдийн засгийн холбоо"* хэмээн онцгойлон ач холбогдол өгөн хамтын ажиллаганы хүрээнд оролцогч талуудын харилцан ойлголцсон бодлого, хууль эрх зүйн тогтвортой байдал, засаглалын институтүүдийн харилцан уялдсан хамтын ажиллагааны үр нөлөөтэй хамтын ажиллагаагаар дамжин хэрэгжих нь зайлшгүй. Энэ талаар ч гурван улсын төрийн тэргүүнүүдн өмнөх жилүүдийн форумын үйл ажиллагаанд оролцохдоо цохон тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, БНХАУ-ын дарга Си Зиньпин "Хөтөлбөр нь гурван улсын хөгжлийн стратегийг уялдуулсан тодорхой арга хэмжээг хэрэгжүүлжгурван талын бодит хамтын ажиллагааны нэн тэргүүний чиглэлийг тодорхойлсон болно"[8] гэсэн бол, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В. Путин "...төслүүдийг хэрэгжүүлэх нь бүс нутгийн интеграцчилалын төслүүдийг урагшлуулах, юуны өмнө Евразийн бүс нутагт, түүний дотор Евразийн эдийн засгийн холбоо... түншлэлийг бий болгоход дэмжлэг болно"[9] гэж онцолсон байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухайд гурван орны хамтын ажиллагааг илүү өргөн хүрээнд гүнзгийрүүлэх сонирхолтой буйгаа "Манай хамтын ажиллагаа нь зөвхөн эдийн засгийн коридор, тээвэр, гаалийн салбараар хязгаарлагдахгүй. Ирээдүйтэй салбаруудын нэг нь бүс нутаг хоорондын хамтын ажиллагаа юм" хэмээн илэрхийлсэн байна.[10] Энэ бол, гурван улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтууд эдийн засгийн коридорын хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдаж байгаа нь төслүүдийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Бид энэхүү илтгэлдээ эдийн засгийн корридорын хөгжлийн тогтвортой стратегийг хэрэгжүүлэхэд улс төрийн чадавхийг бэхжүүлэх, хүмүүсийн итгэл болон байгууллагуудын харилцан уялдаатай итгэлцэл дээр суурилсан харилцаа, түүний чадавхийг хэрхэн бүрдүүлэх тухайд онцгойлон анхаарсан болно. Эдийн засгийн коридорын бүтэц, түүний түвшин нь хэдийгээр эдийн засгийг бүрдүүлэхэд зайлшгүй чухал шаардлагатай ч түүний үнэт зүйлс юунд оршидогийг тодруулах нь зүйн. Үнэндээ эдийн засгийн цаана улс төр (гэрээ, амлалт г.м.), соёл (үндэсний үнэт зүйлс, норм, зан үйл)–ыг тооцон үзэхгүйгээр орхиж үл болно.

Үнэндээ, бид хувь хүмүүс, байгууллага, олон нийт, засгийн газрын түвшинд харилцан уялдаа сул байгаа нь өнөөдөр сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйлс төдийгүй харилцааны механизм хангалтгүй буйг шийдвэр-

[7] Өнгөрсөн гурван жилийн хугацаанд гурван талын холбогдох ажлын хэсэг 17 удаагийн уулзалт яриа болсон байна.

[8] 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөрБН Узбекстан улсын нийслэл Ташкент хотноо болсон Гурван талын дээд хэмжээний уулзалтын үеэр БНХАУ-ын дарга Си Зиньпиний хэлсэн үгнээс.

[9] 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөрБН Узбекстан улсын нийслэл Ташкент хотноо болсон Гурван талын дээд хэмжээний уулзалтын үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины хэлсэн үгнээс.

[10] 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөрБН Узбекстан улсын нийслэл Ташкент хотноо болсон Гурван талын дээд хэмжээний уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хэлсэн үгнээс.